



ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ХӨГЖЛИЙН ТӨВ



World Health  
Organization

Representative Office  
for Mongolia

# ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ



# 2020



ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ХӨГЖЛИЙН ТӨВ



World Health  
Organization

Representative Office  
for Mongolia

# ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ

# 2020

Энэхүү эмхэтгэлийн талаарх саналыг дараах хаягаар ирүүлнэ үү.  
Эрүүл мэндийн хөгжлийн төв

Шуудангийн хаяг: С.Зоригийн гудамж  
Улаанбаатар -210648  
Факс: 976-11-320633  
Утас: 70111485  
Э-шуудан: admin@hdc.gov.mn  
www.hdc.gov.mn

Эрхэлсэн: Б.Нарантуяа, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал  
Хянасан: Б.Доржмягмар, ЭММА-ны дарга

Эмхэтгэсэн: С.Даваажаргал, ЭММА-ны ахлах мэргэжилтэн  
Х.Нарантуяа, ЭММА-ны мэргэжилтэн  
Б.Болдбаатар, ЭММА-ны мэргэжилтэн  
Х.Дэлгэрмаа, ЭММА-ны мэргэжилтэн  
Б.Отгончимэг, ЭММА-ны мэргэжилтэн  
Д.Уранчимэг, ЭММА-ны ажилтан  
Г. Мөнхсоёл, ЦССҮТ-ийн статистикч  
П.Батчулуун, ЭЭШСҮАЗА-ны албаны дарга  
Г.Батцэцэг, ЭЭШСҮАЗА-ны ахлах мэргэжилтэн  
Б.Алтантулга, ЭЭШСҮАЗА-ны мэргэжилтэн  
Х.Мөнхтуяа, ЭМЭЗБСА-ны мэргэжилтэн  
Ш.Энхзаяа, ЭЭХХЗГ-ын ЭХЛА Хариуцсан дарга



# ГАРЧИГ

ЗУРГИЙН ЖАГСААЛТ	9
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	16
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	18
ӨМНӨХ ҮГ	19
ХУРААНГУЙ	20
<b>БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫН ХҮН АМ</b>	<b>23</b>
1.1 ХҮН АМЫН НАС ХҮЙСИЙН БҮТЭЦ	24
1.2 ХҮН АМ ЗҮЙН АЧААЛАЛ	25
1.3 ХҮН АМЫН НЯГТРАЛ	26
1.4 ХҮН АМЫН ТӨРӨЛТ	27
1.5 ХҮН АМЫН ДУНДАЖ НАСЛАЛТ	28
<b>БҮЛЭГ 2. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ БА БҮХ НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАМРАЛТ</b>	<b>32</b>
2.1 БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД	32
2.2 ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ИНДЕКСЫН ОНОО	33
2.3 ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД	34
2.4 ХАЛДВАРТ ӨВЧИН	35
2.5 ХАЛДВАРТ БУС ӨВЧИН	36
2.6 БҮХ НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАМРАЛТ	37
<b>БҮЛЭГ 3. ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД</b>	<b>39</b>
<b>3.1 ЭХИЙН ЭРҮҮЛ МЭНД</b>	<b>40</b>
3.1.1 Жирэмсний хяналт ба төрөхийн өмнөх үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ	40
3.1.2 Төрөлт, төрөх үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ	43
3.1.3 Төрсний дараах тусламж, үйлчилгээ	47
3.1.4 Эхийн эндэгдэл	49
3.1.5 Төрсөн нярайн мэдээлэл	51
3.1.6 Үр хөндөлт	53
3.1.6 Жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн аргын хэрэглээ (ЖСА)	55
<b>3.2 ХҮҮХЭД, ӨСВӨР НАСНЫХНЫ ЭРҮҮЛ МЭНД</b>	<b>56</b>
3.2.1 Хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үзүүлэлт	56
3.2.2 Стационарын тусламж үйлчилгээ	57
3.2.3 Идэвхтэй хяналтын мэдээлэл	57
3.2.4 Хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээл	58
3.2.5 Дархлаажуулалтын хамралт	59
3.2.7 Нялхас болон нярайн эндэгдэл	63
3.2.8 Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	67
3.2.9 Хүүхэд, өсвөр насныхны нас баралтын шалтгаан	71



<b>БҮЛЭГ 4. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ</b>	<b>75</b>
4.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ТҮҮХЭН ТОВЧОО	76
4.2 ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	78
4.3 ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА, ОРНЫ ХАНГАМЖ	78
4.4 ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ	81
4.5 СУМ, ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ	83
4.7 БҮСИЙН ОНОШЛОГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ	90
4.8 ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛЭГ, ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ТӨВҮҮДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ	93
4.9 ХУВИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ	95
4.10 КОРОНАВИРУСТ ХАЛДВАР(COVID-19) –ЫН ҮЕИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ	99
<b>БҮЛЭГ 5. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦ</b>	<b>103</b>
5.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НИЙТ АЖИЛЛАГЧИД	103
5.2 ИХ ЭМЧ, СУВИЛАГЧ	107
5.3 ИХ ЭМЧ, СУВИЛАГЧИЙН ХАРЬЦАА	110
<b>БҮЛЭГ 6. ХАЛДВАРТ ӨВЧИН</b>	<b>115</b>
6.1 БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ	115
6.2 ХАЛДВАРТ ӨВЧНИЙ БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ТҮҮХ	115
6.3 ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	120
<b>6.4 АМЬСГАЛЫН ЗАМЫН ХАЛДВАРТ ӨВЧИН</b>	<b>122</b>
6.4.1 Салхинцэцэг	123
6.4.2 Менингококкт халдвар	124
6.4.3 Гахай хавдар	124
6.4.4 Сүрьеэ	125
6.4.5 Хүүхдийн сүрьеэгийн өвчлөл	126
6.4.6 Сүрьеэгийн эмчилгээний үр дүн	127
6.4.7 Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн үзүүлэлт	127
<b>6.5 ГЭДЭСНИЙ ХАЛДВАРТ ӨВЧИН</b>	<b>128</b>
6.5.1 Цусан суулга өвчин	129
6.5.2 Хоолны хордлогот халдвар	129
6.5.3 Вирүст гепатит	130
<b>6.6 БЭЛГИЙН ЗАМААР ДАМЖИХ ХАЛДВАРТ ӨВЧИН</b>	<b>131</b>
<b>6.7 ЗООНОЗЫН ХАЛДВАРТ ӨВЧИН</b>	<b>133</b>
<b>БҮЛЭГ 7 ХАЛДВАРТ БУС ӨВЧЛӨЛ</b>	<b>136</b>
7.1. ХҮН АМЫН ӨВЧЛӨЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН	137



7.1.1. Амьсгалын тогтолцооны өвчин	138
7.1.2 Хоол боловсруулах тогтолцооны өвчин	140
7.1.3 Зүрх судасны тогтолцооны өвчин	143
7.1.4 Шээс бэлгийн тогтолцооны өвчин	146
7.2 ЧИХРИЙН ШИЖИН ӨВЧИН	150
7.3 ХОРТ ХАВДАР	151
7.3.1 Хүүхдийн хорт хавдар	155
7.3.2 Хорт хавдрын хяналт	156
7.4 ОСОЛ ГЭМТЭЛ БА ЗАРИМ ГАДНЫ ШАЛТГААНЫ ҮР ДАГАВАР	157
7.5 ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЭГЧДИЙН ӨВЧЛӨЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН	160
7.6 ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРТ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГ	162
7.7 МЭС ЗАСЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	164
<b>БҮЛЭГ 8 ХҮН АМЫН НАС БАРАЛТ</b>	<b>169</b>
8.1 ХҮН АМЫН НАС БАРАЛТЫН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН	169
8.2 ЗҮРХ СУДАСНЫ ТОГТОЛЦООНЫ ӨВЧНИЙ ШАЛТГААНТ НАС БАРАЛТ	173
8.3 ХОРТ ХАВДРЫН ШАЛТГААНТ НАС БАРАЛТ	174
8.4 ХҮҮХДИЙН ХОРТ ХАВДРЫН ШАЛТГААНТ НАС БАРАЛТ	175
8.5 ОСОЛ ГЭМТЭЛ, ГАДНЫ ШАЛТГААНТ НАС БАРАЛТ	177
8.4.1 Зам тээврийн ослын шалтгаант нас баралт	178
8.4.2 Амиа хорлолт	179
8.4.3 Бусад ослын шалтгаант нас баралт	181
8.5 ХООЛ БОЛОВСРУУЛАХ ТОГТОЛЦООНЫ ӨВЧНИЙ ШАЛТГААНТ НАС БАРАЛТ	183
8.6 АМЬСГАЛЫН ТОГТОЛЦООНЫ ӨВЧНИЙ ШАЛТГААНТ НАС БАРАЛТ	184
<b>БҮЛЭГ 9. ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>	<b>186</b>
9.1 Цус, цусан бүтээгдэхүүний хангалт	187
9.2 Цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэл	190
<b>БҮЛЭГ 10. ЭС, ЭД, ЭРХТНИЙГ ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>	<b>192</b>
10.1.2 Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагаа	193
10.2 Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний дараах хяналт	196
<b>БҮЛЭГ 11. ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭДИЙН ЗАСАГ</b>	<b>199</b>
11.1. Эрүүл мэндийн салбарын төсвийн гүйцэтгэл	199
11.2. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зардал	204
<b>БҮЛЭГ 12 МОНГОЛ УЛСЫН ЭМ ЗҮЙН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ</b>	<b>208</b>
12.1 Эм хангамжийн байгууллагын үзүүлэлт	209
12.2 Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэр	209
12.3 Эм ханган нийлүүлэх байгууллага	210
12.4 Эмийн бүртгэл	211
<b>БҮЛЭГ 13. ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРҮҮД, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ</b>	<b>215</b>
13.1 Үндэсний хөтөлбөрүүд, хэрэгжилт	215
13.2 Үндэсний хөтөлбөрүүдийн шалгуур үзүүлэлтүүд	216

13.2.1	Халдварт бус өвчнөөс сэргийлэх үндэсний хөтөлбөр	216
13.2.2	“Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах” үндэсний хөтөлбөр	218
13.2.3	“Осол гэмтлээс сэргийлэх” үндэсний хөтөлбөр	222
13.2.4	“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр	224
13.2.5	“Эрүүл насжилт, настны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр	228
13.2.6	Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын үндэсний хөтөлбөр	230
13.2.7	Орчны эрүүл мэнд хөтөлбөр, 2021-2024 он	232
БҮЛЭГ 14. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, 10 ЖИЛЭЭР		235
БҮЛЭГ 15. СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД		250
БҮЛЭГ 16. ХАВСРАЛТ ХҮСНЭГТҮҮД		297



## ЗҮРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. 1 Хүн амын тоо, жилийн дундаж өсөлтийн хувь, 2009-2020 он	23
Зураг 1. 2 Хүн амын нас хүйсийн суварга, 2000, 2020 он	24
Зураг 1. 3 Хүн амын насны бүтэц, сонгосон оноор	25
Зураг 1. 4 Хүн ам зүйн ачаалал, сонгосон оноор	25
Зураг 1. 5 Хүн амын нягтрал, аймаг, нийслэлээр, 2020 он	27
Зураг 1. 6 Хүн амын төрөлтийн түвшин, 1000 хүн амд, сонгосон онуудаар	27
Зураг 1. 7 Төрөх үеийн хүйсийн харьцаа, 2010-2020 он	28
Зураг 1. 8 Амьд төрсөн хүүхдийн тоо, хүйсээр, 2010-2020 он	28
Зураг 1. 9 Хүн амын дундаж наслалт, сонгосон онуудаар	29
Зураг 1. 10 Хүн амын дундаж наслалт, аймаг, нийслэлээр, 2020 он	29
Зураг 1. 11 Дундаж наслалт, хүйсээр, сонгосон онуудаар	30
Зураг 2. 1 Хүн амын дундаж наслалт, хүйсээр, сонгосон онуудаар	33
Зураг 2. 3 ТХЗ 3.1.1 Эхийн эндэгдлийн харьцаа (100 000 амьд төрөлтөд)	34
Зураг 2. 4 ТХЗ: 3.1.2 Эрүүл мэндийн мэргэжлийн ажилтан эх барьсан төрөлтийн хувь	34
Зураг 2. 5 ТХЗ 3.7.2 Өсвөр насны охидын төрөлтийн түвшин (15-19 насны 1000 охидод)	34
Зураг 2. 6 ТХЗ: 3.2.1 Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох)	34
Зураг 2. 7 ТХЗ: 3.2.2 Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох)	35
Зураг 2. 8 ТХЗ 3.3.1 ХДХВ-ийн халдварлаагүй 1000 хүн амд ногдох ХДХВ-ийн шинэ тохиолдлын тоо	35
Зураг 2. 9 ТХЗ 3.3.2 Сүрьеэ өвчний тохиолдлын түвшин /100 000 хүн амд/	36
Зураг 2. 10 ТХЗ 3.4.1 30 настай хүний Зүрх судасны өвчин, хавдар, чихрийн шижин, амьсгалын замын архаг өвчнөөр нас барах магадлал, 2016 он	36
Зураг 2. 11 ТХЗ 3.6.1 Зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин (100 000 хүнд ногдох зам тээврийн ослоор нас барсан хүний тоо)	37
Зураг 2. 12 ТХЗ 3.4.2 Амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин (100,000 хүнд ногдох амиа хорлосон хүний тоо)	37
Зураг 2. 13 ТХЗ 3.8.1 Эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээний хамралтын хувь	37
Зураг 3. 1 Жирэмсний эхний 3 сартайд хяналтад хамрагдсан хувь, сонгосон онуудаар	41
Зураг 3. 2 Цус багадалттай жирэмсэн эхчүүдийн эзлэх хувь, 2020 он	41
Зураг 3. 3 Жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш удаа хяналтанд хамрагдсан эмэгтэйчүүдийн хувь, аймгаар, 2020 он	42
Зураг 3. 4 Төрөлт, амьгүй төрөлтийн тоо, сонгосон онуудаар	43
Зураг 3. 5 Төрөлтийн ерөнхий болон тусгай коэффициент, 2010-2020 он	44
Зураг 3. 6 1000 хүн амд ногдох төрөлтийн түвшин, аймгаар, 2020 он	44
Зураг 3. 7 Мэс заслын аргаар төрсөн эхийн хувь, аймгаар, 2020 он	45
Зураг 3. 8 Улаанбаатар хотод хөдөө орон нутгаас ирж төрсөн эхчүүд, бодит тоо, 2020	46
Зураг 3. 9 Жирэмсэн, төрөх, төрсний дараах хүндрэлийн шалтгаан, хувиар, 2020 он	47
Зураг 3. 10 Жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэлийн тохиолдол, эмнэлгийн төрлөөр, 2020 он	47
Зураг 3. 11 Жирэмсний хүндрэлд манас таталтын эзлэх хувь, аймгаар 2020 он	48
Зураг 3. 12 Төрөх үеийн хүндрэлд төрөх хүчний сулралын эзлэх хувь, аймгаар 2020 он	48
Зураг 3. 13 Төрсний дараах хүндрэлд цус алдалтын эзлэх хувь, 2020	49
Зураг 3. 14 Эхийн эндэгдлийн тохиолдол, сонгосон онуудаар	49
Зураг 3. 15 Эхийн эндэгдэл 100 000 амьд төрөлтөд, аймгаар, 2020 он	50
Зураг 3. 16 Эхийн эндэгдэл бүсээр, 100 000 амьд төрөлтөд, 2020 он	51
Зураг 3. 17 Бага жинтэй /2500гр-аас доош/ төрсөн хүүхдийн тоо, хувь, 2010-2020 он	52

Зураг 3. 18 Амьгүй төрөлтийн түвшин 1000 нийт төрөлтөд, аймгаар 2020 он	53
Зураг 3. 19 Үр хөндөлтийн тохиолдол, 2009-2020 он	54
Зураг 3. 20 15 хүртэлх насны хүүхдийн тоо, хүн амд эзлэх хувь, сонгосон онуудаар	56
Зураг 3. 21 Хүүхдийн эмчийн тоо, сонгосон онуудаар	56
Зураг 3. 22 Хүүхдийн орны тоо, сонгосон онуудаар	57
Зураг 3. 23 Заавал хийх дархлаажуулалтын хамралтын хувь, бүсээр 2011-2020 он	59
Зураг 3. 24 Амьсгалын тогтолцооны өвчин, 10000 хүн амд, насны бүлгээр, 2011-2020 он	63
Зураг 3. 25 Нэг хүртэлх насны хүүхдийн амьсгалын тогтолцооны өвчлөл, тухайн насны 10000 хүүхдэд, сүүлийн 10 жилийн дундаж	63
Зураг 3. 26 Нялхсын эндэгдлийн түвшин, 1000 амьд төрөлтөд бүсээр, сонгосон онуудаар	64
Зураг 3. 27 Нялхсын эндэгдэлд нярайн эндэгдлийн эзлэх хувь	64
Зураг 3. 28 Нярайн эндэгдлийн шалтгаан, Төрөх тойрны /перинаталь/ үед үүсэх зарим оёг, 2010-2020 он	65
Зураг 3. 29 Нярайн эндэгдлийн шалтгаан, Төрөлхийн гажиг, гаж хөгжил, 2010-2020 он	66
Зураг 3. 30 Нярайн эндэгдлийн шалтгаан, Амьсгалын тогтолцооны эмгэг, 2010-2020 он	66
Зураг 3. 31 Нярайн эндэгдлийн шалтгаан, Осол гэмтэл, гадны шалтгаан, 2010-2020 он	67
Зураг 3. 32	68
Зураг 3. 33 Нялхсын эндэгдэл, 1000 амьд төрөлтөд, хүйсээр, 2010-2020 он	69
Зураг 3. 34 Эмнэлгийн нас баралтын тоо, хоног болоогүй нас баралтын хувь, 2010-2020 он	69
Зураг 3. 35 Гэрийн эндэгдлийн тохиолдол, хувь, 2010-2020 он	69
Зураг 3. 36 Гэрийн эндэгдлийн шалтгаан, 2020 он	70
Зураг 3. 37 Перинаталь эндэгдэл, бодит тоо, хувь, 2010-2020 он	70
Зураг 3. 38 Амьсгалын тогтолцооны эмгэгийн шалтгаант эндэгдэл, 2010-2020 он	71
Зураг 3. 39 Уушгины хатгалгаа өвчний улмаас эндсэн нялхсын тоо, хүйсээр, 2010-2020 он	71
Зураг 3. 40 0-19 насны эндэгдлийн тэргүүлэх 5 шалтгаан, 10 000 хүүхдэд, 2010-2020 он	72
Зураг 3. 41 5-9 насны эндэгдлийн тохиолдол, 10 000 хүүхдэд, 2010-2020 он	72
Зураг 3. 42 5-9 насны эндэгдлийн тэргүүлэх 5 шалтгаан, 10 000 хүүхдэд, 2010-2020 он	73
Зураг 3. 43 10-14 насны эндэгдлийн тохиолдол, 10 000 хүүхдэд, 2010-2020 он	73
Зураг 3. 44 5-9 насны эндэгдлийн тэргүүлэх 5 шалтгаан, 10 000 хүүхдэд, 2010-2020 он	73
Зураг 3. 45 15-19 насны эндэгдлийн тохиолдол, 10 000 хүүхдэд, 2010-2020 он	74
Зураг 3. 46 15-19 насны эндэгдлийн тэргүүлэх 5 шалтгаан, 10 000 хүүхдэд, 2010-2020 он	74
Зураг 4. 1 Эрүүл мэндийн байгууллагын тоо, сонгосон онуудаар	77
Зураг 4. 2 Эрүүл мэндийн байгууллагын тоо, сонгосон онуудаар	77
Зураг 4. 3 Эмнэлгийн орны тоо, 10 000 хүн амд, 1925-2000 сонгосон онуудаар	77
Зураг 4. 4 Эмнэлгийн орны тоо, 2010-2020 он	79
Зураг 4. 5 10 000 хүнд ногдох орны тоо, мэргэжлийн төрлөөр, 2010-2020 он	79
Зураг 4. 6 10 000 хүнд ногдох орны тоо, мэргэжлийн төрлөөр, 2010-2020 он	80
Зураг 4. 7 10 000 хүнд ногдох орны тоо, мэргэжлийн төрлөөр, 2010-2020 он	80
Зураг 4. 8 Эмнэлгийн ор ашиглалтын үзүүлэлтүүд, аймгаар, 2020 он	80
Зураг 4. 9 Өрхийн эрүүл мэндийн төвийн тоо, 2010-2020 он	81
Зураг 4. 10 Өрхийн эрүүл мэндийн төвийн их эмчийн тоо, 2010-2020 он	82
Зураг 4. 11 Өрхийн эрүүл мэндийн төвийн сувилагчийн тоо, 2010-2020 он	82
Зураг 4. 12 Нэг өрхийн эмчид ногдох үзлэг, нэг иргэний үзүүлсэн тоо, 2010-2020 он	82
Зураг 4. 13 Өрхийн эрүүл мэндийн төвд хийгдсэн амбулаторийн үзлэгийн тоо /саяаар/	83
Зураг 4. 14 Жирэмсний эрт хяналтын хувь, 2010-2020 он	83
Зураг 4. 15 Сумын эрүүл мэндийн төвийн эмч, сувилагчийн тоо, 2010-2020 он	84
Зураг 4. 16 Стационарын тусламж үйлчилгээний үзүүлэлт, 2010-2020 он	85
Зураг 4. 17 Жирэмсний эрт хяналтын хувь, 2010-2020 он	86
Зураг 4. 18 Сумын эрүүл мэндийн төвийн эмчийн үзлэг, 2010-2020 он	86
Зураг 4. 19 Эх, хүүхдийн эндэгдлийн түвшин, 2010-2020 он	87
Зураг 4. 20 Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн их эмчийн тоо, 2010-2020 он	87



Зураг 4. 21 Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн сувилагчийн тоо, 2010-2020 он	88
Зураг 4. 22 Амбулаториор үйлчлүүлсэн хүний тоо, 2010-2020 он	88
Зураг 4. 23 Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь, 2010-2020 он	88
Зураг 4. 24 Эх, хүүхдийн эндэгдлийн түвшин, 2010-2020 он	89
Зураг 4. 25 Аймгийн нэгдсэн эмнэлгийн стационарын тусламж үйлчилгээний үзүүлэлт, 2010-2020 он	89
Зураг 4. 26 Дүүргийн нэгдсэн эмнэлгийн стационарын тусламж үйлчилгээний үзүүлэлт, 2010-2020 он	90
Зураг 4. 27 Хоног болоогүй нас баралтын хувь, 2010-2020 он	90
Зураг 4. 28 БОЭТ-ийн хүний нөөцийн үзүүлэлт, 2010-2020 он	91
Зураг 4. 29 БОЭТ-ийн стационарын тусламж үйлчилгээний үзүүлэлт, 2010-2020 он	91
Зураг 4. 30 БОЭТ-ийн хоног болоогүй нас баралтын хувь, 2010-2020 он	91
Зураг 4. 31 Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо, 2010-2020 он	92
Зураг 4. 32 Эх, хүүхдийн эндэгдлийн түвшин, 2010-2020 он	92
Зураг 4. 33 Тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүдийн их эмч, сувилагчийн тоо, 2010-2020 он	93
Зураг 4. 34 Стационарын тусламж үйлчилгээний үзүүлэлт, 2010-2020 он	93
Зураг 4. 35	94
Зураг 4. 36 Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо, 2010-2020 он	94
Зураг 4. 37 Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд хөдөө орон нутгаас ирж эмчлүүлэгчдийн эзлэх хувь	94
Зураг 4. 38 Хувийн хэвшлийн эмнэлгийн тоо, 2010-2020 он	96
Зураг 4. 39 Хувийн хэвшлийн эмнэлгийн орны тоо, 2010-2020 он	96
Зураг 4. 40 Хувийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тоо, 2010-2020 он	97
Зураг 4. 41 Хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн шалтгаан, хувиар, 2020 он	97
Зураг 4. 42 Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо, мянган хүн, 2010-2020 он	98
Зураг 4. 43 Шуурхай хариу арга хэмжээний багийн голомтын халдваргүйжүүлэлт зохион байгуулсан тоо	100
Зураг 4. 44	100
Зураг 4. 45 ЗӨСҮТ-ийн вирус судлалын лабораторийн шинжилгээ	101
Зураг 5. 1 Эрүүл мэндийн байгууллагын ажиллагчдын тоо, 1990-2000 он	103
Зураг 5. 2 Эрүүл мэндийн байгууллагын дунд мэргэжилтнүүд, 10 000 хүн амд, 1960-2000, сонгосон онуудаар	104
Зураг 5. 3 Эрүүл мэндийн ажиллагчид, 2000, 2005, 2009-2020 он	105
Зураг 5. 4 Эрүүл мэндийн ажиллагчид, насны бүлгээр, 2020 он	106
Зураг 5. 5 Эрүүл мэндийн ажиллагчид, 10 000 хүн амд, бүс, аймгаар, 2020 он	106
Зураг 5. 6 Их эмчийн тоо, 1925-2000 сонгосон онуудаар	107
Зураг 5. 7 Их эмч, сувилагчийн тоо, 10 000 хүн ам тутамд, 2000, 2005, 2009, 2010-2020 он	107
Зураг 5. 8 10 000 хүн амд ногдох их эмч, мэргэшлийн төрлөөр, 2000, 2005, 2009-2020 он	108
Зураг 5. 9 10 000 хүн амд ногдох их эмч, мэргэшлийн төрлөөр, 2000, 2005, 2009-2020 он	108
Зураг 5. 10 10 000 хүн амд ногдох их эмч, мэргэшлийн төрлөөр, 2020 он	109
Зураг 5. 11 10 000 хүн амд ногдох их эмч, бүс нутгаар, 2016-2020 он	109
Зураг 5. 12 10 000 хүн амд ногдох сувилагч, бүс нутгаар, 2016-2020 он	110
Зураг 5. 13 Эмч, сувилагчийн харьцаа, бүс нутгаар, 2020 он	110
Зураг 5. 14 Нэг сувилагчид ногдох хүний тоо, байршлаар, 2016-2020 он	113
Зураг 6. 1 Цагаан цэцэг өвчний өвчлөлийн түвшин, 10 000 хүн амд, 1928-1938 он	116
Зураг 6. 2 Тарваган тахлын өвчлөлийн түвшин, 1928-2000 он	116
Зураг 6. 3 Улаанбурханы өвчлөл, 10 000 хүн амд, сонгосон онуудаар	117
Зураг 6. 4 Полимиелит өвчний өвчлөлийн түвшин, 1962-1993 он	117
Зураг 6. 5 Амьсгалын замын зарим халдварт өвчнүүд, 10 000 хүн амд, сонгосон онуудаар	117
Зураг 6. 6 Балнад, цусан суулгын өвчлөл эндэгдэл, 1966-2000 он	118



Зураг 6. 7 Бэлгийн замаар дамжих халдварт өвчин, 10 000 хүн амд, 1965-2000 он	119
Зураг 6. 8 Сүрьеэгийн өвчлөл, нас баралт, 1962-2000 он	119
Зураг 6. 9 Халдварт өвчнөөр өвчлөгчид, 2010-2020 он	120
Зураг 6. 10 Халдварт өвчнөөр өвчлөгчид, бүсээр, 2010-2020 он	120
Зураг 6. 11 Халдварт өвчнөөр өвчлөгчид, төрлөөр, дүнд эзлэх хувиар	121
Зураг 6. 12 Халдварт өвчний тохиолдол (10000 хүнд ногдох), төрлөөр, 2010-2020 он	121
Зураг 6. 13 Амьсгалын замын халдварт өвчний тоо, хувь, 2010-2020 он	122
Зураг 6. 14 Амьсгалын замын халдварт өвчнүүд, 10 000 хүн амд, бүсээр, 2010-2020 он	123
Зураг 6. 15 Салхинцэцэг өвчин, 2010-2020 он	123
Зураг 6. 16 Гахайн хавдрын өвчлөл, сүүлийн 10 жилээр	124
Зураг 6. 17 Сүрьеэгийн өвчлөлийн түвшин, 2010-2020 он	125
Зураг 6. 18 Сүрьеэгийн өвчлөл, 10 000 хүн амд, бүсээр, 2010-2020 он	125
Зураг 6. 19 Хүүхдийн сүрьеэгийн бүртгэгдсэн тохиолдол, 2012-2020 он	126
Зураг 6. 20 Уушгины халдвартай хэлбэрийн сүрьеэгийн эмчилгээний амжилт, 2012-2020 он	127
Зураг 6. 21 Риф/ОЭТС-ийн эмчилгээний үр дүн, 2016-2020 он	127
Зураг 6. 22 Гэдэсний халдварт өвчин, 2010-2020 он	128
Зураг 6. 23 Цусан суулга өвчний өвчлөлийн тоо, түвшин, 2010-2020 он	129
Зураг 6. 24 Хоолны хордлогот халдвар, 2010-2020 он	130
Зураг 6. 25 Нийслэлд бүртгэгдсэн хоолны хордлогот халдвар, 10 000 хүн ам тутамд	130
Зураг 6. 26 Вируст гепатитын бүртгэгдсэн тохиолдол, 2010-2020 он	131
Зураг 6. 27 Вируст гепатитын бүтэц, 2020 он	131
Зураг 6. 28 Бэлгийн замаар дамжих халдварт өвчин, 2010- 2020 он	131
Зураг 6. 29 Бэлгийн замаар дамжих халдвар, 10 000 хүн амд, бүсээр, 2010-2020 он	132
Зураг 6. 30 Нийт халдварт өвчинд бэлгийн замын халдварт өвчний эзлэх хувь, 2010-2020 он	132
Зураг 6. 31 Бэлгийн замын халдварт өвчин, төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2009-2020 он	133
Зураг 6. 32 Зоонозын халдварт өвчний тохиолдол, 10 000 хүн амд, 2010-2020 он	134
Зураг 6. 33 Зоонозын халдварт өвчний бүтэц, 2020 он	134
Зураг 7. 1 Хүн амын өвчлөлийн тохиолдол, мянган хүн	137
Зураг 7. 2 Хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, 2011-2020 он	137
Зураг 7. 3 Амьсгалын тогтолцооны өвчин, 10000 хүнд амд, байршлаар, 2011-2020 он	138
Зураг 7. 4 Амьсгалын тогтолцооны өвчин, 10000 хүнд амд, хүйсээр, 2011-2020 он	139
Зураг 7. 5 Амьсгалын тогтолцооны өвчин, улс, хот, бүсээр, 10000 хүнд ногдох, 2020 он	139
Зураг 7. 6 Амьсгалын тогтолцооны өвчин, насны бүлгээр, 10000 хүнд ногдох, 2011, 2020 он	139
Зураг 7. 7 Амьсгалын тогтолцооны өвчнүүд, 10000 хүнд ногдох, 2011-2020 он	140
Зураг 7. 8 Хоол боловсруулах тогтолцооны өвчний тохиолдлын түвшин, 10000 хүн амд, байршлаар, 2011-2020 он	141
Зураг 7. 9 Хоол боловсруулах тогтолцооны өвчний тохиолдлын түвшин, 10000 хүн амд, хүйсээр, 2011-2020 он	141
Зураг 7. 10 Хоол боловсруулах тогтолцооны өвчин, улс, хот, бүсээр, 10000 хүн амд, 2011, 2020 он	142
Зураг 7. 11 Хоол боловсруулах тогтолцооны өвчин, насны бүлгээр, 10000 хүнд ногдох, 2011, 2020 он	142
Зураг 7. 12 Зүрх, судасны тогтолцооны өвчний тохиолдлын түвшин, 10 000 хүнд амд, байршлаар, 2011-2020 он	143
Зураг 7. 13 Зүрх судасны тогтолцооны өвчний тохиолдлын түвшин, 10000 хүнд амд, хүйсээр, 2011-2020 он	144
Зураг 7. 14 Зүрх судасны өвчин, 10000 хүн амд ногдохоор, бүсээр, 2019, 2020 он	144
Зураг 7. 15 Зүрх судасны тогтолцооны өвчин, насны бүлгээр, 10000 хүнд ногдох, 2011, 2020 он	144
Зураг 7. 16 Цусны даралт ихсэх өвчин, 10 000 хүн амд, 2011-2020 он	146



Зураг 7. 17 Цусны даралт ихсэх өвчин, хүйсээр, бүсээр, 2020 он	146
Зураг 7. 18 Шээс бэлгийн тогтолцооны өвчний тохиолдлын түвшин, 10000 хүн амд, хүйсээр, 2011-2020 он	147
Зураг 7. 19 Шээс бэлгийн тогтолцооны өвчин, улс, хот, бүсээр, 10000 хүнд ногдох, 2019, 2020 он	147
Зураг 7. 20 Шээс бэлгийн тогтолцооны өвчин, насны бүлгээр, 10000 хүнд ногдох, 2011, 2020 он	148
Зураг 7. 21 Чихрийн шижин өвчин, хүйсээр, бүсээр, 10000 хүн амд, 2020 он	150
Зураг 7. 22 Хорт хавдрын өвчлөлийн бүтэц, 2020 он	152
Зураг 7. 23 Зонхилох эхний 10 байрлалын хорт хавдар, өвчлөлийн түвшин, хүйсээр, 100 000 хүн амд, 2020 он	154
Зураг 7. 24 Хүүхдийн хорт хавдрын бүтэц, хувиар, 0-19 нас	155
Зураг 7. 25 Хорт хавдрын хяналт, 2020 он	156
Зураг 7. 26 Хорт хавдрын хяналт, амьдарч буй хугацаагаар, 2020 он	156
Зураг 7. 27 Хорт хавдрын хяналтанд байгаа хүмүүсийн 5-аас дээш жил амьдарч байгаа хувь, зонхилох байрлалаар	157
Зураг 7. 28 Осол гэмтлийн шинэ тохиолдол, 10 000 хүн амд, 2016-2020 он	157
Зураг 7. 29 Осол гэмтлийн тохиолдол, улирлаар, 2020 он	159
Зураг 7. 30 Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтын хувь, 2012-2020	162
Зураг 7. 31 Кольпоскоп шинжилгээний үзүүлэлт 2012-2020	164
Зураг 7. 32 Мэс заслын хагалгааны тоо, аймгаар, 2020 он	164
Зураг 7. 33 Цочмог мухар олгойн мэс заслын хагалгаа, аймгаар, 2020 он	167
Зураг 7. 34 Цөсний замын мэс заслын хагалгаа, аймгаар, 2020 он	167
Зураг 8. 1 Хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан, 10 000 хүн амд, 1979-2000 он	169
Зураг 8. 2 Хүн амын нас баралт, 10 000 хүн амд, хүйсээр, 2019-2020 он	169
Зураг 8. 3 Насны бүлэг дэх нас баралтын коэффициент, хүйсээр, 2020 он	170
Зураг 8. 4 Нас баралтын түвшний хүйсийн харьцаа, 2020 он	170
Зураг 8. 5 Нас бүлэг дэх нас баралтын хувь, хүйсээр, 2020 он	171
Зураг 8. 4 Хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан, 10 000 хүн амд, 2009-2019 он	171
Зураг 8. 5 Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нас баралтын хувь, насны бүлгээр, 2020	172
Зураг 8. 8 Зүрх судасны тогтолцооны эмгэгийн шалтгаант нас баралт, 10 000 хүн амд, бүсээр, 2020 он	173
Зураг 8. 9 Зүрх судасны тогтолцооны эмгэгийн шалтгаант нас баралт, насны ангиллаар, хувь, 2020 он	173
Зураг 8. 10 Зүрхний шигдээсээр нас баралтын түвшин, 10000 хүнд амд, хүйсээр, 2009-2020 он	174
Зураг 8. 11 Тархинд цус харвалтын шалтгаант нас баралт, 10000 хүнд амд, хүйсээр, 2009-2020 он	174
Зураг 8. 12 Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин, 10000 хүнд амд, хүйсээр, 2009-2020 он	175
Зураг 8. 13 Элэгний хорт хавдрын шалтгаант нас баралт, 10000 хүнд амд, хүйсээр, 2009-2020 он	175
Зураг 8. 14 Хүүхдийн хорт хавдрын шалтгаант нас баралтын тохиолдол, 2010-2020 он	176
Зураг 8. 15 Лимфолейкеми, Лейкеми шалтгаант нас баралтын тохиолдол, 2010-2020 он	176
Зураг 8. 16	178
Зураг 8. 17 Зам тээврийн ослыг шалтгаант нас баралт, 2009-2020 он	178
Зураг 8. 18 Зам тээврийн ослын шалтгаант нас баралт, насны ангиллаар, 2020 он	179
Зураг 8. 19 Зам тээврийн ослын шалтгаант нас баралт, шалтгаанаар, 2009-2020 он	179
Зураг 8. 20 Амиа хорлож нас барсан тохиолдол, 10 000 хүн амд, хүйсээр	180
Зураг 8. 21 Архи, спиртэнд санамсаргүй хордож нас барсан тохиолдол, хүйсээр, 2009-2020 он	



	182
Зураг 8. 22 Нас баралтын бусад ослын шалтгаан, 2020 он	182
Зураг 8. 23 Хоол боловсруулах өвчний шалтгаант нас баралт, 2009-2020 он	183
Зураг 8. 24 Хоол боловсруулах тогтолцооны шалтгаант нас баралт, 10 000 хүн амд, хүйсээр, 2009-2020 он	183
Зураг 8. 25 Элэгний циррозын шалтгаант нас баралтын тоо, хүйсээр, 2009-2020 он	184
Зураг 8. 26 Амьсгалын тогтолцооны өвчний шалтгаант нас баралтын тохиолдол, хүйсээр	184
Зураг 8. 27 Амьсгалын тогтолцооны өвчний шалтгаант нас баралт, 10 000 хүн амд, 2009-2020 он	185
Зураг 8. 28 Уушгины хатгалгаа өвчний шалтгаант нас баралтын тохиолдол, 2009-2020 он	185
Зураг 9. 1 Нийт цус цуглуулалтын тоо, 2016-2020 он	188
Зураг 9. 2 1000 хүн амд ногдох цус цуглуулалтын тоо, 2016-2020 он	188
Зураг 9. 3 Цус цуглуулалтын тоо, аймгаар, 2020 он	189
Зураг 9. 4 Цусны донорын төрөл, 2016-2020 он	189
Зураг 9. 5 Цус сэлбэлтээр дамжих халдвар илрүүлэх шинжилгээгээр хасагдалтын хувь, 2016-2020 он	190
Зураг 9. 6 Цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 2016-2020 он	190
Зураг 9. 7 Цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлд шинэ технологийг нутагшуулах, 2020-2024 он	191
Зураг 10. 1 Амьд болон тархины үхэлтэй донороос хийгдсэн эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын тоо, 2006-2020 он	194
Зураг 10. 2 Тархины үхэл тодорхойлох багуудын илрүүлэлт, 2018-2020 он	195
Зураг 10. 3 Элэг шилжүүлэн суулгах мэс заслын хүлээх	195
Зураг 10. 4 Эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын хүлээх	196
Зураг 10. 5 Дархлаа дарангуйлах эм хэрэглэж буй хүний тоо, 2020 он	196
Зураг 10. 6 Эд, эс, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний дараа хяналтад буй хүний тоо, аймгаар, 2020	196
Зураг 10. 7 Эд, эс, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний дараа хяналтад буй хүний тоо, Нийслэлийн дүүргүүдээр, 2020	197
Зураг 11. 1 ДНБ-д эрүүл мэндийн салбарын зардлын эзлэх хувь	199
Зураг 11. 2 Эрүүл мэндийн салбарын зардал, эдийн засгийн ангиллаар (тэрбум төг)	200
Зураг 11. 3 Эрүүл мэндийн салбарын зардал, эдийн засгийн ангиллаар (хувиар)	200
Зураг 11. 4 Эрүүл мэндийн салбарын зардал, үндсэн үйл ажиллагааны чиглэлээр (хувиар)	201
Зураг 11. 5 Эрүүл мэндийн зардал, дэд бүлгээр (хувиар)	201
Зураг 11. 6 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардал, тусламж, үйлчилгээний шатлалаар (тэрбум төгрөгөөр)	202
Зураг 11. 7 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардал, тусламж, үйлчилгээний шатлалаар (хувиар)	202
Зураг 11. 8 Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төрлөөр (тэрбум төгрөгөөр)	203
Зураг 11. 9 Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төрлөөр (хувиар)	203
Зураг 11. 10 Эрүүл мэндийн салбарын зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр (хувиар)	204
Зураг 11. 11 Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зардал, (тэрбум төгрөгөөр)	204
Зураг 11. 12 Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, орлогын эх үүсвэрээр (тэрбум төгрөгөөр)	205
Зураг 11. 13 Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, орлогын эх үүсвэрээр (хувиар)	205
Зураг 11. 14 Эрүүл мэндийн даатгалын сангийн зардал (хувиар)	206
Зураг 11. 15 Эрүүл мэндийн даатгалын сангийн зардал (хувиар)	207
Зураг 12. 1 Эмийн үйлдвэр, ханган нийлүүлэх байгууллагын тоо. /2016-2020 он/	209
Зураг 12. 2 Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл, үйл ажиллагааны чиглэлээр, 2020 он	210
Зураг 12. 3 Эмийн үйлдвэр, үйл ажиллагааны чиглэлээр, 2020 он	210
Зураг 12. 4 Эм ханган нийлүүлэх байгууллага, үйл ажиллагааны чиглэлээр, 2020 он	210



Зураг 12. 5 Монгол улсын эмийн бүртгэлд шинээр бүртгэгдсэн эм, эмийн түүхий эд, 1994-2020 он	211
Зураг 12. 6 Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн эм, эмийн түүхий эдийн тоо, 2015-2020 он	211
Зураг 12. 7 Бүртгэлтэй эмийн олгох нөхцөл, хувиар, 2020 он	212
Зураг 12. 8 Монгол улсын эмийн бүртгэлд эм бүртгүүлсэн эхний 10 улс, хувиар, 2020 он	212
Зураг 12. 9 Эмийн бүртгэлд үндэсний үйлдвэрийн эмийн эзлэх хувь, 2015-2020 он	212
Зураг 12. 10 Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн эм, 2015-2020 он	213

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. 1 Хүн амын тоо, хүн ам зүйн зарим үзүүлэлтүүд, аймаг, нийслэлээр, 2020 он	26
Хүснэгт 1. 2 Хүн амын дундаж наслалт, бүс, аймгаар, 2020 он	30
Хүснэгт 2. 1 Тогтвортой хөгжлийн зорилтын гүйцэтгэлийн индексн оноо	33
Хүснэгт 2. 2 Дэлхийн болон бүсийн дундажтай харьцуулсан ТХЗ-ын эрүүл мэндийн үзүүлэлтүүд	38
Хүснэгт 3. 1 Төрөлтийн коэффициентүүд, сонгосон онуудаар	44
Хүснэгт 3. 2 Мэс заслын аргаар төрүүлсэн хувь, бүсээр 2020 он	45
Хүснэгт 3. 3 Төрөлтийн тоо, эмнэлгийн байгууллагын төрлөөр, 2020	46
Хүснэгт 3. 4 Эхийн эндэгдэл 100 000 амьд төрөлтөд, насны ангиллаар, 2020	50
Хүснэгт 3. 5 Төрсөн хүүхдийн мэдээ, бүсээр, 2020 он	52
Хүснэгт 3. 6 Амьгүй төрөлт, перинаталь эндэгдлийн түвшин, 2009-2020	53
Хүснэгт 3. 7 Үр хөндөлт байршлаар, 2020 он	55
Хүснэгт 3. 8 ЖСА хэрэглэж байгаа эмэгтэйчүүдийн тоо байршлаар, 2020 он	55
Хүснэгт 3. 9 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, өсвөр насныхны тоо, төрлөөр, 2020 он	58
Хүснэгт 3. 10 Хүүхдийн өвчлөл, 1000 хүн амд ногдохоор, 2011-2020 оны дундажаар	61
Хүснэгт 3. 11 Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөлийн шалтгаан, (хот,хөдөө) 2020 он	62
Хүснэгт 3. 12 Хүүхэд, өсвөр үеийнхний өвчлөлийн тэргүүлэх шалтгаан, насны бүлгээр, тухайн насны 10 000 хүүхдэд, 2020 он	62
Хүснэгт 3. 13 Амьгүй төрөлт, перинаталь болон нярайн эндэгдлийн түвшин, 2010-2020 он	65
Хүснэгт 3. 14 Эрт нярайн эндэгдлийн тэргүүлэх 5 шалтгаан, 2010-2020 он	67
Хүснэгт 3. 15 Хожуу нярайн эндэгдлийн тэргүүлэх 5 шалтгаан, 2010-2020 он	67
Хүснэгт 4. 1 Эрүүл мэндийн байгууллагын тоо, 2020 он	78
Хүснэгт 4. 2 Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлтүүд	95
Хүснэгт 4. 3 Хувийн эмнэлгийн орны хүчин чадлын үзүүлэлт, сонгосон оноор	98
Хүснэгт 5. 1 Эрүүл мэндийн байгууллагын ажиллагчдын тоо, 1990-2020 он, сонгосон онуудаар	104
Хүснэгт 5. 2 Их эмч, сувилагчийн харьцаа, бүсээр, 2016-2020 он	111
Хүснэгт 5. 3 Нэг их эмчид ногдох хүний тоо, байршлаар, 2016-2020 он	112
Хүснэгт 5. 4 Эм зүйчийн тоо, байршлаар, сонгосон онуудаар	113
Хүснэгт 6. 1 Амьсгалын замын халдварт өвчнүүдийн тоо, 2010-2020 он	122
Хүснэгт 6. 2 Гэдэсний халдварт өвчнүүдийн тохиолдлын тоо, 10 000 хүн амд	128
Хүснэгт 7. 1 Хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, байршлаар, дүнд эзлэх хувиар, 2011-2020 он	138
Хүснэгт 7. 2 Амьсгалын тогтолцооны өвчний тэргүүлэх шалтгаан, хүйсээр, 2011, 2020 он	140
Хүснэгт 7. 3 Хоол боловсруулах тогтолцооны өвчнүүд, дүнд эзлэх хувиар, 2010, 2020 он	143
Хүснэгт 7. 4 Зүрх судасны тогтолцооны өвчнүүд, дүнд эзлэх хувиар, 2011, 2020 он	145
Хүснэгт 7. 5 Шээс бэлгийн тогтолцооны өвчнүүд, дүнд эзлэх хувиар, 2011, 2020 он	148
Хүснэгт 7. 6 Хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, нас, хүйсээр, 2020 он, 10 000 хүн амд	151
Хүснэгт 7. 7 Зонхилох арван байрлалын хорт хавдрын өвчлөл, хүйсээр 2020 он	151
Хүснэгт 7. 8 Хорт хавдрын шинэ өвчлөл, эзлэх хувь, ӨТ, ӨСТ 2020 он	152



Хүснэгт 7. 9 Хорт хавдрын шинэ өвчлөл, бодит тоо, 100 000 хүн амд, 2020 он	154
Хүснэгт 7. 10 Хорт хавдрын оношлогдох үеийн үе шат (TNM ангилал), 2020 он, хувиар	155
Хүснэгт 7. 11 Осол гэмтлийн шинэ тохиолдлын шалтгаан, хувиар, 2016-2020 он	158
Хүснэгт 7. 12 Осол гэмтэл бүртгэгдсэн байдал аймгаар, тохиолдлын тоо, 2016-2020 он	159
Хүснэгт 7. 13 Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, 10000 хүн амд, 2011-2020 он	160
Хүснэгт 7. 14 Хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, 2020 он	160
Хүснэгт 7. 15 Зонхилон тохиолдох хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн бүтэц, хувиар	161
Хүснэгт 7. 17 Эрт илрүүлэг үзлэгээр илэрсэн умайн хүзүүний хавдрын үе шат /2012-2020/	163
Хүснэгт 7. 18 Умайн хүзүү, хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтын хувь, 2020 он	163
Хүснэгт 7. 19 Улаанбаатар хотын эмнэлгүүдэд хийгдсэн мэс заслын тоо, 2020 он	165
Хүснэгт 7. 20 Зонхилон хийгдсэн мэс засал, төрлөөр, 2020 он	165
Хүснэгт 8. 1 Хүн амын нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан 10 000 хүн амд, 2020 он	172
Хүснэгт 8. 2 Хүн амын нас баралтын хэлбэр, 2005, 2010, 2015, 2020 он	177
Хүснэгт 8. 3 Амиа хорлолт, хэлбэрээр, 2010, 2015-2020 он	180
Хүснэгт 10. 2 Шилжүүлэн суулгасан бөөр, элэгний мэс засал, 1996, 2006-2020 он	194
Хүснэгт 10. 3 Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах чиглэлээр сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтний тоо, 2018-2020 он	197
Хүснэгт 12. 2 Эм хангамжийн байгууллагын тоо, 2020 он	209

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ДОХ	Дархлалын олдмол хомсдол
ХДХВ	Хүний дархлал, хомсдлын вирус
БЗДХ	Бэлгийн замаар дамжих халдвар
ӨОУА	Өвчний олон улсын ангилал
ҮОУА	Үйлдлийн олон улсын ангилал
ДОТС	Богино хугацааны шууд хяналттай эмчилгээ
МХЗ	Мянганы хөгжлийн зорилт
НҮЭМ	Нөхөн үржихүйн эрүүл мэнд
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМХТ	Эрүүл мэндийн хөгжлийн төв
СЭМТ	Сумын эрүүл мэндийн төв
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
БЦЖ	Сүрьеэгийн эсрэг вакцин
ЗХУ	Зөвлөлт холбоот улс
ТЕК	Төрөлтийн ерөнхий коэффициент
НБТК	Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент
ТНК	Төрөлтийн нийлбэр коэффициент
ТТК	Төрөлтийн тусгай коэффициент
НБЕК	Нас баралтын ерөнхий коэффициент
ХБӨ	Халдварт бус өвчин
БОЭТ	Бүсийн оношлогоо эмчилгээний төв
СХ	Стандарт хазайлт



## ӨМНӨХ ҮГ

Эрүүл мэндийн хөгжлийн төв нь Монгол Улсын хэмжээнд өмчийн бүх хэлбэрийн байгууллагын хүний нөөц, хүчин чадал, үйл ажиллагааны тайланг нэгтгэж, жил болгон шийдвэр гаргагчид, бодлого боловсруулагчид, судлаач, эрдэмтэн, профессор, эмч, мэргэжилтнүүд, мэдээлэл хэрэглэгчдийг албан ёсны тоон мэдээллээр хангадаг билээ.

2020 онд Эрүүл мэндийн салбар үүсч хөгжсөний 100 жилийн ой тохиож байгаа бөгөөд тухайн жилийн эмхэтгэлд зарим боломжит үзүүлэлтүүдийг эрүүл мэндийн салбарын тоон мэдээллийг бүртгэж эхэлсэн үеэс харьцуулан тооцоолж оруулснаараа онцлог болсон.

Мөн дэлхий нийтээр Коронавируст халдвар COVID-19-ийн цар тахлын хүнд нөхцөл байдалд байгаа өнөө үед Монгол улсад ч мөн адил халдвар тархаж, цар тахлын хүнд цаг үед хүн амын эрүүл мэнд болон үзүүлж буй нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээнд хэрхэн өөрчлөлт орж буйг тооцоолж харуулахыг зорьсон.

Тус төвөөс нэгтгэн гаргадаг мэдээллийг үндэслэн Эрүүл мэндийн салбарын бодлогын судалгаа, шинжилгээ, нийгэм, эдийн засгийн тооцоолол, төсөв хийгддэг ба урт болон богино хугацааны хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх, дотоодын хяналт, шинжилгээ үнэлгээ, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг төлөвлөх, сайжруулах, бодлого боловсруулах зэрэгт өргөнөөр ашиглаж байна.

Тиймээс бид мэдээлэл хэрэглэгчдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нэгжийн түвшинд гаргах, түгээх мэдээллээ өргөжүүлэхийг эрмэлзэж буй бөгөөд энэхүү эмхэтгэлд тусгагдсан мэдээллүүдийг цаашид дэлгэрүүлэн, задаргаа байдлаар авахыг хүсвэл бид хамтран ажиллахад бэлэн байдаг.

Энэхүү эмхэтгэлийг хэвлэн нийтлүүлэх ажилд санхүүгийн дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгчийн газарт талархал илэрхийлье.

Эрүүл мэндийн салбарын албан ёсны статистик мэдээлэл болох сар, улирал, жилийн эмхэтгэл болон эрүүл мэндийн статистикийн мэдээллүүдэд та бүхэн өөрийн санал хүсэлтээ илгээвэл хамтран ажиллахад таатай байх ба Эрүүл мэндийн салбарын бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид болон мэдээлэл хэрэглэгч нийт хүмүүст нотолгоонд тулгуурласан оновчтой шийдвэр гаргахад бидний энэхүү эмхэтгэл дэмжлэг үзүүлнэ гэдэгт гүнээ итгэлтэй байна.

### ХҮНДЭТГЭСЭН:

ЗАХИРАЛ

Б.НАРАНТУЯА

## ХУРААНГУЙ

2020 оны “Эрүүл мэндийн үзүүлэлт” нь нийт 16 бүлэг, 65 дэд бүлгээс бүрдэж байгаа ба эрүүл мэндийн үзүүлэлтүүдийг боломжит албан ёсны статистик бүртгэгдсэн оноос эхлэн харьцуулан гаргасан.

Монгол улсын хүн ам 1921 онд 649.9 мянга байсан бол 1962 онд 1 сая хүн амтай болсон. 1988 онд 2 сая дахь иргэнээ өлгийдөн авсан бол 2015 онд 3 сая болсон байна. 2020 онд 3 сая 357.5 мянга болж, сүүлийн 60 жилийн хугацаанд 2.3 саяар нэмэгдсэн байна. 2020 оны байдлаар нийт хүн амын 31.9 хувийг 15 хүртэлх насны хүүхэд, 63.8 хувийг 15-64 насны хүн ам, 4.3 хувийг 65 аас дээш насныхан эзэлж байна.

Манай улс хүн амын нягтралаараа дэлхийн бусад улс оронтой харьцуулахад хамгийн сийрэг суурьшилтай орнуудын тоонд ордог бөгөөд 2020 онд нэг хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт 2.1 хүн ногдож байгаа нь 1963 онтой харьцуулахад 1.4 хүнээр нэмэгдсэн байна.

Монгол улсын хүн ам сүүлийн 60 жилд 2.3 сая хүнээр өссөний дотор 1969 оноос хойш хүн амын эрчимтэй өсөлт явагдсан. 2020 онд 1000 хүн амд ногдох төрөлтийн түвшин 23.4 байна. 2020 онд нийт 75694 эх амаржиж, 76261 нярай амьд төрж, 413 нярай амьгүй төрсөн байна. Амаржсан эхийн тоо өмнөх онтой харьцуулахад 1907 тохиолдлоор буурсан байна. Төрөх үеийн хүйсийн харьцаа 2020 онд 100 охинд ойролцоогоор 105 хөвгүүн ногдож байна. Амьд төрсөн хүүхдийн 1847 нь хоёр ихэр, 57 нь гурван ихэр байна. 2020 онд өсвөр насны охидын төрөлтийн түвшин тухайн насны 1000 эмэгтэйд харьцуулахад 27.8 байгаа нь 2010 онтой харьцуулахад 1.0-оор нэмэгдсэн хэдий ч сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 5.3-оор буурсан байна.

Төрөлтөөс тооцсон дундаж наслалт 2020 онд улсын хэмжээнд 70.7 болж өмнөх оноос 0.3 пунктээр өссөн бөгөөд эмэгтэйчүүдийн дундаж наслалт 76.2, эрэгтэйчүүдийнх 66.7 жил болсон байна. Монгол хүний эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү 1965 онд 2.3 байсан бол 2020 онд 9.5 жил болж 55 жилийн хугацаанд 7.2 жилээр нэмэгдсэн байна.

Монгол улсад 1971 онд эхийн эндэгдлийн 116 тохиолдол буюу 100 000 амьд төрөлтөд 235 байсан бол 1993 онд 243 болж өссөн үзүүлэлттэй байв. 2000 оноос хойш эхийн эндэгдлийн тохиолдол тууштай буурсаар 2020 оны байдлаар эхийн эндэгдлийн 23 тохиолдол бүртгэгдэж 100 000 амьд төрөлтөд 30.2 байна.

Улсын хэмжээнд 1965 онд 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин 70.3 байсан бол 1980 онд 78.8 болж өссөн. 1980 оноос хойш нялхсын эндэгдлийн түвшин тууштай буурч 1990 онд 64.4 болсон ба 2000 онд 32 болж 2 дахин буурсан байна. 1990 оноос хойш нялхсын эндэгдлийн түвшин тууштай буурч байгаа ба 2020 оны байдлаар 11.5 болсон байна.

2020 оны байдлаар Монгол улсын хэмжээнд нийт 4 575 эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа ба төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг 12, тусгай мэргэжлийн төв 14, бүсийн оношилгоо эмчилгээний төв 5, аймгийн нэгдсэн эмнэлэг 16, дүүргийн нэгдсэн эмнэлэг 4, нийгмийн эрүүл мэндийн төв 9, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг 6, сумын эрүүл мэндийн төв 322, өрхийн эрүүл мэндийн төв 209, хувийн ортой эмнэлэг 241, хувийн клиник 1491 ажиллаж эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.

2020 онд улсын хэмжээнд 27 083 эмнэлгийн ор ажилласан бөгөөд 73.1 хувь нь төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагуудад, 26.9 хувь нь хувийн хэвшлийн эмнэлгийн ор байна. 2010-2020 оны хооронд манай улсын эмнэлгийн орны тоо 51.9 хувиар, 10 000 хүн амд ногдох ор 16.5-оор нэмэгдсэн байна.

2020 оны байдлаар эрүүл мэндийн салбарт нийт 56.5 мянган ажиллагчид Монгол улсад оршин суугаа 3.253.3 мянган хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж байна. 2000 онтой харьцуулахад нийт ажиллагчдын тоо 24.9 мянгаар буюу 10 000 хүн амд 40.8-оор, өмнөх онтой харьцуулахад 3.8-аар нэмэгдсэн байна. Нийт ажиллагчидаас 92.4 хувь нь эрүүл мэндийн





салбарын, 7.6 хувь нь бусад салбарын эрүүл мэндийн ажиллагчид эзэлж байна. Эрүүл мэндийн ажиллагчдын 22 хувийг их эмч, 23.2 хувийг сувилагч, 4.7 хувийг эмч зүйч, 3.3 хувийг бага эмч, 2.3 хувийг удирдах ажилтан, 2.3 лабораторийн техникч эзэлж байна.

Эмч, сувилагчийн харьцаа улсын түвшинд 1:1.1, Улаанбаатар хотод 1:0.9, аймгийн түвшинд 1:1.4 байна. Нэг их эмчид ногдох хүний тоо 2020 онд 259 байгаа нь өмнөх оныхоос 11 хүнээр, нэг сувилагчид ногдох хүний тоо 246 болж, өмнөх оныхоос 4 хүнээр тус тус буурсан байна

Сүүлийн 10 жилийн дунджаар улсын хэмжээнд нийт 32 төрлийн 45102 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүн амд харьцуулахад 10 жилийн дунджаар 155.0 байна. Улсын хэмжээнд 2020 онд 31 төрлийн халдварт өвчин бүртгэгдэж, халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 33.4 мянгад хүрчээ.

2020 оны байдлаар 10000 хүн амд амьсгалын тогтолцооны өвчин 1414, хоол боловсруулах тогтолцооны өвчин 1833, зүрх-судасны тогтолцооны өвчин 1268, шээс бэлгийн тогтолцооны өвчин 1084, гэмтэл, хордлого ба бусад гадны шалтгаант өвчин 598 ногдож байгаа бөгөөд 2019 онтой харьцуулахад өвчлөлийн тэргүүлэх шалтгаанууд 12-685-аар буурсан үзүүлэлттэй байна. Монгол улсад 2020 оны жилийн эцсийн тайлангаар 23278 хүн хорт хавдрын улмаас хяналтад байгаагийн 36.0(8452) хувийг эрэгтэй, 63.6(14826) хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. 2020 онд Монгол улсын хэмжээнд 145 497 осол гэмтлийн шинэ тохиолдол бүртгэгдсэн нь 10 000 хүн ам тутамд 441.3 ногдож байгаа ба өмнөх оноос 42.6 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна.

Монгол Улсад сүүлийн 10 жилийн дунджаар 16.5 мянган нас баралтын тохиолдол бүртгэгдсэнээс 61 хувь нь эрэгтэйчүүд, 39 хувь нь эмэгтэйчүүд байгаа бөгөөд шалтгаанаар авч үзвэл зүрх судасны тогтолцооны өвчин (34.2%), хавдар (24.3%), осол гэмтэл, гадны шалтгаан (16.9%) зонхилж байна. Нас баралтад эрэгтэйчүүдийн эзлэх хувь өссөөр байна. Хүн амын нас баралт 2020 онд 15.9 мянга болж, сүүлийн 10 жилийн дунджаас 634 хүн (3.8%)-ээр нэмэгдэж, өмнөх оноос 1283 (7.5%) хүнээр буурсан байна. 10 000 хүн амд ногдох нас баралт 2020 онд 49.4 байгаа ба 10 000 эрэгтэй хүн амд 59.4, эмэгтэй хүн амд 39.1 байна.

Эд, эс, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааны мэдээллийг энэ жилээс эмхтгэлд оруулж байгаа бөгөөд 2020 оны жилийн эцсийн байдлаар бөөр шилжүүлэн суулгах мэс засал 230, элэг шилжүүлэн суулгах мэс засал 112, ясны чөмөг үүдэл эс 22, нүдний эвэрлэг 24, арьс шилжүүлэн суулгах мэс засал 735, шөрмөс шилжүүлэн суулгах мэс засал нийт 22 эмчилгээг тус тус амжилттай хийгээд байна.

Эрүүл мэндийн сайдын багцын зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2017 онд 2.5 байсан бол 2018-2019 онуудад тогтмол 2.2 хувь болж 0.3 функтээр буурч, 2020 онд 0.5 функтээр өссөн байна. Эрүүл мэндийн салбарын зардлыг 2020 оны байдлаар эдийн засгийн ангилалаар авч үзвэл 31.5 хувийг ажиллагсдын цалин, хөлстэй холбоотой зардал, 14.9 хувийг эм, эмнэлгийн хэрэгсэлийн зардал, 1.3 хувийг хоолны зардал, 3.1 хувийг ашиглалтын зардал, 11 хувийг хөрөнгө оруулалтын зардал, 16.2 хувийг анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын зардал буюу засгийн газрын дотоод шилжүүлгийн зардал, 22.1 хувийг бусад зардал эзэлж байна. Эрүүл мэндийн салбарын нийт зардлыг эдийн засгийн ангилалаар нь авч үзвэл дийлэнх хувийг цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал эзэлж байна.





БҮЛЭГ

1

МОНГОЛ  
УЛСЫН  
ХҮН АМ



# БҮЛЭГ 1.

## МОНГОЛ УЛСЫН ХҮН АМ

Монгол улсын хүн ам 1921 онд 649.9 мянга байсан бол 1962 онд 1 сая хүн амтай болсон. 1988 онд 2 сая дахь иргэнээ өлгийдөн авсан бол 2015 онд 3 сая болсон байна.


Монгол улсын хүн ам 2020 онд 3 сая 357.5 мянга болж, сүүлийн 60 жилийн хугацаанд 2.3 саяар нэмэгдсэн бөгөөд 1969 оноос хойш хүн амын эрчимтэй өсөлт явагдсан нь хүн амын эрүүл мэндэд анхаарч эрүүлжсэнтэй холбон авч үздэг.

Монгол улс ЗХУ-ын шууд оролцоо дэмжлэгтэйгээр хүн амынхаа эрүүлийг хамгаалах социалист хэв шинжийн тогтолцоог бий болгоод 70 гаруй жил хөгжүүлж ирсний үр дүнд Монголын хүн ам эрүүлжиж чадсан түүхтэй. Монгол улс тусгаар тогтнолоо олсноос хойш хүн амынхаа асуудалд онцгой анхаарч хүн амаа 9 удаа албан ёсоор тоолсноос 1956 оноос эхлэн хүн амын тооллогыг олон улсын туршлага аргачлалын дагуу явуулж хүн амын тооллогонд тооцоолон бодох техник технологи ашиглаж түүний үндсэн дээр хүн амаа хөгжүүлэх бодлого боловсруулан мөрдөж ирсэн байна. 1950 оноос эхлэн хүн амын төрөлт, нас баралт, гэр бүл бололтыг албан ёсоор бүртгэж мэдээллийн тогтолцоо буй болгосон.

Хүн амаа өсгөх бодлогын нэн тэргүүнд хүн амын төрөлтийг дэмжиж олон хүүхэд төрүүлсэн эхчүүдийг дэмжсэн хууль тогтоомжуудыг гаргаж мөрдүүлсэн, гэр бүлийг бэхжүүлэх хүн амыг эрүүлжүүлэх бодлого барьж насанд хүрсэн хүн амаа 1950-аад онуудад сүрьеэ, арьс өнгөний өвчнийг илрүүлэх үзлэгт хамруулж өвчтэй хүмүүсийг эмчлэх эрүүлжүүлэх эмнэлэг диспансеруудыг олноор байгуулж эдгээр өвчнийг устгах боломжийг бүрдүүлж чадсан байна.

1990 оноос эхлэн Монгол оронд өрнөсөн улс төр нийгэм эдийн засгийн их өөрчлөн байгуулалтын эхний үеэс эхлэн Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол улсын төрөөс баримтлах хүн амын бодлого болон хүн амын эрүүл мэндтэй холбоотой хууль тогтоомжууд хэрэгжиж, хүн амын эрүүл мэндийг дэмжих, эрүүлжүүлэх бодлогууд хэрэгжиж байна.

Зураг 1. 1 Хүн амын тоо, жилийн дундаж өсөлтийн хувь, 2009-2020 он



Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- [www.1212.mn](http://www.1212.mn)


Хүн амын өсөлтийн хувь 1927, 1960, 1975 онуудад хамгийн өндөр байсан ба сүүлийн жилүүдэд 2008 оноос хойш жигд өсөх хандлагатай байна. (Зураг 1.1)

## 1.1 ХҮН АМЫН НАС ХҮЙСИЙН БҮТЭЦ

Нас, хүйсийн бүтэц нь хүн ам зүйн хамгийн чухал үзүүлэлтүүдийн нэг юм. Улс орнуудын хүн амын нас, хүйсийн бүтэц өөр хоорондоо харилцан адилгүй байдаг ба нийгэм, эдийн засгийн өнөөгийн болон ирээдүйн асуудалд ихээхэн хэмжээний нөлөө үзүүлдэг.

Хүн амын насны бүтцийг судлах нь тухайн улсын хүн ам зүйн түүхэн замналыг харах, одоогийн үйл явцыг үнэлж дүгнэх, цаашдын чиг хандлагыг тодорхойлох бололцоо олгодгоороо ихээхэн ач холбогдолтой юм. Ингэснээрээ хүн амын нас, хүйсийн бүтцийн өөрчлөлтийн чиг хандлагыг харгалзан улс орныхоо нийгэм, эдийн засгийн урт, богино хугацааны бодлого хөтөлбөр боловсруулах үндэслэл болдог. Хүн амын төрөлт, нас баралтын түвшнээс хамааран тухайн улсын хүн амын насны бүтэц өөрчлөгдөж байдаг. Хүн амын хэдэн хувь нь хүүхэд залуучууд, идэр насныхан, эсвэл хөгшчүүд байгаагаас хамааран үе үеийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн хандлагад нөлөөлдөг.

Зураг 1. 2 Хүн амын нас хүйсийн суварга, 2000, 2020 он



Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан [www.1212.mn](http://www.1212.mn)


2020 оны хүн амын нас, хүйсийн суваргаас харахад, дунд хэсгээрээ аажмаар өргөсч байгаа нь хүн амын насны бүтэц идэрших хандлагатай байгааг харуулж байна. Харин 15-24 насны бүлгийн хүн амын хэсгээр нарийссан байгаа нь 1990 оноос хойш төрөлтийн түвшин эрс буурч байсныг харуулж байна. Дээрх суваргад хөдөлмөрийн насны хүн ам буюу 25-34 насны бүлгийн хүн ам харьцангуй их харагдаж байна.

Хүн амын дунд хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь нэмэгдэж байгааг (Зураг 1.2) харж болно. Нийт хүн амд хөдөлмөрийн насныхны эзлэх хувь өндөр байх үеийг “Хүн ам зүйн цонх” гэдэг. Энэ үед улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд хүн ам зүйн хүчин зүйл эерэгээр нөлөөлдөг.

2020 оны байдлаар нийт хүн амын 31.9 хувийг 15 хүртэлх насны хүүхэд, 63.8 хувийг 15-64 насны хүн ам, 4.3 хувийг 65 аас дээш насныхан эзэлж байна. 1960 аад оны дунд, сүүл үед 15 хүртэлх насны хүүхэд хүн амын бараг тэн хагасыг эзэлж байсан бөгөөд 1969 онд нийт хүн амын 44.5 хувийг 15 хүртэлх насны хүүхдүүд эзэлж байсан байна.



Зураг 1.3 Хүн амын насны бүтэц, сонгосон оноор




Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- [www.1212.mn](http://www.1212.mn)

## 1.2 ХҮН АМ ЗҮЙН АЧААЛАЛ

Манай улсын хүн амын төрөлтийн түвшин 1970-1989 онд өндөр байснаас шалтгаалан хүн ам зүйн ачаалал өндөр байжээ. Тэгвэл 2020 онд хөдөлмөрийн насны хүн ам ихэнх хувийг эзэлж байгаа учир хүн ам зүйн ачаалал буурсан байна. Амьдралд энэ үзүүлэлт тооцооноос нэлээд илүү байдаг. Тухайлбал, хөдөлмөрийн насанд байгаа үедээ 15-24 насныхан ихэнх нь боловсролоо ахиулах, мэргэжил эзэмшихээр суралцдаг учраас тэжээлгэгч байдаг. Мөн хөдөлмөрийн насанд байгаа боловч тухайн үед ажил эрхлээгүй жирэмсэн, бага насны хүүхэд болон өндөр настанг асран хамгаалагч, хөгжлийн бэрхшээлтэй, ажиллах чадваргүй эсвэл ажилгүйчүүд гэх мэт тэжээлгэгчдийн тоо өсдөг. Монгол Улсын хүн ам зүйн ачаалал 1990-ээд оны эхээр хөдөлмөрийн насны 100 хүнд тэжээлгэгч 85 ногдож байсан бол 2000 оноос буурах хандлагатай харагдаж байна. (Зураг 1.3)

Зураг 1.4 Хүн ам зүйн ачаалал, сонгосон оноор



Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- [www.1212.mn](http://www.1212.mn)

Монгол Улсын хүн ам зүйн ачаалал 2020 онд хөдөлмөрийн насны 100 хүнд тэжээлгэгч 59 хүн ногдож байна. Хөгшрөлтийн индекс буюу 0-15 насны 100 хүүхдэд ногдох 65 ба түүнээс дээш настай хүний тоо 7.7 байна.

Хүн амын хүйсийн харьцаа Төв (105.3), Булган (102.9), Сэлэнгэ (103.0), Хэнтий (102.1), Сүхбаатар (100.9), Увс (100.9), Дундговь (101.0), Өмнөговь (100.3), Дорноговь (100.1), Архангай (100.6) аймагт 100 эмэгтэйд 100-аас дээш эрэгтэй ногдож байгаа бол Улаанбаатар хот (92.8), Дорнод

(99.7), Орхон (96.4), Дархан-Уул (96.6) аймгууд болон бусад аймгуудад 100 эмэгтэйд 100-гаас цөөн эрэгтэй ногдож байна.

*Хүснэгт 1. 1 Хүн амын тоо, хүн ам зүйн зарим үзүүлэлтүүд, аймаг, нийслэлээр, 2020 он*

Аймаг, нийслэл	Хүн амын тоо	Хүн ам зүйн ачаалал	Үүнээс:		Хөгшрөлтийн индекс	Хүйсийн харьцаа
			Хүүхэд	Хөгшид		
Улсын дүн	3 357 542	55.3	48.9	6.4	7.7	96.6
Баруун бүс	415 091	57.8	51.9	5.9	8.8	99.9
Баян-Өлгий	110 597	60.9	55.7	5.3	10.6	99.7
Говь-Алтай	57 674	52.6	46.5	6.1	7.6	99.3
Завхан	72 763	54.2	47.3	7.0	6.8	99.7
Увс	83 524	59.2	53.6	5.5	9.7	100.9
Ховд	90 533	59.2	53.4	5.8	9.2	99.9
Хангайн бүс	604 200	54.3	47.8	6.6	7.3	98.8
Архангай	94 088	54.8	48.0	6.8	7.0	100.6
Баянхонгор	88 955	56.1	50.0	6.1	8.2	96.7
Булган	61 955	52.3	44.6	7.7	5.8	102.9
Орхон	107 765	51.8	45.8	6.0	7.6	96.4
Өвөрхангай	115 732	55.2	48.1	7.0	6.9	99.3
Хөвсгөл	135 705	55.1	48.8	6.3	7.8	98.3
Төвийн бүс	515 880	54.5	47.7	6.7	7.1	101.0
Говьсүмбэр	17 965	60.0	54.2	5.8	9.3	101.4
Дархан-Уул	106 909	53.8	46.9	6.9	6.8	96.6
Дорноговь	71 207	54.5	48.9	5.6	8.8	100.1
Дундговь	46 981	54.7	46.6	8.1	5.7	101.0
Өмнөговь	70 371	56.3	50.4	5.9	8.5	100.3
Сэлэнгэ	109 285	52.1	45.6	6.5	7.0	103.0
Төв	93 162	55.5	47.6	7.9	6.0	105.3
Зүүн бүс	225 081	55.8	49.3	6.5	7.6	100.9
Дорнод	83 087	57.4	51.0	6.4	8.0	99.7
Сүхбаатар	63 822	54.6	48.5	6.1	7.9	100.9
Хэнтий	78 172	55.1	48.2	6.9	7.0	102.1
Улаанбаатар	1 597 290	55.2	48.9	6.3	7.7	92.8

Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- [www.1212.mn](http://www.1212.mn)

### 1.3 ХҮН АМЫН НЯГТРАЛ


Манай улс хүн амын нягтралаараа дэлхийн бусад улс оронтой харьцуулахад хамгийн сийрэг суурьшилтай орнуудын тоонд ордог бөгөөд 2020 онд нэг хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт 2.1 хүн ногдож байгаа нь 1963 онтой харьцуулахад 1.4 хүнээр нэмэгдсэн байна.

Монгол улсын хэмжээнд нэг хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт ногдох хүн ам буюу хүн амын нягтрал хамгийн өндөр нь Улаанбаатар, Орхон аймгууд байгаа бөгөөд 2020 онд



Улаанбаатар хотод 339.8 байгаа нь 1963 онтой харьцуулахад 7 дахин буюу 292 хүнээр нэмэгдсэн байна. Орхон аймагт хүн амын нягтрал 1979 онд 39.9 байсан бол 2020 оны байдлаар 134.7 болж 40 жилийн хугацаанд 95 хүнээр нэмэгдсэн байна.

**Зураг 1.5 Хүн амын нягтрал, аймаг, нийслэлээр, 2020 он**




Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- [www.1212.mn](http://www.1212.mn)

Аймаг, нийслэлээр авч үзвэл Улаанбаатар хот нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн дөнгөж 0.3 хувийг эзэлдэг бол хүн амын нягтралаар хамгийн өндөр 339.8 байна. Аймагуудын хүн амын нягтрал газар нутгийн хэмжээ, хүн амын тооноос шалтгаалан харилцан адилгүй, тухайлбал Орхон, Дархан-Уул аймаг нь бусад аймгуудаас өндөр 32.4-134.7, Говь-Алтай, Өмнөговь, Дорноговь, Дундговь, Дорнод, Баянхонгор, Сүхбаатар, Завхан аймгуудад хамгийн бага 0.4-0.9 буюу нэг хүрэхгүй хүн ногдож байна. Бусад аймагт 1.2-3.3 байна. Энэ нь мөн л хүн амын дотоод шилжих хөдөлгөөний урсгал төврүү чиглэсэн байгааг илэрхийлж байна.

## 1.4 ХҮН АМЫН ТӨРӨЛТ

Монгол улсын хүн ам сүүлийн 60 жилд 2.3 сая хүнээр өссөний дотор 1969 оноос хойш хүн амын эрчимтэй өсөлт явагдсан. Хүн амын төрөлт 1960 онд хамгийн өндөр түвшин 1000 хүн амд 43.2 хүрч байснаа аажмаар багсаж 1980 онд 39.2 болсон. 1985 оноос төрөлтийн түвшин байнгийн буурсаар 2005 онд хамгийн бага буюу 17.8 болсон бөгөөд 2009 оноос өсч 2014 онд хамгийн өндөр төрөлттэй буюу 1000 хүн амд ногдох төрөлтийн түвшин 28.0 болсон. 2020 онд 1000 хүн амд ногдох төрөлтийн түвшин 23.4 байна.

**Зураг 1.6 Хүн амын төрөлтийн түвшин, 1000 хүн амд, сонгосон онуудаар**




Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- [www.1212.mn](http://www.1212.mn)

Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент буюу 15-49 насны 1000 эмэгтэйд ногдох төрөлт (ТТК) 1980 онд 180 байсан бол 2005 онд хамгийн бага түвшинд хүрч 63.0 болсон. ТТК 2020 онд 89.7 байгаа нь 2010 онтой харьцуулахад 13.7-оор нэмэгдсэн байна.


Манай улсын хүн амын төрөх үеийн хүйсийн харьцаа 2020 онд 100 охинд ойролцоогоор 105 хөвгүүн ногдож байна. Төрөх үеийн хүйсийн харьцааг аймгаар харвал Булган аймагт хамгийн их зөрүүтэй 100 охинд 119 хөвгүүн ногдож байгаа бол Дорнод аймагт 100 охинд 100 хөвгүүн ногджээ.

Зураг 1. 7 Төрөх үеийн хүйсийн харьцаа, 2010-2020 он



Монгол Улсын нийт төрөлтийн 56.7 хувийг Улаанбаатар хотын төрөлт эзэлж, төрөлтийн түвшин улсын дунджаас 4.0-өөр их байна. Төрөлтийн түвшинг бүс нутгаар харвал Баруун бүсийн төрөлт бусад бүсүүдээс өндөр 24.5 байгаа ч улсын дунджаас 0.3-аар бага, төвийн бүсийн төрөлт хамгийн бага 19.0 болж, улсын дунджаас 5.8-аар бага байна.

Зураг 1. 8 Амьд төрсөн хүүхдийн тоо, хүйсээр, 2010-2020 он



## 1.5. ХҮН АМЫН ДУНДАЖ НАСЛАЛТ

Хүний амьдрах хугацааг тодорхойлох гол хэмжүүр нь “ДУНДАЖ НАСЛАЛТ” юм. Төрөлтөөс тооцсон дундаж наслалт 2020 онд улсын хэмжээнд 70.7 болж өмнөх оноос 0.3 пунктээр өссөн бөгөөд эмэгтэйчүүдийн дундаж наслалт 76.2, эрэгтэйчүүдийнх 66.7 жил болсон байна.


Дундаж наслалт нь таамаглах хэмжигдэхүүн бөгөөд насны бүлэг дэх нас баралтын коэффициентийг үндэслэн тооцсон тухайн хүний цаашид амьдрах дундаж хугацаагаар тодорхойлогддог. Тухайн улсын хүн амын дундаж наслалтыг төрөлтөөс тооцсон дундаж наслалтаар тодорхойлдог. Дундаж





наслалт нь хүйс, одоогийн нас, амьдралын хэв маяг зэргээс шалтгаалан ялгаатай байдаг. Монгол хүний дундаж наслалт 1965 онд 65.5 байсан бол 2020 онд 70.7 болж сүүлийн 50 жилийн хугацаанд 5 жилээр нэмэгдсэн байна.


**Зураг 1.9 Хүн амын дундаж наслалт, сонгосон онуудаар**



Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- [www.1212.mn](http://www.1212.mn)

Хүн амын төрөлтөөс тооцсон дундаж наслалтыг аймгуудаар авч үзвэл Дундговь аймаг улсын дунджаас харьцангуй өндөр буюу 3.7 жилээр их, Хөвсгөл аймаг харьцангуй бага буюу 3.5 жилээр бага байна. Ерөнхийдөө улсын дунджаас доогуур 4 аймаг байна. Дундаж наслалт аймгийн түвшинд ялгаатай байгаа нь тухайн аймгийн хүн амын нас баралтын түвшин, тэр дундаа нялхсын нас баралттай холбоотой юм.

**Зураг 1.10 Хүн амын дундаж наслалт, аймаг, нийслэлээр, 2020 он**




Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- [www.1212.mn](http://www.1212.mn)

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү 2016 оны байдлаар дэлхийн дундаж 4.4 байхад манай улс дэлхийн дунджаас 2 дахин өндөр байгаа нь зөрүү хамгийн их орнуудын тоонд орж байна.

Монгол хүний эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү 1965 онд 2.3 байсан бол 2020 онд 9.5 жил болж 55 жилийн хугацаанд 7.2 жилээр нэмэгдсэн байна. Аймаг, нийслэлээр, 2020 оны байдлаар харахад Орхон аймагт хамгийн их 11.7 байгаа нь улсын дунджаас 2-оор их, Сэлэнгэ, Дорноговь, Дархан-Уул, Сүхбаатар аймагт улсын дунджаас 0.5-1.1-ээр их, хамгийн бага нь Говьсүмбэр аймагт 3.7 буюу улсын дунджаас 6-гаар бага байна.



Зураг 1. 11 Дундаж наслалт, хүйсээр, сонгосон онуудаар



Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- www.1212.mn

Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү урт наслах хандлага аль ч улсад байсаар ирсэн бөгөөд энэ нь эрүүл мэнд, нас баралт, нийгэм, эдийн засаг, тэгш бус байдал, эрүүл мэндийн систем, улс төр, байгаль орчин, газарзүйн байршил зэрэг олон хүчин нөлөөлдөг байна.

2020 оны байдлаар дундаж наслалт аймаг, бүсүүдээр ялгаатай байгаа ба Хангайн бүсийн хүн амын дундаж наслалт хамгийн бага буюу 71.31, Төвийн бүсийн хүн амын дундаж наслалт 72.29 байгаа нь хамгийн өндөр байна. Аймагуудаар харуулбал Хөвсгөл /67.6/, Увс /70.29/, Дорнод /69.78/, Дархан-Уул /68.63/ зэрэг аймгууд дундаж наслалтаараа улсын дундаж үзүүлэлтээс доогуур байна.

Хүснэгт 1. 2 Хүн амын дундаж наслалт, бүс, аймгаар, 2020 он

Аймаг, нийслэл	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>Бүгд</b>	70.71	66.71	76.22
<b>Баруун бүс</b>	71.76	67.94	75.07
Баян-Өлгий	73.62	70.58	76.09
Говь-Алтай	70.71	65.41	75.52
Завхан	71.08	68.46	73.88
Увс	70.29	65.46	74.21
Ховд	73.11	69.79	75.64
<b>Хангайн бүс</b>	71.31	68.49	75.40
Архангай	72.08	69.49	73.67
Баянхонгор	70.89	67.69	72.90
Булган	73.59	69.08	76.35
Орхон	72.34	71.19	82.95
Өвөрхангай	71.37	68.98	74.08
Хөвсгөл	67.60	64.48	72.45
<b>Төвийн бүс</b>	72.29	68.99	76.86
Говьсүмбэр	73.65	73.15	75.68
Дархан-Уул	68.63	64.31	74.43
Дорноговь	72.02	67.39	77.95
Дундговь	74.61	71.48	79.38
Өмнөговь	72.66	68.74	77.17
Сэлэнгэ	71.96	67.51	78.31
Төв	72.53	70.37	75.13
<b>Зүүн бүс</b>	72.02	67.91	76.51
Дорнод	69.78	65.66	74.26
Сүхбаатар	73.29	68.04	78.50
Хэнтий	73.00	70.03	76.78
Улаанбаатар	72.09	67.39	75.36



БҮЛЭГ



2

ТОГТВОРТОЙ  
ХӨГЖЛИЙН  
ЗОРИЛТ БА  
БҮХ НИЙТИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ХАМРАЛТ

## БҮЛЭГ 2.


# ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ БА БҮХ НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАМРАЛТ

### 2.1 БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД

Газар нутгийн хэмжээ (1 000 км<sup>2</sup>)


**1.567**

Хүн амын тоо



Хүн амын нягтрал

Нэг хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт  
ногдох хүний тоо -2.0



Төрөлтийн нийлбэр коэффициент **24.0**

Нас баралтын нийлбэр коэффициент **5.1**

Төрөлтийн ерөнхий коэффициент **2.9**

Насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлагдалт  
/хувь/ **97.8**

#### 1. Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого (Монгол Улсын Их хурлын 2020 оны 52-р тогтоол)

Зорилт 2.2 Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ.

Урт хугацааны хөгжлийн бодлогын I үе шат нь 2020-2030 онд хэрэгжүүлэхээр “Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй тогтолцооны шинэчлэлийн үе” гэж нэрлэн дараах үндсэн 4 чиглэлийг баталсан байна.

1. Иргэн, гэр бүл, ажил олгогчийн оролцоонд тулгуурласан нийгмийн эрүүл мэндийн/нийтийн эрүүл мэнд/ тусламж үйлчилгээний үндэсний тогтолцоо бүрдүүлэх
2. Нотолгоонд суурилсан орчин үеийн оношилгоо, эмчилгээний техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, гүйцэтгэлд тулгуурласан санхүүжилт, даатгалын тогтолцоо бүрдүүлэх
3. Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн үндэсний эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдүүлэх
4. Эрүүл мэндийн хүний нөөцийн хангалт, үр чадвар нийгмийн хамгааллыг сайжруулах

#### 2. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” (Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор)

Зорилт 2.2 Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцооны шинэчлэл хийнэ.


#### 3. “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”

(Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоол)

**Зорилго:** Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэдний эрэлт, хэрэгцээнд тулгуурлан аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, нотолгоонд суурилсан оношилгоо, эмчилгээний шинэ технологийг нэвтрүүлэх, эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн зохистой тогтолцоог бүрдүүлэх замаар тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан монгол хүний дундаж наслалтыг үртасгахад оршино.



Зураг 2. 1 Хүн амын дундаж наслалт, хүйсээр, сонгосон онуудаар



## 2.2 ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ИНДЕКСИЙН ОНОО

Нэгдсэн үндэстний байгууллага болон Дэлхийн банкнаас гишүүн орнуудын Тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтийг үнэлдэг үнэлгээний индексийг тооцон гаргадаг. 2020 оны Тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтийн индексээр НҮБ-ын гишүүн 193 орноос Швед улс 84.7 оноотойгоор тэргүүлж байгаа бол Денмарк 84.5, Финланд улс 83.7 оноотойгоор удаах байруудад орсон байна.

Монгол улс ТХЗ-ын гүйцэтгэлийн индекс 64 оноотойгоор 107 дугаарт жагссан байна. Уг гүйцэтгэлтийн индекс ТХЗ-ын үзүүлэлт тус бүрийн зорилтыг амжилттай биелүүлсэн, гүйцэтгэл дунд зэрэг ч сайжирч байгаа, хэрэгжилт зогсонги байдалд байгаа, зорилтын хэрэгжилт буурч байгаа, мэдээлэл байхгүй гэж ангилж үзэж байгаа бөгөөд Монгол Улсын эрүүл мэндийн зорилтын хэрэгжилт гүйцэтгэл дунд зэрэг ч сайжирч байгаа гэсэн үнэлгээтэй байна.

Эх үүсвэр: [www.sdgindex.org](http://www.sdgindex.org)

Монгол улсын тогтвортой хөгжлийн зорилтын эрүүл мэндийн хамааралтай болон бүх нийтийн эрүүл мэндийн хамралтын эрүүл мэндийн үзүүлэлтүүдийн гүйцэтгэлийн индекс оноо нь 66.3 байгаа нь Номхон далайн баруун эргийн бүсийн дундаж үзүүлэлтээс 2.3 хувиар доогуур үзүүлэлттэй байна.


Тогтвортой хөгжлийн зорилтын гүйцэтгэлийн индекс оноо зорилтын үзүүлэлт тус бүр дээр ялгаатай байгаа бөгөөд доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 2. 1 Тогтвортой хөгжлийн зорилтын гүйцэтгэлийн индексийн оноо

Гүйцэтгэлийн индекс оноо 0-100%		
Улаан: <50%	Шар: 50-80%	Ногоон: >80%
ТХЗ	Үзүүлэлтийн түвшин	Зорилт: 100%
<b>Эх, хүүхдийн эрүүл мэнд</b>		
Эхийн эндэгдлийн түвшин (100 000 амьд төрөлтөд), 2020		
3.1.1	44.0 ↑	94.8%
Мэргэжлийн ажилтан эх барьсан төрөлтийн эзлэх хувь (%), 2018		
3.1.2	99.0% ↑	98.6%
Гав хуртэлх насны хүүхдийн эндэгдэл (1000 амьд төрөлтөд), 2019		
3.2.1	16.3 ↑	89.3%
Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд), 2019		
3.2.2	8.7 ↑	80.3%
Өсвөр насны охидын төрөлтийн түвшин (түүхэйн насны 1000 охидод), 2017		
3.7.2	30.2	79.2%
Үндэсний хөтөлбөрт тусгагдсан бүх төрлийн вакцинуудад Хамрагдсан зорилтот хүн амын эзлэх хувь (%), 2018		
3.b.1	99.8 ↑	98%
<b>Халдварт өвчин</b>		
ХДХВ-ийн халдваргүй 1000 хүнд ногдох тухайн жилд халдвар авсан шинэ тохиолдлын тоо, 2019		
3.3.1	0.0 ↑	99.8%
Сүрьеэгийн өвчлөлийн түвшин (100 000 хүн амд), 2018		
3.3.2	428.0 →	23.7%
<b>Халдварт бус өвчин</b>		
Зүрх судасны өвчин, хорт хавдар, чихрийн шижин болон амьсгалын замын архаг өвчний шалтгаант нас баралтын түвшин (%), 2018		
3.4.1	30.2% →	3.7%
Амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин (10,000 хүн амд ногдох), 2017		
3.4.2	28.3	67%
Зам тээврийн ослын шалтгаант нас баралт (100 000 хүн амд), 2019		
3.6.1	16.5	56.4%


## 2.3 ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

Зураг 2. 2 ТХЗ 3.1.1 Эхийн эндэгдлийн харьцаа (100 000 амьд төрөлтөд)




2020 оны байдлаар 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл 30.2 байгаа нь дэлхийн дундажаас 7 дахин (211 2019 он), номхон далайн баруун эргийн бүсийн дундажаас (60.1 2019 он) доогуур үзүүлэлттэй 2 дахин байна. Бүсийн орнуудтай харьцуулахад 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл өндөртэй орнуудын 9 дүгээрт орж байна.

Зураг 2. 3 ТХЗ: 3.1.2 Эрүүл мэндийн мэргэжлийн ажилтан эх барьсан төрөлтийн хувь




2020 онд төрсөн эхчүүдийн 99.7 хувь нь эмнэлэгт, 0.3 хувь нь гэртээ төрсөн байна. Эмнэлгийн мэргэжлийн ажилтан эх барьсан төрөлтийн эзлэх хувь 2020 онд 99.2 байгаа ба энэ үзүүлэлт сүүлийн 10 жилийн хугацаанд тогтвортой байна. Дэлхийн болон бүсийн дундажтай харьцуулахад дээгүүр үзүүлэлттэй байна.

Зураг 2. 4 ТХЗ 3.7.2 Өсвөр насны охидын төрөлтийн түвшин (15-19 насны 1000 охидод)



2020 онд өсвөр насны охидын төрөлтийн түвшин тухайн насны 1000 эмэгтэйд харьцуулахад 27.8 байгаа нь 2010 онтой харьцуулахад 1.1-оор буурсан байна.

Зураг 2. 5 ТХЗ: 3.2.1 Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох)




Хүүхдийн эндэгдэл буурч байна. 1990 онд тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 87.5 байсан бол 2020 онд 14.0, нялхсын эндэгдэл 63.4-оос 11.5 болж тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин дэлхийн дундаж (39)-аас доогуур байгаа хэдий ч номхон далайн баруун эргийн бүсийн дундаж (11.5)-аас 2.5-оор өндөр байна.



Зураг 2. 6 ТХЗ: 3.2.2 Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох)



2010 онд нярайн эндэгдлийн түвшин 11.6 байсан бол 2020 онд 7.3 болсон байна. Нярайн эндэгдлийн түвшин 2020 онд дэвшүүлсэн зорилт (10)-доо хүрсэн бөгөөд дэлхийн дундаж (18)-аас доогуур байгаа хэдий ч номхон далайн баруун эргийн бүсийн дундаж (6)-аас 1.3-оор өндөр байна.

## 2.4 ХАЛДВАРТ ӨВЧИН


Халдварт болон халдварт бус өвчний тулгамдсан асуудал хэвээр байна. Халдварт өвчинтэй тэмцэх олон хууль, бодлогууд гарч байгаа ч хүн ам урьдчилан сэргийлж болох өвчинд нэрвэгдсээр байна.

Урьдчилан сэргийлж болохуйц өвчлөлөөс шалтгаалан цаг бусаар нас барах тохилдол буурахгүй байна. Дархлаажуулалтын хамралт өндөр (98 хувь) байгаа хэдий ч улаан бурхан зэрэг зарим халдварт өвчний дэгдэлт 2015- 2016 онуудад гарч, бага насны хүүхдийн эндэгдлийн тоо өсөх шалтгаан болсон. 15-34 болон 65-с дээш насныхны дунд сүрьеэгийн шинэ тохиолдлууд өндөр байна.

Номхон далайн баруун бүсийн орнуудын шинэ ХДХВ-ийн халдварын түвшин дэлхийн дунджаас доогуур байгаа ч ХДХВ-ийн эмчилгээнд хамрагдах асуудал анхаарал татсан хэвээр байна. 5 настай хүүхдүүдийн дунд гепатит В гадаргуугийн антиген (HBsAg) -ийг 1% -ийн бүс нутгийн зорилтот түвшинд хүрлээ.

Сүрьеэгийн өвчлөл дэлхийн зорилтот түвшинтэй харьцуулахад аажмаар буурч байгаа бөгөөд хүнд эрсдэл өндөртэй орнуудад хумхаа өвчний тохиолдлын түвшин бараг хоёр дахин нэмэгдсэн байна.

Зураг 2. 7 ТХЗ 3.3.1 ХДХВ-ийн халдварлаагүй 1000 хүн амд ногдох ХДХВ-ийн шинэ тохиолдлын тоо




Монгол улсын нийт хүн амын дунд Хүний дархлал хомсдолын вирусийн халдварын тархалтын түвшин 0.1 хувиас бага, эрсдэлт бүлгийн хүн амын дунд 5.0 хувиас бага байгаа нь нийт хүн амын дунд бага, эрсдэлт бүлгийн хүн амын дунд төвлөрсөн тархалттай орны тоонд орж байна.

1992 онд Монгол улсад ХДХВ/ДОХ-ын анхны тохиолдол бүртгэгдсэнээс хойш 2020 оны жилийн эцсийн байдлаар ХДХВ/ДОХ-ын нийт 311 тохиолдол бүртгэгдэж, үүнээс 25

тохиолдол нь 2020 онд шинээр бүртгэгдсэн байна. Бүртгэгдсэн 311 тохиолдлын 47 нь нас барсан байна.



Зураг 2. 8 ТХЗ 3.3.2 Сүрьеэ өвчний тохиолдлын түвшин /100 000 хүн амд/



Монгол улсын хүн амын дундах сүрьеэгийн өвчлөлийн түвшин номхон далайн баруун бүсийн орнуудын дунд 4 дэх өндөр тархалттай орон болж байна. ДЭМБ-ын тооцооллоор 100 000 хүн амд ногдох сүрьеэгийн өвчлөлийн түвшин 428 байгаа нь дэлхийн дундаж (132)-аас 296, бүсийн дундаж (96)- аас 332-оор тус тус өндөр байна.


Эрүүл мэндийн статистик

мэдээллээр 100 000 хүн амд ногдох сүрьеэгийн өвчлөлийн түвшин 1996 онд 146.0 байсан бол 2020 онд 104 болсон байна.

## 2.5 ХАЛДВАРТ БУС ӨВЧИН

Халдварт бус өвчний гол 4 шалтгаан болох зүрх судас, хавдар, чихрийн шижин, амьсгалын замын архаг өвчнөөс шалтгаалсан эрт нас барах эрсдэл буурч байгаа хэдий ч одоогийн төсөөллөөс харахад Номхон далайн баруун бүсийн ихэнх улс орнууд 2030 он гэхэд ХБӨ-ээс эрт нас баралтыг гуравны нэгээр бууруулах ТХЗ-ын 3.4 зорилтод хүрэхгүй болох нь харагдаж байна. Тамхи, архины хэрэглээ тууштай буурахгүй байгаа нь ихэнх улс орнууд дэлхийн 2025 оны ХБӨ-ний зорилтыг биелүүлж чадахгүй байгааг харуулж байна гэж бүсийн тайланд дурьдсан байна.


Зураг 2. 9 ТХЗ 3.4.1 30 настай хүний Зүрх судасны өвчин, хавдар, чихрийн шижин, амьсгалын замын архаг өвчнөөр нас барах магадлал, 2016 он



ДЭМБ-ын тооцооллоор Монгол улсын 30-70 насны хүн амын дундах халдварт бус өвчний дөрвөн гол өвчнөөр нас барах магадлал 30.2 байгаа нь дэлхийн дундаж (18.3)-аас 11.9, бүсийн дундаж (16.2)- аас 14-иар тус тус өндөр байна




**Зураг 2. 10 ТХЗ 3.6.1 Зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин (100 000 хүнд ногдох зам тээврийн ослоор нас барсан хүний тоо)**



Монгол улсын хүн амын дундах зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин номхон далайн баруун бүсийн орнуудын дунд 9 дэх өндөр тархалттай орон болж байгаа бөгөөд 100 000 хүн амд ногдох зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин 2020 онд 15.1 байгаа нь дэлхийн дундаж (18.2)-аас 3.1, бүсийн дундаж (16.1)- аас 1.0-оор тус тус бага байна


**Зураг 2. 11 ТХЗ 3.4.2 Амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин (100,000 хүнд ногдох амиа хорлосон хүний тоо)**



Амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин номхон далайн баруун бүсийн орнуудын дунд 5 дахь өндөр тархалттай орон болж байна. Монгол улсын хүн амын дундах амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин 100 000 хүн амд 14 байгаа нь дэлхийн дундаж (10.6)-аас 3.4, бүсийн дундаж (10.2)- аас 3.8-оор тус тус өндөр байна

## 2.6 БҮХ НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАМРАЛТ

**Зураг 2. 12 ТХЗ 3.8.1 Эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээний хамралтын хувь**




Эрүүлмэндийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээний хамралтын хувь 2020 онд 85 хувь байгаа нь дэлхийн дундаж (66)-аас 19, бүсийн дундаж (77)- аас 8 хувиар тус тус өндөр байна.



## Хүснэгт 2.2 Дэлхийн болон бүсийн дундажтай харьцуулсан ТХЗ-ын эрүүл мэндийн үзүүлэлтүүд

ТХЗ зорилт	Үзүүлэлт	Он	Улсын дундаж	Дэлхийн дундаж	Бүсийн дундаж
3.1.1	Эхийн эндэгдэл	2017	45	211	60.1
3.1.2	Мэргэжлийн ажилтан эх барьсан төрөлтийн эзлэх хувь	2019	99.3	81.3	
3.2.1	Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	2019	15.63	37.69	11
3.2.2	Нярайн эндэгдэл	2019	8.14	17.47	6.0
3.3.1	ХДХД/ДОХ-ын 1000 халдварлаагүй хүн амд эзлэх хувь	2018	0.01	0.24	0.06
3.3.2	Сүрьеэгийн өвчлөлийн түвшин	2018	428	132	96
3.3.3	Хумхаагийн өвчлөлийн түвшин	2018	-	57.4	2.6
3.3.4	Вирүст хепатитын өвчлөлийн түвшин				
3.4.1	Халдварт бус өвчний шалтгаант нас баралт	2016	30.2	18.3	16.2
3.4.2	Амиа хорлосон нас баралтын түвшин	2016	13.2	10.6	10.2
3.5.2	Нэг хүнд (15 ба түүнээс дээш насны) жилд ногдох цэвэр спиртийн хэмжээгээр илэрхийлэгдсэн согтууруулах ундааны хэмжээ, литрээр	2018	8.2	6.2	7.2
3.6.1	Зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин	2016	16.5	18.2	16.9
3.7.1	Жирэмснээс хамгаалах орчин үеийн аргын хэрэглээ	2020	63.6	76.8	86.8
3.7.2	Өсвөр насны охидын төрөлтийн түвшин	2018	32.5	42.5	14.4
3.8.1	Эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээний хамралтын хувь	2017	62	66	77
3.8.2	Өрхийн зардлын дийлэнх хувийг эрүүл мэнддээ зарцуулдаг хүн амын эзлэх хувь	2018	2.4	12.7	15.9
3.9.1	Агаарын бохирдлоор нөхцөлдсөн нас баралтын түвшин	2016	155.9	114.1	102.8
3.9.3	Хордлогын шалтгаант нас баралтын түвшин	2016	1.6	1.4	1.1
3.с.1	Эрүүл мэндийн ажиллагчид /Их эмч/	2019	28.6	15.6	18.8
3.d.1	Олон улсын эрүүл мэндийн журмыг хэрэгжүүлэх чадавх болон эрүүл мэндийн яаралтай тусламж үзүүлэх бэлэн байдал	2019	84	63	71
16.1.1	Бусдад хорлогдож нас барсан тохиолдлын түвшин	2017	7.1	6.3	1.7

Эх үүсвэр: World Health Statistics – Global Health Observatory. Geneva: World Health Organization



БҮЛЭГ

З

ЭХ, ХҮҮХДИЙН  
ЭРҮҮЛ МЭНД

## БҮЛЭГ 3.

# ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

### 3.1 ЭХИЙН ЭРҮҮЛ МЭНД

Монгол Улсын Засгийн Газраас 2017 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 78 дугаар тогтоолоор “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” Үндэсний хөтөлбөрийг баталсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2017-2021 онуудад Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг сайжруулах нийгэм, эдийн засгийн таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлж, иргэдийн болон иргэний нийгмийн оролцоог хангах замаар эрүүл мэндийн хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээг бүх нийтэд тэгш хүргэснээр эх, хүүхдийн эндэгдлийг тогтвортой бууруулах юм.

#### 3.1.1 ЖИРЭМСНИЙ ХЯНАЛТ БА ТӨРӨХИЙН ӨМНӨХ ҮЕИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Жирэмсэн үеийн хяналт нь эх, ургийн эрүүл мэндэд учирч болох эрсдэлт хүчин зүйлүүдийг цаг алдалгүй илрүүлэх, хүндрэлээс урьдчилан сэргийлэх, эсэн мэнд амаржуулах, төрсний дараах үед тусламжийг цаг алдалгүй үзүүлэхэд чиглэгддэг нэн чухал тусламж үйлчилгээ юм.

ДЭМБ-аас жирэмсэн үеийн хяналтад наад зах нь найман удаа хамрагдсан байхыг зөвлөмж болгосон ба цусны даралт хэмжих, шээсэнд бактери, уураг илрүүлэх шинжилгээ, тэмбүү болон хүнд хэлбэрийн цус багадалтыг илрүүлэх цусны шинжилгээ, жин/өндрийн хэмжилт зэрэг тусгайлсан үйлчилгээг зөвлөмж болгодог.

Жирэмсний хяналтад аль болох эрт орох нь илүү ач холбогдолтой бөгөөд жирэмсний эхний гурван сартайдаа хяналтад орсноор эх, хүүхдийн аль алиных нь эрүүл мэндэд нөлөөлж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжтой. Жирэмсний хяналт нь жирэмсний нийт хугацааны турш үргэлжилнэ.

Түүнчлэн, жирэмсний хяналтын үеэр нялхас эсэн мэнд төрж, өсөхөд нөлөө үзүүлдэг хүчин зүйл болох төрөлт хоорондын зайн талаар мэдлэг мэдээллийг олгодог. Дархлаажуулалт нь эх хүүхэд эсэн мэнд амаржихад чухал ач холбогдолтой. Жирэмсэн эмэгтэйчүүдийг жирэмсэн үеийн цус багадалтыг эрт илрүүлж эмчилснээр эхийн эрүүл мэнд сайжирч, нялхас эсэн мэнд мэндэлнэ.


Цаашлаад эхийн хоол тэжээлийн байдлыг дээшлүүлэх, БЗДХ болон бусад халдвараар өвчлөхөөс зайлсхийх зэргээр бага жинтэй хүүхэд төрөхөөс урьдчилан сэргийлэх хосолсон арга хэмжээ авах нөхцөл бүрддэг. Мөн сүүлийн үед ХДХВ эхээс хүүхдэд дамжин халдварлахаас сэргийлэхийн тулд жирэмсний хяналтын үеийн үйлчилгээ, хүртээмжийг нэмэгдүүлэхэд ихээхэн анхаарах боллоо.

1971 оны байдлаар жирэмсэн эмэгтэйчүүдийн 34.8 хувь нь эхний 3 сартайд хяналтад орж байсан бол 1980 онд 45.7 хувь, 1990 онд 52.9 хувь байсан ба 2005 оноос хойш 80-аас дээш хувь нь эхний 3 сартайд хяналтад хамрагдсан үзүүлэлттэй байна. Жирэмсний эрт хяналтын хувь сүүлийн 10 жилийн жилийн хугацаанд тогтмол 85 хувиас дээш хувьтай байгаа ба 1971 оны үзүүлэлттэй харьцуулахад 50 орчим хувиар нэмэгдсэн байна. (Зураг 3.1)



Манай улсад хэвийн явцтай жирэмсэн эмэгтэйг 6 удаа, өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйг 8 удаа үзүүлэхийг зөвлөдөг бөгөөд эх жирэмсэн болсноо мэдмэгц 12 долоо хоногоос дотогш хугацаанд эхний үзлэгт хамрагдахыг шаарддаг. Жирэмсний хугацаанд 6 ба түүнээс удаа хяналтын үзлэгт хамрагдсан эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2005 онд 83.7 байсан ба 2013 онд 91.8 хувь байгаа нь хамгийн өндөр үзүүлэлттэй байна. Харин сүүлийн жилүүдэд буурах хандлагатай байгаа ба 2020 оны байдлаар 78.8 хувь байгаа нь өмнөх оноос 2.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

**Зураг 3. 1 Жирэмсний эхний 3 сартайд хяналтад хамрагдсан хувь, сонгосон онуудаар**




2020 оны байдлаар улсын хэмжээнд 76472 жирэмсэн эмэгтэйчүүд шинээр хяналтад хамрагдсан бөгөөд 89.9 хувь нь жирэмсний эрт үедээ буюу эхний 3 сартайдаа, 9.2 хувь нь 4-6 сартайдаа, 0.9 хувь нь хожуу буюу 7 ба түүнээс дээш сартайдаа хяналтад хамрагджээ.

Жирэмсний эрт үеийн хяналтыг хот, хөдөөгөөр авч үзвэл хотод жирэмсэн эмэгтэйчүүдийн 89.3 хувь нь, хөдөө орон нутагт 90.5 хувь нь жирэмсний эрт үедээ хяналтад хамрагдсан ба өмнөх онтой харьцуулахад хот 0.5 хувиар, хөдөө орон нутагт 0.6 хувиар өссөн байна.

Шинээр хяналтад орсон нийт жирэмсэн эхчүүдийн 97.9 хувь нь цусны ерөнхий шинжилгээнд хамрагдсанаас 3.6 хувь нь цус багадалттай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 0.1 хувиар өссөн байна. Архангай, Баян-Өлгий, Дархан-Уул, Дорноговь, Ховд, Сүхбаатар аймагт шинжилгээгээр илэрсэн цус багадалттай жирэмсэн эхчүүдийн эзлэх хувь улсын дүнгээс 0.4-7.0 хувиар их байна.


**Зураг 3. 2 Цус багадалттай жирэмсэн эхчүүдийн эзлэх хувь, 2020 он**



Шинээр хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд тэмбүү илрүүлэх ийлдэс судлалын шинжилгээнд 99.1 хувь хамрагдсанаас 1.7 хувьд нь тэмбүү өвчин илэрсэн ба энэ үзүүлэлт Архангай 2.3, Дундговь 1.8, Орхон 2.1, Увс 2.2, Хөвсгөл 2.6 хувьтай улсын дундаж үзүүлэлтээс 0.1-0.9 хувиар их байна. Заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд жирэмсэн эмэгтэйчүүдийн 92.1 хувь нь хамрагдсан нь өмнөх оноос 1.1 хувиар өссөн байна. Шинжилгээнд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн 0.3 хувьд нь заг хүйтэн өвчин илэрчээ. Баян-Өлгий 0.5, Завхан 0.5, Дорнод 0.8, Сүхбаатар 0.8, Сэлэнгэ 0.9, Увс 0.6, Хөвсгөл 1.3 хувийг тус тус эзэлж байгаа нь улсын дүнгээс 0.2-1.0 хувиар их байна. Трихомониаз илрүүлэх шинжилгээнд жирэмсэн эмэгтэйчүүдийн 92.2 хувь нь хамрагдсанаас 1.6 хувьд нь эерэг үзүүлэлттэй байна. Баянхонгор 7.2, Булган 6.0, Дархан 2.3, Дорнод 2.5, Орхон 2.4, Сүхбаатар 3.0, Сэлэнгэ 2.5, Увс 2.5, Төв 3.4, Хэнтий 2.5 хувийг тус тус эзэлж байгаа нь улсын дүнгээс 0.7-5.6 хувиар их байна.

2020 онд эхчүүдийн амрах байр улсын хэмжээнд 336 ажиллаж байгаагаас 312 нь сум, тосгоны эрүүл мэндийн төвд, 18 нь аймгийн нэгдсэн эмнэлэгт, БОЭТ-д 4, Улаанбаатар хотын эмнэлэгт-2 тус тус ажилласан байна. Эхчүүдийн амрах байрны 113 буюу 33.6 хувь нь зориулалтын байранд байгаа ба 223 буюу 64.4 хувь нь эмнэлэгт байрлаж нийт 61707 ор хоног ашигласан ба дундаж ор хоног 6.8 байна. 2020 онд 15 байр шинээр баригдаж, 49 байранд засвар үйлчилгээ, 73 байранд тохижилт хийгдсэн байна. Нийт амарвал зохих эхчүүдийн 69.1 хувь нь амрах байранд амарсан байна.

*Зураг 3. 3 Жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш удаа хяналтанд хамрагдсан эмэгтэйчүүдийн хувь, аймгаар, 2020 он*





### 3.1.2 ТӨРӨЛТ, ТӨРӨХ ҮЕИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

2020 онд нийт 75694 эх амаржиж, 76261 нярай амьд төрж, 413 нярай амьгүй төрсөн байна. Амаржсан эхийн тоо өмнөх онтой харьцуулахад 1907 тохиолдлоор буурсан байна. Нийт амаржсан эхчүүдийн 99.7 хувь нь эмнэлэгт, 236 эх буюу 0.3 хувь нь гэртээ төрсөн байна. Гэртээ төрсөн эхчүүдийн 66 тохиолдол буюу 27.9 хувь эмнэлгийн тусламжгүй төрсөн байна.


Эмнэлгийн мэргэжлийн ажилтан эх барьсан төрөлтийн эзлэх хувь 2020 онд 99.2 байгаа ба энэ үзүүлэлт сүүлийн 10 жилийн хугацаанд тогтвортой түвшинд байна. Амаржсан эхчүүдийн 452 тохиолдол буюу 0.6 хувь нь эх барихын хавчуурын тусламжтай төрсөн ба 204 тохиолдол буюу 0.3 хувьд нь эхсийг гардаж авах тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

Мөн төрөх үедээ хүссэн байрлалаа сонгосон 909 эх байгаа нь нийт амаржсан эхчүүдийн 1.2 хувийг эзэлж байгаа ба 4.1 хувь буюу 3150 эхийн гэр бүлээс нь хэн нэг нь амаржих үед нь хамт байсан байна. Амаржсан эхчүүдийн 217 нь буюу 0.3 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй буюу ямар нэгэн тусгай хэрэгцээ шаардлагатай ээжүүд байна.

Амаржсан эхчүүдийн 24.5 хувь нь анхны төрөлт, 29.1 хувь нь хоёрдахь төрөлт, 45 хувь нь 3-5 дахь төрөлт, 1.5 хувь нь 6 ба түүнээс дээш удаагийн төрөлт байна. Төрөлт хоорондын зайгаар нь авч үзвэл 7.6 хувь 1 жил, 16.5 хувь нь 2 жил, 51.4 хувь нь 3 ба түүнээс дээш жилийн зайтай амаржсан байна. Насны хувьд 3.9 хувь нь 20 хүртэлх насны, 50.4 хувь нь 20-29 насныхан, 26.5 хувийг 30-34 насныхан, 19.2 хувийг 35 ба түүнээс дээш насныхны төрөлт эзэлж байна.

2020 онд өсвөр насны охидын төрөлтийн түвшин тухайн насны 1000 эмэгтэйд харьцуулахад 27.8 байгаа нь 2010 онтой харьцуулахад 1.0-оор нэмэгдсэн хэдий ч сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 5.3-оор буурсан байна.

Зураг 3. 4 Төрөлт, амьгүй төрөлтийн тоо, сонгосон онуудаа



Төрөлтийн ерөнхий коэффициент нь тухайн жилд 1000 хүн амд ногдох амьд төрсөн хүүхдийн тоогоор илэрхийлдэг үзүүлэлт бөгөөд Монгол улсад 1990 оны байдлаар 1000 хүн амд ногдох төрөлтийн түвшин 35.3 байсан бол 2005 онд 17.8 болж 2 дахин буурч хамгийн бага түвшинд хүрсэн бөгөөд 2006 оноос тогтвортой нэмэгдэн 2020 онд 24 болсон байна.

Төрөлтийн тусгай коэффициент нь төрөх насны (15-49) 1000 эмэгтэйчүүдэд ногдох амьд төрсөн хүүхдийн тоог илэрхийлдэг бөгөөд 2020 оны байдлаар 1000 эмэгтэй тутмын 94 нь хүүхэд төрүүлсэн байна гэдгийг харуулж байна.

Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент (НБТК) нь тухайн насны бүлэг дэх 1 000 эмэгтэйд



ногдох төрөлтийн тоогоор илэрхийлэгдэх ба насны бүлэг дэх төрөлтийн түвшинг харуулах ба 20-24 насны 1000 эмэгтэй тутмын 149.6 нь, 25-29 насны 1000 эмэгтэй тутмын 176.9 нь хүүхэд төрүүлж байгаа нь насны бүлэг дотроо өндөр үзүүлэлттэй байна.


Хүснэгт 3. 1 Төрөлтийн коэффициентүүд, сонгосон онуудаар

Коэффициент	1980	1985	1990	1995	2000	2005	2010	2015	2020
15-19	44.9	34.9	39.3	32.9	27.4	15.5	18.9	29.9	26.9
20-24	280.0	265.3	249.6	188.5	142.6	110.9	129.2	155.3	141.0
25-29	339.9	348.7	263.9	158.9	135.1	123.9	147.1	168.7	165.0
30-34	258.6	212.8	179.8	92.3	85.7	84.0	105.5	137.1	135.2
35-39	194.8	132.4	108.2	51.5	39.9	42.7	63.9	87.1	92.2
40-44	124.3	74.6	41.8	22.8	13.6	12.0	19.0	23.5	25.4
45-49	39.7	26.5	11.8	5.1	4.2	4.5	2.6	1.3	1.5
ТЕК	39.2	38.2	34.4	24.4	20.4	17.9	23.1	27.1	23.4
ТТК	179.8	167.0	149.6	94.9	73.7	63.0	76.0	95.1	89.7
ТНК	6.4	5.5	4.5	2.8	2.2	2.0	2.4	3.0	2.9

Эх үүсвэр: YCX

Төрөлт Булган, Говьсүмбэр, Дорнод, Дорноговь, Говь-Алтай, Сүхбаатар, Завхан, Хэнтий аймгуудад өмнөх онтой харьцуулахад өссөн ба бусад аймагт буурсан үзүүлэлттэй байна. 1000 хүн амд ногдох төрөлтийн түвшин улсын дүнгээр 24.0 байгаа бол энэ үзүүлэлт Баян-Өлгий 27.6, Орхон 24.7, Дорнод 24.4, Увс 24.3, Ховд 25.8 зэрэг аймгуудад улсын дунджаас илүү байна.

Зураг 3. 6 1000 хүн амд ногдох төрөлтийн түвшин, аймгаар, 2020 он



Нийт төрөлтийн 47.0 хувь нь Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв болон Улаанбаатар хотын амаржих газруудад, 29.9 хувь нь аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт, 12.8 хувь нь Бүсийн оношилгоо эмчилгээний төвд, 7.0 хувь нь сум, тосгоны эрүүл мэндийн төвд, 3.0 хувь нь хувийн эмнэлэг, Халдварт өвчин судлалын үндэсний төвд, 0.3 хувь нь гэртээ төрсөн байна.



Зураг 3.7 Мэс заслын аргаар төрсөн эхийн хувь, аймгаар, 2020 он



ДЭМБ-ын зөвлөснөөр нийт төрөлтийн 5-15 хувь нь мэс заслын аргаар төрүүлж болно гэж үздэг. Манай улсын хувьд 2020 оны байдлаар харьцангуй өндөр буюу 26.4 хувь нь мэс заслын аргаар хүүхдээ төрүүлсэн байна.

Мэс заслын аргаар төрсөн эхийн тоог өмнөх онтой харьцуулахад 0.4 хувиар өссөн байна. Мэс заслын аргаар төрлөгийг шийдсэн хувийг аймгийн дундажтай харьцуулахад баруун бүсэд 2.1, төвийн бүсэд 0.6 хувиар тус тус бага, харин хангай болон зүүн бүсэд 0.6-2.0 хувиар их байна. Улаанбаатар хотод амаржсан эхчүүдийн 30.4 хувь нь мэс заслын аргаар төрүүлсэн байгаа нь улсын дунджаас 4.0 хувиар өндөр байна.


Хүснэгт 3.2 Мэс заслын аргаар төрүүлсэн хувь, бүсээр 2020 он

Байршил	Төрсөн эх	Мэс заслын аргаар төрсөн эхийн тоо	Мэс заслын аргаар төрсөн эхийн хувь
Баруун бүс	9884	1978	20.0
Хангайн бүс	12126	2923	24.1
Төвийн бүс	9407	2018	21.5
Зүүн бүс	4899	1111	22.7
Аймгийн дүн	36316	8030	22.1
Улаанбаатар	39378	11965	30.4
Улсын дүн	75694	19995	26.4

Гэрийн төрөлтийн 236 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд өмнөх онтой харьцуулахад 7 тохиолдлоор нэмэгдсэн байна. Гэрийн төрөлтийн 51.7 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн ба өмнөх оноос 2.0 хувиар буурсан байна.

Эмнэлгийн тусламжгүй төрөлт 66 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 6 тохиолдлоор буюу нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Улаанбаатар хотын эмнэлгүүдэд хөдөө орон нутгийн харьяат 7290 эх амаржсан нь өмнөх оноос 779 төрөлтөөр буурсан ба Улаанбаатар хотод бүртгэгдсэн төрөлтийн 18.5 хувийг эзэлж байна.

Зураг 3. 8 Улаанбаатар хотод хөдөө орон нутгаас ирж төрсөн эхчүүд, бодит тоо, 2020



Хүснэгт 3. 3 Төрөлтийн тоо, эмнэлгийн байгууллагын төрлөөр, 2020

Аймаг, хот	Нийт төрөлт	Үүнээс гэртээ	БОЭТ	Аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэгт	Сумын ЭМТ	УБ хотын амаржих газар болон ЭХЭМҮТ-д	Хувийн эмнэлэгт	Бусад газарт
Архангай	1628	3	0	1345	280	0	0	0
Баян-Өлгий	2849	6	0	2385	458	0	0	0
Баянхонгор	2044	9	0	1879	156	0	0	0
Булган	760	3	0	636	121	0	0	0
Говь-Алтай	1395	8	0	1281	106	0	0	0
Говьсүмбэр	435	0	0	434	1	0	0	0
Дархан-Уул	2238	9	0	2227	2	0	0	0
Дорноговь	1455	5	0	1131	319	0	0	0
Дорнод	1988	6	1929	0	53	0	0	0
Дундговь	889	3	0	801	85	0	0	0
Завхан	1361	4	0	881	476	0	0	0
Орхон	2547	3	2540	0	4	0	0	0
Өвөрхангай	2421	8	1922	0	491	0	0	0
Өмнөговь	1677	6	1370	0	301	0	0	0
Сүхбаатар	1337	2	0	1267	68	0	0	0
Сэлэнгэ	1641	3	0	825	813	0	0	0
Төв	1072	6	0	900	166	0	0	0
Увс	2016	8	0	1731	277	0	0	0
Ховд	2263	7	1902	0	354	0	0	0
Хөвсгөл	2726	4	0	2253	469	0	0	0
Хэнтий	1574	11	0	1262	301	0	0	0
<b>Аймгийн дүн</b>	<b>36316</b>	<b>114</b>	<b>9663</b>	<b>21238</b>	<b>5301</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>Улаанбаатар</b>	<b>39378</b>	<b>122</b>	<b>0</b>	<b>1383</b>	<b>3</b>	<b>35576</b>	<b>2272</b>	<b>22</b>
<b>Улсын дүн</b>	<b>75694</b>	<b>236</b>	<b>9663</b>	<b>22621</b>	<b>5304</b>	<b>35576</b>	<b>2272</b>	<b>22</b>




### 3.1.3 ТӨРСНИЙ ДАРААХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Төрөх болон төрсний дараах богинохон үе бол эх, хүүхдийн эрүүл мэнд, амь насанд онцгой нөлөөтэй мөч байдаг. Дэлхий дээр жил бүр ойролцоогоор 3 сая хүүхэд төрсний дараах сарын хугацаанд эндэж, эндэгдлийн дийлэнх нь эхний 1-2 хоногт тохиолдож байна. Мөн эхийн эндэгдлийн олонх нь энэ хугацаанд бүртгэгдэж байна.

2020 онд хяналтад байж төрсөн эхчүүдийн 99.5 хувь нь төрсний дараа 42 хоногтойдоо идэвхтэй хяналтад хамрагдсан ба өмнөх онтой харьцуулахад 10.0 хувиар өссөн байна. Энэ үзүүлэлт төрсний дараах хүндрэл болон эхийн эндэгдэл буурахад чухал ач холбогдолтой юм.

2020 оны байдлаар жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэлийн 58947 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөд 779 ноогдож байна. Нийт бүртгэгдсэн хүндрэлийн тохиолдлын 35.8 хувийг жирэмсэн үеийн хүндрэл, 49.2 хувийг төрөх үеийн хүндрэл, 2.5 хувийг төрсний дараах үеийн хүндрэл, 12.4 хувийг жирэмсэн, төрөхөөс үл хамаарах өвчний хүндрэл-12.4 хувийг тус тус эзэлж байна.


Зураг 3. 9 Жирэмсэн, төрөх, төрсний дараах хүндрэлийн шалтгаан, хувиар, 2020 он



Жирэмсэн үеийн хүндрэлүүдээс манас таталтын урьтал 26.3, даралт ихсэх өвчин 10.1 хувийг эзэлж байгаа нь хамгийн түгээмэл тохиолдож буй хүндрэлийн хэлбэр болж байгаа бөгөөд чихрийн шижин 2.0, эхэс цагаас өмнө ховхрох хүндрэл 1.8 хувийг эзэлж байна.


Төрөх үеийн хүндрэлээс төрөх хүчний анхдагч болон хоёрдогч сулралт 35.1 хувь, ус эрт гарах 28.2 хувь, хярзан урагдалт 9,5 хувийг эзэлж байгаа дийлэнх хувийг эзэлж байна. Төрсний дараах хүндрэлээс төрсний дараах үеийн цус алдалт 65 хувийг, төрсний дараах халдвар 19.2 хувийг эзэлж байна.

Зураг 3. 10 Жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэлийн тохиолдол, эмнэлгийн төрлөөр, 2020 он




2020 онд төрөлхийн тэмбүүгийн нийт 37 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 29 тохиолдлоор буурсан байна. Улаанбаатар хотод 20, Булган 4, Дорнод 1, Орхон 5, , Ховд 2, Хэнтий 2, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл аймагт тус тус 1 тохиолдол бүртгэгдсэн байна.

Зураг 3. 11 Жирэмсний хүндрэлд манас таталтын эзлэх хувь, аймгаар 2020 он



Жирэмсний хүндрэлд манас таталтын эзлэх хувь Баян-Өлгий 87.4, Завхан 86.7, Булган 84.2, Увс 74.9, Сүхбаатар 70.1, Хөвсгөл 59.5, Төв 59.5, Дархан-Уул 56.7, Ховд 45.1, Баянхонгор 34.7, Дорноговь 27.8, Архангай 26.6 байгаа нь улсын дунджаас өндөр үзүүлэлттэй байна.

Зураг 3. 12 Төрөх үеийн хүндрэлд төрөх хүчний сулралын эзлэх хувь, аймгаар 2020 он



Төрөх үеийн хүндрэлд төрөх хүчний сулралын хувь Сэлэнгэ 82.8, Завхан 65.8, Өвөрхангай 56.2, Дорноговь 55.6, Говьсүмбэр 55.0, Төв 50.0, Хөвсгөл 49.4, Орхон 47.8, Архангай 47.8, Ховд 43.4, Увс 39.4 байгаа нь улс, аймгийн дунджаас өндөр байна.



Зураг 3. 13 Төрсний дараах хүндрэлд цус алдалтын эзлэх хувь, 2020 он




### 3.1.4 ЭХИЙН ЭНДЭГДЭЛ

Тогтвортой хөгжлийн зорилтод Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, хүүхдийн эндэгдэл, хоол тэжээлийн дутагдлыг тогтвортой бууруулна гэж заасан

2025 онд Эхийн эндэгдлийн түвшинг 100 000 амьд төрөлтөд 20, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 12, нялхсын эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 11 болгож бууруулах зорилтыг тавьсан. Манай улсад эхийн эндэгдэл 100 000 амьд төрөлтөд харьцуулахад 1990 оны түвшингээс 168.8-оор буурч, эхийн эндэгдэл өндөр орноос эхийн эндэгдэл дунд зэрэгтэй орны түвшинд хүрээд байна.

Монгол улсад 1971 онд эхийн эндэгдлийн 116 тохиолдол буюу 100 000 амьд төрөлтөд 235 байсан бол 2000 онд 81 тохиолдол бүртгэгдэж 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн харьцаа 161 байсан бөгөөд 1993 онд 243 болж өссөн үзүүлэлттэй байв. 2000 оноос хойш эхийн эндэгдлийн тохиолдол тууштай буурсаар 2015 онд 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн харьцаа 26 болсон хэдий ч 2016 онд 49 болж өссөн.

Зураг 3. 14 Эхийн эндэгдлийн тохиолдол, сонгосон онуудаар






2020 оны байдлаар эхийн эндэгдлийн 23 тохиолдол бүртгэгдэж 100 000 амьд төрөлтөд 30.2 байна. 2019 оноос эхийн эндэгдэл 5 тохиолдол, 100000 амьд төрөлт тутамд 7.2 эндэгдлээр нэмэгдсэн байна. Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Завхан, Орхон, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Хэнтий зэрэг аймгуудад эхийн эндэгдлийн тохиолдол бүртгэгдээгүй байна.

Эхийн эндэгдлийн 88.9 хувь нь эмнэлэгт, 11.1 хувь нь гэртээ эндсэн байна. 2020 онд эхийн эндэгдлийн харьцаа 30.2 болж, “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр (2017-2021)-ийн шалгуур үзүүлэлтэд хараахан хүрээгүй байна.

Зураг 3. 15 Эхийн эндэгдэл, 100 000 амьд төрөлтөд, аймгаар, 2020 он



Эхийн эндэгдлийг эмнэлгийн төрлөөр нь авч үзвэл 39.1 хувь нь аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт, 13 хувь нь сумын эмнэлэгт, 13 хувь нь нийслэлийн амаржих газарт, 8.7 хувь нь Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд, 4.3 хувь нь Бүсийн оношлогоо эмчилгээний төвд, 21.9 хувь нь бусад эмнэлгүүдэд байна.

Эндсэн эхчүүдийн 39.1 хувь нь жирэмсэн үеийн хүндрэл, 8.7 хувь нь төрөх үеийн хүндрэл, 39.1 хувь нь төрсний дараах хүндрэл, 21.8 хувь нь жирэмсэн, төрөлт төрсний дараах үеийн хүндрэл болсон эхийн эрхтэн тогтолцооны эмгэгийн шалтгаант эндэгдэл байна.


Хүснэгт 3. 4 Эхийн эндэгдэл 100 000 амьд төрөлтөд, насны ангиллаар, 2020

Насны бүлэг	Эндсэн эхийн тоо	Эзлэх хувь	Тухайн насны бүлгийн амьд төрүүлсэн хүүхдийн тоо	Тухайн насны бүлгийн 100000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин
20 хүртэлх	0	0	2935	0.0
20-24	4	17	16537	24.2
25-29	5	22	21792	22.9
30-34	3	13	20262	14.8
35-39	8	35	11668	68.6
40-өөс дээш	3	13	3032	98.9

Эхийн эндэгдлийн түвшинг 100 000 амьд төрөлтөд насны бүлгээр авч үзэхэд 20-24 насанд 24.2, 25-29 насанд 22.9, 30-34 насанд 14.8, 35-39 насанд 68.6, 40-өөс дээш насанд 98.9 байна.



Зураг 3. 16 Эхийн эндэгдэл, 100 000 амьд төрөлтөд, бүсээр 2020 он



Эхийн эндэгдлийн түвшинг 100000 амьд төрөлтөд бүс нутгаар авч үзвэл хангайн болон баруун бүсэд улсын дунджаас 10.9-30.2 тохиолдлоор өндөр, харин улаанбаатар болон төвийн бүсэд улсын дунджаас 2.5-19.6 тохиолдлоор бага байна. 2020 онд зүүн бүсийн аймгуудад эхийн эндэгдлийн тохиолдол бүртгэгдээгүй байна.

### 3.1.5 ТӨРСӨН НЯРАЙН МЭДЭЭЛЭЛ

2020 онд нийт 76261 хүүхэд амьд төрсөн нь өмнөх онтой харьцуулахад 1962 хүүхдээр буюу 2.5 хувиар буурсан байна. Амьд төрсөн хүүхдийн 39 068 буюу 51.2 хувь нь хүү, 37 193 буюу 48.8 хувь нь охин байна.

Төрөх үеийн хүйсийн харьцаа 2020 онд 100 охинд ойролцоогоор 105 хөвгүүн ногдож байна. Нийт төрөлтийн 0.5 хувийг амьгүй төрөлт эзэлж байна. Амьгүй төрөлтийн түвшин (1000 нийт төрөлтөд ногдох) 2020 онд 5.4 болж, өмнөх оноос 0.2-ээр нэмэгдсэн байна.

Амьд төрсөн хүүхдийн 1847 нь хоёр ихэр, 57 нь гурван ихэр хүүхэд байгаа ба 618 хүүхэд буюу 0.8 хувь нь төрөлхийн гажигтай, 1192 хүүхэд бүтэлттэй төржээ. Мөн 6935 нярай буюу 9.1 хувь нь өвчтэй болон хүндрэлтэй төрсөн байна.

Нярайн нэн яаралтай тусламж үйлчилгээний тайлангаас харахад нийт амьд төрсөн нярайн 80.9 хувийг төрөнгүүт нь эхтэй нь арьс- арьсаар шүргэлцүүлсэн ба үүнээс 67 хувь нь төрсний дараа эхтэй нь 90 минутаас дээш хугацаанд арьс арьсаар шүргэлцүүлсэн гэсэн статистик тайлан гарчээ.

Мөн 56.1 хувийг усанд оруулсан ба 77.8 хувийг төрсний дараах 1 минутын дотор эхийн цээжин дээр байрлуулсан ба үүнээс 56.2 хувийг төрсний дараа 90 минутаас дээш хугацаанд эхийн цээжин дээр байрлуулсан байна.

Нийт амьд төрсөн нярайн 99.6 хувь нь төрсний дараах 24 цагийн дотор БЦЖ, гепатит, халдварт саагийн вакцин хийлгэжээ.

Амьгүй төрөлтийн 413 тохиолдол бүртгэгдсэн нь 1000 нийт төрөлтөд 5.4 байгаа ба онтой харьцуулахад 8 тохиолдлоор нэмэгдсэн байна.

## Хүснэгт 3. 5 Төрсөн хүүхдийн мэдээ, бүсээр, 2020 он

Бүсээр	Төрсөн хүүхэд				Нийт төрөлтөд	
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа /100-д/	Бага жинтэй хүүхдийн эзлэх хувь	Амьгүй төрөлтийн түвшин /1000 төрөлтөд/
Баруун бүс	9939	5165	4774	108.2	4.5	5.9
Төвийн бүс	9453	4851	4602	105.4	3.1	5.1
Хангайн бүс	12161	6157	6004	102.5	3.7	5.4
Зүүн бүс	4929	2526	2403	106.4	3.2	4.0
Аймгийн дүн	36482	18699	17783	105.3	3.7	5.3
Улаанбаатар	39779	20369	19410	104.9	5.2	5.5
Улсын дүн	76261	39068	37193	105.1	4.5	5.4

Шинээр төрсөн хүүхдийг нярай үед нь буюу төрсний дараах нэг сар хүртэлх хугацаанд нь хамрагдвал зохих эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээнд хамруулснаар амьдрах боломжийг нэмэгдүүлж, хэвийн өсөлт хөгжилтэй, эрүүл саруул өсөж торних үндэс болдог.

Албан ёсны статистик үзүүлэлтээр төрөөд нэг цагийн дотор хөхөө амласан хүүхдийн хувь 96.5 байна.

Хүүхдийн төрөх үеийн жин зөвхөн эхийн эрүүл мэнд, хоол тэжээлийн байдлыг илтгээд зогсохгүй, нярайн эсэн мэнд торних, өсч хөгжих, удаан хугацаанд эрүүл байх, нийгэм, сэтгэл зүйн хувьд зөв хүн болж төлөвших үндэс болдог.

Бага жинтэй төрөлт (2500 граммаас бага) хүүхдийн эрүүл мэндэд маш олон эрсдэлийг авчирдаг. Эхийн хэвлийд байхдаа хоол тэжээлийн дуталтай байсан хүүхэд амьдралынхаа эрт үед эндэх өндөр эрсдэлтэй байдаг. Эсэн мэнд амьдарч чадсан ч дархлааны тогтолцооны хэвийн үйл ажиллагаа алдагдах, амьдралынхаа туршид өвчлөх өндөр эрсдэлтэй, тэжээлийн дуталд өртөх, булчингийн хүч багатай байх магадлалтай ажээ.

2020 оны байдлаар нийт амьд төрсөн хүүхдийн 3413 нярай буюу 4.5 хувь нь 2500 грамаас доош жинтэй төрсөн нь 2010 онтой харьцуулахад 494 тохиолдлоор нэмэгдсэн байна.

## Зураг 3. 17 Бага жинтэй /2500гр-аас доош/ төрсөн хүүхдийн тоо, хувь, 2010-2020 он



2020 оны байдлаар амьд төрсөн нярайн жинг хүйсээр харьцуулан харвал: төрсөн эрэгтэй нярайн 4.1 хувь нь 2500 гр-аас бага жинтэй, 10.5 хувь нь 2500-3000 гр жинтэй, дийлэнх нь буюу 85.4 хувь нь 3000 граммаас дээш жинтэй төрсөн байна. Харин эмэгтэй нярайн 4.9 хувь нь 2500 гр-аас бага жинтэй, 14.0 хувь нь 2500-3000 гр жинтэй, 81.1 хувь нь 3000 граммаас дээш жинтэй төрсөн байна.



Ихэнхи эмэгтэйчүүд хүсээгүй үедээ жирэмслэсэнээс үр хөндүүлдэг. Хөгжиж буй орнуудад хүсээгүй жирэмслэлтийн 84 хувийг орчин үеийн ЖСАХ-ийн хангагдаагүй хэрэгцээтэй эмэгтэйчүүд эзэлдэг. Иймд үр хөндөлтийн хувь хэмжээ нь гэр бүл төлөвлөлтийн хөтөлбөрүүдийн үр ашгийг харуулах чухал үзүүлэлт болдог.

Үр хөндөлтийн харьцаа нь үр хөндөлтийн тоог тухайн хугацаан дахь амьд төрөлтийн тоонд харьцуулан 1000 амьд төрөлтөд ногдохоор илэрхийлдэг үзүүлэлт бөгөөд 2020 онд 191.7 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 7.3-оор буурсан байна. Үр хөндөлтийн тусгай коэффициент тухайн хугацаанд 15-49 насны 1 000 эмэгтэй тутамд ногдох үр хөндөлтийн тоог илэрхийлдэг үзүүлэлт юм.

2020 оны байдлаар үр хөндөлтийн 14622 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 191.7, нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэйд 17.8 үр хөндөлт ногдож байна.

Зураг 3. 19 Үр хөндөлтийн тохиолдол, 2009-2020 он



Үр хөндөлтийн тохиолдол өмнөх онтой харьцуулахад 1000 амьд төрөлт тутамд 6.3, төрөх насны 1000 эмэгтэйд харьцуулахад 1.1 тохиолдлоор тус тус буурсан байна.

1000 амьд төрөлтөд ногдох үр хөндөлтийн тохиолдол Өмнөговь /431/, Дархан-Уул /312.1/, Дорноговь /217/, Дорнод /209.0/ зэрэг аймгууд болон Улаанбаатар хотод /261.8/ байгаа нь улсын дунджаас өндөр байна.

2020 онд Хувийн эмнэлэгт үр хөндөлтийн 3378 тохиолдол бүртгэгдэж нийт үр хөндөлтийн 23.1 хувийг эзэлж байгаа ба өмнөх оноос 14 тохиолдлоор буюу 0.4 хувиар буурсан байна. Хожуу үеийн үр хөндөлтийн түвшин 1000 амьд төрөлтөд 8.3 байна.

Үр хөндөлт хийлгэж буй эмэгтэйчүүдийг насны бүлгээр авч үзэхэд 20-иос доош насных 4.8 хувь, 20-34 насных 66.8 хувь, 35-аас дээш насны эмэгтэйчүүд 28.4 хувийг тус тус эзэлж байна. Өмнөх онтой харьцуулахад 20-иос доош насны үр хөндөлтийн түвшин 0.2 хувиар буурсан байна. Үр хөндүүлсэн эмэгтэйчүүдийн 25.6 хувь нь төрөөгүй эмэгтэйчүүд ба анхны удаа үр хөндүүлсэн тохиолдол байна.

Үр хөндөлтийн хүндрэл 7 тохиолдол бүртгэгдсэн ба умайн агшилт суларч цус алдсан 5, умай цоорсон 2 тохиолдол бүртгэгдсэн байна.



### Хүснэгт 3. 7 Үр хөндөлт байршлаар, 2020 он

№	Эрүүл мэндийн байгууллага	Бүртгэгдсэн үр хөндөлтийн тоо	Эзлэх хувь
1	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	1556	10.6
2	Амаржих газрууд	6772	46.3
3	Дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төв	83	0.6
4	Бүсийн оношлогоо эмчилгээний төв	680	4.7
5	Аймгийн нэгдсэн эмнэлэг	2078	14.2
6	Сум, тосгоны эрүүл мэндийн төв	75	0.5
7	Хувийн эмнэлэг	3378	23.1
8	Бусад эмнэлэг	0	0.0
	<b>Бүгд</b>	<b>14622</b>	<b>100.0</b>

#### 3.1.6 ЖИРЭМСЛЭЛТЭЭС СЭРГИЙЛЭХ ОРЧИН ҮЕИЙН АРГЫН ХЭРЭГЛЭЭ (ЖСАХ)

Жирэмслэхээс сэргийлэх арга, хэрэгслийг зөв зохистой хэрэглэх нь хэт эрт, хожуу жирэмслэхээс сэргийлэх, хэт ойрхон төрөхгүй, төрөлт хоорондын зайг төлөвлөх, нийт хүүхдийн тоог хязгаарлах зэрэг боломжийг олгодог учир эмэгтэйчүүд, хүүхдийн эрүүл мэндэд нэн чухал юм.

ЖСАХ-ийг дотор нь орчин үеийн болон уламжлалт гэж ангилдаг ба орчин үеийн аргад умайн гуурсан хоолой эрэгтэй үрийн суваг боох, ерөндөг, тариа, суулгац, эм, эрэгтэй/эмэгтэй бэлгэвч, диафрагм, лаа, царцмаг болон яаралтай ууж хамгаалах эмийг ууж хамгаалах аргууд хамаардаг.

2020 онд эрүүл мэндийн статистикаар нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэйн 539 нь, 15-49 насны эмэгтэйчүүдийн 53.9 хувь нь ямар нэг жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэглэдэг байна. Нийт ЖСАХ хэрэглэж буй эмэгтэйчүүдийн 2.8 хувь буюу 12 162 нь хөгжлийн бэрхшээлтэй буюу тусгай хэрэгцээ шаардлагатай эмэгтэйчүүд байна.

Жирэмслэлтээс сэргийлэх аргын хэрэглээг төрлөөр нь авч үзэхэд бэлгэвч 29.0, ерөндөг 26.0, бэлдмэл /эм/ 21.7, тариа 8.7, бусад 8.6, суулгац/норплант/ 3.8, стерилизаци 2.5 хувийг тус тус эзэлж байна. Жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэглэж байсан эмэгтэйчүүдийн 17.0 хувь хэрэглэхээ больж 1.1 хувь нь жирэмсэлсэн байна.

2018 оны Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаагаар гэрлэсэн, эсвэл хамтран амьдрагчтай 15-49 насны эмэгтэйчүүдийн 48.1 хувь нь ЖСАХ (орчин үеийн эсвэл уламжлалт арга) хэрэглэдэг гэсэн үр дүн гарсан байна. Мөн гэрлэсэн, эсвэл хамтран амьдрагчтай бөгөөд гэр бүл төлөвлөхдөө ЖСАХ-ийн орчин үеийн арга хэрэгслийг 15-49 насны эмэгтэйчүүдийн 63.9 хувь нь хэрэглэдэг гэсэн судалгааны үр дүнд дурьджээ.

#### Хүснэгт 3. 8 ЖСАХ хэрэглэж байгаа эмэгтэйчүүдийн тоо, байршлаар, 2020 он


№	Эрүүл мэндийн байгууллага	ЖСАХ хэрэглэж буй эмэгтэйчүүдийн тоо	Эзлэх хувь
1	Өрхийн эрүүл мэндийн төв	306468	69.4
2	Сум, тосгоны эрүүл мэндийн төв	128447	29.1
3	Аймгийн нэгдсэн эмнэлэг	4163	0.9
4	Бусад	2800	0.6
	<b>Бүгд</b>	<b>441878</b>	<b>100</b>



### 3.2 ХҮҮХЭД, ӨСВӨР НАСНЫХНЫ ЭРҮҮЛ МЭНД

Монгол улсад 2020 оны байдлаар 1 114.5 мянган 15 хүртэлх насны хүүхэд байгаа бөгөөд нийт хүн амын 33.2 хувийг эзэлж байна. Үүнээс 5 хүртэлх насны хүүхэд 12.0 хувь, 5-9 насны хүүхэд 11.2 хувь, 10 хувийг 10-14 насны хүүхэд эзэлж байна.


Зураг 3. 20 15 хүртэлх насны хүүхдийн тоо, хүн амд эзлэх хувь, сонгосон онуудаар



#### 3.2.1 ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

2020 оны байдлаар хүүхдийн эмчээр мэргэшсэн нийт 725 эмч 18 хүртэлх насны хүүхдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд нэг эмчид 1537 хүүхэд ногдож байна. 2010 онтой харьцуулахад хүүхдийн эмчийн тоо 231-ээр нэмэгдсэн байна.

Зураг 3. 21 Хүүхдийн эмчийн тоо, сонгосон онуудаар



Хүүхдийн эмчийн тоо жил дараалан нэмэгдэж байгаа хэдий ч нэг эмчид ногдох хүүхдийн тоо өндөр хэвээр байгаа ба 2014, 2015 онд хүүхдийн тооноос хамаараад харьцангуй бага байгаа хэдий ч цаашид энэ тоо нэмэгдэх хандлагатай байна.

Нэг хүүхдийн эмчид ногдох хүүхдийн тоо бүсээр харьцуулан харахад ялгаатай байгаа ба зүүн бүсэд хамгийн өндөр буюу улсын дунджаас 314 хүүхдээр их байна. 2020 оны байдлаар Улаанбаатар хотод улсын дунджаас бага, хөдөө орон нутагт буюу бүх бүсүүдэд улсын дунджаас өндөр байна. Аймгуудаар харьцуулан харвал Орхон, Өмнөговь, Хэнтий, Архангай, Завхан, Дорноговь аймгуудад улсын дунджаас бага байна.



### 3.2.2 СТАЦИОНАРЫН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

1990 онд эмнэлэгт хүүхдийн хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээнд ашиглаж буй орны тоо 6384 байсан ба нийт эмнэлгийн орны 24.2 хувийг эзэлж байсан. 2010 он хүртэл хүүхдийн орны тоо буурч 2315 буюу нийт орны 13.0 хувийг эзэлж байсан ба түүнээс хойш аажмаар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

2020 оны байдлаар хүүхдийн орны тоо 3642 байгаа нь нийт улсын хэмжээнд ажиллаж байгаа орны 13.4 хувийг эзэлж байна. Хүүхдийн орны 28.6 хувь нь сум, тосгоны эрүүл мэндийн төвд, 26.9 хувь нь нийслэлийн дүүргийн нэгдсэн эмнэлэгт, 16.3 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт, 14.3 хувь нь хувийн эмнэлэгт, 6.3 хувь нь бүсийн оношлогоо, эмчилгээний төвд, 5.9 хувь нь төрөлжсөн мэргэшлийн төв, тусгай мэргэжлийн төвүүдэд, 1.6 хувь нь бусад эмнэлэгүүдэд ажиллаж хүүхдийг хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээг үзүүлж байна.

Зураг 3. 22 Хүүхдийн орны тоо, сонгосон онуудаар



2020 оны байдлаар 135.9 мянган хүүхэд эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн нь нийт хэвтэн эмчлүүлсэн хүний 16.3 хувийг эзэлж байна. Нялхас болон тав хүртэлх насны хүүхдийн өвчлөл хот, хөдөөд амьсгалын тогтолцооны өвчин тэргүүлэх шалтгаан болж байна. Нялхас болон тав хүртэлх насны хүүхдийн дунд тохиолдох амьсгалын тогтолцооны өвчлөлөөс уушгины хатгалгаа 25.4 хувь, цочмог амьсгуурстас 21.0 хувь, томуу, томуу төст өвчлөл 10.9 хувийг тус тус эзэлж байна. Хоол боловсруулах тогтолцооны өвчлөлийн дийлэнх буюу 48.5 хувийг халдварт бус суулгалт өвчин эзэлж байна.

Өсвөр насны хүүхдийн өвчлөлд амьсгал, хоол боловсруулах тогтолцооны өвчлөл ба гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг, арьс арьсан доорх эслэгийн өвчлөл, шээс бэлгийн тогтолцооны өвчлөл, халдварт ба шимэгчит зарим өвчин тэргүүлэх шалтгаан болж байна.

### 3.2.3 ИДЭВХТЭЙ ХЯНАЛТЫН МЭДЭЭЛЭЛ

Өрх, сумын эрүүл мэндийн төвийн бүтэц үйл ажиллагааны стандарт болон Эрүүл мэндийн сайдын тушаалаар нэг хүртэлх насны хүүхэд бүрийн идэвхтэй хяналтад хамруулж, тусламж үйлчилгээг байнга үзүүлж байхыг заасан байдаг. 2020 оны байдлаар нэг хүртэлх насны хүүхдийн идэвхтэй хяналтын хамралтын хувь 85.6 байгаа нь 2012 онтой харьцуулахад 15 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Эрүүл мэндийн статистик мэдээгээр 2020 онд тав хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжлийн хяналтад хамрагдсан хүүхдүүдийн 0.3 хувь нь туранхай, 0.2 хувь нь тураалтай, 0.3 хувь нь өсөлтийн хоцрогдолтой байсан байна.

Хоол тэжээлийн дутлын тархалтыг бууруулснаар урьдчилан сэргийлэх боломжтой нярай, хүүхдийн эндэгдлийг тэглэх зэрэг дэлхий нийтээр дэвшүүлсэн бусад олон чухал зорилтын хэрэгжилтэд хувь нэмэр оруулах боломжтой.

Хоол тэжээлийн байдлын гурван үзүүлэлт – насанд харьцуулсан жин, насанд харьцуулсан өндөр,

өндөрт харьцуулсан жин гэсэн хэмжүүрүүдийг жишиг хүн амын үзүүлэлтийн голчоос хазайх стандарт хазайлтын нэгжээр (z оноо) илэрхийлдэг.

Биеийн жин, насны харьцаа нь 5 хүртэлх насны хүүхдийн голч үзүүлэлтээс 2 стандарт хазайлтаас доогуур байвал дунд эсвэл хүнд зэргийн тураалтай, харин 3 СХ-аас доогуур байвал хүнд хэлбэрийн тураалтай гэж үнэлдэг. Биеийн өндрийг насанд харьцуулсан үзүүлэлт нь хүүхдийн өсөлтийг илэрхийлэх хэмжигдэхүүн юм. Хоол тэжээлийн архаг дуталд хүүхэд өртвөл хүүхдийн өсөлт удааширч үеийнхнээсээ намхан болдог.

Биеийн өндрийг насанд харьцуулсан үзүүлэлт нь 5 хүртэлх насны хүүхдийн голч утгаас 2 стандарт хазайлтаас доогуур байвал дунд эсвэл хүнд зэргийн өсөлт хоцролттой, харин 3 СХ-аас доогуур байвал хүнд хэлбэрийн өсөлт хоцролттой гэж үнэлдэг. Өсөлт хоцролт нь хүүхэд насандаа байвал зохих өндөрт хүрэхгүй буюу намхан байгааг харуулах бөгөөд энэ нь хоол тэжээлийн архаг дутлын илэрхийлэл болдог. Өсөлт хоцролт нь урт удаан хугацааны туршид хангалтгүй хооллож байсан, архаг өвчтэй болсон, олон дахин өвчилсөн зэргээс шалтгаалж үүсдэг.

Биеийн жинг өндөрт харьцуулсан үзүүлэлт нь туранхай болон илүүдэл жинтэй байдлыг илэрхийлдэг. 5 хүртэлх насны жишиг хүн амын голчоос 2 СХ доогуур байвал дунд эсвэл хүнд зэргийн туранхай, харин 3 СХ доогуур байвал хүнд хэлбэрийн туранхай гэж үнэлдэг. Хүүхэд туранхай байх нь хоол тэжээлийн хурц дутлын илэрхийлэл болно. Энэ нь ихэвчлэн улирлын байдлаас шалтгаалсан хоол хүнсний хомсдол, өвчлөлтэй холбоотой. Харин жишиг хүн амын 2 СХ дээгүүр байвал дунд болон хүнд зэргийн илүүдэл жинтэй хүүхдийг илэрхийлдэг.

2018 оны “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа”-ны үр дүнгээр Тав хүртэлх насны хүүхдийн 1.8 хувь нь тураалтай, 0.5 хувь нь хүнд хэлбэрийн тураалтай байна. Мөн тав хүртэлх насны хүүхдийн 9.4 хувь нь өсөлт хоцролттой буюу намхан, 2.3 хувь нь өсөлт зогсонгишилттой (хүнд хэлбэрийн өсөлт хоцролттой), 0.9 хувь нь туранхай буюу өндөртөө байвал зохих жингээс бага жинтэй, 10.5 хувь нь илүүдэл жинтэй байна.

### 3.2.4 ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ХОЦРОГДОЛ, БЭРХШЭЭЛ

2020 оны байдлаар улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 1 хүртэлх насны 324, тав хүртэлх насны 2048 хүүхэд байгаа нийт хүүхдийн 2 орчим хувийг эзэлж байгаа нь хэдий бага мэт боловч хүүхдийг эрт илрүүлэг үзлэгт хамруулж, хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлж эмчлэх нь өрх, сумын эрүүл мэндийн төвийн гол үйл ажиллагааны нэг юм.

Улсын хэмжээнд 5 хүртэлх насны нийт хүүхдийн 0.5 хувь, 5-9 насны хүүхдийн 0.9 хувь, 10-14 насны хүүхдийн 1.1 хувь, 15-19 насныхны 2.2 хувь нь ямар нэгэн үйл ажиллагааны бэрхшээлтэй байна.

Хүснэгт 3. 9 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, өсвөр насныхны тоо, төрлөөр, 2020 он

Хөгжлийн бэрхшээлийн төрөл	5 хүртэлх			5-9 нас			10-14 нас			15-19 нас		
	тоо	хувь	тухайн насны 1000 хүүхдэд	тоо	хувь	тухайн насны 1000 хүүхдэд	тоо	хувь	тухайн насны 1000 хүүхдэд	тоо	хувь	тухайн насны 1000 хүүхдэд
Харааны	155	7.6	0.4	308	9.4	0.8	354	11.1	1.2	477	10.7	2.2
Сонсголын	108	5.3	0.3	158	4.8	0.4	211	6.6	0.7	349	7.8	1.6
Ярианы	121	5.9	0.3	218	6.7	0.6	199	6.2	0.7	270	6.0	1.3
Хөдөлгөөний	369	18.0	1.0	645	19.7	1.7	621	19.4	2.1	807	18.0	3.8
Сэтгэцийн	351	17.1	0.9	687	21.0	1.8	700	21.9	2.4	1022	22.8	4.8
Хавсарсан	286	14.0	0.7	434	13.2	1.1	373	11.7	1.3	491	11.0	2.3
Бусад	658	32.1	1.7	827	25.2	2.2	742	23.2	2.5	1058	23.6	4.9
<b>Нийт</b>	<b>2048</b>		<b>5.4</b>	<b>3277</b>		<b>8.6</b>	<b>3200</b>		<b>10.9</b>	<b>4474</b>		<b>20.9</b>



### 3.2.5 ДАРХЛААЖУУЛАЛТЫН ХАМРАЛТ

Дархлаажуулалт нь амь насанд аюултай халдварт өвчнийг хянах, устгахад чиглэсэн шалгарсан арга бөгөөд жил бүр 2-3 сая хүний амь насыг авардаг гэсэн тооцоо бий. Энэ нь өртөг зардал хамгийн багатай эрүүл мэндийн хөрөнгө оруулалтын нэг бөгөөд хүрэхэд хамгийн хүндрэлтэй, эмзэг бүлгийн хүн амд хүртээмжтэй хүрч чаддаг хамгийн үр дүнтэй хэрэгсэл юм. ДЭМБ-ын Хүүхдийн Дархлаажуулалтын Товлолын талаарх Зөвлөмжид бүх хүүхдийг сүрьеэ, сахуу, татран, хөхүүл ханиад, саа, улаан бурхан, гепатит В, хемофилюс инфлюэнза Б, пневмококийн нян, ротавирус, улаануудын эсрэг зэрэг вакцинд хамруулахыг зөвлөмж болгосон.


2001 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар УИХ дархлаажуулалтын тухай хуулийг баталсан. Дархлаажуулалтын арав хоногийн аяныг хоёр жилд нэг удаа улсын хэмжээнд зохион байгуулж байгаа ба өрх, сумын эрүүл мэндийн төв, багийн эмч, сувилагч нар хүүхдэд вакцинжуулах хөтөлбөрийг зохион байгуулдаг.

Манай Улсад 2005 оноос өмнө хүүхдийг сүрьеэ, сахуу, хөхүүл ханиад, татрангийн гуравт, улаан бурхан, хепатит В-гийн болон улаан бурханы вакцинаар дархлаажуулж байсан. 2005 оноос хойш сахуу, хөхүүл ханиад, татран, В вирүст хепатит, Хиб-ийн таван вакциныг нэгтгэсэн нэг вакциныг үе шаттайгаар нэвтрүүлж, 2009 оноос улаанбурхан, гахайн хавдар, улаануудын эсрэг нийлсэн нэг вакциныг “Заавал хийх дархлаажуулалтын үндэсний товллол”-д шинээр оруулсан. Харин 2011 оноос А вирүст хепатитийн эсрэг вакциныг “Заавал хийх дархлаажуулалтын үндэсний товллол”-д шинээр оруулсан

Нэг хүртэлх насны хүүхдийн дархлаажуулалтыг 2020 оны байдлаар сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулан харахад төрсний дараа 24 цагийн дотор хийдэг сүрьеэгийн эсрэг (БЦЖ) вакцины хамралт 0.2 пункт, халдварт саагийн эсрэг вакциных 0.1 пункт, гепатит В-ийн эсрэг вакцины хамралт 0.6 пунктээр тус тус өссөн байна. Хүүхдэд 2 сартайгаас эхэлж 3 тун хийдэг тавт вакцины (сахуу, хөхүүл ханиад, татран, гепатит В, хемофилюс инфлюэнз В өвчний эсрэг вакцин) 3 дугаар тунгийн хамралт 0.1 пунктээр буурч, 9 сартай хийдэг УГУ (улаанбурхан, гахайн хавдар, улаануудын хавсарсан вакцин )-ын эсрэг вакцины хамралт 0.3 пунктээр нэмэгдсэн байна.

Амьдралын эхний 2-4 сартай нярай хүүхдэд саагийн эсрэг вакцинжуулалтын хамрах хүрээ 96.7% -д, тавт вакцин 96.9%-д тус тус хүрчээ. Амьдралын эхний 9 сартайд нярай хүүхдийн 98.0% нь саа, улаанбурхан, гахайн хавдар, улаанууд өвчний эсрэг дархлаажуулалтад хамрагджээ.

Зураг 3. 23 Заавал хийх дархлаажуулалтын хамралтын хувь, 2011-2020 он



### 3.2.6 ХҮҮХДИЙН ӨВЧЛӨЛ

2011-2020 оны байдлаар хүн амын нийт өвчлөлд хүүхдийн өвчлөл дундажаар 29.1%-ийг эзэлж байна. Хүүхдийн өвчлөлийг сүүлийн 10 жилийн дундажаар тухайн насны 1000 хүн амд тооцож үзэхэд 15 хүртэлх насны хүүхдийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан нь амьсгалын тогтолцооны өвчин байгаа бөгөөд удаах шалтгаанд хоол боловсруулах тогтолцооны өвчин эзэлж байгаа ба 15-19 насанд нэгдүгээр шалтгаанд хоол боловсруулах тогтолцооны өвчин, хоёрдугаарт амьсгалын тогтолцооны өвчин удаах байранд орж байна. Хүүхдийн өвчлөлийн хамгийн гол шалтгаан нь уушгины хатгалгаа, шүд цоорох өвчин байна.

Насны ангилал тус бүрээр харуулбал, сүүлийн 10 жилийн дундажаар тухайн насны 1000 хүн амд тооцож үзэхэд 1 хүртэлх насны хүүхдийн өвчлөлийн нэгдүгээр шалтгаанд амьсгалын тогтолцооны өвчин, хоёрдугаарт хоол боловсруулах тогтолцооны өвчин, гуравдугаарт перинаталь эмгэг, дөрөвдүгээрт арьсны өвчин, тавдугаарт мэдрэлийн тогтолцооны өвчин эзэлж байна.

1-4 насанд нэгдүгээр шалтгаанд амьсгалын тогтолцооны өвчин, хоёрдугаарт хоол боловсруулах тогтолцооны өвчин, гуравдугаарт арьсны өвчин, дөрөвдүгээрт гэмтэл, хордлого ба гадны шалтгаант эмгэг, тавдугаарт халдварт өвчин эзэлж байна.

5-9 насанд нэгдүгээр шалтгаанд амьсгалын тогтолцооны өвчин, хоёрдугаарт хоол боловсруулах тогтолцооны өвчин, гуравдугаарт арьсны өвчин, дөрөвдүгээрт гэмтэл, хордлого ба гадны шалтгаант эмгэг, тавдугаарт чихний өвчин,

10-14 насанд нэгдүгээр шалтгаанд амьсгалын тогтолцооны өвчин, хоёрдугаарт хоол боловсруулах тогтолцооны өвчин, гуравдугаарт арьсны өвчин, дөрөвдүгээрт шээс бэлгийн тогтолцооны өвчин, тавдугаарт мэдрэлийн тогтолцооны өвчин,

15-19 насанд нэгдүгээр шалтгаанд хоол боловсруулах тогтолцооны өвчин, хоёрдугаарт амьсгалын тогтолцооны өвчин, гуравдугаарт арьсны өвчин, дөрөвдүгээрт гэмтэл, хордлого ба гадны шалтгаант эмгэг, тавдугаарт шээс бэлгийн тогтолцооны өвчин тус тус тэргүүлэх 5 шалтгаан болж байна.

1 хүртэлх насны хүүхдийн амьсгалын тогтолцооны өвчлөл 0-19 насны хүүхдийн өвчлөлд хамгийн их тохиолдож байгаа ба байршлаар нь 2011-2020 оны байдлаар харьцуулахад Дорноговь, Говьсүмбэр, Өмнөговь, Архангай, Булган, Сүхбаатар, Увс, Хэнтий, Баянхонгор, Дархан-уул, Төв аймгуудад улс болон аймгийн дундажаас дээгүүр байна.

Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны хүүхдийн өвчлөлийн шалтгааныг насны бүлгээр, 10000 хүн амд харьцуулж харахад 1 хүртэлх насны хүүхдийн өвчлөлд нэгдүгээрт халдварт бус гэдэсний өвчин, хоёрдугаарт ходоод гэдэсний өвчин, гуравдугаарт шүд амны хөндийн эрхтэний өвчин, 1-4 насанд нэгдүгээрт халдварт бус гэдэсний өвчин, хоёрдугаарт шүд ба амны хөндийн эрхтэний өвчин, гуравдугаарт ходоод гэдэсний өвчин, 5-9 насанд нэгдүгээрт шүд ба амны хөндийн эрхтэний өвчин, хоёрдугаарт халдварт бус гэдэсний өвчин, гуравдугаарт мухар олгойн өвчин, 10-14 насанд нэгдүгээрт шүд ба амны хөндийн эрхтэний өвчин, хоёрдугаарт мухар олгойн өвчин, гуравдугаарт ходоод гэдэсний өвчин, 15-19 насанд нэгдүгээрт шүд ба амны хөндийн эрхтэний өвчин, хоёрдугаарт ходоод гэдэсний өвчин, гуравдугаарт мухар олгойн өвчин тус тус эзэлж байна.

1 хүртэлх насны хүүхдийн арьс халимын өвчлөлийг сүүлийн 10 жилийн дундажаар, 10000 хүн амд харьцуулан тооцож харахад Дорноговь, Сүхбаатар, Өмнөговь, Дархан-уул, Улаанбаатар хот, Баянхонгор, Өвөрхангай, Говь-алтай, Архангай аймагт улс, аймгийн дундаж(1121;927)--аас дээгүүр байна.

Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг 1-4, 5-9, 15-19 насны хүүхдийн өвчлөлийн гуравдугаар шалтгаан болж байна.

Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг дотор биеийн өвөрмөц, өвөрмөц бус ба олон бүс хэсгийн бусад бэртлүүд, түлэгдэл, оглорол, гавал доторх бэртэл, биеийн өвөрмөц



ба олон бүс хэсэг сунах, тулах мултрах гэмтлүүд зонхилон тохиолдож байна.

2020 оны байдлаар харахад хүүхдийн өвчлөлд 1-14 насны хүүхдэд амьсгалын тогтолцооны өвчин, 15-19 насанд хоол боловсруулах тогтолцооны өвчин тэргүүлж байна.

Нэг хүртэлх насны хүүхдэд бүртгэгдсэн төрөлхийн гажгийн 4243 тохиолдлоос зүрх, цусны эргэлтийн тогтолцооны төрөлхийн гажиг 25.4 хувь, шээс ялгаруулах тогтолцооны төрөлхийн гажиг 10.7 хувь, сэтэрхий уруул ба тагнай 8.5 хувь, хоол боловсруулах тогтолцооны төрөлхийн гажиг 5.7 хувь, түнхний төрөлхийн гажиг 4.1 хувьтай тэргүүлэх байрыг эзэлж байна.

*Хүснэгт 3. 10 Хүүхдийн өвчлөл, 1000 хүн амд ногдохоор, 2011-2020 оны дундажаар*

Өвчний нэршил	1 хүртэлх	1-4 нас	5-9 нас	10-14 нас	15-19 нас
Халдварт өвчин	567	414	203	138	238
Хавдар	45	24	20	21	29
Цус төлжүүлэх эрхтэний өвчин	131	44	37	28	24
Дотоод шүүрэл, бодисын солилцоо	311	64	23	31	34
Сэтгэцийн эмгэг	4	11	27	34	56
Мэдрэлийн эмгэг	1088	128	123	189	300
Нүдний өвчин	459	226	182	179	182
Чихний өвчин	934	310	204	162	124
Зүрх судасны өвчин	20	10	15	43	134
Амьсгалын тогтолцооны өвчин	11655	5309	1615	1165	796
Хоол боловсруулах тогтолцооны эмгэг	2394	1169	1308	1024	986
Арьсны өвчин	1128	754	477	493	594
Яс, булчингийн тогтолцооны эмгэг	23	27	34	67	104
Шээс бэлгийн тогтолцооны өвчин	99	167	188	249	518
Жирэмсэн, төрөх, төрсний дараах үе	0	0	0	2	286
Перинаталь эмгэг	1549	0	0	0	0
Төрөлхийн гажиг	317	80	55	34	29
Шинж тэмдэг	83	42	46	36	14
Гэмтэл, хордлого, гадны шатгаан	339	564	395	493	551
Нийт	21154	9359	4969	4403	5010
1-рт					
2-рт					
3-рт					
4-рт					
5-рт					



Хүснэгт 3. 11 Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөлийн шалтгаан, (хот,хөдөө) 2020 он

Үзүүлэлт	1 хүртэлх насны		5 хүртэлх насны	
	Хот	Хөдөө	Хот	Хөдөө
Амьсгалын тогтолцооны өвчин	23.4	56.8	27.0	57.1
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	14.5	13.5	14.9	16.0
Перинаталь үед үүссэн зарим эмгэг	16.8	6.4	7.1	2.5
Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг	3.0	0.9	10.1	2.1
Халдварт ба шимэгчит зарим өвчин	1.5	0.7	3.6	1.6
Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин	8.1	6.1	10.9	7.8
Чих ба хөхлөг сэртэнгийн өвчин	5.6	5.7	4.2	5.1
Мэдрэлийн тогтолцооны өвчин	9.5	3.8	4.6	2.0
		Тэргүүлэх шалтгаан		
		Хоёрдугаар шалтгаан		
		Гуравдугаар шалтгаан		


Хүснэгт 3. 12 Хүүхэд, өсвөр үеийнхний өвчлөлийн тэргүүлэх шалтгаан, насны бүлгээр, тухайн насны 10 000 хүүхдэд, 2020 он

Үзүүлэлт	1-4 нас	5-9 нас	10-14 нас	15-19 нас
Амьсгалын тогтолцооны өвчин	2923.5	1952.2	1964.4	1431.6
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	1081.2	2204.3	2390.7	2340.2
Халдварт ба шимэгчит зарим өвчин	230.9	156.3	133.6	264.4
Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг	564.7	631.2	866.0	887.5
Чих ба хөхлөг сэртэнгийн өвчин	229.6	370.9	386.2	259.3
Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин	711.0	860.1	1188.4	1265.0
		Тэргүүлэх шалтгаан		
		Хоёрдугаар шалтгаан		
		Гуравдугаар шалтгаан		

Нэг хүртэлх насны хүүхдийн дунд бүртгэгдсэн амьсгалын тогтолцооны өвчлөлийн тохиолдол 10 жилийн дундажаар, 10000 хүүхдэд ногдохоор харьцуулж үзэхэд Улаанбаатар хотод улс, аймгийн түвшингээс 2706-5224-өөр бага түвшинд байна.




Зураг 3. 24 Амьсгалын тогтолцооны өвчин, 10000 хүн амд, насны бүлгээр, 2011-2020 он



Нэг хүртэлх насны хүүхдийн амьсгалын тогтолцооны өвчлөл хүүхдийн өвчлөлд хамгийн өндөр тохиолдож байгаа ба байршлаар нь 2011-2020 оны байдлаар харьцуулахад Дорноговь, Говьсүмбэр, Өмнөговь, Архангай, Булган, Сүхбаатар, Увс, Хэнтий, Баянхонгор, Дархан-уул, Төв аймгуудад улс болон аймгийн дунджаас дээгүүр үзүүлэлттэй байна.

Зураг 3. 25 Нэг хүртэлх насны хүүхдийн амьсгалын тогтолцооны өвчлөл, тухайн насны 10000 хүүхдэд, сүүлийн 10 жилийн дундаж




### 3.2.7 НЯЛХАС БОЛОН НЯРАЙН ЭНДЭГДЭЛ

Тогтвортой хөгжлийн зорилтод 2030 онд сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эхийн эндэгдлийн түвшинг 100000 амьд төрөлтөд 15, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 9, нялхсын эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 8 болгож бууруулах зорилтыг дэвшүүлсэн байна.


Улсын хэмжээнд 1965 онд 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин 70.3 байсан бол 1980 онд 78.8 болж өссөн. 1980 оноос хойш нялхсын эндэгдлийн түвшин тууштай буурч 1990 онд 64.4 болсон ба 2000 онд 32 болж 2 дахин буурсан байна. 1990 оноос хойш нялхсын эндэгдлийн түвшин тууштай буурч байгаа ба 2020 оны байдлаар 11.5 болсон байна.

Зураг 3. 26 Нялхсын эндэгдлийн түвшин, 1000 амьд төрөлтөд бүсээр, сонгосон онуудаар



Нярайн эндэгдлийн түвшин 2020 онд 7.3 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 3.3-ээр буурсан байна. 2020 онд нярайн эндэгдэл нялхсын эндэгдлийн 67.9 хувийг эзэлж байгаа нь сүүлийн 10 жилийн дунджаас 1.5 пунктээр нэмэгдсэн байна.

Зураг 3. 27 Нялхсын эндэгдэлд нярайн эндэгдлийн эзлэх хувь





Хүснэгт 3. 13 Амьгүй төрөлт, перинаталь болон нярайн эндэгдлийн түвшин, 2010-2020 он


Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Нярайн эндэгдэл /1000 амьд төрөлтөд/											
Аймгийн дундаж	12.2	11.8	10.3	9.6	9.5	9.9	9.1	8.5	8.1	8.3	7.8
Улаанбаатар хот	11	8.5	9.9	9.7	10.4	10.4	9.3	8.9	9.2	8.0	8.3
Улсын дундаж	11.6	10.2	10.1	9.7	10.0	10.2	9.2	8.7	8.7	8.6	7.3
Эрэгтэй	13.1	10.8	11.3	10.6	11.2	11.6	10.5	9.8	9.9	9.4	8.7
Эмэгтэй	10.1	9.6	8.8	8.6	8.8	8.7	7.8	7.6	7.3	7.1	6.9
Амьгүй төрөлт /1000 нийт төрөлтөд/											
Аймгийн дундаж	8.4	8.0	7.0	6.9	6.6	5.8	5.9	5.5	4.7	4.4	5.3
Улаанбаатар хот	6.1	6.0	6.5	6.5	6.2	7.8	6.5	6.6	6.4	5.9	5.5
Улсын дундаж	7.3	7.0	6.7	6.7	6.4	6.8	6.2	6.0	5.6	5.2	5.4
Перинаталь эндэгдэл /1000 нийт төрөлтөд/											
Аймгийн дундаж	18.2	17.4	14.6	14.4	14.3	13.5	12.6	11.9	10.8	10.6	10.4
Улаанбаатар хот	15.4	13.2	14.3	14.3	14.7	15.6	13.2	12.9	12.8	11.4	11.2
Улсын дундаж	16.9	15.4	14.5	14.4	14.5	14.6	12.9	12.4	11.9	11.0	11.0

Перинаталь эндэгдлийн түвшин 2020 онд 11.0 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 2.9-оор буурчээ. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт болох нярайн эндэгдлийн болон перинаталь эндэгдлийн түвшин 2020 онд хүрэх зорилтоо хангаад байна.

Нярайн эндэгдлийн шалтгааныг сүүлийн 10 жилийн байдлаар харуулбал, перинаталь үед үүссэн эмгэг тэргүүлж, 2020 оны байдлаар 492 тохиолдол буюу 82.6 хувь болж, сүүлийн 10 жилийн дунджаас 1, өмнөх оноос 2.5 пунктээр тус тус нэмэгдсэн байна.

Перинаталь үед үүссэн эмгэгт нярайн бүтэлт, нярайн тархины ишеми, нярайн өвөрмөц халдварууд зонхилох шалтгаан болж байна. Хүүхдийн эндэгдлийн шалтгаанд перинаталь эндэгдэл хамгийн өндөр байгаа нь жирэмсний хяналт, төрөх үеийн тусламж үйлчилгээтэй шууд холбоотой байдаг тул жирэмсэн эхийн эрүүл мэндийг үйлчилгээг сайжруулах талаар анхаарч ажиллах шаардлагатай нь харагдаж байна.


Зураг 3. 28 Нярайн эндэгдлийн шалтгаан, Төрөх тойрны /перинаталь/ үед үүсэх зарим оёг, 2010-2020 он



Нярайн эндэгдлийн 2-р гол шалтгаан нь Төрөлхийн гажиг, гаж хөгжлийн шалтгаант эндэгдэл эзэлж байгаа ба 2020 оны байдлаар 73 тохиолдол бүртгэгдэж нярайн эндэгдлийн шалтгааны 12.2 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 6, өмнөх оноос 22 тохиолдлоор буурсан байна. Төрөлхийн гажгийн шалтгаант эндэгдэлд зүрхний төрөлхийн гажиг, хромосомын эмгэгүүд дийлэнх хувийг эзэлж байна.

Төрөлхийн гажиг хөгжлийн улмаас нярайн 12.2 хувь нь эндэж байгаа нь жирэмснийг эрт илрүүлж, жирэмсэн үед 6 ба түүнээс дээш удаа эмчийн хяналтад хамруулж, эрхтэн тогтолцооны эмгэгийг эрт илрүүлж эмчлэх шаардлагатай байгааг харуулж байна.


Зураг 3. 29 Нярайн эндэгдлийн шалтгаан, Төрөлхийн гажиг, гаж хөгжил, 2010-2020 он



Нярайн эндэгдлийн 3-р гол шалтгаан нь Амьсгалын тогтолцооны эмгэгийн шалтгаант эндэгдэл эзэлж байгаа ба 2020 оны байдлаар 9 тохиолдол бүртгэгдэж нярайн эндэгдлийн 1.4 хувийг эзэлж байна.

Сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 1 хувиар буурч, өмнөх оноос 2 тохиолдлоор нэмэгдсэн байна. Амьсгалын тогтолцооны эмгэгийн шалтгаант эндэгдэлд уушгины хатгалгаа дийлэнх хувийг эзэлж байна.

Зураг 3. 30 Нярайн эндэгдлийн шалтгаан, Амьсгалын тогтолцооны эмгэг, 2010-2020 он




Нярайн эндэгдлийн 4-р гол шалтгаан нь Осол гэмтэл, гадны шалтгаант эндэгдэл эзэлж байгаа ба 2020 оны байдлаар 11 тохиолдол бүртгэгдэж нярайн эндэгдлийн 1.7 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 2 тохиолдлоор буюу 0.3 хувиар буурсан байна.



Осол гэмтэл, гадны шалтгаант эндэгдэлд амьсгалын зам тодорхойгүй шалтгаанаар бөглөрөх / хөхөөр дарагдах/ шалтгаан тэргүүлж байна.

**Зураг 3. 31 Нярайн эндэгдлийн шалтгаан, Осол гэмтэл, гадны шалтгаан, 2010-2020 он**



**Хүснэгт 3. 14 Эрт нярайн эндэгдлийн тэргүүлэх 5 шалтгаан, тоо, 2010-2020 он**

Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Төрөх тойрны үед үүсэх зарим оёг	556	494	520	511	573	559	448	420	415	394	384
Төрөлхийн гажиг хэв гажил, өнгөт цогцын гажуудал	63	74	76	84	72	49	57	37	47	59	42
<b>Осол гэмтэл, гадны шалтгаан</b>	<b>7</b>	<b>2</b>	<b>4</b>	<b>6</b>	<b>3</b>	<b>2</b>	<b>8</b>	<b>6</b>	<b>10</b>	<b>1</b>	<b>4</b>
<b>Халдварт ба шимэгчит зарим өвчин</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>7</b>	<b>3</b>	<b>8</b>	<b>17</b>	<b>13</b>	<b>9</b>	<b>10</b>	<b>7</b>	<b>8</b>
Амьсгалын тогтолцооны өвчин	8	18	3	7	3	0	0	0	1	0	0

**Хүснэгт 3. 15 Хожуу нярайн эндэгдлийн тэргүүлэх 5 шалтгаан, тоо, 2010-2020 он**

Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Төрөх тойрны үед үүсэх зарим оёг	75	75	99	100	113	159	128	112	126	124	108
Төрөлхийн гажиг хэв гажил, өнгөт цогцын гажуудал	21	17	12	30	17	26	35	42	33	36	31
<b>Осол гэмтэл, гадны шалтгаан</b>	<b>7</b>	<b>9</b>	<b>6</b>	<b>6</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>9</b>	<b>8</b>	<b>12</b>	<b>10</b>	<b>7</b>
<b>Халдварт ба шимэгчит зарим өвчин</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>2</b>
Амьсгалын тогтолцооны өвчин	19	18	19	11	15	0	13	6	6	9	6




### 3.2.8 ТАВ ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ

“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтэд 2020 он гэхэд 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 15 болгох зорилт тавьсан бөгөөд 2019 онд 16 болж хараахан биелээгүй, харин нялхсын эндэгдлийн түвшинг 13 болгох, нярайн эндэгдлийн түвшинг 9 болгох зорилт тус бүр 2019 оны байдлаар биелсэн байна.

ДЭМБ-аас гаргасан “Дэлхийн эрүүл мэндийн статистик 2018” тайланд Номхон далайн баруун бүсийн нийт 27 улсын 5 хүртэлх насны болон нярайн эндэгдлийн түвшинг 2016 оны байдлаар тооцсон бөгөөд Монгол Улс хүүхдийн эндэгдлийн түвшингээр 13 дугаарт эрэмбэлэгджээ

Нялхсын эндэгдлийн түвшин 2020 онд 11.5 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 5-аар, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 14.0 болж, 3-аар тус тус буурсан байна. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтэд 2020 он гэхэд нялхсын эндэгдлийн түвшинг 13 болгох зорилтыг 2020 оны байдлаар биелүүлсэн байна.

Зураг 3. 32 Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 1000 амьд төрөлтөд, сонгосон онуудаар




Нялхсын эндэгдэл сүүлийн сүүлийн 10 жилийн байдлаар харахад тодорхой түвшинд буурч, 2020 оны байдлаар 1000 амьд төрөлтөд ногдох эндэгдэл 11.5 болж хамгийн бага түвшинд хүрсэн байна.

2020 оны байдлаар нялхсын эндэгдлийн 878 тохиолдол бүртгэгдсэнээс 727 тохиолдол буюу 82.8 хувь нь эмнэлэгт нас барсан ба үүнээс 26.8 хувь нь хоног болоогүй нас баралт эзэлж байна.




Зураг 3. 33 Нялхсын эндэгдэл, 1000 амьд төрөлтөд, хүйсээр, 2010-2020 он




Эмнэлэгт хоног болоогүй нас баралтын хувь сүүлийн 10 жилийн дунджаар 28.4 хувь байгаа ба 2020 онд 10 жилийн дунджаас 1.6 хувиар бага байгаа ба өмнөх оноос 1.6 хувиар нэмэгдсэн байна. Хоног болоогүй нас баралтын шалтгаанд 2020 оны байдлаар 73 хувийг перинаталь үеийн эмгэг эзэлж байна.

Зураг 3. 34 Эмнэлгийн нас баралтын тоо, хоног болоогүй нас баралтын хувь, 2010-2020 он




Сүүлийн 10 жилийн дунджаар нялхсын эндэгдлийн 190 тохиолдол буюу 16.4 хувь нь эмнэлгийн тусламж аваагүй гэртээ эндсэн байна. 2020 онд 134 тохиолдол буюу 15.9 хувь нь гэртээ эндсэн байна.

Зураг 3. 35 Гэрийн эндэгдлийн тохиолдол, хувь, 2010-2020 он



2020 оны байдлаар нялхсын гэрийн эндэгдлийн шалтгаанд 30.5 хувь нь осол гэмтэл, гадны шалтгаант эмгэг, 27.5 хувийг уушгины хатгалгаа, 11.5 хувийг төрөлхийн гаж хөгжил, 8.5 хувийг нярайн гэнэтийн эндэл, 5.0 хувийг хүүхдийн тархины саажилт эзэлж нийт гэрийн эндэгдлийн 83 хувийг эзэлж байна.

Зураг 3. 36 Гэрийн эндэгдлийн шалтгаан, 2020 он




Осол гэмтэл, гадны шалтгаант эмгэг 30 хувийг эзэлж байгаа ба үүнээс орон дотроо санамсаргүй амьсгал боогдох, дарагдах шалтгаан 50 хувь, хоол хүнсний зүйлд хахах, амьсгал боогдох 21.1 хувь, зам тээврийн осол 8 хувийг тус тус эзэлж байна. Гэртээ эндсэн хүүхдийн шалтгааны дийлэнх буюу 81 хувь нь сэргийлж болох эндэгдэл байна.

Нялхсын эндэгдлийн шалтгааныг сүүлийн 10 жилийн байдлаар харвал перинаталь үед үүссэн зарим эмгэг тэргүүлж, 2020 оны байдлаар 505 тохиолдол буюу 57.5 хувийг эзэлж

байна. Перинаталь үед үүссэн эмгэгт нярайн бүтэлт, нярайн тархины ишеми, нярайн өвөрмөц халдварууд зонхилох шалтгаан болж байна.

Нялхсын эндэгдлийн шалтгааныг өмнөх онтой харьцуулахад перинаталь үеийн эмгэгийн улмаас эндсэн эндэгдэл 0.1 пунктээр, амьсгалын тогтолцооны өвчин 1.6 пунктээр буурч, төрөлх гажиг, гаж хөгжил ба хромосомын эмгэг 1.9 пунктээр нэмэгдсэн байна.


Зураг 3. 37 Перинаталь эндэгдэл, бодит тоо, хувь, 2010-2020 он



Нялхсын эндэгдлийн 2-р гол шалтгаан нь Амьсгалын тогтолцооны эмгэгийн шалтгаант эндэгдэл эзэлж байгаа ба 2020 оны байдлаар 58 тохиолдол бүртгэгдэж нялхсын эндэгдлийн 6.6 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 102 тохиолдлоор, өмнөх оноос 76 тохиолдлоор тус тус буурсан байна




**Зураг 3. 38 Амьсгалын тогтолцооны эмгэгийн шалтгаант эндэгдэл, 2010-2020 он**



Амьсгалын тогтолцооны эмгэгийн шалтгаант эндэгдэлд уушгины хатгалгаа дийлэнх хувийг эзэлж байна. Сүүлийн жилүүдэд уушигны хатгалгаа өвчний улмаас эндэх тохиолдол буурч байгаа хэдий ч гэрийн эндэгдлийн голлох шалтгаан болж байна.

**Зураг 3. 39 Уушгины хатгалгаа өвчний улмаас эндсэн нялхсын тоо, хүйсээр, 2010-2020 он**



### 3.2.9 ХҮҮХЭД, ӨСВӨР НАСНЫХНЫ НАС БАРАЛТЫН ШАЛТГААН

2010 онд 0-19 насны хүүхдийн эндэгдлийн 2048 тохиолдол буюу тухайн насны 10 000 хүүхдэд 19.9 тохиолдол бүртгэгдэж байсан бол 2020 оны байдлаар 1442 тохиолдол буюу 10 000 хүүхдэд 11.2 байгаа нь 2010 онтой харьцуулахад 606 тохиолдол, 10 000 хүүхдэд 8.7 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна.

0-19 насны хүүхдийн эндэгдлийг насны бүлгээр эзлэх хувийг тооцож үзэхэд сүүлийн 10 жилийн байдлаар 60.2-65.7 хувийг нялхсын эндэгдэл эзэлж байна.


2010 оны байдлаар хүүхдийн эндэгдлийн 62.3 хувийг нялхсын эндэгдэл, 16.9 хувийг 1-4 насны, 4.8 хувийг 5-9 насны, 5.5 хувийг 10-14 насны, 10.5 хувийг 15-19 насны хүүхдийн эндэгдэл эзэлж байна.

2020 онд энэ үзүүлэлт 60.9 хувийг нялхсын эндэгдэл, 13 хувийг 1-4 насны, 6.9 хувийг 5-9 насны, 8 хувийг 10-14 насны, 11.2 хувийг 15-19 насны хүүхдийн эндэгдэл эзэлж байна.

Хүүхдийн эндэгдлийн шалтгааныг нийт дүнгээр харьцуулан харахад нас баралтын 1-р шалтгаан нь перинаталь үеийн эмгэг байгаа бөгөөд насны ангилал тус бүрээр харьцуулахад ангилал тус бүрээр ялгаатай байна.


Хүүхдийн эндэгдэл сүүлийн жилүүдэд харьцангуй буурч байгаа жишгийн дагуу 10 000 хүүхдэд ногдох эндэгдлийн шалтгаан тасралтгүй буурсан үзүүлэлттэй байгаа хэдий ч төрөлхийн гажиг, хромосомын эмгэг, мэдрэлийн тогтолцооны эмгэгийг шалтгаант нас баралт төдийлэн буураагүй зураглал харагдаж байна.

Зураг 3. 40 0-19 насны хүүхдийн эндэгдлийн тэргүүлэх 5 шалтгаан, 10 000 хүүхдэд, 2010-2020 он




2010 онд 5-9 насны хүүхдийн эндэгдлийн 99 тохиолдол буюу тухайн насны 10 000 хүүхдэд 4.3 тохиолдол бүртгэгдэж байсан бол 2020 оны байдлаар 100 тохиолдол буюу 10 000 хүүхдэд 2.6 байгаа нь 2010 онтой харьцуулахад 10 000 хүүхдэд 1.7 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 3. 41 5-9 насны хүүхдийн эндэгдлийн тохиолдол, 10 000 хүүхдэд, 2010-2020 он







Зураг 3. 42 5-9 насны хүүхдийн эндэгдлийн тэргүүлэх шалтгаан, 10 000 хүүхдэд, 2010-2020 он



Зураг 3. 43 10-14 насны хүүхдийн эндэгдлийн тохиолдол, 10 000 хүүхдэд, 2010-2020 он




Зураг 3. 44 10-14 насны хүүхдийн эндэгдлийн тэргүүлэх шалтгаан, 10 000 хүүхдэд, 2010-2020 он




2020 онд бүртгэгдсэн 10-19 насны хүүхэд, залуучуудын нас баралтын шалтгааны 50 хувиас илүү нь осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт эзэлж байгаа ба үүнээс 15-19 насныхны 80 хувь орчим нь осол гэмтэл, гадны шалтгааны улмаас амиа алдсан байна. Мөн 10-14 насны хүүхдийн 51 хувь, 5-9 насны хүүхдийн 44 хувь нь гадны шалтгааны улмаас амь насаа алдсан байна.



Зураг 3. 45 15-19 насны хүүхдийн эндэгдлийн тохиолдол, 10 000 хүүхдэд, 2010-2020 он




Зураг 3. 46 15-19 насны хүүхдийн эндэгдлийн тэргүүлэх 5 шалтгаан, 10 000 хүүхдэд, 2010-2020 он



Өсвөр үе, залуучуудын дунд амиа хорлолт тэргүүлж байгаа төдийгүй тэдгээрийн дийлэнх нь эрэгтэйчүүд байна. Тухайлбал, амиа хорлон эндсэн 10-14 насныхны 66.7 хувь, 15-19 насныхны 72.1 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна

Хэлбэрийн хувьд дийлэнх нь дүүжлэх, боймлох, амьсгал боох гэсэн аргаар амиа хорлосон байна. Осол гэмтэл, гадны шалтгаант эмгэгийн дотор амиа хорлолт, зам, тээврийн осол дийлэнх хувийг эзэлж байна. Өсвөр үе, залуучуудын дунд амиа хорлолт тэргүүлж байгаа төдийгүй тэдгээрийн дийлэнх нь эрэгтэйчүүд байна. Тухайлбал, амиа хорлон эндсэн 10-14 насныхны 66.7 хувь, 15-19 насныхны 72.1 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Хэлбэрийн хувьд дийлэнх нь дүүжлэх, боймлох, амьсгал боох гэсэн аргаар амиа хорлосон байна.



БҮЛЭГ

4

ЭМНЭЛГИЙН  
ТУСЛАМЖ  
ҮЙЛЧИЛГЭЭ

## БҮЛЭГ 4.

# ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

### 4.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ТҮҮХЭН ТОВЧОО

Дотоод яаманд Эрүүлийг хамгаалах хэлтэс байгуулагдсанаар эрүүл мэндийн байгууллагын цэг, салбар, ажиллагчдын тоо, хөрөнгийн бүртгэлийг 1925 оноос эхлэн албан ёсоор мэдээлж эхэлсэн түүхтэй. Ардын эрүүлийг хамгаалах ажлыг хариуцах төрийн байгууллага болох Эрүүлийг хамгаалах яам 1930 онд байгуулагдаж, түүний ерөнхий хэлтэст эмнэлгийн салбар цэг, хүн амын эрүүл мэндтэй холбоотой мэдээ, тайлан гаргах тоо бүртгэгчийг ажиллуулж эхэлсэн байна.

1925 оны 10-р сард шинжлэх ухааны үндэстэй европ эмнэлгийг анх 8 ортойгоор байгуулсан ба дараа нь 15 ортой болгож “Ардын эмнэлэг” байгуулсан ба Ардын эмнэлэг өргөжиж, мэс засал, дотор, арьс өнгө, эх барих эмэгтэйчүүд, шүдний өвчтэй өвчтөнг эмчлэх тасгуудтай ажиллаж эхэлжээ. 1925 оноос Монгол улсын засгийн газрын хүсэлтийн дагуу Холбоот Орос Улсын эрүүлийг хамгаалах ардын комиссариатын газрын эмнэлэг ариун цэврийн экспедицийг 5 удаа ирүүлж, хүн амд эрүүл мэндийн үзлэг шинжилгээ хийлгэн, эмнэлгийн тусламж үзүүлэх, эмнэлэг урьдчилан сэргийлэх байгууллагуудыг байгуулах ажлыг хийж эхэлсэн байна.


Эрүүлийг хамгаалах байгууллагын тоо 1940 он гэхэд нэмэгдэж, үйлчлэх хүрээ нь өсөж, 12 их эмч, 159 бага эмч, эмийн тусгай дунд боловсролтой 38 мэргэжилтэн, 269 сувилагч ажиллаж байсан. 1940 онд хөдөөд багийн бага эмчийн 157 салбар, аймаг, хотод тусгай мэргэжлийн больниц 1, нэгдсэн больниц 20, арьс өнгөний диспансер 1, сүрьеэгийн диспансер 1, амбулатори ба поликлиник 23, гоц халдварт өвчнийг эсэргүүцэн судлах станц 1, сувилагчийн салбарууд 169 ажиллаж байв.<sup>1</sup>

Энэ үед эмнэлгийн байгууллагын тоо, ор, төсөв, эмнэлгийн тусламж үзүүлсэн хүний тоо, эмч, эмнэлгийн ажилтны тоо зэрэг үзүүлэлтийг байршлаар нэгтгэн, гаргадаг болсон. Эрүүлийг хамгаалах яаманд тоо бүртгэлийн хэлтэс, аймгуудын эрүүлийг хамгаалах хэлтэст 1945 оноос тоо бүртгэгчтэй болж, тайлан мэдээг салбарын хэмжээнд нэгтгэн дүгнэдэг болсноос эхлэн эрүүл мэндийн салбарын мэдээллийн нэгдсэн тогтолцоо бий болжээ. Эрүүл мэндийн байгууллагын тоо хэрхэн нэмэгдсэн статистикийг зураг 4.1 ба зураг 4.2-т харуулав.


<sup>1</sup> Бүгд Найрамдах Монгол Ард Улсын эрүүлийг хамгаалах явдал, Статистикийн товч лавлах



**Зураг 4. 1 Эрүүл мэндийн байгууллагын тоо, сонгосон онуудаар**




**Зураг 4. 2 Эрүүл мэндийн байгууллагын тоо, сонгосон онуудаар**



Монгол улсад 1925 онд 2 нэгдсэн больниц 15 ортой ажиллаж байсан бол 1940 онд нийт 1746 эмнэлгийн ор ажиллаж 10 000 хүн ам тутамд 23.6 ор ногдож байв. Үүнээс нэгдсэн больницод 1002, бага эмчийн салбарт 744 ор байсан.

Эмнэлгийн нэг оронд ногдох хүний тоо 1940 онд 423 байсан бол эмнэлгийн тоо нэмэгдсэнээр 1960 онд 107, 1980 онд 90 хүн болсон ба 1990 оноос нэмэгдэж 2000 онд 132 хүн ногдож байв.

**Зураг 4. 3 Эмнэлгийн орны тоо, 10 000 хүн амд, 1925-2000 сонгосон онуудаар**



Манай улс 1962 онд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын гишүүн болсон нь Монгол Улсын эрүүл мэндийн салбарын хөгжлийг бусад улс, орнуудтай харьцуулах, статистикийн үзүүлэлт, аргачлалыг олон улсын жишигт нийцүүлэх шаардлагатай болсон.

## 4.2 ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол улсын эрүүл мэндийн байгууллагын тогтолцоо нь нийгмийн эрүүл мэндийн, эмнэлгийн тусламж, үйлчилгээний, эм хангамжийн, анагаах ухааны боловсрол, эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагаа хариуцсан төрийн, хувийн хэвшлийн, холимог өмчийн эрүүл мэндийн байгууллагаас бүрдэнэ.

Эмнэлгийн тусламж үйлчилгээ нь төрийн онцгой ивээлд нэгдсэн зохицуулалттай байж, тусламж үйлчилгээг үзүүлэхдээ төр, иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг харилцан ашигтай, шудрага, үйлчлүүлэгчээ дээдэлсэн тэгш хүртээмжтэй байхад чиглэнэ.

“Эмнэлгийн тусламж, үйлчилгээ” гэж өвчин эмгэг, гэмтэл бэртэл, хүний биеийн үйл ажиллагааны алдагдлыг орчин үеийн болон уламжлалт анагаах ухаанд тулгуурлан оношлох, эмчлэх, сувилал, хөнгөвчлөх, сэргээн засах цогц үйл ажиллагааг хэлнэ гэж хуулинд заасан.

Энэхүү бүлэгт эмнэлгийн тусламж үйлчилгээний албан ёсны статистик мэдээллийг Эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц үйл ажиллагааны стандарттай харьцуулан дүгнэхийг хичээсэн.

Монгол улсын хүн амд Өрхийн эрүүл мэндийн төв, Сум, тосгоны эрүүл мэндийн төв, Клиник, Амаржих газар, Нийгмийн эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, Сувилал, Түргэн тусламжийн төв, Бүсийн оношлогоо, эмчилгээний төв, Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвүүд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлж байна.

## 4.3 ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА, ОРНЫ ХАНГАМЖ

2020 оны байдлаар Монгол улсын хэмжээнд нийт 4 575 эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа ба төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг 12, тусгай мэргэжлийн төв 14, бүсийн оношилгоо эмчилгээний төв 5, аймгийн нэгдсэн эмнэлэг 16, дүүргийн нэгдсэн эмнэлэг 4, нийгмийн эрүүл мэндийн төв 9, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг 6, сумын эрүүл мэндийн төв 322, өрхийн эрүүл мэндийн төв 209, хувийн ортой эмнэлэг 241, хувийн клиник 1491 ажиллаж эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.


Хүснэгт 4.1 Эрүүл мэндийн байгууллагын тоо, 2020 он

Эрүүл мэндийн байгууллагууд	Аймгийн дүн	Улаанбаатар	Улсын дүн
Өрхийн эрүүл мэндийн төв	78	131	209
Тосгоны эрүүл мэндийн төв	1	5	6
Сумын эрүүл мэндийн төв	А зэрэглэл	54	54
	Б зэрэглэл	123	123
	В зэрэглэл	145	145
Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг	6		6
Аймгийн нэгдсэн эмнэлэг	16		16
Дүүргийн нэгдсэн эмнэлэг	0	4	4
Дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төв, НЭМҮТ	0	9	9
Бүсийн оношлогоо эмчилгээний төв	5		5
Тусгай мэргэжлийн төв	11	3	14
Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг	0	12	12
Амаржих газар	0	3	3
Түргэн тусламжийн төв	0	1	1
Клиник /хувийн/	402	1088	1490
Ортой хувийн эмнэлэг	109	132	241
Сувилал	51	51	102
Эм ханган нийлүүлэх байгууллага	75	275	350
Эмийн үйлдвэр	0	40	40
Эмийн сан	639	974	1613
Тусгай эмнэлэг	14	5	19
Бусад	73	40	113
<b>Нийт</b>	<b>1802</b>	<b>2773</b>	<b>4575</b>



2020 онд улсын хэмжээнд 27 083 эмнэлгийн ор ажилласан бөгөөд 73.1 хувь нь улсын төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагуудад, 26.9 хувь нь хувийн хэвшлийн эмнэлгийн ор байна. 2010-2020 оны хооронд манай улсын эмнэлгийн орны тоо 51.9 хувиар, 10 000 хүн амд ногдох ор 16.5-оор нэмэгдсэн байна.


**Зураг 4. 4 Эмнэлгийн орны тоо, 2010-2020 он**



2020 онд улсын хэмжээнд 10 000 хүн тутамд дунджаар 84.0 ор ногдож байна. Улсын хэмжээнд ажиллаж буй орны дөрөвний гурав буюу 29 хувийг дотрын тусламж үйлчилгээний ор, 13.4 хувийг хүүхдийн эмчилгээний ор, 10.8 хувийг мэс засал, гэмтлийн тусламж үйлчилгээний ор эзэлж байна.


Эмнэлгийн орны төрлөөр харьцуулан харахад 2010-2020 онд мэс засал ба гэмтлийн тусламж үйлчилгээний орны тоо 10 000 хүн ам тутамд 7.7-оос 8.3 болж өссөн, мэдрэлийн тусламж үйлчилгээний ор 10 000 хүн тутамд 3.9-өөс 5.7 болж тус тус өссөн байна.

**Зураг 4. 5 10 000 хүнд ногдох орны тоо, мэргэжлийн төрлөөр, 2010-2020 он**






Зураг 4. 6 10 000 хүнд ногдох орны тоо, мэргэжлийн төрлөөр, 2010-2020 он




Зураг 4. 7 10 000 хүнд ногдох орны тоо, мэргэжлийн төрлөөр, 2010-2020 он



2020 онд орны фонд ашиглалтын хувь 77.1, дундаж ор хоног 7.0 байна. Дархан-Уул аймагт орны фонд ашиглалтын хувь хамгийн өндөр буюу 79.7 хувь, Өмнөговь аймагт хамгийн бага буюу 42.5 хувь байна.

Зураг 4. 8 Эмнэлгийн ор ашиглалтын үзүүлэлтүүд, аймгаар, 2020 он





## 4.4 ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Өрхийн эрүүл мэндийн төв нь хот, суурин газрын хүн амд төрөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх үндсэн чиг үүрэг бүхий сайн дурын үндсэн дээр бүртгүүлсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага юм.


Эмнэлгийн тусламж үйлчилгээ нь бүх иргэдэд үнэ төлбөргүй байдаг бөгөөд Эрүүл мэндийн тухай хуульд заасны дагуу улсын нэгдсэн төсвийн орлогоос санхүүждэг.

Монгол улсад өрх, сумын эрүүл мэндийн төвүүд нь харьяаллын хүн амд чиг үүргийн дагуу тав хүртэлх насны хүүхдийн дархлаажуулалт, жирэмсэн эмэгтэйчүүдийн хяналт, эх, хүүхдийн гэрийн эргэлт зэрэг 8 төрлийн тусламж үйлчилгээг үзүүлэн ажилладаг. Монгол орны цаг уурын эрс тэс уур амьсгалын улмаас өвөл, хаврын улиралд амьсгалын замын өвчлөл нэмэгддэг нь өрхийн эрүүл мэндийн төвүүдийн ажлын ачааллыг нэмэгдүүлдэг байна.

Өрхийн эрүүл мэндийн төвүүд нь харьяаллын хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ, тодруулбал, амбулаторийн үзлэг, урьдчилан сэргийлэх үзлэг, зарим лабораторийн шинжилгээ, дархлаажуулалт, гэрийн үзлэг, эмчилгээг хийж байна.

2020 оны байдлаар 209 өрхийн эрүүл мэндийн төв үйл ажиллагаа явуулж байгаагаас Улаанбаатар хотын 1 сая 466.1 мянган хүн амд 131 өрхийн эрүүл мэндийн төв, 21 аймгийн төвийн 702.1 мянган хүн амд 78 өрхийн эрүүл мэндийн төв эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.

Зураг 4.9 Өрхийн эрүүл мэндийн төвийн тоо, 2010-2020 он




2020 онд нийт 56 502 эрүүл мэндийн ажиллагчид байгаагаас 3175 нь өрхийн эрүүл мэндийн төвд ажиллаж байна. Өрхийн эрүүл мэндийн төвийн нийт ажиллагчдын 35.4 хувь нь их эмч, 32.9 хувь нь сувилагч, 4.2 хувь нь нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн байна.


Их эмч сувилагчийн харьцаа улсын хэмжээнд 1:1.1 байгаа ба өрхийн эрүүл мэндийн төвийн хэмжээнд 1:0.9 байгаа нь олон улсын дундаж үзүүлэлтээс доогуур байна. Улаанбаатар хотод ажиллаж буй их эмчийн тоо орон нутагт ажиллаж буй эмчийн тооноос харьцангуй их байна.

209 өрхийн эрүүл мэндийн төвд их эмч 1123, сувилагч 1045 болон нийт 3175 эмч, эмнэлгийн ажиллагчид хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж байна. Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц үйл ажиллагааны стандартад 1800-2000 хүн тутамд 1 их эмч ажиллана гэж заасан хэдий ч 2020 оны байдлаар улсын хэмжээнд 1 өрхийн эмчид 1971 хүн ногдож байна. Баян-Өлгий, Баянхонгор, Говь-сүмбэр, Говь-Алтай, Дорнод, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Төв, Ховд аймагт нэг их эмчид ногдох хүний тоо стандартад заасан хэмжээнд байгаа бусад аймгуудад стандартын хэмжээнээс өндөр байна.

Зураг 4. 10 Өрхийн эрүүл мэндийн төвийн их эмчийн тоо, 2010-2020 он




Зураг 4. 11 Өрхийн эрүүл мэндийн төвийн сувилагчийн тоо, 2010-2020 он



2020 онд өрхийн эрүүл мэндийн төвийн түвшинд жилд дунджаар 5.6 сая үзлэг хийгдэж, нэг иргэн жилд дунджаар 2.6 удаа өрхийн эрүүл мэндийн төвд хандаж эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авсан байгаа нь 2010 онтой харьцуулахад 0.8-аар буурсан байна.

Зураг 4. 12 Нэг өрхийн эмчид ногдох үзлэг, нэг иргэний үзүүлсэн тоо, 2010-2020 он




Амбулаторийн нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь 38.8 байгаа ба УБ хотын өрхийн эрүүл мэндийн төвийн түвшинд 43.0 хувь, харин аймгийн өрхийн эрүүл мэндийн төвийн түвшинд 39.2 хувь байна. Өрхийн эрүүл мэндийн төвийн урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь өмнөх оноос 3.1 хувиар буурсан байна. “Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны



стандарт”-д гэрийн идэвхтэй эргэлтийн хувь 30 хувиас доошгүй байна гэж заасан хэдий ч 2020 оны байдлаар 31.6 хувь байгаа ба өмнөх оноос 5.8 хувиар нэмэгдсэн байна.


**Зураг 4. 13 Өрхийн эрүүл мэндийн төвд хийгдсэн амбулаторийн үзлэгийн тоо /мянга/**



Улаанбаатар хотын өрхийн эрүүл мэндийн төвийн түвшинд 2005 онд 3.0 сая үзлэг хийгдэж байсан бол 2007 онд 3.9 сая, 2020 онд 4.0 сая үзлэг хийгдсэн байна. Жилд нэг өрхийн эмчид ногдох үзлэгийн тоо Улаанбаатар хотод 6071, аймгийн түвшинд 5326 байна.

2020 оны байдлаар өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нарын жирэмсний хяналтад 54730 эмэгтэйг шинээр хяналтад авсан ба үүнээс 89.3 хувь нь эхний 3 сартайд хяналтад хамрагдсан байна.

**Зураг 4. 14 Жирэмсний эрт хяналтын хувь, 2010-2020 он**



## 4.5 СУМ, ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Сум, тосгоны эрүүл мэндийн төв нь харьяа нутаг дэвсгэрийнхээ хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны аргаар үзүүлэх бөгөөд сумын эрүүл мэндийн төв нь тухайн сумын хүн амын тоо, байршлаас хамааран багийн эмчийн салбартай байж болно.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/540 дугаар тушаалаар сумын эрүүл мэндийн төвүүдийг нь аймгийн төвөөс алслагдсан байдал, хүн амын тоо, аймгийн төв хүртэлх зорчих хугацаанаас хамааран А, Б, В гэсэн 3 зэрэглэлд ангилна.

Сумын эрүүл мэндийн төвийн А зэрэглэлд өөрийн сумын иргэдэд өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үзүүлэхээс гадна зэргэлдээх сумын хүн амд 4-өөс доошгүй үндсэн мэргэшлийн тусламж үйлчилгээг үзүүлэх чадавхи бүхий сумын эрүүл мэндийн төвүүд хамаарна.


Сумын эрүүл мэндийн төвийн Б зэрэглэлд улсын хилийн дагуу болон улсын чанартай автозам, төмөр зам дагуу байрласан, осол гэмтлийн онцгой бүс, уул уурхай, үйлдвэрлэл, аялал жуулчлал хөгжсөн бүс нутгийн сумын эрүүл мэндийн төвүүд хамаарна. Сумын эрүүл мэндийн төвийн А болон Б зэрэглэлд хамрагдаагүй бусад бүх сумын эрүүл мэндийн төвүүд В зэрэглэлд хамрагдана.

2020 оны байдлаар А зэрэглэлд хамаарах сумын эрүүл мэндийн төв 54, Б зэрэглэлийн 123, В зэрэглэлд хамрагдах сумын эрүүл мэндийн төв 145, сумын нэгдсэн эмнэлэг 6 байгаа бөгөөд тухайн оны үзүүлэлтэд сумын нэгдсэн эмнэлгийн үзүүлэлтийг оруулж тооцсон болно.

Сум, тосгоны эрүүл мэндийн төвүүд, сумын нэгдсэн эмнэлэгт нийт 8399 ажиллагчид хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байна. Үүнээс А зэрэглэлд хамаарах сумын эрүүл мэндийн төвд 20.9 хувь, Б зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төвд 31.8 хувь, В зэрэглэлд хамрагдах сумын эрүүл мэндийн төвд 36.8, тосгоны эрүүл мэндийн төвд 2.2, сумын нэгдсэн эмнэлэгт 8.23 хувь нь тус тус ажиллаж байна.

2020 оны байдлаар хүний их эмч 1257 буюу нийт ажиллагчдын 15.0 хувийг эзэлж байгаа ба сувилагч 2038 /24.3 хувь/, бага эмч 1019 /9.9 хувь/, эх баригч 370 /4.4 хувь/, эм найруулагч 153 /1.8 хувь/ тус тус ажиллаж байна.

Зураг 4. 15 Сумын эрүүл мэндийн төвийн эмч, сувилагчийн тоо, 2010-2020 он




2020 оны байдлаар эмнэлгийн нийт орны 16.5 хувь нь сум, тосгоны эрүүл мэндийн төв, сумын нэгдсэн эмнэлэгт ногдож байгаа бөгөөд 2010 онтой харьцуулбал 369 ороор буюу 10.2 хувиар нэмэгдсэн байна. Сумын эрүүл мэндийн төв болон сум дундын эмнэлэгт жилд 115.5 мянган хүн



хэвтэн эмчлүүлсэн байна. 2020 онд хэвтэн эмчлүүлэгчдийн тоог 2010 онтой харьцуулахад 21.8 мянгаар буурсан байна.

Зураг 4. 16 Стационарын тусламж үйлчилгээний үзүүлэлт, 2010-2020 он




Сум, тосгоны эрүүл мэндийн төвүүд нь хүн амын эрүүл мэндийг сайжруулах чиглэлээр Бүх нийтийн эрүүл мэндийн хамралт, Тогтвортой хөгжлийн зорилтын үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэдэг.

Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний багц нь эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хяналт, хөнгөвчлөх тусламж, яаралтай түргэн тусламжийн үйлчилгээ зэргээс бүрдэнэ.

Сум, өрхийн эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн сайдын 180 тоот тушаалын дагуу 5 хүртэлх насны хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд, өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг гэрийн эргэлтээр үзүүлдэг. Мөн Эрүүл мэндийн сайдын А/147 тоот тушаалын дагуу эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэгчид лавлагаа шатлалын нарийн мэргэжлийн эмч, ажилтнуудтай хамтран эрүүл мэндийн явуулын тусламж үйлчилгээг хүүхэд, насанд хүрэгчдийн дунд жилдээ нэг эсвэл хоёр жилдээ нэг удаа зохион байгуулан ажилладаг.


2020 онд сум, тосгоны эрүүл мэндийн төвийн түвшинд жирэмсний эрт үеийн хяналт 91.6 хувь болж өмнөх оноос 0.7, сүүлийн 10 жилийн дунджаас 0.9 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Зураг 4. 17 Жирэмсний эрт хяналтын хувь, 2010-2020 он



2020 оны байдлаар сум, тосгоны эрүүл мэндийн төвд 2.2 сая үзлэг хийгдэж нэг иргэний үзүүлсэн дундаж тоо 2.3 байна. Нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь 39.2, гэрийн эргэлтийн үзлэгийн хувь 13.2 байгаа ба урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь өмнөх оноос 0.9 хувиар нэмэгдсэн байна.

Зураг 4. 18 Сумын эрүүл мэндийн төвийн эмчийн үзлэг, 2010-2020 он




2020 онд сум, тосгоны эрүүл мэндийн төвд эхийн эндэгдлийн 3 тохиолдол бүртгэгдэж 100 000 амьд төрөлтөд 60.7 байгаа нь сүүлийн 10 жилийн дундаж үзүүлэлтээс 1.2-оор бага байна. 1000 амьд төрсөн хүүхдэд ногдох нялхсын эндэгдэл сум, тосгоны эрүүл мэндийн төвийн түвшинд 28.2 байгаа нь өмнөх оноос 24.0, сүүлийн 10 жилийн дунджаас 11.0-оор тус тус бага байна.





Зураг 4. 19 Эх, хүүхдийн эндэгдлийн түвшин, 2010-2020 он




## 4.6 НЭГДСЭН ЭМНЭЛЭГ, НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Нэгдсэн эмнэлэг нь хүн амд 7-оос доошгүй чиглэл /дотор, хүүхэд, эх барих, эмэгтэйчүүд, ерөнхий мэс засал, шүд, мэдрэл, халдварт/-ээр эмнэлгийн тусламж, үйлчилгээг амбулатори болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх бөгөөд хүн амын байршил, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээг үндэслэн салбар амбулаторитой байж болно.

Нийгмийн эрүүл мэндийн төв нь нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх үйл ажиллагааг аймаг, дүүргийн түвшинд зохион байгуулна.

2020 оны байдлаар 16 аймгийн нэгдсэн эмнэлэгт 1213 их эмч, 1865 сувилагч, нийтдээ 5199 эмч, ажиллагчид, Улаанбаатар хотын дүүргийн нэгдсэн эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төвүүдэд 945 их эмч, 1011 сувилагч, нийтдээ 3578 эмч, эмнэлгийн ажиллагчид байна.

Зураг 4. 20 Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн их эмчийн тоо, 2010-2020 он




Зураг 4. 21 Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн сувилагчийн тоо, 2010-2020 он



Амбулаториор үйлчлүүлсэн хүний тоо 2020 онд аймгийн нэгдсэн эмнэлгийн түвшинд 1.9 сая байгаа ба нийт эмчийн үзлэгийн 11.2 хувийг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн түвшинд 2.0 сая буюу нийт үзлэгийн 11.8 хувийг тус тус эзэлж байна. Аймгийн нэгдсэн эмнэлэгт амбулаториор үйлчлүүлэгчдийн дийлэнх нь буюу 63.5 хувь нь өвчний учир ирж үзүүлсэн, 9.1 хувь нь идэвхтэй хяналтын үзлэг эзэлж байна.


Дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвийн амбулаториор үйлчлүүлэгчдийн дийлэнх нь буюу 48.5 хувь нь өвчний учир ирж үзүүлсэн, 17.7 хувь нь идэвхтэй хяналтын үзлэг эзэлж тус тус байна.

Зураг 4. 22 Амбулаториор үйлчлүүлсэн хүний тоо, 2010-2020 он



2020 оны байдлаар нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь аймгийн нэгдсэн эмнэлгийн түвшинд 27.3 байгаа нь сүүлийн 10 жилийн дунджаас 5.4 хувиар, дүүргийн нэгдсэн эмнэлгийн түвшинд 36.9 байгаа нь 3.3 хувиар тус тус буурсан байна.

Зураг 4. 23 Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь, 2010-2020 он






2020 оны байдлаар аймгийн нэгдсэн эмнэлэгт эхийн эндэгдлийн 8 тохиолдол бүртгэгдэж 100 000 амьд төрөлтөд 36.7 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 22.8-оор нэмэгдсэн ба сүүлийн 10 жилийн дунджаас 6.6-оор өндөр байна.

Аймгийн нэгдсэн эмнэлэгт бүртгэгдсэн нялхсын эндэгдлийн түвшин 2020 онд 7.4 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 1.1-оор буурсан ба сүүлийн 10 жилийн дунджаас 3.6-оор бага байна.

**Зураг 4. 24 Эх, хүүхдийн эндэгдлийн түвшин, 2010-2020 он**



Аймгийн нэгдсэн эмнэлгүүдэд эмнэлгийн нийт орны 15.6 хувь нь ногдож байгаа бөгөөд 2020 онд аймгийн нэгдсэн эмнэлгүүдийн орны тоо 4237 байна.

2020 онд аймгийн нэгдсэн эмнэлэгт нийт 136.0 мянган хүн хэвтэн эмчлүүлсэн ба нийт эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн 15.9 хувийг эзэлж байна. 2020 онд орны фонд ашиглалтын хувь 68.7 байгаа нь улсын дундаж үзүүлэлтээс 3.7 хувиар их байна. Дундаж ор хоног 7.1 байгаа ба 2010 онтой харьцуулахад 0.8-аар буурсан байна.


**Зураг 4. 25 Аймгийн нэгдсэн эмнэлгийн стационарын тусламж үйлчилгээний үзүүлэлт, 2010-2020 он**



Дүүргийн нэгдсэн эмнэлгүүдэд эмнэлгийн нийт орны 11.8 хувь нь ногдож байгаа бөгөөд 2020 онд дүүргийн нэгдсэн эмнэлгүүдийн орны тоо 3190 байна. 2020 онд дүүргийн нэгдсэн эмнэлэгт нийт 147.9 мянган хүн хэвтэн эмчлүүлсэн ба нийт эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн 17.3 хувийг эзэлж байна.

2020 онд орны фонд ашиглалтын хувь 81.0 байгаа нь улсын дундаж үзүүлэлтээс 16.1 хувиар их байгаа ба хамгийн өндөр ачаалалтай ажилласан нь харагдаж байна. Дундаж ор хоног 5.8 байгаа ба 2010 онтой харьцуулахад 1.9-аар буурсан байна.


Зураг 4. 26 Дүүргийн нэгдсэн эмнэлгийн стационарын тусламж үйлчилгээний үзүүлэлт, 2010-2020 он



2020 онд эмнэлгийн хоног болоогүй нас баралтын эзлэх хувь аймгийн нэгдсэн эмнэлгийн түвшинд 36.9 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 4.9 хувиар, сүүлийн 10 жилийн дундаж үзүүлэлтээс 3.7 хувиар тус тус өндөр байна.

Дүүргийн нэгдсэн эмнэлгийн түвшинд 28.5 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 2.9 хувь, сүүлийн 10 жилийн дундаж үзүүлэлтээс 0.5 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Зураг 4. 27 Хоног болоогүй нас баралтын хувь, 2010-2020 он




## 4.7 БҮСИЙН ОНОШЛОГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Бүсийн оношлогоо эмчилгээний төв нь бүс нутгийн хүн амд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн бусад байгууллагад мэргэжлийн аргачилсан зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах чиг үүрэг бүхий эрүүл мэндийн байгууллага юм.

2020 оны байдлаар улсын хэмжээнд Орхон, Дорнод, Өвөрхангай, Ховд, Өмнөговь аймгийн нэгдсэн эмнэлгүүд БОЭТ-ийн статусаар үйл ажиллагаа явуулж байгаа ба 514 их эмч, 766 сувилагч, 293 эмнэлгийн мэргэжлийн болон техникийн боловсролтой ажилтан, нийтдээ 2112 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд ажиллаж байна.




Зураг 4. 28 БОЭТ-ийн хүний нөөцийн үзүүлэлт, 2010-2020 он



2020 онд Бүсийн оношлогоо, эмчилгээний төвүүдэд 1870 ор ажиллаж, нийт эмнэлгийн орны 6.9 хувь нь ногдож байгаа бөгөөд 2010 онтой харьцуулахад 741 ороор нэмэгдсэн байна.

2020 онд нийт 54.1 мянган хүн хэвтэн эмчлүүлсэн ба нийт эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн 6.3 хувийг эзэлж байна. 2020 онд орны фонд ашиглалтын хувь 60.1 байгаа нь улсын дундаж үзүүлэлтээс 4.8 хувиар бага байна. Дундаж ор хоног 6.9 байгаа ба 2010 онтой харьцуулахад 0.7-аар буурсан байна.

Зураг 4. 29 БОЭТ-ийн стационарын тусламж үйлчилгээний үзүүлэлт, 2010-2020 он



2020 онд Бүсийн оношлогоо, эмчилгээний төвүүдэд нийт нас баралтын 356 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд түүнээс 127 тохиолдол нь эмнэлэгт ирээд 24 цагийн дотор нас барсан байна. Үүнээс эмнэлгийн тусламж авснаас хойш 8-24 цагийн дотор 74 тохиолдол нь буюу 58 хувь нь нас баржээ. Хоног болоогүй нас баралтын хувь 35.7 байгаа нь өмнөх оноос 8.0 хувь, сүүлийн 10 жилийн дунджаас 5.8 хувиар тус тус өндөр байна.


Зураг 4. 30 БОЭТ-ийн хоног болоогүй нас баралтын хувь, 2010-2020 он



Бүсийн оношлогоо эмчилгээний төвүүдэд 2020 онд амбулаториор үйлчлүүлсэн хүний тоо 671.3 мянга байгаа нь 2010 онтой харьцуулахад 216.8-аар нэмэгдсэн байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад 7.8 мянгаар буурсан үзүүлэлттэй байна.

Нийт үзлэгийн 24.5 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 11.5 хувийг идэвхтэй хяналтын үзлэг эзэлж байна. Амбулаториор үйлчлүүлэгчдийн 19.5 хувь нь бүсийн аймгуудаас буюу өвчтөн илгээх хуудсаар ирж үйлчлүүлсэн байна.


Зураг 4. 31 Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо, 2010-2020 он



Бүсийн оношлогоо эмчилгээний төвүүдэд 2020 онд 9733 нярай амьд төрсөн ба үүнээс 182 нь ихэр төрөлт байна. Амьгүй төрөлтийн 43 тохиолдол бүртгэгдсэнээс 2 нь ихэр хүүхэд байжээ. Амаржсан эхчүүдийн 26.8 хувь нь мэс заслын аргаар төрсөн ба 46 тохиолдол нь эх барихын хавчуураар төрж, 14 тохиолдолд эхсийг гардаж авсан байна.

Сүүлийн жилүүдэд улсын хэмжээнд нялхсын эндэгдэл тогтвортой бага түвшинд байгаа хандлагын дагуу БОЭТ-ийн 1000 амьд төрсөн хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийн түвшин сүүлийн 3 жилийн дунджаар 1000 амьд төрөлтөд 9.2 байгаа нь аймгийн дунджаас доогуур байна.

Зураг 4. 32 Эх, хүүхдийн эндэгдлийн түвшин, 2010-2020 он



2020 онд Бүсийн оношлогоо эмчилгээ төвүүдэд эхийн эндэгдлийн 1 тохиолдол бүртгэгдэж, 100 000 амьд төрөлтөд 10.3 байна.

2020 онд нялхсын эндэгдлийн 79 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөд 8.1 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 0.3-оор нэмэгдсэн ба сүүлийн 10 жилийн дунджаас 2.4-оор бага байна.




## 4.8 ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛЭГ, ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ТӨВҮҮДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг нь улсын хэмжээнд төрөлжсөн мэргэжлээр эмнэлгийн тусламж үйлчилгээг амбулатори болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх, сургалт, судалгааны ажил эрхлэх, эрүүл мэндийн бусад байгууллагыг лавлагаа мэргэжил арга зүйгээр хангаж ажиллаж байна.

Тусгай мэргэжлийн төв нь улсын хэмжээнд тухайн мэргэжлээр эмнэлгийн тусламж, үйлчилгээг амбулатори болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх, лавлагаа, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэн эрүүл мэндийн бусад байгууллагыг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллаж байна. 2020 оны байдлаар Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвүүдэд 1437 их эмч, 2210 сувилагч, 725 эмнэлгийн мэргэжлийн болон техникийн боловсролтой бусад ажилтан, нийтдээ 7010 ажиллагчид ажиллаж байна.

**Зураг 4. 33 Тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүдийн их эмч, сувилагчийн тоо, 2010-2020 он**



Нийт эмнэлгийн орны 17.8 хувь нь, мөн хэвтэн эмчлүүлэгчдийн 19.1 хувь нь Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд ногдож байна. 2020 онд 163.6 мянган хүн хэвтэн эмчлүүлсэн нь сүүлийн 10 жилийн дунджаас 15.8 мянган хүнээр, өмнөх онтой харьцуулахад 5.7 мянган хүнээр тус тус нэмэгдсэн байна.

2020 онд орны фонд ашиглалтын хувь 75.9 байгаа нь улсын дундаж үзүүлэлтээс 11.0 хувиар өндөр байна. Дундаж ор хоног 2010 онд 10.0 байсан бол 2020 онд 7.4 болж буурсан байна. Дундаж ор хоног мэргэшлийн төрөл бүрээр ялгаатай байгаа ба сүрьеэгийн тасгийн дундаж ор хоног 29, сэтгэцийн 20.1, гэмтэл 11, уламжлалтын тасагт 7.7 байгаа нь улсын дундаж үзүүлэлтээс өндөр байна.


**Зураг 4. 34 Стационарын тусламж үйлчилгээний үзүүлэлт, 2010-2020 он**






2020 онд Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд нийт нас баралтын 1895 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд түүнээс 377 тохиолдол нь эмнэлэгт ирээд 24 цагийн дотор нас барсан байна. Үүнээс эмнэлгийн тусламж авснаас хойш 8-24 цагийн дотор 182 тохиолдол нь буюу 48 хувь нь нас баржээ. Хоног болоогүй нас баралтын хувь 19.9 байгаа нь өмнөх оноос 0.5 хувиар нэмэгдсэн ба сүүлийн 10 жилийн дунджаас 1.5 хувиар бага байна.

Зураг 4. 35 Хоног болоогүй нас баралтын хувь, 2010-2020 он




Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд 2020 онд амбулаториор үйлчлүүлсэн хүний тоо 1411.6 мянга байгаа нь нийт эмчийн үзлэгийн 7.8 хувийг эзэлж байна. 2010 онтой харьцуулахад 224.0 мянган хүнээр нэмэгдсэн байна. Нийт үзлэгийн 6.0 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг эзэлж байгаа ба нийт үйлчлүүлэгчдийн 20.0 хувь нь орон нутгаас өвчтөн илгээх хуудсаар ирж үйлчлүүлсэн байна.

Зураг 4. 36 Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо, 2010-2020 он



Сүүлийн 10 жилд дунджаар Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд 145.0 мянган хүн хэвтэн эмчлүүлж байгаагийн 22.8 хувийг хөдөө, орон нутгаас ирж хэвтэн эмчлүүлэгчид эзэлж байна. 2010 онтой харьцуулбал хөдөө орон нутгаас ирж 2020 онд хэвтэн эмчлүүлэгчдийн эзлэх хувь 6.6 хувиар буурсан байна.

Зураг 4. 37 Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд хөдөө орон нутгаас ирж эмчлүүлэгчдийн эзлэх хувь





**Хүснэгт 4. 2 Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлтүүд**

Эрүүл мэндийн байгууллагууд	Амбулаторийн үзлэгийн тоо	Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид	Дундаж ор хоног	Хоног болоогүй нас баралт
Улсын нэгдүгээр төв эмнэлэг	331440	21841.5	6.1	12.2
Улсын хоёрдугаар төв эмнэлэг	110708	4495.0	6.7	13.7
Улсын гуравдугаар төв эмнэлэг	162111	41122.0	7.0	18.4
Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	201721	38253.0	6.1	3.3
Хавдар судлалын үндэсний төв	87661	8773.0	7.5	30.8
Халдварт өвчин судлалын үндэсний төв	73323	7365.5	14.5	8.6
Гэмтэл согог судлалын үндэсний төв	164989	15007.0	8.2	30.8
Арьсны өвчин судлалын үндэсний төв	93300	5083.5	8.4	100.0
Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	47408	6370.0	30.0	0.0
Хүүхдийн төв сувилал	806	1417.5	16.2	0.0
Уламжлалт анагаах ухаан технологийн хүрээлэн	25612	5973.5	6.8	0.0
Монгол-Японы сургалтын эмнэлэг	78943	2961.5	6.7	0.0
Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн	13457	0.0	0.0	0.0
Геронтологийн үндэсний төв	23423	0.0	0.0	0.0


#### 4.9 ХУВИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

2020 оны байдлаар улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын 42.0 хувийг хувийн эмийн сангууд, 38.9 хувийг хувийн клиник, 9.1 хувийн эм ханган нийлүүлэх байгууллага, 6.3 хувийг ортой хувийн эмнэлэг, 2.7 хувийг сувилал, 1.0 хувийг эмийн үйлдвэр эзэлж байна.

Эдгээр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад нийт 19.5 мянган ажиллагчид байгаагаас нийт ажиллагчдын 16.1 хувь нь хувийн клиникт, 44.8 хувь нь ортой хувийн эмнэлэгт, 27.4 хувь нь эмийн сангуудад, 9.4 хувь нь сувилалд, 2.3 хувь нь эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн үйлдвэрт тус тус ажиллаж байна


2020 оны байдлаар улсын хэмжээнд 241 ортой, 1491 хувийн клиник үйл ажиллагаа явуулж хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж байна. 2010 онд ортой хувийн эмнэлэг 166 байсан бол 2020 онд 71-ээр нэмэгдэж, хувийн клиник 497-оор нэмэгдсэн байна. Хувийн хэвшлийн эмнэлгүүдийн 30.8 хувь нь хөдөө орон нутагт, 69.2 хувь нь, улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 4. 38 Хувийн хэвшлийн эмнэлгийн тоо, 2010-2020 он



Хувийн хэвшлийн эмнэлгийн орны тоо 2010 онд 2527 байсан бол 2020 онд 7291 болж 4.7 мянгаар нэмэгдсэн бөгөөд нийт эмнэлгийн орны 26.9 хувийг эзэлж байна. 2005 оноос хувийн хэвшлийн эмнэлгүүдийг ялангуяа ортой эмнэлгийг шинээр байгуулахыг хязгаарлах, харин үйл ажиллагааны чиглэл нь улсын эмнэлгийн үзүүлж байгаа зарим эмнэлгийн тусламж үйлчилгээг хувийн хэвшлийн эмнэлгүүдээр гүйцэтгүүлэх, үйл ажиллагааны чиглэлийг өргөжүүлэх, төрөлжүүлэх бодлогыг хэрэгжүүлж ирсэн байна.

Зураг 4. 39 Хувийн хэвшлийн эмнэлгийн орны тоо, 2010-2020 он




2020 оны байдлаар нийт эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн 21.5 хувь нь хувийн эмнэлгүүдэд ногдож байна. 2020 онд 184.1 мянган хүн хэвтэн эмчлүүлсэн нь сүүлийн 10 жилийн дунджаас 37.3 мянган хүнээр, 2010 онтой харьцуулахад 99 мянган хүнээр тус тус нэмэгдсэн байна.

2020 онд орны фонд ашиглалтын хувь 51.3 байгаа нь улсын дундаж үзүүлэлтээс 13.6 хувиар доогуур буюу орны ачаалал харьцангуй бага байгаа ч эмнэлэг тус бүрээр ялгаатай байна. Дундаж ор хоног 2010 онд 7.9 байсан бол 2020 онд 6.7 болж буурсан байна. Орны эргэлт 29.3 байгаа нь улсын дундаж үзүүлэлтээс 7.0-оор бага байна.




Зураг 4. 40 Хувийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тоо, 2010-2020 он



2020 оны байдлаар хувийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаанд зүрх судасны тогтолцооны өвчин 22.0 хувь, шээс бэлгийн тогтолцооны өвчин 19.7 хувь, хоол боловсруулах тогтолцооны өвчин 12.5 хувь, мэдрэлийн тогтолцооны өвчин 11.8 хувь, яс булчингийн тогтолцооны өвчин 9.9 хувь, амьсгалын тогтолцооны өвчний улмаас хэвтэн эмчлүүлэгчид 9.5 хувийг эзэлж байгаа нийт өвчлөлийн 85.4 хувийг эзэлж байна.

Хувийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн дунд зонхилж буй өвчнүүдийг шалтгаанаар авч үзвэл: зүрх судасны тогтолцооны өвчний дотор даралт ихсэх өвчний улмаас хэвтэн эмчлүүлэгчид 53.9 хувийг, зүрхний ишеми өвчний улмаас хэвтэн эмчлүүлэгчид 20.8 хувийг, шээс бэлгийн тогтолцооны өвчний улмаас хэвтэн эмчлүүлэгчдийн 68.3 хувийг бөөрний сувганцрын үрэвсэлт өвчин, хоол боловсруулах тогтолцооны өвчний дотор элэгний эмгэг 27.4 хувийг, ходоод гэдэсний шархлаат өвчин 24.9 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 4. 41 Хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн шалтгаан, хувиар, 2020 он



Хувийн хэвшлийн эмнэлгүүдийг орны хүчин чадлаар ангилж авч үзвэл 5-8 ортой эмнэлэг 2020 онд 4.1 хувийг, 10-12 ортой эмнэлэг 15.8 хувийг, 15 ортой эмнэлэг 20.3 хувийг тус тус эзэлж байгаа бөгөөд хувийн эмнэлгийн 40.2 хувь нь 20 хүртэлх ортой эмнэлгүүд байна.


## Хүснэгт 4.3 Хувийн эмнэлгийн орны хүчин чадлын үзүүлэлт, сонгосон оноор

Үзүүлэлт	2011 он				2015 он				2020 он			
	Эмнэлгийн тоо		Хэвтэн эмчлүүлэгчид		Эмнэлгийн тоо		Хэвтэн эмчлүүлэгчид		Эмнэлгийн тоо		Хэвтэн эмчлүүлэгчид	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
5-8 ортой	17	9.9	3291	3.4	17	7.6	2501	1.8	10	4.1	834	0.5
10-12 ортой	70	40.9	27565	28.2	54	24.1	17278	12.2	38	15.8	12260.5	6.7
15 ортой	39	22.8	19229	19.7	37	16.5	16038	11.3	49	20.3	17497.5	9.5
20-25 ортой	27	15.8	16859	17.2	61	27.2	37158	26.2	65	27.0	49411	26.8
30 ортой	8	4.7	7406	7.6	18	8.0	14604	10.3	18	7.5	15087	8.2
40-50 ортой	7	4.1	10827	11.1	24	10.7	19655	13.8	41	17.0	39806	21.6
50 ба дээш	3	1.8	12644	12.9	13	5.8	34818	24.5	20	8.3	49168.5	26.7
<b>Нийт дүн</b>	<b>171</b>	<b>100.0</b>	<b>97821</b>	<b>100.0</b>	<b>224</b>	<b>100.0</b>	<b>142052</b>	<b>100.0</b>	<b>241</b>	<b>100.0</b>	<b>184065</b>	<b>100.0</b>

2020 онд хувийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн 48.2 хувь нь дотрын, 15.1 хувь нь мэдрэл, 11.2 хувь нь уламжлалт, 6.1 хувь нь мэс заслын, 5.8 хувь нь эмэгтэйчүүд, 4.9 хувь нь хүүхдийн тасагт хэвтэн эмчлүүлсэн байна.

Хувийн хэвшлийн эмнэлгүүдэд 2020 онд амбулаториор үйлчлүүлсэн хүний тоо 2419.5 мянга байгаа нь нийт эмчийн үзлэгийн 13.8 хувийг эзэлж байна. 2010 онтой харьцуулахад 1382.6 мянган хүнээр нэмэгдсэн байна. Нийт үзлэгийн дийлэнх нь буюу 92.8 хувь нь өвчний учир ирж үйлчлүүлсэн байна.

Зураг 4.42 Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо, мянган хүн, 2010-2020 он





## 4.10 КОРОНАВИРУСТ ХАЛДВАР(COVID-19) –ЫН ҮЕИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

### ШИНЭ КОРОНАВИРУСИЙН (COVID-19) ХАЛДВАР

БНХАУ-ын Хэбэй мужийн Вухань хотод 2019 оны 12 сарын 31-нд шалтгаан тодорхойгүй уушгины хатгалгаа өвчний тохиолдол бүртгэгдэж 1 дүгээр сарын 8-нд БНХАУ-ын эрүүл мэндийн яам шинэ төрлийн коронавирусын халдварыг илрүүлсэн тухай ДЭМБ-д мэдээлсэн. ДЭМБ-аас 2020.02.12-нд Шинэ коронавируст халдвар Covid-19 гэж нэрлэхээр болсоныг зарласан ба 2020 оны 3-р сард цар тахал гэдгийг албан ёсоор зарласан.

Манай улс Коронавирусийн халдварын дэгдэлтээс урьдчилан сэргийлж 2020 оны 1 дүгээр сараас БНХАУ-тай харилцдаг хилийн хөдөлгөөнөө хаах, олон улсын нислэгээ цуцлах, сургууль, цэцэрлэгээ хаах зэрэг шуурхай, шийдэмгий арга хэмжээнүүдийг авч ирсэн. Гэхдээ дотооддоо хүмүүс ажиллах боломжтой хэвээр байв. Энэ өндөржүүлсэн бэлэн байдлыг 2020 оны 5 дугаар сарын 31-нээс сулруулж 9 дүгээр сарын 1-нд сургууль, цэцэрлэг хэвийн ажиллаж эхэлсэн.

Гэвч Ковид-19 халдварыг дотооддоо алдсанаас шалтгаалан 11 дүгээр сарын 12-ноос бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж хөл хорио тогтоосон. Бүх нийтийн бэлэн байдлын үеэр зөвшөөрөгдсөн тодорхой тооны байгууллагын үйл ажиллагаанаас бусдыг бүгдийг зогсоосон. Бүх нийтийн бэлэн байдлыг 12 дугаар сарын 14-нөөс сулруулсан боловч сургуулиудыг хаах, олон нийтийг хамарсан үйлчилгээг хориглох зэрэг ихэнх хориг арга хэмжээнүүд хэвээр мөрдөгдөж байсан.

Монгол Улсад 2020 оны 3-12 дугаар сард коронавирусын нийт 1215 тохиолдол бүртгэгдсэний 830 (68.3%) нь эдгэрсэн байна. Нийт тохиолдлын 399 (32.8%) нь зөөвөрлөгдсөн, 816 (67.2%) нь дотоодод тархсан халдвар байна.

Коронавирусын нийт тохиолдлын 614 (50.5%) нь эрэгтэй, 601 (49.5%) нь эмэгтэй байна. Насны бүлгээр харвал 20-44 насныхан 626 (51.5%), 45-аас дээш насныхан 339 (27.9%), 0-19 насныхан 250 (20.6%) байна. Харин 12 дугаар сард коронавирусын 16 зөөвөрлөгдсөн, 408 дотоодод тархсан халдвар, нийт 424 тохиолдол илэрсэн байна.

Энэ оны эхнээс коронавируст халдвар дэгдсэнтэй холбоотойгоор хөл хорио тогтоон иргэдийг олон нийтийн газраар явахгүй байж, гараа тогтмол угааж, маск зүүхийг зөвлөж байсны нөлөөгөөр ханиад, томуугийн дэгдэлт өнгөрсөн онуудаас эрс багасаж, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тоо буураад байна. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид 2020 онд 836.3 мянга болж, өмнөх оноос 91.0 (9.8%) мянган хүнээр буурсан байна.

Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа хязгаарлагдсанаас шалтгаалан амьсгалын замаар дамжих халдвар (коронавирусээс бусад) өнгөрсөн оны мөн үеэс 32.7 хувиар буурчээ

Хүн амыг олноор хамарсан халдварт өвчний дэгдэлт болон аюулт үзэгдлийн үед голомтыг хязгаарлах, цомхотгох, хохирлыг багасгахад чиглэсэн эрүүл мэндийн байгууллагын дангаар болон төр, олон нийт, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй хамтран үзүүлэх гамшгийн үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг Гамшгаас хамгаалах тухай хуульд заасны дагуу байгуулагдсан гамшгаас хамгаалах эрүүл мэндийн алба мөн хуульд заасны дагуу зохион байгуулна” гэж Эрүүл мэндийн тухай хуулинд заасан.


### COVID-19 ХАЛДВАРЫН ҮЕД ЗӨСҮТ-ӨӨС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

ЗӨСҮТ-ийн Тохиолдлын удирдлагын тогтолцооны баг 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн идэвхжлийн зэрэгт шилжин 24 цагаар ажиллаж байна.

Цар тахлын үеийн шуурхай хариу арга хэмжээний 8 багийг томилгоожуулан өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэн. Халдварын тоо нэмэгдэхийн хирээр багийн тоог нэмэгдүүлж, багийн чадавхийг өргөжүүлж бүх ажилчдыг ариутгагчаар хөрвүүлэн ажилуулсан байна.

Ард, иргэдэд зөвлөгөө өгөх 70284393 дугаарын утсыг 24 цагаар ажиллуулж, дуудлагад зөвлөгөө, мэдээлэл өгсөн.


**Зураг 4. 43 Шуурхай хариу арга хэмжээний багийн голомтын халдваргүйжүүлэлт зохион байгуулсан тоо**



2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн халдваргүйтгэлийн протокол №1 Чингис хаан нисэх онгоцны буудалд Хонг Конг ирсэн нислэг байсан. ЗӨСҮТ-ийн дуудлагын баг коронавирусийн халдвартай байж болзошгүй зорчигч халдварын гинжин хэлхээг таслах, халдварын эрсдэлийг бууруулах зорилгоор эцсийн халдваргүйтгэлийг онгоцонд, тусгаарлах өрөөнүүдэд тус тус хийж эхэлсэн. 2020-12-31 байдлаар №875 удаагийн протоколын тэмдэглэл хөтлөгджээ.

Эцсийн халдваргүйтгэлийг онгоц, вагон, машин зэрэг тээврийн хэрэгсэлүүд, тусгаарлах байр, орон сууц, хашаа байшингуудад, олон нийтийн талбай, аж ахуй нэгж байгууллага, эмнэлэгүүд, буяны зан үйл, оршуулгын ажилд эцсийн халдваргүйтгэл тогтмол хийсэн байна.

**Зураг 4. 44 ЗӨСҮТ-ийн вирус судлалын лабораторид хийсэн ковид-19 халдварын шинжилгээ**



2020 оны 05 сарын 1-нээс тус төвийн Вирус судлалын лаборатори болон явуулын автолабораторид ковид-19 халдварын шинжилгээг Бодит хугацааны ПГУ-ын аргаар хийж эхэлсэн.

Явуулын автолаборатори нь Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Мандал, Архангай аймгийн Батцэнгэл, Өвөрхангай аймгийн Хужирт, Дорноговь аймгийн Замын-Үүд, Өмнөговь аймгийн Ханбогд суман дах Гашуун сухайт хилийн боомт, Баян-Өлгий аймгийн Улаан байшинт хилийн боомт зэрэг газруудад очиж ковид-19 халдварын шинжилгээ хийсэн.






Шинжилгээнд тусгай үүргийн нислэгээр ирсэн иргэд, өвчтний ойрын хавьтал, тандалт судалгаагаар цуглуулсан сорьцыг хамруулсан.

Шинжилгээний үр дүнд ковид-19 халдварыг хугацаа алдалгүй илрүүлж, оношийг лабораторийн шинжилгээгээр баталгаажуулсан байна.

Зураг 4. 45 ЗӨСҮТ-ийн вирус судлалын лабораторид хийсэн ковид-19 халдварын шинжилгээ





# БҮЛЭГ

5

ЭРҮҮЛ  
МЭНДИЙН  
САЛБАРЫН  
ХҮНИЙ НӨӨЦ



## БҮЛЭГ 5

# ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦ

1942 онд монгол улсын их сургуулийн хүн эмнэлгийн факультет анх байгуулагдсан нь манай орны хувьд орчин цагийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх түүхэн замналын эхлэл болсон юм. Их сургуулийн факультетийн хичээлийг тэр үеийн зөвлөлтийн багш нар өөрийн анагаах ухааны хөтөлбөрийг үндэслэн манай орны өвөрмөц нөхцөлд тохируулан зааж байв. Зөвлөлтийн мэргэжилтэн доцент В.Н.Топольский багшаар ажиллаж байсан төдийгүй, хүн эмнэлгийн анхны деканаар томилогдсон байна.


Хүн эмнэлгийн факультетийн анхны 13 төгсөгчдөөс 9 нь хожмоо хүн эмнэлгийн факультет болон анагаах ухааны дээд, их сургууль, ЭМШУИС-ын багш профессорууд болсоноор барахгүй монголын эрүүлийг хамгаалах байгууллага болон шинжлэх ухааны салбарын нэрт зүтгэлтнүүд болсон байна.

### 5.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НИЙТ АЖИЛЛАГЧИД

1990 онд эрүүл мэндийн байгууллагын ажиллагчдын тоо нийт 47205 буюу 10 000 хүн амд харьцуулахад 217.9 байсан бол 2000 онд 31205 буюу 10 000 хүн амд 132.4 болж 1990 онтой харьцуулахад 85.5-аар буурсан. 10 000 хүн амд ногдох ажиллагчдын тоо улаанбаатар хотод улсын дунджаас 54.1-оор өндөр, аймаг, бүсүүдэд улсын дунджаас 26.3-оор бага байна.


1990 онд хүний их эмчийн тоо 6180 буюу 10 000 хүн амд 27.9 байсан ба нийт ажиллагчдийн 13.1 хувийг эзэлж байна. 2000 онд хүний их эмчийн тоо 6498 болж 10 000 хүн амд харьцуулахад 27.3 байсан ба нийт ажиллагчдын 20.6 хувийг эзэлж байна.

Зураг 5. 1 Эрүүл мэндийн байгууллагын ажиллагчдын тоо, 1990-2000 он



Эрүүл мэндийн салбарт ажиллаж буй эмнэлгийн дунд мэргэжилтэн (бага эмч, эх баригч, эм зүйч, сувилагч, техникч) 1960 онд 10 000 хүн амд харьцуулахад 47.4 байсан бол 1990 онд 88.8 болж нэмэгдсэн ба 2000 онд 56.6 болсон байна.

Зураг 5. 2 Эрүүл мэндийн байгууллагын дунд мэргэжилтнүүд, 10 000 хүн амд, 1960-2000, сонгосон онуудаар



Хүснэгт 5. 1 Эрүүл мэндийн байгууллагын ажиллагчдын тоо, 1990-2020 он, сонгосон онуудаар

Мэргэжил	1990	2000	2005	2010	2015	2020
Бүгд	47 205	31507	33649	39608	47429	56502
Үүнээс: Эмэгтэй	37 482	25284	27556	32591	38737	46379
Эмнэлгийн удирдах ажилтан		0	290	616	871	1277
Эм зүйчид		648	787	1176	1504	2639
Их эмч-Бүгд	6 180	6498	6788	7497	9563	12431
Үүнээс: Эмэгтэй	4406	4999	5306	5919	7376	9518
Ерөнхий мэргэжлийн		858	692	736	2012	1973
Үндсэн ба төрөлжсөн мэргэжлийн:		5094	4977	5825	5833	7895
Дотрын	1041	971	701	749	951	1200
Хүүхдийн	1311	716	488	494	706	725
Мэс заслын ба гэмтэл, согог заслын	333	361	407	491	632	868
Мэдээгүйжүүлэлт, эрчимт эмчилгээний		146	193	254	252	453
Эх барих, эмэгтэйчүүд	403	475	528	608	721	862
Хавдарын	78	29	62	73	58	83
Мэдрэлийн	242	139	188	240	290	378
Сэтгэцийн		98	129	130	127	171
Нүдний	87	84	106	139	147	182
Чих, хамар, хоолойн	116	105	114	127	138	194
Арьс, харшлын	136	152	58	61	145	192
Халдвартын:	202	171	144	165	285	382
БЗДХ/ДОХ		0	70	69	82	76
Сүрьеэгийн	132	93	115	105	97	120
Сэргээн засахын	124	128	94	81	127	161
Эмгэг судлалын	84	91	114	76	91	67
Дүрс оношлогооны	104	89	205	270	416	420
Лабораторийн	219	192	177	264	308	227
Бусад мэргэжлийн		1054	1084	1429	439	342
Уламжлалт анагаахын		178	307	348	700	1015
Нүүр амны	293	368	522	588	1018	1548



2020 оны байдлаар эрүүл мэндийн салбарт нийт 56.5 мянган ажиллагчид Монгол улсад оршин суугаа 3.253.3 мянган хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж байна. 2000 онтой харьцуулахад нийт ажиллагчдын тоо 24.9 мянгаар буюу 10 000 хүн амд 40.8-оор, өмнөх онтой харьцуулахад 3.8-аар нэмэгдсэн байна. Нийт ажиллагчидаас 92.4 хувь нь эрүүл мэндийн салбарын, 7.6 хувь нь бусад салбарын эрүүл мэндийн ажиллагчид эзэлж байна.

Эрүүл мэндийн ажиллагчдын дийлэнх нь эмэгтэйчүүд байгаа ба 2020 онд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2000 онтой харьцуулахад 1.9 хувиар нэмэгдсэн байна. Эрүүл мэндийн ажиллагчдын 22 хувийг их эмч, 23.2 хувийг сувилагч, 4.7 хувийг эмч зүйч, 3.3 хувийг бага эмч, 2.3 хувийг удирдах ажилтан, 2.3 лабораторийн техникч эзэлж байна.

Эрүүл мэндийн байгууллагын шилжилт хөдөлгөөний тайлангаас харахад 12093 хүн нэмэгдсэн ба үүнээс 10.6 хувь нь сургууль төгсөж ирсэн, 66.0 хувь нь шинээр ажилд орсон, 13.4 хувь нь эрүүл мэндийн байгууллага хооронд шилжиж ирсэн, 9.8 хувь нь жирэмсний болон хүүхэд асрах чөлөөнөөс ажилдаа орсон байна.

Тухайн онд 10278 хүн хасагдсан байгаа ба үүнээс 47.2 хувь өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн, 20 хувь нь жирэмсний болон хүүхэд асрах чөлөө авсан, 13.1 хувь нь эрүүл мэндийн байгууллага хооронд шилжсэн, 7.9 хувь нь өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, 0.6 хувь нь нас барсан, 0.4 хувь нь хөдөлмөрийн чадвар алдалтын зэрэг тогтоолгосон ба 10.9 хувь нь бусад шалтгаанаар ажлаас чөлөөлөгдсөн байна.

**Зураг 5. 3 Эрүүл мэндийн ажиллагчид, 2000, 2005, 2009-2020 он**




2020 оны байдлаар 10 000 хүн амд ногдох эрүүл мэндийн ажиллагчид 175.2 байгаа нь 2000 онтой харьцуулахад 40.8, өмнөх онтой харьцуулахад 5.9-оор тус тус нэмэгдсэн байна. Насны бүлгээр авч үзвэл нийт ажиллагчдын 24.4 хувийг 30 хүртэлх насны, 30.1 хувийг 30-39 насны, 22.7 хувийг 40-49 насны, 12.2 хувийг 50-54 насны, 6.3 хувийг 55-59 насны, 4.2 хувийг 60-аас дээш насныхан эзэлж байна. Мэргэжлийн төрөл бүрээр насны ангилал харилцан адилгүй байгаа бөгөөд эх баригч нарын 43.8 хувь, эмч зүйчид 32.4, сувилагч 29.5, их эмч нарын 27.4 хувь нь 30 хүртэлх насныхан эзэлж байна.


10 000 хүн амд ногдох ажиллагчдын тоо улаанбаатар хотод улсын дунджаас 38.4, Говь-Алтай аймагт 21.5-оор өндөр байна. Бусад аймаг, бүсүүдэд улсын дунджаас 2.7-60.2-оор бага байна. Нийт ажиллагчдын тоог бүсээр харьцуулбал, баруун бүсэд хамгийн өндөр буюу 155.5, төвийн бүсэд 142.8, хангайн бүсэд 137.3 байгаа ба зүүн бүсэд хамгийн бага буюу 132.3 байна.

Аймгуудаар харьцуулбал, Говь-Алтай аймагт улсын дунджаас өндөр буюу 10 000 хүн амд ногдох эрүүл мэндийн ажиллагчдын тоо 196.7 байгаа ба Хөвсгөл, Сэлэнгэ, Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгуудад хамгийн бага буюу эрүүл мэндийн ажиллагчдын ачаалал өндөр байгаа нь харагдаж байна. Эрүүл мэндийн ажиллагчдыг хүйсээр харьцуулбал баруун бүсийн аймгуудад эмэгтэйчүүдийн эзлэх хувь улсын дунджаас харьцангуй бага буюу 75-81 хувь байна. Төв, Хангайн бүсийн аймгуудад эмэгтэйчүүдийн эзлэх хувь хамгийн өндөр байна.

Зураг 5. 4 Эрүүл мэндийн ажиллагчид, насны бүлгээр, 2020 он



Зураг 5. 5 Эрүүл мэндийн ажиллагчид, 10 000 хүн амд, бүс, аймгаар, 2020 он






## 5.2 ИХ ЭМЧ, СУВИЛАГЧ

Монгол улсад 1940 онд нийт 108 эмч буюу 10 000 хүн ам тутамд 1.5 эмч ногдож хүн амд орчин үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж байсан бол 1960 онд 10 000 хүн тутамд 10 орчим эмч ногдож байсан. 1965 оноос хүний их эмчийн тоо нэмэгдэж 10 000 хүн ам тутамд 14 эмч буюу нэг эмчид ногдох хүний тоо 742 болж буурсан байна. 2000 оны байдлаар 10 000 хүн ам тутамд 27.3 эмч ногдож байсан ба 1 эмчид ногдох хүний тоо 366 болсон.


Зураг 5.6 Их эмчийн тоо, 1925-2000 сонгосон онуудаар



2020 оны байдлаар нийт 12431 буюу 10 000 хүн ам тутамд 38.5 эмч, нийт 13112 сувилагч буюу 10 000 хүн амд 40.7 сувилагч ногдож байна. Үүнээс хүний их 9868 байгаагаас 80 хувь нь үндсэн ба төрөлжсөн мэргэжлийн чиглэлээр ажиллаж байна.

Уламжлалт анагаахын эмч 1015, Нүүр амны эмч 1548 байна. Насны бүлгээр авч үзвэл 27.4 хувийг 30 хүртэлх насны, 35.5 хувийг 30-39 насны, 15.6 хувийг 40-49 насны, 8.5 хувийг 50-54 насны, 6.1 хувийг 55-59 насны, 7.0 хувийг 60-аас дээш насны эмч нар эзэлж байна.

Зураг 5.7 Их эмч, сувилагчийн тоо, 10 000 хүн ам тутамд, 2000, 2005, 2009, 2010-2020 он




Монгол улсад 2020 оны байдлаар 10 000 хүн амд ногдох их эмчийн тоо 2000 онтой харьцуулахад их эмч 10.8-аар, сувилагч 9.2-оор, өмнөх онтой харьцуулахад их эмч 1.5-оор, сувилагч 0.7-аар тус тус нэмэгдсэн байна.


Их эмчийг мэргэшлийн төрлөөр нь харуулбал: 2000 онд 10 000 хүн амд ногдох дотрын эмч 4.1 байсан бол 2010 онд 2.8 болж буурсан хэдий ч сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа ба 2020 онд 3.7 болсон байна. 2020 онд мэс засал ба гэмтэл согог засал, эх барих эмэгтэйчүүдийн эмч тус бүр 10 000 хүн ам тутамд 2.7 ногдож байгаа нь 2000 оноос 0.7 ба 1.2-оор тус тус нэмэгдсэн байна. Мэдээгүйжүүлэлт, эрчимт эмчилгээний эмч 1.4 байгаа нь 2000 оноос 0.8, 2010 оноос 0.4-оор тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.



Зураг 5. 8 10 000 хүн амд ногдох их эмч, мэргэшлийн төрлөөр, 2000, 2005, 2009-2020 он



Зураг 5. 9 10 000 хүн амд ногдох их эмч, мэргэшлийн төрлөөр, 2000, 2005, 2009-2020 он




2020 оны байдлаар хүүхдийн эмч 725 ажиллаж байгаа нь 10 000 хүүхдэд 7.2 хүүхдийн эмч, эх барих эмэгтэйчүүдийн эмч 862 байгаа 10 000 эмэгтэйд 5.1 эмч ногдож байна.

Эмч, сувилагчийг байршлаар авч үзэхэд хөдөө орон нутагт 10 000 хүн амд ногдох их эмч 24.7, сувилагч 33.4 байхад Улаанбаатар хотод эмч 52.4, сувилагч 46.8 байгаа нь хот суурин газар эмчийн нягтрал ихтэй байгаа нь харагдаж байна. Ялангуяа аймагт Улаанбаатар хоттой харьцуулахад мэс заслын эмч 2.2 дахин, гэмтэл, согог заслын эмч 2.3 дахин, дүрс оношилгоо, нүүр амны эмч 3.2-3.8 дахин тус тус бага байна.




Зураг 5. 10 10 000 хүн амд ногдох их эмч, мэргэшлийн төрлөөр, 2020 он




Нийт эмч нарын 62.4 хувь нь Улаанбаатар хотод, 37.6 хувь нь аймаг, орон нутагт ажиллаж байна. 10 000 хүн амд ногдох их эмчийн тоо улаанбаатар хотод 52.4 буюу улсын дунджаас 13.9-оор их байгаа ба баруун бүсэд 27.6, хангайн бүсэд 24.5, төвийн бүсэд 29.5, зүүн бүсэд 25.3 байна.

Зураг 5. 11 10 000 хүн амд ногдох их эмч, бүс нутгаар, 2016-2020 он




Зураг 5. 12 10 000 хүн амд ногдох сувилагч, бүс нутгаар, 2016-2020 он



### 5.3 ИХ ЭМЧ, СУВИЛАГЧИЙН ХАРЬЦАА

Эмч, сувилагчийн харьцаа улсын түвшинд 1:1.1, Улаанбаатар хотод 1:0.9, аймгийн түвшинд 1:1.4 байна. Эмч, сувилагчийн харьцаа аймаг бүсүүдээр ялгаатай байгаа ба хангай, баруун, зүүн бүсийн аймгуудад 1:1.4 байгаа бол төвийн бүсийн аймгуудад 1:1.2 байна.

Зураг 5. 13 Эмч, сувилагчийн харьцаа, бүс нутгаар, 2020 он





Хүснэгт 5. 2 Их эмч, сувилагчийн харьцаа, бүсээр, 2016-2020 он

Аймаг, нийслэл	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
Улсын дундаж	1.1	1.1	1.1	1.1	1.1
Баруун бүс	1.5	1.4	1.4	1.4	1.4
Баян-Өлгий	1.7	1.6	1.5	1.5	1.5
Говь-Алтай	1.4	1.4	1.3	1.4	1.2
Завхан	1.5	1.5	1.6	1.6	1.5
Увс	1.6	1.5	1.6	1.5	1.6
Ховд	1.4	1.3	1.3	1.2	1.1
Хангайн бүс	1.4	1.4	1.4	1.3	1.4
Архангай	1.5	1.6	1.5	1.5	1.4
Баянхонгор	1.7	1.6	1.5	1.4	1.4
Булган	1.6	1.6	1.7	1.5	1.5
Орхон	1.3	1.3	1.3	1.1	1.2
Өвөрхангай	1.3	1.3	1.3	1.2	1.3
Хөвсгөл	1.5	1.5	1.5	1.4	1.6
Төвийн бүс	1.2	1.2	1.2	1.2	1.2
Говьсүмбэр	1.2	1.2	1.0	0.9	0.9
Дархан - Уул	1.3	1.3	1.4	1.6	1.4
Дорноговь	1.0	1.1	1.0	0.9	1.0
Дундговь	1.2	1.1	1.1	1.0	1.0
Өмнөговь	1.0	0.9	1.0	0.8	0.9
Сэлэнгэ	1.3	1.3	1.3	1.3	1.4
Төв	1.5	1.4	1.3	1.4	1.2
Зүүн бүс	1.5	1.4	1.4	1.4	1.4
Дорнод	1.6	1.5	1.5	1.4	1.5
Сүхбаатар	1.4	1.4	1.4	1.5	1.4
Хэнтий	1.4	1.3	1.3	1.3	1.2

Нэг их эмчид ногдох хүний тоо 2020 онд 259 байгаа нь өмнөх оныхоос 11 хүнээр, нэг сувилагчид ногдох хүний тоо 246 болж, өмнөх оныхоос 4 хүнээр тус тус буурсан байна. Нэг их эмчид ногдох хүний тоо Хангайн бүсэд хамгийн өндөр буюу 409 хүн ногдож байгаа ба баруун бүсэд 362, зүүн бүсэд 395, төвийн бүсэд 339 хүн ногдож байна. Улаанбаатар хотод нэг их эмчид ногдох хүний тоо 191, нэг сувилагчид ногдох хүний тоо 211 байна. Нэг сувилагчид ногдох хүний тоо хангайн бүсийн аймгуудад хамгийн өндөр буюу 298 байна.

Нийт ажиллагчдын 35.9 мянга буюу 65.7 хувь нь төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагуудад, 18.7 мянга 34.3 хувь нь хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж байна.

Төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагуудад нийт 35.9 мянган ажиллагчид хүн амд эрүүл


мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байна. Үүнээс сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд 23.9, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүдэд 17.4, аймгийн нэгдсэн эмнэлгүүдэд 14.5, дүүргийн нэгдсэн эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төвүүдэд 9.7, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 7.9 хувь нь тус тус ажиллаж байна.

Хүснэгт 5. 3 Нэг их эмчид ногдох хүний тоо, байршлаар, 2016-2020 он

Аймаг, нийслэл	Нэг их эмчид ногдох хүний тоо				
	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
Улсын дундаж	309	293	283	271	259
Баруун бүс	425	409	403	381	362
Баян-Өлгий	539	495	482	436	411
Говь-Алтай	319	305	300	313	282
Завхан	386	395	408	399	395
Увс	477	485	459	423	424
Ховд	404	374	368	334	311
Хангайн бүс	447	449	437	403	409
Архангай	503	548	516	464	455
Баянхонгор	485	461	435	414	437
Булган	503	505	558	459	418
Орхон	312	313	298	278	296
Өвөрхангай	442	445	438	406	393
Хөвсгөл	539	526	513	490	516
Төвийн бүс	375	369	368	353	339
Говьсүмбэр	322	301	277	264	311
Дархан - Уул	357	368	380	366	336
Дорноговь	295	304	285	280	259
Дундговь	348	326	340	305	292
Өмнөговь	343	342	342	306	300
Сэлэнгэ	455	438	434	437	468
Төв	457	430	437	437	382
Зүүн бүс	427	415	418	412	395
Дорнод	443	430	430	410	420
Сүхбаатар	391	397	395	430	388
Хэнтий	443	416	427	400	376
Улаанбаатар	237	218	208	201	191




Зураг 5. 14 Нэг сувилагчид ногдох хүний тоо, байршлаар, 2016-2020 он



Хүснэгт 5. 4 Эм зүйчийн тоо, байршлаар, сонгосон онуудаар

Аймаг, нийслэл	1990	1995	2000	2005	2010	2015	2020
Бүгд	195	311	648	787	1176	1504	2639
Баруун бүс	43	42	40	40	46	117	217
Баян-Өлгий	8	8	7	8	10	26	48
Говь-Алтай	6	4	5	3	10	20	34
Завхан	11	14	9	9	10	19	28
Увс	9	8	8	10	9	28	53
Ховд	9	8	11	10	7	24	54
Хангайн бүс	54	48	61	55	103	159	288
Архангай	6	5	6	5	13	24	36
Баянхонгор	7	6	7	9	11	18	47
Булган	9	9	9	7	8	12	25
Орхон	10	12	19	22	46	51	101
Өвөрхангай	12	8	9	8	13	27	36
Хөвсгөл	10	8	11	4	12	27	43
Төвийн бүс	67	42	62	66	79	163	227
Говьсүмбэр	0	2	4	2	5	8	12
Дархан-Уул	13	8	19	26	22	61	61
Дорноговь	7	4	7	10	17	26	41
Дундговь	8	6	6	4	2	12	22
Өмнөговь	14	10	10	8	15	25	48
Сэлэнгэ	14	4	11	11	11	18	26
Төв	11	8	5	5	7	13	17
Зүүн бүс	26	20	22	17	23	40	76
Дорнод	11	7	11	6	6	16	33
Сүхбаатар	5	7	4	5	6	9	22
Хэнтий	10	6	7	6	11	15	21
Улаанбаатар	5	159	463	609	925	1025	1831



БҮЛЭГ

6

ХАЛДВАРТ  
ӨВЧИН





## БҮЛЭГ 6.

# ХАЛДВАРТ ӨВЧИН

### 6.1 БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 11 дүгээр тогтоолоор халдварт өвчнийг тандах, сэргийлэх, дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээг уян хатан, чанартай, хүртээмжтэй, шуурхай зохион байгуулах чадавхийг бэхжүүлэхэд бусад салбарын оролцоог нэмэгдүүлэх, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүгийн тогтвортой байдлыг хангах замаар халдварт өвчний тархалтыг бууруулах зорилгоор “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах” үндэсний хөтөлбөрийг баталсан. “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах” үндэсний хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтэд сүрьеэгийн бүртгэгдсэн тохиолдлыг ( 10000 хүн амд ногдох) 2020 он гэхэд 14.4 болгох зорилт тавьсан байна. Гепатит А вирусун цочмог халдварт өвчний түвшин ( 10000 хүн амд ногдох-г 2020 онд 8 болгох зорилт 2019 онд 0.2 болж биелсэн байна. Гепатит В вирусун цочмог халдварын өвчлөлийн түвшин 2020 онд 1.3 болгох зорилт 2019 онд 0.4 болж мөн зорилтот түвшинд хүрсэн байна. Цусан суулга ( 10000 хүн амд ногдох) өвчний түвшин 2020 онд 7.0 болгох зорилт 2019 онд 8.0 байна.

### 6.2 ХАЛДВАРТ ӨВЧНИЙ БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ТҮҮХ

Эрүүл мэндийн статистикийн мэдээгээр 1928 онд 8 төрлийн халдварт өвчний 153 тохиолдол бүртгэсэн мэдээлэл байгаа бөгөөд 1930 онд 11 төрлийн халдварт 1595 тохиолдол, 15 нас баралт бүртгэгдэж байсан байна.

Түүнээс хойш 2020 оны байдлаар Монгол улсад нийт 50 төрлийн халдварт өвчин бүртгэгдсэн ба энэ хугацаанд хяналт, сэргийлэлт, дархлаажуулалтын үр дүнд зарим өвчнийг устгасан орноор бүртгэгдэж, хэд хэдэн өвчнийг хяналтандаа авч чадсан байна. Тухайлбал, Монгол улс дархлаажуулалтын дүнд дэлхий дахинаа цагаан цэцэг, халдварт саа өвчний устгасан орноор бүртгэгдсэн ба, вакцинаар сэргийлж болох бага насны хүүхдийн өвчлөл, эндэгдлийн үндсэн шалтгаан болох сахуу, нярайн татран, хөхүүл ханиадны өвчлөлийг хяналтандаа авч, сүүлийн 20 жилд бүртгэгдээгүй байна.


Полиомиелитын эсрэг дархлаажуулалтыг 1962 онд тэр үеийн ЗХУ-д үйлдвэрлэдэг байсан үрлэн вакцинаар эхэлсэн бөгөөд 1982 оны эпидемийн дараа шингэн вакцин шилжсэн болно.

1993 оноос хойш Монгол улсад полиомиелит өвчин бүртгэгдээгүй, полиовирусун зэрлэг омгийн эргэлт зогссон тул 2000 онд полиомиелит өвчин устгасныг баталгаажуулсан юм

Цагаан цэцэг өвчний эсрэг дархлаажуулалтыг БНМАУ-д 1923 оноос эхлэн хэрэглэсэн нь дархлаажуулалтын хөтөлбөрийн эхлэл болсон. 1933 онд бактери шинжилгээний газар буюу Санбакинститутц байгуулагдсан бөгөөд 1933 оноос тус газар цагаан цэцгийн вакциныг үйлдвэрлэж, цэцгийн тарилгаар 186 800 хүнийг тарьжээ.


Монгол улсад цагаан цэцэг өвчний сүүлийн тохиолдол 1938 онд бүртгэгдсэн нь уг өвчнийг дэлхий дахинд устгасныг баталгаажуулснаас 42 жилийн өмнө болсон байна. 1940 он гэхэд өвчилсөн хүний 50 хувь нас барж байсан цагаан цэцэг өвчнийг устгасан байна.

Зураг 6. 1 Цагаан цэцэг өвчний өвчлөлийн түвшин, 10 000 хүн амд, 1928-1938 он



Байгалийн голомтот халдвар болон мал амьтнаас хүнд халдварлах өвчин, түүний дотроос тарваган тахал өвчнийг 1928 оноос эхлэн бүртгэсэн мэдээлэл байгаа ба 1990 оноос хойш 2019 оны байдлаар нийт 136 хүн тарваган тахлаар өвчилсний 30 нь нас барж, өвчлөлийн голомт жил тутамд бүртгэгдсээр байна. Галзуу боомоор өвчилсөн малын тоо олон дахин өсч байгаа нь хүний өвчлөлд шууд нөлөөлж байна.

Зураг 6. 2 Тарваган тахлын өвчлөлийн түвшин, 1928-2000 он



Монгол улсад 1928 онд улаанбурхан өвчний 55 тохиолдол бүртгэгдэж байсан бөгөөд улаанбурхан өвчний эсрэг вакциныг 1974 оноос эхлэн товллын хүрээнд Монгол улсад хийж эхэлсэн.


Энэ нь уг өвчнийг бууруулахад дорвитой нөлөөлж, улмаар устгах өвчний тоонд оруулах болсон. Гэвч манай улсад 1965, 1977, 2002 онуудад дэгдэлт гарсан ба Монгол Улс 2014 онд ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсэд улаанбурхан өвчинг бүрэн устгасан орны тоонд орсон.

Гэсэн хэдий ч 2015, 2016 онуудад томоохон тахалт дэгдэлт гарсан байна. Дархлалгүй, халдвар авсан бүх хүн өвчлөх боломжтой бөгөөд 1980 оноос хойш 15-аас дээш насныхан илүү өвчлөх хандлагатай болсон. Урьд нь өвчилсөн буюу дархлаажуулагдсан эхээс өрсөн хүүхэд эхээсээ дархлаа авсан байдаг учраас эхний 3 сардаа энэ өвчнөөр өвчлөхгүй. Харин энэ дархлаа 6-10 дахь сард бараг байхгүй болдог тул улаан бурхнаар өвчлөх боломжтой.

Монгол улсад 2015 онд 100 гаруй нялхсын амь насыг авч одсон вакцинаар сэргийлж болох улаанбурхан өвчний дэгдэлтэнд нөлөөлсөн хүчин зүйлийн нэгэнд сүүлийн 25 жилийн хугацаанд давхардсан тоогоор 122 557 хүүхэд улаанбурханы эсрэг вакцинаас хоцорсонтой холбон үзэж байна.




Зураг 6. 3 Улаанбурханы өвчлөл, 10 000 хүн амд, сонгосон онуудаар



Полиомиелитын эсрэг дархлаажуулалтыг 1962 онд тэр үеийн ЗХУ-д үйлдвэрлэдэг байсан үрлэн вакцинаар эхэлсэн бөгөөд 1982 оны эпидемийн дараа шингэн вакцинд шилжсэн болно.


1993 оноос хойш Монгол улсад полиомиелит өвчин бүртгэгдээгүй, полиовирусын зэрлэг омгийн эргэлт зогссон тул 2000 онд полиомиелит өвчин устгасныг баталгаажуулсан юм.

Зураг 6. 4 Полимиелит өвчний өвчлөлийн түвшин, 1962-1993 он



Амьсгалын замын халдварт өвчнүүдээс улаан эсэргэнэ, улаанбурхан, салхинцэцэг өвчнийг 1928 оноос, гахай хавдрын өвчлөл 1961 оноос бүртгэж эхэлсэн ба энэ хугацаанд салхинцэцгийн хэд хэдэн удаагийн дэгдэлт гарч байсан бөгөөд одоо ч өвчлөлийн тохиолдол дорвитой буурахгүй байна.


Зураг 6. 5 Амьсгалын замын зарим халдварт өвчнүүд, 10 000 хүн амд, сонгосон онуудаар



Гэдэсний халдварт өвчнүүдээс цусан суулга, гэдэсний хижиг өвчнийг 1928 оноос эхлэн бүртгэсэн мэдээлэл байгаа ба одоогийн байдлаар гэдэсний халдварт өвчний 6 төрлийн өвчин бүртгэгдэж байна. Гэдэсний хижиг өвчин 1928-1938 оны хооронд нийт 1636 тохиолдол бүртгэгдсэн ба 1938 оноос бүртгэгдээгүй утсан өвчний тоонд орж байна. Сүүлийн жилүүдэд цусан суулга ихсэх

хандлагатай болж хоолны хордлого нэмэгдсээр байна. Энэ нь баталгаагүй хоол хүнс хэрэглэх, хөрс орчны бохирдол их болсонтой холбон үзэх үндэстэй юм.

Зураг 6. 6 Балнад, цусан суулгын өвчлөл эндэгдэл, 1966-2000 он



## БЭЛГИЙН ЗАМААР ДАМЖИХ ХАЛДВАРЫН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЭЛ

1921 оноос эхлэн хүн амын эрүүл мэндийг судлах, эрүүлжүүлэх 7 удаагийн экспедици, отрядын үйл ажиллагааны нэг хэсэг болох Шастин эмчийн мэдээлснээр 1927 онд тэмбүү өвчний өвчлөл үзлэгт хамрагдсан хүн амын 50%-д илэрч байсан, 1934 оны Хетимана, Каркина нарын судалгаагаар 40.8%-д 1937-1938 онд их эмч Лейны судалгаагаар 33.4%-д нь үзлэгт хамрагдсан хүмүүст тэмбүү өвчин илэрч байсан. 1956 онд 15%, 1960 онд 7.7% болон буурчээ. Үүнээс үзэхэд 1927-1960 онд тэмбүү өвчин 6 дахин буурсан байна.

1958-1960 оны эрүүлжүүлэх отрядын дүнг хэлэлцээд 1960 оны 4-р улирлаас эхлэн бүх аймгуудад тухайн аймагт нь ажилласан эрүүлжүүлэх отрядын материаллаг бааз, боловсон хүчнийг түшиглэн 36-40 ортой арьс өнгөний диспансер байгуулах, 1961 оноос илэрсэн бүх тэмбүү өвчнийг “яаралтай мэдэгдэх хуудас”-аар бүртгэх, Арьс өнгөний төв диспансерт төвлөрүүлэн нэгтгэн дүгнэж, холбогдох газруудад мэдээлж, арга хэмжээ авч ажиллах, ухуулга сурталчилгаа явуулах нь зүйтэй гэжээ.


Ингээд 1960 оны сүүлч гэхэд 18 аймагт хэвтүүлэн эмчлэх ортой, эргүүл дуудлагын сувилагчтай, серологи лабораторитой, аймгийн ЭХГ-ын шууд харьяанд ажиллах орон тоо, төсөвтэй Арьс өнгөний диспансерууд ажиллаж эхэлсэн байна.

Энэ хугацаанд эмгэг судлалын лаборатори, нян судлалын лаборатори нээсэн ба тэмбүү өвчнийг оношлоход онцгой анхаарч РИТ, РИФ-ийн лабораторийн байгуулан ажиллуулжээ. Түүнчлэн 1964 онд УБ хотын 4 районд Арьс өнгөний кабинет нээн ажиллуулсан ба 1977 онд Арьс өнгөний диспансер болгон өргөтгөсөн байна.

1966-1989 онуудад Монгол оронд бэлгийн замын өвчин нилээд буурч, улсын хэмжээнд тэмбүү өвчин 10.000 хүн амд 36.1-3.9 болж, төрөлхийн тэмбүүгийн тохиолдол 1-2 болсон байна.



Зураг 6. 7 Бэлгийн замаар дамжих халдварт өвчин, 10 000 хүн амд, 1965-2000 он



### СҮРЬЕЭ ӨВЧНИЙ БҮРТГЭЛ


1958-1960, 1959-1961 онд ажилласан Зөвлөлт-Монголын хамтарсан экспедици сүрьеэ, өнгөний өвчнийг илрүүлэн эмчлэх түүнтэй тэмцэх эмнэлгийн салбарыг байгуулах ажлыг зохион байгуулснаар сүрьеэ, өнгөний өвчинтэй тэмцэх салбарын тогтолцоог бүрдүүлсэн түүхтэй. ЗХУ-аас олон удаа ирүүлж ажиллуулсан экспедици монголын ард түмний дунд ямар өвчин эмгэг зонхилж буйг тогтоох түүнтэй тэмцэх арга замыг тодорхойлж өгсөнд түүний ач холбогдол оршдог.

1994 оноос хэрэгжиж эхэлсэн сүрьеэтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд сүрьеэгийн оношлогоо, эмчилгээний олон улсын стандарт (ДОТС) нэвтрүүлсэн.

Үүний дүнд сүрьеэгийн илрүүлэлт сайжирсантай холбоотойгоор сүрьеэгийн өвчлөл өсөх хандлагатай болсон. Энэ нь мөн нийгэм-эдийн засгийн хямрал гүнзгийрсэнтэй, өмнө нь тайлан, бүртгэлд хамрагддаггүй байсан бүлгүүд болох хоригдлууд, тэнэмэл хүүхдүүд улсын бүртгэлд хамрагдах болсонтой холбоотой юм.

Харин сүрьеэгийн тархалт тогтвортой буурч, сүрьеэгийн бүрэн эдгэрэлтийн түвшин нэмэгдэж, шинээр илэрсэн сүрьеэтэй өвчтөний дотор нас баралтын эзлэх хувь буурч байгаа нь эмчилгээний шинэ стратеги үр дүнтэй болохыг харуулж байна.


Зураг 6. 8 Сүрьеэгийн өвчлөл, нас баралт, 1962-2000 он



## 6.3 ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ


Сүүлийн 10 жилийн дунджаар улсын хэмжээнд нийт 32 төрлийн 45102 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүн амд харьцуулахад 10 жилийн дунджаар 155.0 байна. Улсын хэмжээнд 2020 онд 31 төрлийн халдварт өвчин бүртгэгдэж, халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 33.4 мянгад хүрчээ.

Зураг 6.9 Халдварт өвчнөөр өвчлөгчид, 2010-2020 он



Халдварт өвчний тохиолдлыг аймаг, нийслэл, бүсээр харьцуулан харвал улаанбаатар хот, зүүн бүсийн аймгуудад улсын дунджаас 10 000 хүн тутамд 25-44 тохиолдлоор өндөр байна. Зүүн бүсийн аймгуудаас 2019 оны байдлаар Дорнод, Сүхбаатар аймгуудад улсын дунджаас өндөр байгаа ба Хэнтийн аймагт 2010 оны байдлаар өвчлөл улсын дунджаас өндөр байсан ба сүүлийн жилүүдэд буурах хандлагатай байна.

Зураг 6.10 Халдварт өвчнөөр өвчлөгчид, бүсээр, 2010-2020 он




Сүүлийн 5 жилийн дунджаар халдварт өвчнөөр өвчлөгчдийг өмнөх 5 жилийн дундажтай харьцуулахад 12.4 мянга (31.4%)-аар, 10000 хүнд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчид 19.8-аар өссөн нь 2015-2016 онд бүх аймаг, нийслэлийг хамарсан улаанбурханы томоохон дэгдэлт гарч, сэжигтэй 53.7 мянган тохиолдол бүртгэгдсэнтэй холбоотой байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчдийг өвчний төрлөөр, дүнд эзлэх хувиар авч үзэхэд 2016-2020 оны дунджаар амьсгалын замын халдварт өвчин 18.9 мянга (36.7%) болж, 2011-2015 оны дунджаас 2.1 мянгаар, бэлгийн замаар дамжих халдварын тохиолдол 16.1 мянга (36.5%) болж, 1.1 (0.8%)-аар тус тус нэмэгджээ. Гэдэсний халдварт өвчин 8.8 мянга (19.4%) болж, 0.4 мянга (8%)-аар, зоонозын халдварт өвчний тохиолдол 410 (0.9%) болж, 91 тохилдлоор тус буурсан байна.




Зураг 6. 11 Халдварт өвчнөөр өвчлөгчид, төрлөөр, дүнд эзлэх хувиар



Халдварт өвчний тохиолдлын (10000 хүнд ногдох) түвшинг сүүлийн 10 жилийн байдлаар харахад 2011-2015 оны дунджаар бэлгийн замаар дамжих халдварын тохиолдлын түвшин тэргүүлж дунджаар 53 болж, сүүлийн 2016-2020 оны дунджаас 1-ээр их байсан байна. Харин сүүлийн 5 жилийн дунджаар амьсгалын тогтолцооны өвчний түвшин дунджаар 78 болж, өмнөх 5 жилийн дунджаас 38-аар нэмэгдэж тэргүүлжээ.

Зураг 6. 12 Халдварт өвчний тохиолдол (10000 хүнд ногдох), төрлөөр, 2010-2020 он



Улсын хэмжээнд 2020 оны байдлаар 28 төрлийн 33.4 мянган халдварт өвчний тохиолдол бүртгэгдсэн нь сүүлийн 10 жилийн дунджаас 7.9 хувиар буурч, өмнөх оноос 7.5 хувиар нэмэгдсэн байна. 10000 хүн амд ногдох халдварт өвчин 142 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 31.4, өмнөх оноос 26 хувиар буурчээ.

Халдварт өвчний тохиолдлын (10000 хүнд ногдох) түвшинг 2020 оны байдлаар, бүсээр харвал зүүн бүсэд улсын дунджаас 10.9-аар их, бусад бүсэд 11-23-аар бага байна. Аймаг, нийслэлээр харвал Сүхбаатар, Дорноговь, Улаанбаатар, Баянхонгор, Дорнодод улсын дунджаас 6-127-гоор их, бусад аймагт 36-103-аар бага байна.

Халдварт өвчний бүтцийг 2020 оны байдлаар харахад нийт халдварт өвчний 48.4 хувийг бэлгийн замаар дамжих халдварт өвчин эзэлж, өмнөх оноос 9.6 хувиар, амьсгалын замын халдварт өвчин 7.6, цусаар дамжих халдвар 0.1 пунктээр нэмэгдэж харин зоонозын халдварт өвчин, гэдэсний халдварт өвчин 0.1-9.1 пунктээр буурчээ.




## 6.4 АМЬСГАЛЫН ЗАМЫН ХАЛДВАРТ ӨВЧИН

Улсын хэмжээнд сүүлийн 10 жилийн дунджаар амьсгалын замын халдварт өвчний нийт 16750 тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүн амд 153.3 байна. Сүүлийн 10 жилийн дунджаар амьсгалын замаар дамжих халдварын дийлэнх хувийг улаанбурхан, салхин цэцэг өвчний тохиолдол эзэлж байна.

Амьсгалын замын халдварт өвчнүүдээс салхинцэцэг, улаан эсэргэнэ өвчлөлийн тохиолдол жил дараалан нэмэгдэж, гахай хавдар буурах хандлагатай байна. Амьсгалын замын халдварт өвчний 49.5 хувь, нийт халдварт өвчний 10 хувийг эзэлж байгаа сүрьеэгийн тохиолдол төдийлөн буурахгүй Жил тутам сүрьеэ өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоолгож буй иргэдийн тоо нэмэгдсээр байгаа ба тэр дундаа 70-аас дээш хувиар тогтоолгох нь нэмэгдсээр байна.

2020 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд амьсгалын замын халдварт өвчний 6750 тохиолдол бүртгэгдэж, нийт халдварт өвчний 20.2% -ийг эзэлж байна. Амьсгалын замын халдварт өвчин өмнөх оноос 8888 тохиолдлоор буюу 56.8%-иар буурсан байна. Улсын хэмжээнд амьсгалын замын халдварын 3 нас баралт бүртгэгдсэн нь менингококкт халдвар (3) тохиолдол байна.

Зураг 6. 13 Амьсгалын замын халдварт өвчний тоо, хувь, 2010-2020 он




Хүснэгт 6. 1 Амьсгалын замын халдварт өвчнүүдийн тоо, 2010-2020 он

Амьсгалын замын халдварт өвчнүүд	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Нийт	6 207	8 373	16 354	14 529	9 677	34 600	43 198	15 805	13 122	15 638	6 750
Сүрьеэ	4 213	3 985	3 944	4 111	4 172	4 270	4 045	3 779	3 498	3 624	3 339
Менингококкт халд	28	20	28	40	14	11	10	13	12	20	8
Салхин цэцэг	1 268	3 097	2 806	4 669	4 639	5 624	6 834	9 643	8 130	10 652	2 883
Улаан бурхан	0	0	0	0		23 464	30 273	17	1	2	1
Улаан эсэргэнэ	21	68	89	271	276	754	1 378	1 797	922	936	261
Гахайн хавдар	524	1 016	9 060	5 268	425	241	346	219	319	125	103
Ёлом	141	169	201	137	136	145	160	236	188	240	147
Халдварт эритема	1	2	11	15	13	42	104	90	48	34	7
Улаанууд	11	16	215	15	1	49	48	11	4	5	1



Жил бүр шинэ сүрьеэгээр дунджаар 400 хүүхэд шинээр сүрьеэгээр өвчилж байгаа нь нийт өвчлөлийн дотор 10%-ийг эзэлж байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд 2016 онд хамгийн их буюу 516 хүүхэд бүртгэгдэж байсан бол 2017 онд 424, 2018 онд 293 болж буурсан ч 2020 онд 382 болж дахин өссөн байна.


Зураг 6. 14 Амьсгалын замын халдварт өвчнүүд, 10 000 хүн амд, бүсээр, 2010-2020 он



#### 6.4.1 САЛХИНЦЭЦЭГ

Улсын хэмжээнд сүүлийн 10 жилийн дунджаар салхинцэцэг өвчний нийт 5477 тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүн амд 18.8 байна. 2010 онд 1268 тохиолдол бүртгэгдэж байсан бол 2020 онд 2883 тохиолдол бүртгэгдэж 10 жилийн дунджаас 2594 тохиолдлоор буурсан байна.

Зураг 6. 15 Салхинцэцэг өвчин, 2010-2020 он



2020 онд салхинцэцгийн 2883 өвчлөл 10 000 хүн амд 9.0 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний дотор 8.6 хувийг, амьсгалын замын халдвар өвчний 42.7 хувийг тус тус эзэлж байна. Нийт тохиолдлын 80-90% нь хөнгөн явцтай, гэрээр ӨЭМТ-ийн хяналтад эмчлэгдсэн байна.

Өвчлөлийн 53.7% Улаанбаатар хотод, 46.3% аймагт бүртгэгдсэн. Өнгөрсөн онтой харьцуулахад Булган аймагт өвчлөл нэмэгдэж бусад аймгуудад бурсан үзүүлэлттэй байна. Сүхбаатар (10.4), Дорноговь (19.4), Өмнөговь (37.6) аймгууд болон Улаанбаатар хотод (10.1) улсын дундажаас 1.4-28.9 тохиолдлоор дээгүүр үзүүлэлттэй байна.

### 6.4.2 МЕНИНГОКОККТ ХАЛДВАР

Улсын хэмжээнд бүртгэгдсэн менингококкт халдварын өвчлөлийн хөдлөлзүйгээс харахад 1974, 1994 онд хүн амыг олноор хамарсан тахалт тархалт гарч 10,000 хүн амд 14-өөс 19 тохиолдол бүртгэгдэж, 1995 оноос өвчлөл тууштай буурсан хэдий ч 2007 онд бага зэрэг нэмэгдэн 10 000 хүн амд 0.6 тохиолдол бүртгэгдэж байсан байна. Сүүлийн 10 жилд 10 000 хүн амд менингококкт халдварын 0.04-өөс 0.3 тохиолдол бүртгэгджээ

2020 онд менингококкт халдварын 8 тохиолдол бүртгэгдсэн байгаа нь өнгөрсөн оноос 12 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна.


Өвчлөлийн улиралчлалаар харахад 90% (18) нь 1-5 дугаар сард бүртгэгддэг байна. 2020 оны 1-5 дугаар саруудад нийт өвчлөлийн 90% (7) нь бүртгэгдсэн байна.

2020 онд бүртгэгдсэн өвчлөлийг насны бүлгээр харуулбал, 35 хүртэлх насныханд бүртгэгдэж, үүнээс 90.0%-ийг 0-9 насныхан эзэлж байна. Энэ нь өмнөх он, сүүлийн 5 жилийн дундажтай харьцуулахад ижил, насны бүлэгт өөрчлөлт ороогүй байна. Нийгмийн байдлаар авч үзэхэд нийт өвчлөлийн 44% нь гэртээ байдаг, 33% цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд бүртгэгдсэн бөгөөд 1 тохиолдол буюу 23% нь албан хаагч байна.

### 6.4.3 ГАХАЙ ХАВДАР

Улсын хэмжээнд сүүлийн 10 жилийн дунджаар гахай хавдрын нийт 1712 тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүн амд 6.2 байна. 2012, 2013 онд дэгдэлт байдлаар бүртгэгдэж байсан бол 2020 онд 103 тохиолдол бүртгэгдэж сүүлийн 10 жилийн дунджаас 1609 тохиолдлоор буурсан байна.

Зураг 6. 16 Гахайн хавдрын өвчлөл, сүүлийн 10 жилээр



Улсын хэмжээнд 2020 онд гахай хавдар өвчний 103 тохиолдол 10 000 хүн амд 0.3 байгаа нь өмнөх оноос 0.1 тохиолдол, сүүлийн 10 жилийн дундажаас 5.9 тохиолдлоор тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Нийт халдварын 40.8% (42) нь Улаанбаатар хотод, 59.2% (61) нь орон нутаг (12 аймаг)-т бүртгэгдсэнээс Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Өвөрхангай, Увс, Ховд аймагт өвчлөл 10,000 хүн амд 0.1-0.5 тохиолдлоор нэмэгдэж, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Дундговь, Өмнөговь, Хөвсгөл, Сүхбаатар, Хэнтий аймгууд болон Улаанбаатар хотод 0.1-0.7 тохиолдлоор буурсан байна. Бүртгэгдсэн өвчлөлийн 65.0% нь 10 хүртэлх насны хүүхдийн өвчлөл эзэлж байна. Нийт өвчлөлийн 53.4% нь сургуулийн, 16.5% нь цэцэрлэгийн, 25.3% нь гэртээ байдаг хүүхдийн өвчлөл эзлэж байна.




### 6.4.4 СҮРЬЕЭ

Монгол Улс нь ДЭМБ-ын Номхон далайн баруун эргийн бүсийн 37 орноос сүрьеэгийн өвчлөл өндөртэй орны тоонд ордог. Сүүлийн таван жилийн эрүүл мэндийн статистик үзүүлэлтээр сүрьеэ нь улсын хэмжээнд бүртгэгдэж буй нийт халдварт өвчний дотор дунджаар 9.8 хувийг эзэлж, жил бүр 4.000 гаруй хүн шинээр сүрьеэ өвчнөөр өвчилж байна.


Дэлхийн бусад улс орнуудын адил Монгол улс 1996 оноос шууд хяналттай богино хугацааны эмчилгээний стратеги (ДОТС)-ийг нэвтрүүлснээр сүрьеэгийн шинээр илэрсэн тохиолдол 1996 оноос хойш тасралтгүй нэмэгдээд 2007 оноос буурах хандлага ажиглагдаж байна.

Зураг 6. 17 Сүрьеэгийн өвчлөлийн түвшин, 2010-2020 он



“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д 2020 он гэхэд 100 000 хүн амд сүрьеэгийн тохиолдлыг 144 болгон бууруулах зорилтыг дэвшүүлсэн.

Зураг 6. 18 Сүрьеэгийн өвчлөл, 10 000 хүн амд, бүсээр, 2010-2020 он



Сүрьеэгийн өвчлөлийн түвшин 100 000 хүн амд харьцуулахад 1996 онд 146.0 байсан бол 2006 онд 186 болж 1.3 дахин нэмэгдсэн байна. Харин 2007 оноос эхлэн өвчлөл буурч 100 000 хүн амд ногдох түвшин 168 байсан бол 2011 онд 143 болж бууран 2020 оны байдлаар 105 болсон байна.

2020 онд сүрьеэгийн нас баралтын түвшин 100 000 хүн амд 2.8 байгаа нь 1996 оны түвшинтэй харьцуулахад 2 дахин буурсан байна.

2020 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд сүрьеэ өвчний 3339 шинэ тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 10.0 хувийг эзэлж байгаа ба өнгөрсөн оны мөн үеэс 285 тохиолдлоор буурч, 10 000 хүн амд ногдох өвчлөл 10.5 болсон байна.

2020 онд нийт 3339 сүрьеэгийн шинэ тохиолдол бүртгэгдсэний 1986 (59.5%) нь УБ хотод, 1281 (38.4%) нь аймаг орон нутагт, 72 (2.2%) нь хорих байгууллагад бүртгэгдсэн ба өнгөрсөн оноос УБ хотод 97, аймгуудад 234 тохиолдлоор тус тус буурсан бол харин хорих байгууллагт 36 тохиолдлоор нэмэгдсэн байна.

2020 онд шинээр бүртгэгдсэн тохиолдлын 1989 (59.6%) нь уушгины сүрьеэ, 1350 (40.4%) нь уушгины бус эрхтний сүрьеэ байгаа ба 2019 онтой харьцуулбал уушгины сүрьеэ 245 тохиолдлоор нэмэгдэж, уушгины бус эрхтний сүрьеэ 40 тохиолдлоор буурсан ба уушгины сүрьеэгийн эзлэх хувь 1.9%-р буурч, Уушгины бус эрхтний сүрьеэгийн эзлэх хувь 1.9%-аар нэмэгдсэн байна. Уушгины сүрьеэгийн доторхи нян судлалаар батлагдсан хувь өнгөрсөн оны мөн үеэс 1.3% өссөн байна.


2020 онд сүрьеэгийн бүртгэгдсэн тохиолдлын 10000 хүн амд ногдох түвшин 15-24 нас, 25-34 нас мөн 65-с дээш насанд өндөр байна. Бүртгэгдсэн тохиолдлын түвшин 0-14 насанд өнгөрсөн оны түвшинд байгаа бол бусад насны ангилалд буурсан үзүүлэлттэй байна.

#### 6.4.5 ХҮҮХДИЙН СҮРЬЕЭГИЙН ӨВЧЛӨЛ

Жил бүр шинэ сүрьеэгээр дунджаар 400 хүүхэд шинээр сүрьеэгээр өвчилж байгаа нь нийт өвчлөлийн дотор 10%-ийг эзэлж байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд 2016 онд хамгийн их буюу 516 хүүхэд бүртгэгдэж байсан бол 2017 онд 424, 2018 онд 293 болж буурсан ч 2020 онд 397 болж дахин өссөн байна. Олон эмэнд тэсвэртэй тохиолдол бүүлийн жилүүдэд нэмэгдэх хандлагатай байна.

2020 онд 0-14 насны 397 хүүхэд сүрьеэгээр өвчилсөн нь нийт тохиолдлын дотор 11.9%-г эзэлж байгаа ба өнгөрсөн оноос 15 тохиолдол буюу 3.9 хувь нэмэгдсэн байна.

Зураг 6. 19 Хүүхдийн сүрьеэгийн бүртгэгдсэн тохиолдол, 2012-2020 он



2020 онд Р/ОЭТС-ийн 195 тохиолдол бүртгэгдснээс 14(7.2%) нь 0-14 насны хүүхэд байна. Р/ОЭТС-ийн бүртгэгдэж буй тохиолдлын тоо сүүлийн жилүүдэд буурч байгаа хэдий ч эмэнд тэсвэртэй сүрьеэгээр өвчлөх хүүхдийн тоо нэмэгдэх хандлагатай байна. 2020 онд 0-4 насны 3 хүүхэд, 5-14 насны 11 хүүхэд ОЭТС-ээр өвчилсөн байна.

2020 онд бүртгэгдсэн Риф/ОЭТС-ийн тохиолдлын түвшин 100000 амд аймгийн дундаж 4.1 болж өнгөрсөн оноос 0.8 буурсан байна.

2020 онд хүүхдийн сүрьеэгийн өвчлөлийн түвшин аймгийн дундаж 1.5 байгаа ба Дархан-Уул(5.9), Сүхбаатар (5.1) аймгуудад улс болон аймгийн дунджаас өндөр байна. Мөн Сэлэнгэ (3.1), Булган




(2.2), Хэнтий (2.1), Хөвсгөл(1.6) аймгуудад хүүхдийн сүрьеэгийн өндөр өвчлөл өндөр бүртгэгдсэн байна. Төв аймагт хүүхдийн сүрьеэгийн тохиолдол 2019 онд 34 бүртгэгдэж байсан бол 2020 онд 4 тохиолдол бүртгэгдэж буурсан байна.

Эмчилгээ хяналтын өвчтөнөөс сүрьеэгээр нас барсан нийт 67 тохиолдол бүртгэгдсэн ба өмнөх онтой харьцуулахад 8 тохиолдлоор нэмэгдсэн байна. 2 хүүхэд нас барсан нь нийт нас баралтын 2.9% байна. Өвчний бүтцээр нь үзвэл: Амьсгалын эрхтний сүрьеэгээр 59 (88%), амьсгалын бус эрхтний сүрьеэгээр 8 (12%) нас барсан байна.

#### 6.4.6 СҮРЬЕЭГИЙН ЭМЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Уушгины халдвартай хэлбэрийн шинэ сүрьеэгийн эмчилгээний амжилт 2020 онд 84.7 хувь байгаа ба орон нутагт 91.4 %, улаанбаатар хотод 79.1% байна.

Зураг 6. 20 Уушгины халдвартай хэлбэрийн сүрьеэгийн эмчилгээний амжилт, 2012-2020 он




2020 онд шинэ халдвартай сүрьеэгийн тохиолдлын эдгэрэлт 76.4 хувь, эмчилгээний амжилт 84.7 хувь, нас баралт 3.4 хувь, хяналт алдагдалт 6.3 хувь байгаа нь сүүлийн 5 жилд бүртгэгдсэн хамгийн тааруу үзүүлэлттэй байна.

#### 6.4.7 ЭМЭНД ТЭСВЭРТЭЙ СҮРЬЕЭГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Олон эмэнд тэсвэртэй сүрьеэгийн бүртгэгдсэн тохиолдлын түвшин 2015-2020 оны байдлаар буурсан үзүүлэлттэй байгаа ба 2020 онд 195 тохиолдол бүртгэгдсэнээс 7 нь эмчилгээнд орохоос өмнө нас барж, 1 нь татгалзаж нийт 187 тохиолдол эмчилгээнд орсон байна.

2020 онд Риф/ОЭТС-ийн эмчилгээний амжилт 67.0% байгаа нь өмнөх оноос 10.6 хувиар нэмэгдсэн байна. Мөн хяналт алдагдалт 2019 онд 26.1% байсан бол 2020 онд 11.8% болж буурсан эерэг үр дүнтэй байна. Харин үр дүнгүй эмчлэгдсэн хувь нэмэгдэж, нас баралт өнгөрсөн оны түвшинд байна.


Зураг 6. 21 Риф/ОЭТС-ийн эмчилгээний үр дүн, 2015-2020 он



## 6.5 ГЭДЭСНИЙ ХАЛДВАРТ ӨВЧИН

Улсын хэмжээнд сүүлийн 10 жилийн дунджаар гэдэсний халдварт өвчний нийт 8646 тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүн амд 29 байна. Сүүлийн 10 жилийн дунджаар гэдэсний халдварын дийлэнх хувийг цусан суулга, вирүст хепатит А, гар хөл амны өвчний тохиолдол эзэлж байна. 2020 онд бүртгэгдсэн тохиолдлыг сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 3386 тохиолдлоор буурсан байна.

Зураг 6. 22 Гэдэсний халдварт өвчин, 2010-2020 он



Улсын хэмжээнд 2020 онд гэдэсний халдварын 7 төрлийн (цусан суулга, хүнсний гаралтай бактерт хордлого, сальмонеллэзын халдвар, суулгалт халдвар, гар, хөл, амны өвчин, цочмог гепатит А, балнад) халдварт өвчний нийт 5265 тохиолдол 10000 хүн ам тутамд (16.5-оор) өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна. Гэдэсний халдварт өвчин нийт халдварт өвчний дотор 15.8 хувийг эзэлж байна.

Хүснэгт 6. 2 Гэдэсний халдварт өвчнүүдийн тохиолдлын тоо, 10 000 хүн амд

Үзүүлэлт		2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Гэдэсний халдвар	тоо	14 893	17 247	9 265	5 350	5 234	5 053	9 086	10 549	10 240	9 173	5 265
	10 000 хүн амд	56.4	64.4	33.9	19.2	18.2	17.0	30.0	34.1	32.4	28.8	16.5
Сальмонеллэз	тоо	146	118	112	83	95	146	181	185	329	349	187
	10 000 хүн амд	0.6	0.4	0.4	0.3	0.3	0.5	0.6	0.6	1.0	1.1	0.6
Цусан суулга	тоо	3 451	2 120	2 051	1 982	2 312	2 737	2 848	4 026	6 265	5 438	2 630
	10 000 хүн амд	13.1	7.9	7.5	7.1	8.0	9.2	9.4	13.0	19.8	17.0	8.2
Бактерийн гаралтай бусад хоолны хордлого	тоо	510	278	719	238	548	482	430	133	554	830	199
	10 000 хүн амд	1.9	1.0	2.6	0.9	1.9	1.6	1.4	0.4	1.8	2.6	0.6
Гар, хөл, амны өвчин	тоо	2 585	1 042	405	1 374	1 788	1 524	5 569	6 051	2 876	2 147	2 097
	10 000 хүн амд	9.8	3.9	1.5	4.9	6.2	5.1	18.4	19.5	9.1	6.7	6.6
Суулгалт халдвар	тоо	84	75	86	84	162	81	19	103	190	235	72
	10 000 хүн амд	0.3	0.3	0.3	0.3	0.6	0.3	0.1	0.3	0.6	0.7	0.2
Вирүст хепатит А	тоо	8 116	13 612	5 892	1 589	325	82	39	51	26	174	79
	10 000 хүн амд	30.8	50.8	21.6	5.7	1.1	0.3	0.1	0.2	0.1	0.5	0.2
Балнад	тоо	1	2	0	0	4	1	0	0	0	0	1
		0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0






Улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт гэдэсний халдварын 50.0 хувь нь цусан суулга, 3.8 хувь бактерийн гаралтай хоолны хордлого, 3.6 хувь нь сальмонеллөз, 1.4 хувь нь суулгалт халдвар, 39.8 хувь гар хөл амны өвчин, 1.5 цочмог гепатит А тус тус эзэлж байна.

### 6.5.1 ЦУСАН СУУЛГА ӨВЧИН

2020 онд цусан суулгын 2630 тохиолдол бүртгэгдэн 10.000 хүн амд 8.2 тохиолдол ба нийт халдварт өвчний дотор 7.9 хувийг эзэлж байна. 2019 оны өвчлөлтэй харьцуулахад 10 000 хүн ам тутамд 8.8, 10 жилийн дундажтай харьцуулахад 2.5 тохиолдлоор тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 6. 23 Цусан суулга өвчний өвчлөлийн тоо, түвшин, 2010-2020 он



Сүүлийн 10 жилд бүртгэгдсэн суулга өвчний хөдлөл зүйг харахад 2018 онд өвчлөл хамгийн өндөр, 2013 онд өвчлөл хамгийн бага байжээ. 2014 оноос өвчлөл нэмэгдсэн ба цаашид нэмэгдэх хандлагатай байгаа нь харагдаж байна.

2020 оны байдлаар өвчлөлийг насны бүлгээр авч үзэхэд бүх насныханы дунд өвчлөл бүртгэгдсэн боловч нийт өвчлөлийн 75.7 хувийг 0-9 насныхан, үүнээс 0-4 насныхан хамгийн өндөр 73.5 хувийг эзэлж байна.

Цусан суулгын өвчлөл жилийн турш бүртгэгддэг ба өвчлөл 4 сараас эхлэн нэмэгдэж, 8 сард оргил үедээ хүрч, буурдаг байна. Өвчлөгсдийг нийгмийн байдлаар авч үзэхэд гэртээ байдаг хүүхэд 1577(59.9%), цэцэрлэгт явдаг хүүхэд 241(9.1%), сургуулийн хүүхэд 343(13.0%) тус тус байна.


### 6.5.2 ХООЛНЫ ХОРДЛОГОТ ХАЛДВАР

Сүүлийн 10 жилийн дунджаар хоолны хордлогот халдварын 441 тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүн амд харьцуулахад 1.5 байна. Хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлтийн тоо сүүлийн жилүүдэд нэмэгдэх хандлагатай байгаа ба 2015 онд 8, 2019 онд 19 удаагийн дэгдэлт бүртгэгдэж байсан бол 2020 оны оны байдлаар 11 удаагийн дэгдэлт бүртгэгдсэн байна.

2020 онд улсын хэмжээнд бактерийн гаралтай бусад хоолны хордлогот халдварын нийт 199 тохиолдол буюу 10 000 хүн амд 0.6 бүртгэгдсэн нь нийт гэдэсний халдварт өвчний дотор 3.8 хувь эзэлж байна. Үүнээс Улаанбаатар хотод 117 (59 хувь) тохиолдол буюу 10 000 хүн амд 0.8 бүртгэгдсэн байна.

2020 онд Улаанбаатар хотод бүртгэгдсэн бактерийн гаралтай бусад хоолны хордлогот халдварын өвчлөлийг өмнөх онтой харьцуулахад 564 тохиолдолоор буурсан үзүүлэлттэй байна. Сүүлийн 10 жилийн байдлаар бүртгэгдсэн бактерийн гаралтай бусад хоолны хордлогот халдварыг авч харьцуулахад 2012, 2019 онуудад хамгийн их тохиолдол бүртгэгдэж байсан бол 2009, 2017 онуудад буурсан байна.


Зураг 6. 24 Хоолны хордлогот халдвар, 2009-2020 он



2020 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн хоолны хордлогот халдварыг аймгаар нь авч үзвэл: 5 аймагт (Дорнод, Орхон, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл) болон нийслэл Улаанбаатар хотод өвчлөл бүртгэгдсэн энэ онд (Архангай, Баянөлгий, Баянхонгор, Булган, Говьалтай, Говьсүмбэр, Дархануул, Дорноговь, Дундговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Увс, Ховд, Хэнтий) зэрэг 16 аймагт өвчлөл бүртгэгдээгүй байна.

Нийт дэгдэлтийн 9% нь хүүхдийн байгууллагад, 45.4% нь нийтийн хоолны газарт, 18% нь түргэн хоолны газар болон айл өрхөд тус тус бүртгэгдсэн байна. Нийт өвчлөгсдийн 47.8% эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн байна.

Зураг 6. 25 Нийслэлд бүртгэгдсэн хоолны хордлогот халдвар, 10 000 хүн ам тутамд



2020 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн хоолны хордлогот халдварын 82.1 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгджээ.

Нийслэлийн хэмжээнд 2020 онд хоолны хордлогот халдварын нийт 117 тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүн амд 0.8 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 564 тохиолдолоор буюу 10 000 хүн амд 3.9-оор буурсан үзүүлэлттэй байна.


### 6.5.3 ВИРУСТ ХЕПАТИТ

Улсын хэмжээнд 2020 оны байдлаар гепатитийн вирусийн цочмог халдварын 353 тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүн амд 1.1 байгаа нь нийт халдварт өвчний дотор 1.1%-ийг эзэлж байна. Өнгөрсөн онд бүртгэгдсэн өвчлөлтэй харьцуулахад 174 тохиолдол буюу 10000 хүн амд 0.6-оор буурсан байна.

Улсын хэмжээнд сүүлийн 10 жилд бүртгэгдсэн гепатитийн вирусийн цочмог халдвар нь 2011 онд хамгийн их буюу 10000 хүн ам тутамд 52.8 ногдож, 2012 оноос өвчлөл тууштай буурч байна.




Зураг 6. 26 Вируст гепатитын бүртгэгдсэн тохиолдол, 2010-2020 он



Гепатитийн вирусийн цочмог халдварын хөдлөл зүй нь 2010 оны 12 дугаар сар, 2011 оны 11 дүгээр саруудад өвчлөл хамгийн их, оргил үедээ хүрч, 2012 оны 12 сараас өвчлөл тууштай буурч байна.

Нийт гепатитийн вируст халдварын 22.4 хувийг гепатитийн А вирусийн халдвар, 40.5 хувийг гепатит В, 21.2 хувийг гепатит С, 15.9 хувийг гепатитийн бусад вирусийн халдвар тус тус эзэлж байна.


Зураг 6. 27 Вируст гепатитын бүтэц, 2020 он



### 6.6 БЭЛГИЙН ЗАМААР ДАМЖИХ ХАЛДВАРТ ӨВЧИН


Улсын хэмжээнд 2020 онд бэлгийн замаар дамжих халдварын 16.2 мянган тохиолдол илэрч сүүлийн 10 жилийн дунджаас 2.5 мянга буюу 16.4 хувиар, өмнөх оноос 1.7 мянга буюу 10.8 хувиар өссөн байна.

Зураг 6. 28 Бэлгийн замаар дамжих халдварт өвчин, 2010- 2020 он




Бэлгийн замаар дамжих халдварын тохиолдлын түвшин 2020 онд 50.6 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 1.6-аар, өмнөх оныхоос 5.4-аар тус тус буурсан байна.

Зураг 6. 29 Бэлгийн замаар дамжих халдвар, 10 000 хүн амд, бүсээр, 2010-2020 он



Сүүлийн 10 жилийн дунджаар нийт халдварт өвчинд бэлгийн замаар дамжих халдвар 34.5 хувь болж, сүүлийн 10 жилийн дунджаас 14 пунктээр, өмнөх оноос 8.9 пунктээр тус тус нэмэгдсэн байна.


Зураг 6. 30 Нийт халдварт өвчинд бэлгийн замын халдварт өвчний эзлэх хувь, 2010-2020 он



Бэлгийн замын халдварт өвчнийг төрлөөр, сүүлийн 10 жилийн байдлаар харвал 2011-2012 онд заг хүйтэн (гонококкт халдвар) нийт бэлгийн замаар дамжих халдварын 36.9-38.4 хувийг эзэлж тэргүүлдэг байсан бол 2013-2020 онд тэмбүү өвчний тохиолдол 38.2-46.0 хувийг эзэлж тэргүүлжээ.



Зураг 6. 31 Бэлгийн замын халдварт өвчин, төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2011-2020 он



### ХДХВ/ДОХ-ЫН ХАЛДВАР

Бэлгийн замаар дамжих халдварт өвчнүүд дунд хүний дархлал хомсдлын вирус (ХДХВ/ ДОХ) нь анх 1981 онд бүртгэгдсэнээс хойш дэлхий нийтийг хамарсан халдварт өвчин болоод байгаа бөгөөд эпидемик халдвар болсноосоо хойш 75 сая хүн ХДХВ-ын халдвар авч, 32 сая хүн нас барсан байна.

Монгол улсын нийт хүн амын дунд Хүний дархлал хомсдолын вирусийн халдварын тархалтын түвшин 0.1 хувиас бага, эрсдэлт бүлгийн хүн амын дунд 5.0 хувиас бага байгаа нь нийт хүн амын дунд бага, эрсдэлт бүлгийн хүн амын дунд төвлөрсөн тархалттай орны тоонд орж байна.


1992 онд Монгол улсад ХДХВ/ДОХ-ын анхны тохиолдол бүртгэгдсэнээс хойш 2020 оны жилийн эцсийн байдлаар ХДХВ/ДОХ-ын нийт 311 тохиолдол бүртгэгдэж, үүнээс 25 тохиолдол нь 2020 онд шинээр бүртгэгдсэн байна. Бүртгэгдсэн 311 тохиолдлын 47 нь нас барсан байна.

## 6.7 ЗООНОЗЫН ХАЛДВАРТ ӨВЧИН

Сүүлийн 10 жилийн байдлаар зоонозын халдварт өвчний 4552 тохиолдол бүртгэгдэж, нийт тохиолдлын 45.7%-ийг хачгаар дамжих халдварт өвчин эзэлж байна. Сүүлийн жилүүдэд тарваган тахал, боом, галзуугийн халдварын намжмал голомтын идэвх сэргэж, хачигаар дамжих халдвар нэмэгдэж, хумхаа, корона, эбола, зика, денгийн чичрэг зэрэг өвчин бусад улсаас зөөвөрлөгдөн орж ирэх эрсдэл өндөр байна.


Улсын хэмжээнд 2020 онд зоонозын халдварт өвчний 301 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 0.9 байгаа ба нийт халдварт өвчний 0.9 хувийг эзэлж байна.


Зураг 6. 32 Зоонозын халдварт өвчний тохиолдол, 10 000 хүн амд, 2010-2020 он



2020 онд бүртгэгдсэн зоонозын халдварт өвчний 60.5 хувь нь хачигт риккетсиоз, 25.6 хувь нь бруцеллез, 6.6 хувь нь хачигт энцефалит, 4.3 хувь нь хачигт боррелиоз эзэлж байна.

Зураг 6. 33 Зоонозын халдварт өвчний бүтэц, 2020 он





БҮЛЭГ

7

ХАЛДВАРТ БҮС  
ӨВЧЛӨЛ



## БҮЛЭГ 7.

# ХАЛДВАРТ БУС ӨВЧЛӨЛ

Зүрх судасны өвчин, хорт хавдар, чихрийн шижин, амьсгалын замын архаг өвчин 30-70 насныханд эрт нас барах эрсдэл 16.2%-тай байна. Хэдийгээр ихэнх улс орнуудад сүүлийн 2 жилд ахиц гарч дэлхийн түвшингээс доогуур байгаа ч 2030 онд гуравны нэгийг бууруулах зорилт тавиад байна.

ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдээр харахад Номхон далайн бүс нутагт холимог дүр зураг харагдаж байна.

Тамхины хэрэглээний тархалт бүсийн улс орнуудад буурч харин архины хэрэглээ тал хувьд нь нэмэгдсэн байна. Хүүхдийн жингийн илүүдэл ихэнх улс орнуудад нэмэгдэж байгаа нь ХБӨ-ны өндөр эрсдэл ялангуяа насанд хүрэгчдийн хоолны дэглэмтэй холбоотой байгаа нь нийгмийн эрүүл мэндийн ноцтой асуудал болохоор байна.

ТХЗ-ын өгөгдлүүд нь тэгш бус байдал, хамгийн их өртсөн эмзэг бүлгийг олж авахад улс хоорондын болон дотоодын аль алинд нь хангалтгүй байдаг. Гэсэн хэдий ч өгөгдөл нь хүйсийн ялгааг илтгэдэг бөгөөд эрчүүд илүү их магадлалтайг харуулж байна. Тухайлбал ХБӨ-өөр эрт нас барах, амиа хорлох, архи, тамхины хэрэглээ өндөр байх зэрэг юм.


Бүс нутгийн хэмжээнд замын хөдөлгөөний нас баралт 2013 онд 100000 хүн амд 17.3 байсан бол 2016 онд 16.9 болж буурсан хэдий ч ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд хоцорч байна. Эмэгтэйчүүдийн 5-26%, хүүхдүүдийн бараг тал хувь нь ямар нэгэн хүчирхийлэлд өртсөн байна. Мэдээлэл цуглуулах системийг хөгжүүлэх нь энэ асуудлыг ойлгох, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахад чухал үүрэг гүйцэтгэнэ.

Монгол улсад 2016-2019 онуудад бүртгэгдсэн нийт тохиолдлын 62.1 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Осол гэмтлийн шалтгаант 10 шинэ тохиолдол тутамд 6 эрэгтэй, 4 эмэгтэй байжээ. Насны хувьд 5 хүртэлх нас, 25-29 насанд тохиолдлын түвшин өндөр байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тооцоолсноор орчноос хамааралтай халдварт бус өвчлөлийн тэргүүлэх 10 шалтгаанд цус харвалт, зүрхний шигдээс, санамсаргүй осол гэмтэл, хавдар, амьсгалын замын архаг өвчин, астма, амьсгалын дээд замын цочмог өвчлөл, нярайн өвчин, санаатай осол гэмтэл зэрэг өвчнүүдийг оруулсан байна.



Зураг 7. 1 Хүн амын өвчлөлийн тохиолдол, мянган хүн




2020 онд улсын хэмжээнд хүн амын өвчлөлийн тохиолдол 3.3 саяд (давхардсан тоогоор) хүрч, 10 жилийн өмнөхөөс 1.9 дахин их байгаа хэдий ч өмнөх оноос 8.1 хувиар буурсан бол Улаанбаатар хотод 1.7 сая болж, 10 жилийн өмнөхөөс 2.2 дахин их, өмнөх оноос 9.2 хувиар буурч, хөдөө, орон нутагт 1.6 сая болж, 10 жилийн өмнөхөөс 1.7 дахин их, өмнөх оноос 6.8 хувиар тус тус буурсан байна.

## 7.1. ХҮН АМЫН ӨВЧЛӨЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН

2020 оны байдлаар 10000 хүн амд амьсгалын тогтолцооны өвчин 1414, хоол боловсруулах тогтолцооны өвчин 1833, зүрх-судасны тогтолцооны өвчин 1268, шээс бэлгийн тогтолцооны өвчин 1084, гэмтэл, хордлого ба бусад гадны шалтгаант өвчин 598 ногдож байгаа бөгөөд 2019 онтой харьцуулахад өвчлөлийн тэргүүлэх шалтгаанууд 12-685-аар буурсан үзүүлэлтэй байна.

Зураг 7. 2 Хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, 2011-2020 он




## Хүснэгт 7. 1 Хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, байршлаар, дүнд эзлэх хувиар, 2011-2020 он

Улсын дүн	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
<b>Нийт</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>
Амьсгалын тогтолцооны өвчин	16.9	16.6	18.9	20.7	19.1	20.0	17.9	17.8	18.6	13.8
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	15.4	15.5	14.9	14.9	15.7	14.9	16.7	16.1	16.3	17.8
Зүрх, судасны тогтолцооны өвчин	12.2	11.5	12.0	12.5	12.2	12.2	12.2	12.0	11.7	12.3
Шээс бэлгэсийн тогтолцооны өвчин	12.4	12.3	10.9	10.3	10.2	9.8	10.2	9.7	9.9	10.6
Мэдрэлийн тогтолцооны өвчин	6.1	6.0	6.2	6.0	6.2	6.2	6.3	6.5	6.6	7.4
Бусад	37.0	38.1	37.2	35.7	36.5	36.9	36.8	37.9	36.9	38.1
<b>Улаанбаатар</b>	<b>2011 он</b>	<b>2012 он</b>	<b>2013 он</b>	<b>2014 он</b>	<b>2015 он</b>	<b>2016 он</b>	<b>2017 он</b>	<b>2018 он</b>	<b>2019 он</b>	<b>2020 он</b>
<b>Нийт</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>
Амьсгалын тогтолцооны өвчин	13.7	13.5	19.4	19.7	17.2	17.7	14.2	14.3	15.2	10.7
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	13.2	14.0	12.9	12.8	13.6	13.2	15.4	14.4	14.9	16.7
Зүрх, судасны тогтолцооны өвчин	10.5	11.1	9.7	11.2	10.6	10.8	10.8	10.0	10.4	10.6
Шээс бэлгэсийн тогтолцооны өвчин	10.2	9.5	8.2	8.5	8.9	8.6	9.3	8.7	9.3	9.8
Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант	12.7	12.2	11.7	10.5	10.3	8.3	8.0	9.4	9.1	8.7
Бусад	39.7	39.6	38.1	37.3	39.4	41.4	42.3	43.2	41.2	43.5

## 7.1.1. АМЬСГАЛЫН ТОГТОЛЦООНЫ ӨВЧИН

Амьсгалын тогтолцооны өвчин (10000 хүнд ногдох) 2020 онд сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад улсын хэмжээнд 1414 болж, 117-оор, Улаанбаатарт 1232 болж, 255-аар тус тус буурч, аймгийн түвшинд 1569 болж, сүүлийн 10 жилийн дундажтай адил түвшинд байна.


Зураг 7. 3 Амьсгалын тогтолцооны өвчин, 10000 хүнд амд, байршлаар, 2011-2020 он



Харин амьсгалын тогтолцооны өвчний түвшин, 2020 оны байдлаар харвал эрэгтэйчүүдийнх 1350 болж, 10 жилийн дундажаас 111-ээр, эмэгтэйчүүдийнх 1477 болж, 10 жилийн дундажаас 81-ээр тус тус буурсан байна.




Зураг 7. 4 Амьсгалын тогтолцооны өвчин, 10000 хүнд амд, хүйсээр, 2011-2020 он




Амьсгалын тогтолцооны өвчнийг газарзүйн байршлаар нь харахад 2020 оны байдлаар 10000 хүнд ногдохоор төвийн бүсэд хамгийн өндөр байна.

Зураг 7. 5 Амьсгалын тогтолцооны өвчин, улс, хот, бүсээр, 10000 хүнд ногдох, 2020 он



Амьсгалын тогтолцооны өвчний түвшинг 10 жилийн өмнөх үетэй харьцуулахад бүх насанд нэмэгдэж, 2020 оны байдлаар, насны бүлгээр харвал 0-4 насанд 4622 болж 10 жилийн өмнөхөөс 210-аар буурч, 2020 оны байдлаар 38.8 хувийг 0-4 насны хүүхдийн өвчлөл эзэлж байна.

Зураг 7. 6 Амьсгалын тогтолцооны өвчин, насны бүлгээр, 10000 хүнд ногдох, 2011, 2020 он




Амьсгалын тогтолцооны өвчнүүдийн бүтцийг 2020 онд амьсгалын дээд замын цочмог халдвар 30.1 хувь, хатгалгаа 13.8 хувь, томуу 9.0 хувь, цочмог бронхит 11.2 хувь, уушгины архаг бөглөрөлт өвчин 9.2 хувийг тус тус эзэлж байна. Өвчлөлийн бүтцийг хүйсээр харуулвал амьсгалын дээд замын цочмог халдвар, хатгалгаа зэрэг цочмог өвчлөлүүд эрэгтэйд илүү хувийг эзэлж байна.

Хүснэгт 7.2 Амьсгалын тогтолцооны өвчний тэргүүлэх шалтгаан, хүйсээр, 2011, 2020 он

Тэргүүлэх өвчлөлүүд	Улс 2011		Улс 2020	
	Эр	Эм	Эр	Эм
Нийт	100.0	100.0	100.0	100.0
Амьсгалын дээд замын цочмог халдвар	28.9	29.5	30.9	29.3
Томуу	14.0	14.1	8.8	9.2
Хатгалгаа	25.8	23.1	15.0	12.7
Цочмог бронхит	10.5	9.1	12.2	10.3
Уушгины архаг бөглөрөлт өвчин	7.0	7.4	8.9	9.5
Бусад өвчин	13.7	16.8	24.1	29.0

Амьсгалын дээд замын цочмог халдварууд /цочмог назофарингит, цочмог синусит, цочмог фарингит, цочмог тонзиллит, цочмог ларингит ба трахеит, бусад амьсгалын дээд замын бусад цочмог халдваруудыг оруулав/-ыг 10 жилийн дундажтай харьцуулахад 84-өөр, хатгалгаа өвчин 95-аар, цочмог бронхит 29-өөр тус тус буурчээ.

Зураг 7.7 Амьсгалын тогтолцооны өвчнүүд, 10000 хүнд ногдох, 2011-2020 он




### 7.1.2 ХООЛ БОЛОВСРУУЛАХ ТОГТОЛЦООНЫ ӨВЧИН

Хүн амын өвчлөлийн хоёрдугаар шалтгаан болсон хоол боловсруулах тогтолцооны өвчин сүүлийн 10 жилийн дунджаар нийт өвчлөлийн 15.7 хувийг эзэлж байна.




**Зураг 7. 8 Хоол боловсруулах тогтолцооны өвчний тохиолдлын түвшин, 10000 хүн амд, байршлаар, 2011-2020 он**



Хоол боловсруулах тогтолцооны өвчний тохиолдлын түвшинг сүүлийн 10 жилийн дунджаар, байршлаар харахад аймгийн түвшинд 1445 болж, улсын дунджаас 5-аар бага, харин Улаанбаатарт 6-аар их байна. Хоол боловсруулах тогтолцооны өвчний тохиолдлын 2020 оны түвшинг өмнөх онтой харьцуулахад улсын хэмжээнд 1833 болж, 12-оор буурч, Улаанбаатарт 1921 болж, 8-аар өсч, аймгийн хэмжээнд 1758 болж, 29-өөр буурчээ.


Харин хоол боловсруулах тогтолцооны өвчний түвшин, 2020 оны байдлаар харвал эрэгтэйчүүдэд 1455 болж, 10 жилийн дундажаас 377-оор, эмэгтэйчүүдэд 2210 болж, 10 жилийн дундажаас 614-өөр тус тус илүү байна.

**Зураг 7. 9 Хоол боловсруулах тогтолцооны өвчний тохиолдлын түвшин, 10000 хүн амд, хүйсээр, 2011-2020 он**




Хоол боловсруулах өвчнийг газарзүйн байршлаар нь харахад 2020 оны байдлаар 10000 хүнд ногдохоор, 2011 онтой харьцуулахад бүх бүсэд өвчлөл нэмэгдсэн бөгөөд улсын дундаж(1833)-аас баруун бүсэд 366-аар, зүүн бүсэд 272-оор, төвийн бүсэд 25-аар тус тус өндөр байна.

Зураг 7. 10 Хоол боловсруулах тогтолцооны өвчин, улс, хот, бүсээр, 10000 хүн амд, 2011, 2020 он



Хоол боловсруулах тогтолцооны өвчний түвшинг насны бүлгээр 2011, 2020 оныг харьцуулан харвал насны бүлэг дэх өвчлөл нэмэгдсэн байна. 2020 онд 60-64 насанд хамгийн их буюу 3417 болж, 2011 оныхоос 1342-оор нэмэгдсэн байна.

Зураг 7. 11 Хоол боловсруулах тогтолцооны өвчин, насны бүлгээр, 10000 хүнд ногдох, 2011, 2020 он



Хоол боловсруулах тогтолцооны өвчнүүдийн бүтцийг харахад 2020 онд амны хөндий, шүлсний булчирхай ба эрүүний өвчин 41.1 хувь, улаан хоолой, ходоод, дээд гэдэсний өвчин 16.2 хувь, цөсний хүүдий, цөсний зам ба нойр булчирхайн өвчин 15.7 хувь, элэгний өвчин 10.8 хувь, халдварт бус энтерит ба колит 8.0 хувь, мухар олгойн өвчин 2.9 хувийг тус тус эзэлж байна.

Өвчлөлийн бүтцийг хүйсээр харвал амны хөндий, шүлсний булчирхай ба эрүүний өвчин, улаан хоолой, ходоод, дээд гэдэсний өвчин, цөсний хүүдий, цөсний зам, нойр булчирхайн өвчин эмэгтэйд, мухар олгойн өвчин, халдварт бус энтерит ба колит, элэгний өвчин эрэгтэйд илүү хувийг эзэлж байна.





*Хүснэгт 7.3 Хоол боловсруулах тогтолцооны өвчнүүд, дүнд эзлэх хувиар, 2010, 2020 он*


Тэргүүлэх өвчлөлүүд	Улс 2011			Улс 2020		
	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд
Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Амны хөндий, шүлсний булчирхай ба эрүүний өвчин	24.8	30.7	28.4	38.5	42.8	41.1
Улаан хоолой, ходоод, дээд гэдэсний өвчин	18.1	19.4	18.9	14.8	17.0	16.2
Элэгний өвчин	15.8	12.6	13.9	11.9	10.2	10.8
Цэсний хүүдий, цэсний зам ба нойр булчирхайн өвчин	13.0	18.0	16.0	13.0	17.4	15.7
Халдварт бус энтерит ба колит	11.5	7.7	9.2	10.5	6.4	8.0
Мухар олгойн өвчин	8.4	7.3	7.7	3.5	2.5	2.9
Хоол боловсруулах тогтолцооны бусад өвчин	8.4	4.3	5.9	7.8	3.8	5.3

### 7.1.3 ЗҮРХ СУДАСНЫ ТОГТОЛЦООНЫ ӨВЧИН

Хүн амын өвчлөлийн гуравдугаар шалтгаан болсон зүрх судасны тогтолцооны өвчин сүүлийн 10 жилийн дунджаар нийт өвчлөлийн 12.1 хувийг эзэлж байна.


Зүрх судасны тогтолцооны өвчлөл (10000 хүн амд ногдох) 2020 онд 1268 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 238-аар илүү, өмнөх оноос 53-аар буурсан байна.

*Зураг 7.12 Зүрх, судасны тогтолцооны өвчний тохиолдлын түвшин, 10 000 хүнд амд, байршлаар, 2011-2020 он*




Харин зүрх судасны тогтолцооны өвчний түвшинг 2020 оны байдлаар харвал эрэгтэйчүүдийнх 980 болж, 10 жилийн дундажаас 199-өөр, эмэгтэйчүүдийнх 1547 болж, 10 жилийн дундажаас 305-аар тус тус илүү байна.

Зураг 7. 13 Зүрх судасны тогтолцооны өвчний тохиолдлын түвшин, 10000 хүнд амд, хүйсээр, 2011-2020 он




Зүрх судасны өвчнийг газарзүйн байршлаар нь харахад 2020 оны байдлаар 10000 хүнд ногдохоор, улсын дундаж(1268)-аас хангайн бүсэд 108-аар, төвийн бүсэд 31-ээр, баруун бүсэд 105-өөр тус тус өндөр байна. Харин Улаанбаатар хотод өмнөх онтой харьцуулахад 149-өөр нэмэгдсэн байна.

Зураг 7. 14 Зүрх судасны өвчин, 10000 хүн амд ногдохоор, бүсээр, 2019, 2020 он



Зүрх судасны тогтолцооны өвчний түвшинг насны бүлгээр 2011, 2020 оныг харьцуулан харвал насны бүлэг дэх өвчлөл нэмэгдсэн байна. 2019 онд 65-аас дээш насанд хамгийн их буюу 7982 болж, 2011 оныхоос 1.6 дахин нэмэгдсэн байна.

Зураг 7. 15 Зүрх судасны тогтолцооны өвчин, насны бүлгээр, 10000 хүнд ногдох, 2011, 2020 он



Зүрх судасны тогтолцооны өвчнүүдийн бүтцийг харахад 2020 онд цусны даралт ихсэх өвчнүүд



47.6 хувь, зүрхний ишеми өвчин 21.8 хувь, тархины судасны өвчин 13.8 хувь, тунгалгийн судас ба зангилааны өвчнүүд 6.2 хувь, хэрлэгийн гаралтай зүрхний өвчин 1.7 хувь, артер, артериол, хялгасан судасны өвчин 1.2 хувь, вен, зүрх судасны тогтолцооны бусад өвчин 7.7 хувийг эзэлж байна.

Өвчлөлийн бүтцийг хүйсээр харвал хэрлэгийн гаралтай зүрхний өвчин, цусны даралт ихсэх өвчнүүд эмэгтэйд илүү, зүрхний ишемит өвчин, тархины судасны өвчин, артери, артериол, хялгасан судасны өвчин, вен, тунгалгийн судас ба зангилааны өвчнүүд, зүрх судасны бусад өвчин эрэгтэйд илүү хувийг эзэлж байна.


*Хүснэгт 7. 4 Зүрх судасны тогтолцооны өвчнүүд, дүнд эзлэх хувиар, 2011, 2020 он*

Тэргүүлэх өвчлөлүүд	Улс 2011			Улс 2020		
	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд
Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Цусны даралт ихсэх өвчнүүд	37.8	43.7	41.5	42.9	50.6	47.6
Зүрхний ишемит өвчин	27.1	21.7	23.8	24.4	20.2	21.8
Тархины судасны өвчин	13.0	9.4	10.8	14.9	13.1	13.8
Вен, тунгалгийн судас ба зангилааны өвчнүүд	6.2	5.4	5.7	6.7	5.9	6.2
Хэрлэгийн гаралтай зүрхний өвчнүүд	4.0	6.0	5.3	1.4	2.0	1.7
Артери, артериол, хялгасан судасны өвчин	2.2	2.4	2.3	1.3	1.1	1.2
Зүрх судасны бусад	9.7	11.4	10.8	8.4	7.2	7.7

**ЗҮРХ СУДАСНЫ ТОГТОЛЦООНЫ ЗОНХИЛОН ТОХИОЛДОХ ЗАРИМ ЭМГЭГИЙГ ХАРВАЛ:**


Цусны даралт ихсэх өвчин зүрх судасны тогтолцооны өвчний дотор сүүлийн 10 жилийн дунджаар 47.4 хувийг эзэлж, 2020 оны байдлаар 47.6 хувь болсон нь 10 жилийн дунджаас 0.2 хувиар илүү, өмнөх оноос 2.1 хувиар буурсан байна. Цусны даралт ихсэх өвчин нь хүн амын дунд тохиолдож буй зүрх-судасны тогтолцооны өвчлөлийн 47.6 хувийг эзэлж, 10 000 хүн амд 604 байна.

Зураг 7. 16 Цусны даралт ихсэх өвчин, 10 000 хүн амд, 2011-2020 он



Хүйсийн хувьд эмэгтэйчүүд 10 000 хүн амд 782.5, эрэгтэйчүүд 10000 хүн амд 420.4 тохиолдож байна. Байршлаар нь үзэхэд баруун болон төвийн бүсийн хүн ам илүүтэй энэ өвчлөлөөр өвдөж байна. Аймгууд дотроос Төв/1437.2/, Хэнтий/1145.5/, Дорноговь/1046.0/, Булган/1071.1/, Баянхонгор/861.1/, Ховд/844.4/, Хөвсгөл/832.7/, Архангай/807.0/ аймгуудад өндөр байна.

Зураг 7. 17 Цусны даралт ихсэх өвчин, хүйсээр, бүсээр, 2020 он




#### 7.1.4 Шээс бэлгийн тогтолцооны өвчин

Хүн амын өвчлөлийн дөрөвдүгээр шалтгаан болсон шээс бэлгийн тогтолцооны өвчин сүүлийн 10 жилийн дунджаар нийт өвчлөлийн 10.6 хувийг эзэлж байна.

Шээс бэлгийн тогтолцооны өвчлөл (10000 хүн амд ногдох) 2020 онд 1084 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 188-аар илүү, өмнөх оноос 36-аар буурсан байна. Харин шээс бэлгийн тогтолцооны өвчний түвшинг 2020 оны байдлаар харвал эрэгтэйчүүдийнх 560 болж, 10 жилийн дундажаас 140-өөр, эмэгтэйчүүдийнх 1594 болж, 10 жилийн дундажаас 263-аар тус тус илүү байна.




Зураг 7. 18 Шээс бэлгийн тогтолцооны өвчний тохиолдлын түвшин, 10000 хүн амд, хүйсээр, 2011-2020 он




Шээс бэлгийн тогтолцооны өвчнийг газарзүйн байршлаар нь харахад 2020 оны байдлаар 10000 хүнд ногдохоор, улсын дундаж(1084)-аас хангайн бүсэд 36-аар, баруун бүсэд 79-өөр тус тус өндөр байна.

Зураг 7. 19 Шээс бэлгийн тогтолцооны өвчин, улс, хот, бүсээр, 10000 хүнд ногдох, 2019, 2020 он



Шээс бэлгийн тогтолцооны өвчний түвшинг насны бүлгээр 2011, 2020 оныг харьцуулан харвал бүх насны бүлэг дэх өвчлөл нэмэгдсэн байна. 2020 онд 65-аас дээш насанд хамгийн их буюу 2543 болж, 2011 оныхоос 2.2 дахин нэмэгдсэн байна.

Зураг 7. 20 Шээс бэлгийн тогтолцооны өвчин, насны бүлгээр, 10000 хүнд ногдох, 2011, 2020 он



Шээс бэлгийн тогтолцооны өвчнүүдийн бүтцийг харахад 2020 онд сувганцрын өвчнүүд 47.7 хувь, эмэгтэйн аарцгийн эрхтэний үрэвсэлт өвчин 15.5 хувь, эм бэлэг эрхтний үрэвсэлт бус өвчин 9.5 хувь, шээс ялгаруулах тогтолцооны бусад өвчин 6.9 хувь, эр бэлэг эрхтний өвчнүүд 7.8 хувь, хөхний өвчин 3.1 хувь, бөөрний түүдгэнцрийн өвчнүүд 2.6 хувь, бөөрний дутмагшил 1.4 хувь, шээс чулуужих өвчин 2.1, цистит 3.2 хувийг тус тус эзэлж байна. Харин шээс бэлгийн тогтолцооны өвчний бүтцийг хүйсээр харвал ялгаатай байна.

Хүснэгт 7. 5 Шээс бэлгийн тогтолцооны өвчнүүд, дүнд эзлэх хувиар, 2011, 2020 он

Тэргүүлэх өвчлөлүүд	Улс 2011			Улс 2020		
	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд
Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Сувганцарын өвчнүүд N10-16	72.5	51.5	56.2	49.2	47.2	47.7
Эмэгтэйн аарцгийн эрхтэний үрэвсэлт N70-77	0.0	22.2	17.2	0.0	20.9	15.5
Эм бэлэг эрхтэний үрэвсэлт бус N80-99	0.0	12.2	9.5	0.0	12.8	9.5
Түүдгэнцрийн өвчнүүд N00-08	11.8	7.2	8.2	4.6	1.9	2.6
Хөхний өвчин N60-64	0.4	3.3	2.6	0.2	4.1	3.1
Цистит N30	1.7	2.4	2.3	1.9	3.6	3.2
Эр бэлэг эрхтэний өвчнүүд N40-51	9.5	0.0	2.1	30.7	0.0	7.8
Шээс ялгаруулах бусад N25-39	1.5	0.5	0.7	6.5	7.1	6.9
Шээс чулуужих өвчин N20-23	1.3	0.4	0.6	4.2	1.4	2.1
Бөөрний дутмагшил N17-19	1.4	0.4	0.6	2.6	1.1	1.4

2020 онд хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгааныг байршлаар авч үзвэл хот, хөдөөд хоол



боловсруулах тогтолцооны өвчин, амьсгалын тогтолцооны өвчин, зүрх судасны тогтолцооны өвчин тэргүүлэх 3 шалтгаанд орж байна. Тухайлбал 10000 хүн амд ногдох хоол боловсруулах тогтолцооны өвчин хотод 1921, хөдөөд 1758, амьсгалын тогтолцооны өвчин хотод 1232, хөдөөд 1569, зүрх судасны тогтолцооны өвчин хотод 1221, хөдөөд 1307, шээс бэлгийн тогтолцооны өвчин хотод 1121, хөдөөд 1053, гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг хотод 1001, хөдөөд 255 ногдож байна.

*Хүснэгт 7. 6 Хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, нас, хүйсээр, 2020 он, 10 000 хүн амд*

Үзүүлэлт	Нийт өвчлөл	Амьсгалын тогтолцооны өвчин	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	Шээс бэлгийн тогтолцооны эмгэг	Зүрх-судасны тогтолцооны өвчин	Гэмтэл, хордлого ба бусад гадны шалтгаант тодорхой эмгэг
<b>Хүйс</b>						
Эрэгтэй	7974	1350	1445	560	980	743
Эмэгтэй	12513	1477	2210	1594	1547	458
<b>Насны бүлэг</b>						
<b>Эрэгтэй</b>						
20 хүртэл	6889	2227	1407	264	39	639
20-44	5810	588	1093	505	510	869
45-65	12243	901	2025	957	2935	727
65 ба түүнээс дээш	23176	1873	2852	2652	7322	619
<b>Эмэгтэй</b>						
20 хүртэл	7028	2157	1590	323	44	401
20-44	12297	896	2024	2337	796	441
45-65	19571	1235	3355	2372	4047	545
65 ба түүнээс дээш	27146	1660	3718	2473	8406	670
<b>Байршил</b>						
Хот	11495	1232	1921	1121	1221	1001
Хөдөө	9238	1569	1758	1053	1307	255
<b>Бүсээр</b>						
Баруун	10016	1315	2199	1163	1373	314
Хангайн	8833	1498	1489	1120	1376	205
Төв	9551	1837	1808	985	1299	282
Зүүн	8196	1615	1561	829	1022	224
<b>Улсын дүн</b>	<b>10275</b>	<b>1414</b>	<b>1833</b>	<b>1084</b>	<b>1268</b>	<b>598</b>



10000 эмэгтэй хүн амд ногдох амбулаторт бүртгэгдсэн өвчлөлийн түвшин эрэгтэй хүн амтай харьцуулахад 1.6 дахин их байна. Өвчлөлийн шалтгаанаар авч үзвэл эрэгтэйчүүд гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэгийн улмаас амбулаторт үзүүлж, эмчлүүлсэн өвчлөлийн түвшин эмэгтэйчүүдтэй харьцуулахад 1.6 дахин их, бусад өвчлөлийн тэргүүлэх шалтгааны хувьд өвчлөлийн түвшин 1.1-2.8 дахин бага байна.


Хүн амын өвчлөлийг бүс нутгаар авч үзвэл баруун бүсэд хоол боловсруулах тогтолцооны өвчин 2199, зүрх судасны тогтолцооны өвчин 1373, амьсгалын тогтолцооны өвчин 1315, хангайн бүсэд амьсгалын тогтолцооны өвчин 1498, хоол боловсруулах тогтолцооны өвчин 1489, зүрх судасны тогтолцооны өвчин 1376, төвийн болон зүүн бүсэд амьсгалын тогтолцооны өвчин 1837 ба 1615, хоол боловсруулах тогтолцооны өвчин 1808 ба 1561 зүрх судасны тогтолцооны өвчин 1299 ба 1022 тэргүүлэх 3 шалтгаанд орж байна.

Мөн амьсгалын тогтолцооны өвчин төвийн болон зүүн бүсэд, хоол боловсруулах тогтолцооны өвчин баруун болон төвийн бүсэд, шээс бэлгийн тогтолцооны өвчин баруун болон хангайн бүсэд, зүрх судасны тогтолцооны өвчин хангайн болон баруун бүсэд, гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг баруун болон төвийн бүсэд бусад бүсүүдтэй харьцуулахад өндөр байна.

## 7.2 ЧИХРИЙН ШИЖИН ӨВЧИН

Чихрийн шижин өвчин нь дотоод шүүрэл, тэжээлийн бодисын солилцооны өвчлөлийн 41.2 хувийг эзэлж, 10000 хүн амд 106.9 байгаа нь өнгөрсөн он /2019 онд 111.4/-оос 4.5-аар буурсан байна. Хүйсийн хувьд эрэгтэйчүүд 10 000 хүн амд 102.8, эмэгтэйчүүд 10000 хүн амд 111.0 байна. Насны бүлгээр нь авч үзэхэд 45-65 насныханд хамгийн өндөр 21811/63.2%/ буюу 10000 хүн амд 354.8 тохиолдож байна. Байршилаар нь үзэхэд төвийн бүсэд 10000 хүн амд 115.1 буюу хамгийн өндөр тохиолдож байна. Төвийн бүсийн аймгууд дотроос Төв/189.0/, Өмнөговь /151.4/, Дорноговь/112.7/, Дархан-Уул/108.0/ аймгуудад өндөр байна.

Зураг 7. 21 Чихрийн шижин өвчин, хүйсээр, бүсээр, 10000 хүн амд, 2020 он





### 7.3 ХОРТ ХАВДАР

ДЭМБ-ын статистик мэдээллээр 2020 онд 19.2 сая гаруй хүн хорт хавдраар өвдөж, 9.9 сая хүн хорт хавдрын шалтгааны улмаас нас баржээ. Монгол улс дэлхийд хорт хавдрын нас баралтаараа нэгдүгээрт, элэгний хорт хавдрын өвчлөл, нас баралтаараа тэргүүлж байна.

ДЭМБ-ын статистик мэдээлэлд зонхилох байрлалын хорт хавдрын өвчлөлд хөх, ходоод, умайн хүзүү, элэг, уушигны хорт хавдрууд орж байна.

Монгол улсад 2020 онд 6702 хорт хавдрын шинэ өвчлөл бүртгэгдэж, үүний дотор 32 хувийг элэгний хорт хавдар, 17 хувийг ходоодны хорт хавдар, 7.6 хувийг уушиг гуурсан хоолойн хорт хавдар, 7.2 хувийг умайн хүзүүний хорт хавдар, 4.7 хувийг улаан хоолойн хорт хавдар эзэлж байна. Шинээр бүртгэгдсэн хорт хавдрын 36 хувь нь орон нутагт, 35 хувь нь Хавдар судлалын үндэсний төв, 19.1 хувь нь нийслэлийн дүүргүүд, 9.1 хувь нь бусад эмнэлэг, хувийн зарим эмнэлэгт оношлогдсон байна. Хүйсийн хувьд эрэгтэйд элэг, ходоод, уушиг гуурсан хоолой, улаан хоолой, бүдүүн шулуун гэдэсний хавдар, эмэгтэйд элэг, умайн хүзүү, ходоод, хөх, улаанхоолойн хорт хавдар тус тус зонхилон тохиолдож байна. Хорт хавдрын өвчлөлийг улсын дундажтай харьцуулахад Орхон, 10 000 хүн амд Сэлэнгэ, Хэнтий, Говьсүмбэр, Дорнод аймгуудад өвчлөл өндөр байна.


*Хүснэгт 7. 7 Зонхилох арван байрлалын хорт хавдрын өвчлөл, хүйсээр 2020 он*

№	Хорт хавдар			Эрэгтэй			Эмэгтэй		
	Хорт хавдрын байрлал	Т/тоо*	%	Хорт хавдрын байрлал	Т/тоо*	%	Хорт хавдрын байрлал	Т/тоо*	%
1	Элэг	2183	32.6	Элэг	1149	34.7	Элэг	1034	30.5
2	Ходоод	1118	16.7	Ходоод	732	22.1	Умайн хүзүү	480	14.2
3	Уушиг, гуурсан хоолой	507	7.6	Уушиг, гуурсан хоолой	415	12.5	Ходоод	386	11.4
4	Умайн хүзүү	480	7.2	Улаанхоолой	159	4.8	Хөх	240	7.1
5	Улаанхоолой	312	4.7	Бүдүүн шулуун гэдэс	127	3.8	Улаанхоолой	153	4.5
6	Бүдүүн шулуун гэдэс	262	3.9	Нойр булчирхай	110	3.3	Бүдүүн шулуун гэдэс	135	4.0
7	Хөх	244	3.6	Бөөр	107	3.2	Өндгөвч	131	3.9
8	Нойр булчирхай	223	3.3	Тархи, мэдрэл	59	1.8	Нойр булчирхай	113	3.3
9	Бөөр	190	2.8	Лимфоид лейкеми	44	1.3	Уушиг, гуурсан хоолой	92	2.7
10	Өндгөвч	131	2.0	Түрүү булчирхай	35	1.1	Бөөр	83	2.4
<b>Бүгд</b>		<b>6702</b>			<b>3311</b>			<b>3391</b>	

Шинээр бүртгэгдсэн нийт хорт хавдрын өвчлөлийн 27.5 хувь нь байрангаас 2 үе шатандаа, 72.5% нь хожуу үе шатандаа тус тус оношлогдсон байна.

Монгол улсад 2020 оны жилийн эцэст хорт хавдрын өвчлөлийн улмаас 23278 хүн амьдарч байгаагийн 433(1.8 хувь) 0-19 насны хүүхэд байна. Хорт хавдрын хяналтад байгаа хүмүүсийн 39 хувь нь 5 ба түүнээс дээш жил амьдарч байна.

Зураг 7. 22 Хорт хавдрын өвчлөлийн бүтэц, 2020 он




Хорт хавдрын өвчлөлийн түвшин (ӨТ) 100 000 хүн амд 210.1 тохиолдол ногдож байгаа ба энэ үзүүлэлт эрэгтэйчүүдэд 210.1, эмэгтэйчүүдэд 209.6 байна. Элэгний хорт хавдрын өвчлөлийн түвшин 100 000 эрэгтэй хүн амд 72.9 тохиолдол, 100 000 эмэгтэй хүн амд 63.9 тохиолдол ногдож байна.



Хүснэгт 7. 8 Хорт хавдрын шинэ өвчлөл, эзлэх хувь, ӨТ, ӨСТ 2020 он

№	Хавдрын байрлал	Эрэгтэй				Эмэгтэй				Бүгд			
		ТТ	Эзлэх хувь	*ӨТ	ӨСТ (дэлхий)	ТТ	Эзлэх хувь	*ӨТ	ӨСТ (дэлхий)	ТТ	Эзлэх хувь	*ӨТ	ӨСТ (дэлхий)
1	Уруул, амны хөндий	32	1.0	2.0	2.6	28	0.8	1.7	1.9	60	0.9	1.9	2.2
2	Бусад залгиур	33	1.0	2.1	2.6	12	0.4	0.7	0.8	45	0.7	1.4	1.6
3	Улаанхоолой	159	4.8	10.1	16.3	153	4.5	9.5	11.4	312	4.7	9.8	13.6
4	Ходоод	732	22.1	46.5	67.3	386	11.4	23.9	26.7	1118	16.7	35.0	44.0
5	Бүдүүн шулуун гэдэс	127	3.8	8.1	12.0	135	4.0	8.3	9.4	262	3.9	8.2	10.4
6	Элэг	1149	34.7	72.9	107.1	1034	30.5	63.9	76.2	2183	32.6	68.4	90.2
7	Цэсний хүүдий бусад	20	0.6	1.3	2.0	21	0.6	1.3	1.4	41	0.6	1.3	1.7
8	Нойр булчирхай	110	3.3	7.0	10.2	113	3.3	7.0	8.0	223	3.3	7.0	9.0
9	Төвөнх	25	0.8	1.6	2.4	1	0.0	0.1	0.1	26	0.4	0.8	1.1
10	Уушиг, гуурсан хоолой	415	12.5	26.3	43.5	92	2.7	5.7	6.6	507	7.6	15.9	21.8
11	Яс	30	0.9	1.9	2.4	21	0.6	1.3	1.3	51	0.8	1.6	1.8
12	Арьсны меланома	10	0.3	0.6	1.0	29	0.9	1.8	2.1	39	0.6	1.2	1.7
13	Хөх	4	0.1	0.3	0.4	240	7.1	14.8	14.6	244	3.6	7.6	8.0
14	Умайн хүзүү		0.0			480	14.2	29.7	28.9	480	7.2	15.0	15.5
15	Умайн их бие		0.0			58	1.7	3.6	3.7	58	0.9	1.8	2.0
16	Өндгөвч		0.0			131	3.9	8.1	8.5	131	2.0	4.1	4.7
17	Түрүү булчирхай	35	1.1	2.2	3.9		0.0			35	0.5	1.1	1.5
18	Төмсөг	17	0.5	1.1	1.1		0.0			17	0.3	0.5	0.5
19	Бөөр	107	3.2	6.8	8.4	83	2.4	5.1	5.5	190	2.8	6.0	6.8
20	Давсаг	29	0.9	1.8	2.5	12	0.4	0.7	0.9	41	0.6	1.3	1.6
21	Тархи, мэдрэлийн	59	1.8	3.7	4.9	48	1.4	3.0	3.2	107	1.6	3.4	4.0
22	Бамбай булчирхай	10	0.3	0.6	0.8	69	2.0	4.3	4.1	79	1.2	2.5	2.6
23	Ходжкины өвчин	6	0.2	0.4	0.4	7	0.2	0.4	0.4	13	0.2	0.4	0.4
24	ХБЛимфома	22	0.7	1.4	1.9	22	0.6	1.4	1.5	44	0.7	1.4	1.7
25	Миелома	3	0.1	0.2	0.3	5	0.1	0.3	0.3	8	0.1	0.3	0.3
26	Лимфоид лейкеми	44	1.3	2.8	2.9	48	1.4	3.0	3.1	92	1.4	2.9	3.0
27	Бусад байрлал	133	4.0	8.4	11.5	163	4.8	10.1	10.5	296	4.4	9.3	11.2
28	Бүгд	3311	100.0	210.1	308.6	3391	100.0	209.6	231.6	6702	100.0	210.1	262.8

Зураг 7. 23 Зонхилох эхний 10 байрлалын хорт хавдар, өвчлөлийн түвшин, хүйсээр, 100 000 хүн амд, 2020 он



Эрэгтэй 100 000 хүн амд ходоодны хорт хавдар 46.5 тохиолдол, уушигны хорт хавдар 26.3 тохиолдол, улаанхоолойн хорт хавдар 10.1 тохиолдол, бүдүүн шулуун гэдэсний хорт хавдар 8.1 тохиолдол ногдож байна.

Харин эмэгтэй 100 000 хүн амд умайн хүзүүний хорт хавдар 29.7 тохиолдол, ходоодны хорт хавдар 23.9 тохиолдол, хөхний хорт хавдар 14.8 тохиолдол, улаанхоолойн хорт хавдар 9.5 тохиолдол ногдож байна.

Хүснэгт 7. 9 Хорт хавдрын шинэ өвчлөл, бодит тоо, 100 000 хүн амд, 2020 он

№	Аймгууд	Өвчлөл		Нас баралт	
		Бодит тоо	100 000 хүн амд	Бодит тоо	100 000 хүн амд
1	Архангай	176	185.1	138	145.2
2	Баян-Өлгий	127	122.3	86	82.8
3	Баянхонгор	153	173.6	95	107.8
4	Булган	112	183.6	92	150.8
5	Говь-Алтай	124	214.3	101	174.6
6	Говь-Сүмбэр	45	258.6*	35	201.1*
7	Дархан-Уул	230	223.0	170	164.8
8	Дорноговь	137	196.6	90	129.1
9	Дорнод	209	254.7*	146	177.9*
10	Дундговь	90	193.0	64	137.3
11	Завхан	152	209.5	117	161.2
12	Орхон	311	299.6*	193	185.9*
13	Өвөрхангай	257	222.1	138	119.3
14	Өмнөговь	113	162.6	74	106.5
15	Сүхбаатар	133	211.8	121	192.7*
16	Сэлэнгэ	303	280.4*	180	166.6
17	Төв	228	243.9	151	161.5
18	Увс	210	252.2	164	196.9*
19	Ховд	166	189.0	132	150.3
20	Хөвсгөл	270	201.3	219	163.3
21	Хэнтий	213	275.9*	131	169.7
22	Улаанбаатар	2943	202.0	1623	111.4
23	Улсын хэмжээнд бүгд	6702	210.1	4260	133.5

\* Дундажаас өндөр аймаг



### ХОРТ ХАВДАР ОНОШЛОГДОХ ҮЕИЙН TNM ҮЕ ШАТААР:

Олон улсад цусны, булчирхай, тархи, мэдрэлийн гаралтай хорт хавдраас бусад байрлалын хорт хавдрыг TNM ангилалаар үе шатыг тогтоодог. TNM ангилалд хамаарах хорт хавдрын үе шатыг байрангаас 2 үе шатыг эрт үеийн хорт хавдар хэмээн тооцоход эрт үеийн хавдар 27.6 хувь, хожуу буюу 3-4 үе шатандаа 72.4 хувь нь оношлогдсон байна. Зонхилох байрлалын хорт хавдраас умайн хүзүүний хорт хавдрын нийт тохиолдлын 54.8% нь эрт үедээ, элэгний хорт хавдрын 76.7% нь хожуу буюу 3-4 үе шатандаа оношлогдсон байна.

Хүснэгт 7. 10 Хорт хавдрын оношлогдох үеийн үе шат (TNM ангилал), 2020 он, хувиар


№	ХАВДРЫН БАЙРЛАЛ	БАЙРАН	I ҮЕ	II ҮЕ	III ҮЕ	IV ҮЕ
1	Элэг	0.1	3.7	19.5	39.0	37.7
2	Ходоод	1.4	6.7	13.6	39.0	39.3
3	Уушиг, гуурсан хоолой	0.2	1.2	6.3	47.5	44.8
4	Умайн хүзүү	10.6	16.9	27.3	32.9	12.3
5	Улаанхоолой	1.9	4.2	12.5	46.2	35.3
6	Бүдүүн шулуун гэдэс	0.8	4.6	15.3	42.0	37.4
7	Хөх	0.4	11.5	41.4	34.8	11.9
8	Нойр булчирхай	0.9	1.8	16.6	33.6	47.1
9	Бөөр	0.0	30.8	30.3	21.6	17.3
10	Өндгөвч	3.1	8.4	20.6	39.7	28.2
	Бүгд	1.6	6.8	19.1	38.8	33.7

### 7.3.1 ХҮҮХДИЙН ХОРТ ХАВДАР

Монгол улсад 2020 онд 0-19 насанд 113 хорт хавдрын шинэ өвчлөл бүртгэгдсэн байна. Үүний 58% (66) хөвгүүд, 34%(47) охид байна. 0-19 насны хүүхдийн өвчлөлийн бүтцэд лейкеми, тархи мэдрэлийн, яс мөгөөрсний, ходжкины өвчин төмсөгний хорт хавдрууд орж байна. 0-19 насны 52 хүүхэд хорт хавдрын шалтгааны улмаас нас барсан байна.

Монгол улсад 2020 оны жилийн эцэст 0-19 насны 433 хүүхэд хорт хавдрын улмаас хяналтад байгаагийн 247 (58%) эрэгтэй, 186(42%) охидууд байна.

Зураг 7. 24 Хүүхдийн хорт хавдрын бүтэц, хувиар, 0-19 нас




### 7.3.2 ХОРТ ХАВДРЫН ХЯНАЛТ


Монгол улсад 2020 оны жилийн эцсийн тайлангаар 23278 хүн хорт хавдрын улмаас аймаг дүүргийн Хавдар судлаач их эмчийн хяналтад байгаагийн 36.0(8452) хувийг эрэгтэй, 63.6(14826) хувийг эмэгтэйчүүд эзлэж байна.

Хорт хавдрын хяналтад элэгний хорт хавдар 23 хувь, умайн хүзүүний хорт хавдар 18 хувь, ходоодны хорт хавдар 13 хувь, хөхний хорт хавдар 8 хувь, бөөрний хорт хавдар 5 хувийг эзэлж байна. Харин хорт хавдар анх оношлогдож хяналтад авсан хугацаагаар амьдарч буй жилүүдийг тооцоход 1 хүртэл жил 28 хувь, 1-2 жил 10 хувь, 2-3 жил 9 хувь, 3-4 жил 8 хувь, 4-5 жил 6 хувь, 5-аас дээш жил 39 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 7. 25 Хорт хавдрын хяналт, 2020 он



Зураг 7. 26 Хорт хавдрын хяналт, амьдарч буй хугацаагаар, 2020 он




Хяналтад авсанаас хойш 5-аас дээш жил амьдарсан хувийг зонхилох байрлалын хорт хавдруудаар тооцоход умайн хүзүүний хорт хавдар 59% байгаа нь бусад байрлалын хорт хавдруудаас өндөр үзүүлэлттэй байна.





Зураг 7. 27 Хорт хавдрын хяналтанд байгаа хүмүүсийн 5-аас дээш жил амьдарч байгаа хувь, зонхилох байрлалаар



## 7.4 ОСОЛ ГЭМТЭЛ БА ЗАРИМ ГАДНЫ ШАЛТГААНЫ ҮР ДАГАВАР

2020 онд Монгол улсын хэмжээнд 145 497 осол гэмтлийн шинэ тохиолдол бүртгэгдсэн нь 10 000 хүн ам тутамд 441.3 ногдож байгаа ба өмнөх оноос 42.6 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 7. 28 Осол гэмтлийн шинэ тохиолдол, 10 000 хүн амд, 2016-2020 он



ДЭМБ-ын 2019 оны судалгаагаар дэлхий дахинд 55.4 сая хүн нас барснаас 3 сая гаруй тохиолдол нь урьдчилан сэргийлэх боломжтой осол гэмтэл байсан байна. Осол гэмтлийн шалтгаант нас баралт нь дэлхийн хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгааны 5-рт бичигддэг бол Монгол улсын хүн амын нас баралтын 3-рт орж байна.

2016-2020 онуудад бүртгэгдсэн нийт тохиолдлын 62.8 хувийг эрэгтэйчүүд, 38.2 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Осол гэмтлийн шалтгаант 10 шинэ тохиолдол тутамд 6 эрэгтэй, 4 эмэгтэй байна. 10000 хүн амд ногдох осол гэмтлийн тохиолдлын түвшинг насны бүлгээр авч үзвэл 5 хүртэлх насанд хамгийн өндөр байна.

**ОСОЛ ГЭМТЛИЙН ШИНЭ ТОХИОЛДЛЫН ТЭРГҮҮЛЭХ 5 ШАЛТГААН:**

- |                                        |         |
|----------------------------------------|---------|
| 1. Уналт W00-W19                       | /34.9%/ |
| 2. Амьгүй механик хүчинд өртөх W20-W49 | /16.5%/ |
| 3. Зам тээврийн осол V00-V99           | /14.1%/ |
| 4. Хүчирхийлэл X85-Y09                 | /12.4%/ |
| 5. Амьтай механик хүчинд өртөх W50-W64 | /6.7%/  |

10000 хүн амд ногдох осол гэмтлийн түвшин аль ч онд 5 хүртэлх насны хүүхдийн осол гэмтлийн түвшин өндөр, харин 30 наснаас хойш буурдаг зүй тогтол ажиглагдаж байна. Хүйсийн хувьд эрэгтэйд 10000 хүнд ногдох осол гэмтэл 25-29 насанд хамгийн өндөр байгаа бол эмэгтэйд 80-аас дээш насанд өндөр байна.

Эрэгтэйчүүдийн гэмтлийн 24.3 хувь, эмэгтэйчүүдийн гэмтлийн 19.2 хувийг толгойн гэмтэл эзэлж нэгдүгээрт орж байна. Эрэгтэйчүүдэд бугуй сарвуу 13.3 хувь болон тохой шууны гэмтэл 12. хувь, эмэгтэйчүүдэд тохой шууны 14.4 хувь болон шагай тавхайн 12.5 хувийг эдгээр гэмтлүүд эзэлж хоёр, гуравдугаарт орж байна.


*Хүснэгт 7. 11 Осол гэмтлийн шинэ тохиолдлын шалтгаан, хувиар, 2016-2020 о*

Осол гэмтлийн шалтгаан (ӨОУА-10 дагуу)	Гэмтсэн он, хувиар					Дундаж %
	2016	2017	2018	2019	2020	
Санамсаргүй осол гэмтэл						
Уналт /W00-W19/	36.3	37.3	39.2	41.2	41.6	39.4
Амьгүй механик хүчинд өртөх /W20-W49/	14.5	15.9	16.5	17.0	17.7	16.5
Зам тээврийн осол /V01-V99/	16.0	15.3	14.3	13.4	12.6	14.1
Амьд механик хүчинд өртөх /W50-W64/	7.7	6.0	6.0	6.9	7.1	6.7
Түлэгдэлт /W85-X19/	5.1	4.9	4.5	4.3	4.7	4.7
Тодорхойгүй осол /Y10-Y34/	2.1	4.1	4.3	2.9	3.4	3.4
Санамсаргүй хордох, хорт бодист өртөх /X40-X49/	0.9	0.9	0.9	1.2	1.4	1.1
Байгалийн хүчинд өртөх /X30-X39/	0.5	0.4	0.6	0.6	0.4	0.5
Амьсгал боогдох /W75-W84/	0.09	0.07	0.13	0.13	0.2	0.1
Бусад осол /X50-X59/	0.1	0.1	0.2	0.3	0.4	0.2
Хорт амьтан ургамалд өртөх /X20-X29/	0.07	0.07	0.08	0.06	0.1	0.1
Усанд унаж живэх /W65-W74/	0.06	0.05	0.09	0.08	0.1	0.1
Санаатай үйлдлээс үүдсэн осол гэмтэл						
Хүчирхийлэл /X85-Y09/	15.7	14.1	12.5	11.3	9.7	12.4
Санаатайгаар өөртөө гэмтэл учруулах /X60-X84/	0.9	0.8	0.7	0.7	0.7	0.8

Осол гэмтлийн тэргүүлэх шалтгаан хүйсийн хувьд статистикийн ач холбогдол бүхий ялгаатай байгаа бөгөөд эрэгтэйчүүдийн хувьд зам тээврийн осол 13.7% (12106) гуравдугаар шалтгаан болж, эмэгтэйчүүдийн амьгүй механик хүчинд өртөх гэмтэл 13.3% (7764) хоёрдугаар шалтгаан болж байна. Осол гэмтлийн шалтгаан бүрт эрэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байна. Ялангуяа усанд живсэн тохиолдлын 80%, байгалийн хүчинд өртсөн тохиолдлын 78%, халдлагад өртсөн тохиолдлын 72.6% нь эрэгтэй буюу 10 хүн тутмын 7-8 тохиолдлыг эрэгтэйчүүд эзэлж байна. Гэмтсэн хүмүүсийн ажил эрхлэлтийн байдлыг гэмтлийн шалтгаантай харьцуулан судлахад амьсгал боогдох аюултай бусад осол болон түлэгдэлтэд 0-15 насны хүүхдүүд илүү их өртөж, ажилгүй иргэд санаатайгаар өөрийгөө болон бусдыг гэмтээх, байгалийн хүчинд өртөх осолд илүү өртжээ.



**Зураг 7. 29 Осол гэмтлийн тохиолдол, улирлаар, 2020 он**



Осол гэмтлийн шинэ тохиолдлын 29% зун, 26% намар, 25% хавар, 20% өвөл бүртгэгдсэн байна.

Сүүлийн 5 жилийн хугацаанд бүртгэгдсэн нийт тохиолдлын 81.4% нийслэлд, 18.2% орон нутагт бүртгэгдэж мэдээлэгдсэн байна.

Он	2016	2017	2018	2019	2020	Дундаж
Нийслэл	78.5	79.2	82.6	84.2	82.6	81.4
Орон нутаг	21.5	20.8	17.4	13.8	17.4	18.2

Осол гэмтлийн шалтгаант өвчлөл тохиолдлын тоогоор Дорноговь аймагт хамгийн их бүртгэгдсэн бөгөөд бүсээр авч үзвэл төвийн бүсэд хамгийн өндөр байна.

**Хүснэгт 7. 12 Осол гэмтэл бүртгэгдсэн байдал аймгаар, тохиолдлын тоо, 2016-2020 он**

	2016	2017	2018	2019	2020	Нийт 5 жил
	Тохиолдлын тоо	Тохиолдлын тоо	Тохиолдлын тоо	Тохиолдлын тоо	Тохиолдлын тоо	Нийт тоо
Баруун бүс	3743	4345	4285	3883	4611	20867
Баян-Өлгий	479	638	737	553	792	3199
Говь-Алтай	1736	1293	1189	876	1279	6373
Завхан	477	1029	1119	1049	987	4661
Увс	855	889	652	664	843	3903
Ховд	196	496	588	741	710	2731
Хангайн бүс	6333	6117	7052	6722	7162	33386
Өвөрхангай	1594	1387	1289	1041	1054	6365
Архангай	1148	1020	1613	1383	1904	7068
Булган	549	580	562	642	650	2983
Орхон	941	1035	1060	968	857	4861
Хөвсгөл	1361	1254	1502	1623	1416	7156
Баянхонгор	740	841	1026	1065	1281	4953
Зүүн бүс	3898	3680	3691	2982	3382	17633
Сүхбаатар	1439	959	871	571	682	4522
Хэнтий	1247	1462	1513	1411	1449	7082
Дорнод	1212	1259	1307	1000	1251	6029
Төвийн бүс	9167	9813	9752	11251	10160	50143
Говьсүмбэр	977	935	808	775	520	4015
Дорноговь	2367	2576	3123	3473	2890	14429
Төв	1005	1051	1028	1581	1683	6348
Дархан-Уул	2016	1980	1222	1966	1587	8771
Сэлэнгэ	1512	1377	1369	1166	1132	6556
Дундговь	468	707	670	932	869	3646
Өмнөговь	822	1187	1532	1358	1479	6378
Аймгийн дүн	23141	23955	24780	24838	25315	122029
Улаанбаатар	84418	91366	117885	131885	120182	545736
Улсын дүн	107559	115321	142665	156723	145497	667765

## 7.5 ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЭГЧДИЙН ӨВЧЛӨЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН

Улсын хэмжээнд сүүлийн 10 жилийн байдлаар 10000 хүнд ногдох эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх шалтгааныг харвал 2013, 2015 онд зүрх судасны тогтолцооны өвчин тэргүүлж, бусад онуудад өвчлөлийн хандлага ижил байна. 10000 хүнд ногдох эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн сүүлийн 10 жилийн дундажыг харьцуулахад амьсгалын тогтолцооны өвчин тэргүүлэх шалтгаан болж байна. 2020 онд 10000 хүнд ногдох эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийг сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад амьсгалын тогтолцооны өвчин 109-өөр, зүрх судасны тогтолцооны өвчин 35-аар буурч, хоол боловсруулах тогтолцооны өвчин 4-өөр, шээс бэлгийн тогтолцооны өвчин 6-аар, мэдрэлийн тогтолцооны өвчин 33-аар тус тус өссөн байна.

*Хүснэгт 7. 13 Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, 10000 хүн амд, 2011-2020 он*

Өвчлөлийн шалтгаан	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Зүрх, судасны тогтолцооны өвчин	381	403	400	393	392	407	412	422	427	365
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	335	331	345	331	338	339	333	341	342	341
Шээс бэлгэсийн тогтолцооны өвчин	320	316	313	309	307	312	316	320	328	323
Амьсгалын тогтолцооны өвчин	388	405	366	424	353	465	432	466	478	298
Мэдрэлийн тогтолцооны өвчин	167	173	181	173	190	198	211	215	226	229

*Хүснэгт 7. 14 Хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, 2020 он*

	Нийт өвчлөл	Амьсгалын тогтолцооны өвчин	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	Шээс бэлгийн тогтолцооны эмгэг	Зүрх-судасны тогтолцооны өвчин	Мэдрэлийн тогтолцооны өвчин
Хүйс						
Эрэгтэй	1909	311	315	164	316	176
Эмэгтэй	3259	286	367	478	412	281
Насны бүлэг /Эрэгтэй/						
20 хүртэл	1289	528	243	56	10	77
20-44	1374	102	271	162	145	177
45-65	3458	209	501	305	944	334
65 ба түүнээс дээш	7260	628	693	733	2605	521
Насны бүлэг /Эмэгтэй/						
20 хүртэл	1270	465	224	93	12	73
20-44	3799	119	269	650	167	254
45-65	4630	213	652	744	1014	600
65 ба түүнээс дээш	8559	480	1024	1005	2805	768
Байршил						
Хот	3026	315	432	317	394	262
Хөдөө	2224	285	263	328	340	201
Бүсээр						
Баруун	2446	275	324	329	375	245
Хангайн	2187	253	255	373	372	191
Төв	2116	316	238	303	301	180
Зүүн	2166	316	232	264	279	191
Улсын дүн	2593	298	341	323	365	229



Эмнэлэгт хэвтэлтийн түвшин 10 000 эрэгтэй хүн амд 1909, 10 000 эмэгтэй хүн амд 3259 ногдож, ойролцоогоор эмнэлэгт хэвтэж байгаа 2 хүний нэг нь эрэгтэйчүүд байна. 10 000 эрэгтэй хүн амд ногдох хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн түвшин 10 000 эмэгтэй хүн амд ногдох стационарын өвчлөлийн түвшингээс 1.7 дахин бага байна.

2020 оны байдлаар эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгааны дотор зонхилж буй өвчнүүдийг авч үзвэл: шээс бэлгийн тогтолцооны өвчний улмаас хэвтэн эмчлүүлэгчдийн 59.3 хувийг бөөрний сувганцрын үрэвсэлт өвчин, амьсгалын тогтолцооны өвчний дотор уушигны хатгалгааны улмаас хэвтэн эмчлүүлэгчид 43.9 хувийг, хоол боловсруулах тогтолцооны өвчний дотор элэгний эмгэг 19.6 хувийг, зүрх судасны тогтолцооны өвчний дотор даралт ихсэх өвчний улмаас хэвтэн эмчлүүлэгчид 34.9 хувийг, зүрхний ишеми өвчний улмаас хэвтэн эмчлүүлэгчид 24.4 хувийг тус тус эзэлж эдгээр өвчнүүд хүн амын дунд зонхилон тохиолдож байна.

Бөөрний сувганцрын үрэвсэлт өвчнийг хөдлөл зүйгээр нь авч үзэхэд 2011 оноос хойш тогтвортой буурсан байна.

#### Хүснэгт 7. 15 Зонхилон тохиолдох хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн бүтэц, хувиар

Өвчний ангилал (ӨОУА-10)	Зонхилох шалтгаан										
		2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Шээс бэлгийн тогтолцооны өвчин	Бөөрний сувганцрын үрэвсэл (N10-N16)	67.4	67.1	66.1	64.1	63.6	63	63.1	62.9	63.1	59.3
Амьсгалын тогтолцооны өвчин	Хатгалгаа (J12-J18)	46.2	46.9	46.1	51.3	44	52.4	49.1	51.8	51.4	43.9
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	Элэгний эмгэг (K70-K77)	26.1	26.6	27	27.8	26.9	26	25.5	23.2	23.6	19.6
	Мухар олгойн өвчин (K35-K38)	15.4	14.6	14.1	13.5	13.1	12.6	12.2	11.3	11.1	10.7
	Цөсний хүүдийн өвчнүүд (K80-K81)	14.2	14.3	14.6	13.6	13.2	13.4	13.5	14.3	13.8	14.9
Зүрх-судасны тогтолцооны өвчин	Даралт ихсэх өвчнүүд (I10-I15)	36.8	37.7	37.6	38.5	40.2	39.7	40.1	40.2	41.3	34.9
	Зүрхний ишеми өвчнүүд (I20,I23-I25)	26	26.1	26.7	24.6	23.6	24.3	24.1	23.3	22.5	24.4
Мэдрэлийн тогтолцооны өвчин	Мэдрэлийн ёзоор ба сүлжээний эмгэг (G50-59)	28.8	30.9	33.8	27.7	34.8	36.4	37.2	38.9	40.4	40.7
	Эпилепси (G40-G41)	12.6	12.1	11.4	11.4	11.1	10.6	9.5	9.5	7.9	6.9

Уушигний хатгаа өвчин 2011 онд амьсгалын тогтолцооны өвчний улмаас хэвтэн эмчлүүлэгчдийн 46.2 хувийг эзэлж байсан бол 2015 онд 44.0 хувь болж бууран, 2019 онтой харьцуулахад 2020 онд 7.5 хувиар буурсан байна.

2011 онд хоол боловсруулах тогтолцооны өвчний дотор 26.1 хувийг элэгний эмгэг, 14.2 хувийг цөсний өвчнүүд эзэлж байсан бол 2015 оноос буурч, 2020 онд элэгний эмгэг 19.6 хувь, цөсний

хүүдийн өвчнүүд 14.9 болж буурсан байна.

Даралт ихсэх өвчин нь 2011 онд зүрх-судасны тогтолцооны өвчний улмаас хэвтэн эмчлүүлэгчдийн 36.8 хувийг эзэлж байсан бол 2020 онд 34.9 болж буурсан байна.

## 7.6 ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРТ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГ

2020 оны байдлаар артерийн даралт ихсэх эрт илрүүлгийн үзлэгт нийт 900 571 хүн хамрагдсан нь хамрагдвал зохих хүн амын 44.1 хувийг эзэлж байна. Хамрагдалтыг өмнөх онтой харьцуулахад 27.6 хувиар буурсан байна. Нийт үзлэгт хамрагдсан хүн амын 41.5 хувь нь эрэгтэй, 58.5 хувь нь эмэгтэй байна. Эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан хүмүүсийн биеийн жингийн индексийн үзүүлэлтээр авч үзвэл 6.8 хувь туранхай, 52.8 хувь нь хэвийн, 31.3 хувь нь илүүдэл жинтэй, 9.1 хувь нь тарган буюу 30кг/м<sup>2</sup>-аас дээш гарсан байна. Мөн үзлэгт хамрагдагсдын 40.4 хувь нь эрүүл мэндийн мэргэжилтний зохион байгуулсан тусгай дуудлагаар хамрагдсан бол 12.8 хувь нь өөрийн хүсэлтээр, 12.8 хувь нь зар сурталчилгаагаар ирсэн байна.


Эрт илрүүлгийн үзлэгийн үр дүнгийн үзүүлэлтээр 84.3 хувь нь хэвийн, 15.7 хувь нь артерийн даралттай байж болох гэж давтан үзлэгт ирүүлэхээр уригдсан байна. Эрт илрүүлгийн давтан үзлэгт нийт 74 220 хүн хамрагдаж 9 869 буюу нийт үзлэгээс 1.8% нь Артерийн даралт ихсэх өвчний онош батлагдсан байна. Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт нийт 835 823 хүн хамрагдаж, хамрагдвал зохих хүн амын 40.9 хувийг эзэлж байна. Үр дүнгийн үзүүлэлтээр хэвийн 95.5%, өлөн үеийн глюкозын өөрчлөлттэй 4.4% илэрч хоёрдогч шатлалын эмнэлэгт онош батлуулахаар илгээсэн байна.

Чихрийн шижин хэв шинж 2 эрт илрүүлгийн үзлэгт хамрагдалтын хувийг хүйсээр авч үзэхэд эрэгтэй 41.4 хувь, эмэгтэй 58.6 хувийг эзэлж байна. Чихрийн шижин эрт илрүүлгийн үзлэгээс онош батлуулахаар хоёрдогч шатлалын эмнэлэгт 30110 хүн ирснээс 1158 хүн буюу нийт үзлэгт хамрагдсан хүмүүсийн 0.2 хувь нь чихрийн шижин хэв шинж 2 өвчний тохиолдол батлагдсан байна.

2020 оны умайн хүзүү, хөхний өмөнгийн эрт илрүүлэг үзлэг

2020 оны байдлаар умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэгт нийт 98568, үүнээс зорилтот насны 91001 эмэгтэй хамрагдсан нь хамрагдвал зохих эмэгтэйчүүдийн 43.4 хувийг эзэлж байна. Эдгээр хамрагдсан үйлчлүүлэгчдийн 2.2 хувь нь пап эерэг буюу умайн хүзүүний эсийн түвшинд өөрчлөлттэй гарсан байна.

Зураг 7. 30 Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтын хувь, 2012-2020







*Хүснэгт 7. 17 Эрт илрүүлэг үзлэгээр илэрсэн умайн хүзүүний хавдрын үе шат /2012-2020/*

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Оношлогдсон өмөнгийн тоо	39	118	103	78	68	55	35	31	72
I үе	13.2	16.3	41.2	52.5	58.8	47.3	51.4	48.4	41.6
II үе	16.4	13.3	10.3	23.0	16.2	18.2	28.6	19.4	31.9
Эрт үе шатанд илэрсэн хувь	29.6	29.6	51.5	75.5	75.0	65.5	80.0	67.8	73.5

Улсын хэмжээнд 2020 онд умайн хүзүүний эрт илрүүлгийн эсийн шинжилгээний нийт 98568 сорьцоос: шаардлага хангаагүй сорьц 0.8 хувь, хэвийн 94.7 хувь, пап эерэг 2.2 хувь, умайн хүзүүний хорт хавдрын 72 шинэ тохиолдол оношлогдсон ба оны эцэст хариу гараагүй хүлээгдэж буй 3313 шинжилгээний наац үлдсэн байна.

*Хүснэгт 7. 18 Умайн хүзүү, хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтын хувь, 2020 он*

№	Аймгийн нэр	Хамрагдвал зохих эмэгтэйчүүдийн тоо	Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан зорилтот насны эмэгтэйчүүдийн тоо	Зорилтот насны эмэгтэйчүүдийн хамрагдалтын хувь	Хөхний хорт хавдрын боломжит илрүүлэгт хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо
1	Архангай	6348	3573	56.3	17716
2	Баян-Өлгий	6412	2053	32.0	15924
3	Баянхонгор	5947	3887	65.4	4513
4	Булган	4241	2141	50.5	9168
5	Говь-Алтай	3934	2267	57.6	10201
6	Говьсүмбэр	1126	608	54.0	4667
7	Дархан-Уул	7384	4885	51.1	29960
8	Дорноговь	4828	2983	66.2	16646
9	Дорнод	5654	3880	68.6	16204
10	Дундговь	2790	2061	73.9	6057
11	Завхан	5238	2138	40.8	4537
12	Орхон	5107	3203	62.7	18324
13	Өвөрхангай	6998	5149	73.6	30365
14	Өмнөговь	3925	2262	57.6	9832
15	Сүхбаатар	4376	3462	79.1	15413
16	Сэлэнгэ	7541	3237	42.9	2848
17	Төв	6240	3422	54.8	18126
18	Увс	4394	2625	59.7	16852
19	Ховд	4548	2687	59.1	8815
20	Хөвсгөл	9282	5815	62.6	30207
21	Хэнтий	5200	2795	53.8	15331
22	Аймгийн дүн	111513	60988	54.7	301706
23	Улаанбаатар	98094	30013	30.6	214419
24	Улсын дүн	209607	91001	43.4	516125



Эрт илрүүлгийн хамрагдалт аймаг бүрд харилцан адилгүй байгаа бөгөөд 2020 онд хамгийн өндөр хамрагдалттай аймаг Сүхбаатар аймаг байгаа бол хамрагдалт хамгийн багатай нь Баян-Өлгий аймаг байна. Улаанбаатар хотод хамрагдалт аймаг, улсын дунджаас бага байсаар байна.

Зураг 7. 31 Кольпоскоп шинжилгээний үзүүлэлт 2012-2020




## 7.7 МЭС ЗАСЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Улсын хэмжээнд 2020 онд 211 142 өвчтөнд мэс заслын эмчилгээ хийгдсэн бөгөөд 80.7 хувь нь Улаанбаатар хотод, 19.3 хувь нь хөдөө орон нутагт хийгджээ. Улаанбаатар хотод хийгдсэн нийт мэс заслын эмчилгээний 21.1 хувь буюу 44 615 тохиолдолд 15 хүртэлх насны хүүхдэд хийгдсэн байна.

Дурангийн мэс засал 11 880 өвчтөнд хийгдсэн бөгөөд 63.6 хувь нь хоол боловсруулах тогтолцооны өвчлөл, 12.3 хувь нь шээс бэлгийн тогтолцооны өвчлөл, 10.9 хувь нь эмэгтэйчүүдийн өвчлөл, 13.2 хувь нь бусад эрхтэн тогтолцооны өвчлөлд хийгдсэн байна.

Зураг 7. 32 Мэс заслын хагалгааны тоо, аймгаар, 2020 он





Хүснэгт 7. 19 Улаанбаатар хотын эмнэлгүүдэд хийгдсэн мэс заслын тоо, 2020 он


Мэс заслын нэр	м/д	Мэс засал хийлгэсэн хүний тоо		Үүнээс		Мэс заслын дараах хүндрэл		Нас барсан	
		Бүгд	Үүнээс: 15 хүртэлх насны хүүхэд	Дурангийн мэс засал	Давтан хагалгаа	Бүгд	Үүнээс: 15 хүртэлх насны хүүхэд	Бүгд	Үүнээс: 15 хүртэлх насны хүүхэд
А	Б	1	2	3	4	5	6	7	8
Улсын нэгдүгээр төв эмнэлэг	1	13273	19	4116	58	58	0	14	0
Улсын хоёрдугаар төв эмнэлэг	2	3037	0	1236	12	21	0	32	0
Улсын гуравдугаар төв эмнэлэг	3	7622	160	902	23	28	2	34	2
Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	4	16047	8749	223	68	53	29	1	1
Хавдар судлалын үндэсний төв	5	2958	16	167	40	66	1	22	
Халдварт өвчин судлалын үндэсний төв	6	416	23		13				
Гэмтэл согог судлалын үндэсний төв	7	10487	1897	332	1	22	1	185	10
НЭМГ-ын харъяа улсын болон хувийн эмнэлгүүд	8	102700	25867	2370	28	18	0	7	0
ЭМЯ-ны харъяа хувийн эмнэлгүүд	9	13893	773	2534	105	22	0	1	0

## Хүснэгт 7. 20 Зонхилон хийгдсэн мэс засал, төрлөөр, 2020 он

Мэс заслын нэр	Мэс засал хийлгэсэн хүний тоо		Үүнээс		Мэс заслын дараах хүндрэл		Нас барсан	
	Бүгд	Үүнээс: 15 хүртэлх насны хүүхэд	Дурангийн мэс засал	Давтан хагалгаа	Бүгд	Үүнээс: 15 хүртэлх насны хүүхэд	Бүгд	Үүнээс: 15 хүртэлх насны хүүхэд
Мэдрэлийн тогтолцоонд хийгдэх мэс заслууд	2224	231	21	19	20	3	110	2
Дотоод шүүрлийн булчирхайн тогтолцоонд хийгдэх мэс заслууд	588	6	1	0	0	0	1	0
Нүдэнд хийгдэх мэс заслууд	8444	1194	1667	47	5	1	0	0
Чихэнд хийгдэх мэс заслууд	1680	398	239	4	0	0	0	0
Хамар, ам, залгиурт хийгдэх мэс заслууд	85813	30171	532	62	20	0	0	0
Амьсгалын эрхтэн тогтолцоонд хийгдэх мэс заслууд	1174	57	55	6	5	1	21	1
Зүрх судасны тогтолцоонд хийгдэх мэс заслууд	4182	191	157	3	6	2	7	1
Цус болон тунгалгийн тогтолцоонд хийгдэх мэс заслууд	235	48	1	2	0	0	1	0
Хоол боловсруулах эрхтэн тогтолцоонд хийгдэх мэс заслууд	33124	4494	7555	184	184	24	103	4
Шээсний замд хийгдэх хагалгаанууд	2329	121	1148	6	8	0	7	0
Эр бэлэг эрхтэнд хийгдэх мэс заслууд	2521	940	318	8	6	0	2	1
Эм бэлэг эрхтэнд хийгдэх мэс заслууд	21812	171	1292	21	20	0	1	0
Эх барихын ажилбарууд	20532	9	8	37	32	0	1	0
Яс, булчингийн тогтолцоонд хийгдэх мэс заслууд	15894	2863	696	20	18	1	29	1
Гадна эрхтэн тогтолцоонд хийгдэх мэс заслууд	10590	3721	1	5	7	2	25	6
<b>Нийт дүн</b>	<b>211142</b>	<b>44615</b>	<b>13691</b>	<b>424</b>	<b>331</b>	<b>34</b>	<b>308</b>	<b>16</b>




Зураг 7. 33 Цочмог мухар олгойн мэс заслын хагалгаа, аймгаар, 2020 он



Улсын хэмжээгээр цочмог мухар олгойн үрэвслийн улмаас 11 242 хүнд мэс заслын хагалгаа хийгдсэн бөгөөд харьяаллаар авч үзвэл 4 371 тохиолдол буюу 38.9 хувь нь Улаанбаатар хотод хийгджээ.

Зураг 7. 34 Цөсний замын мэс заслын хагалгаа, аймгаар, 2020 он



Улсын хэмжээгээр цөсний замын 9 818 мэс заслын хагалгаа хийгдсэн бөгөөд 6 906 тохиолдол буюу 70.3 хувь нь Улаанбаатар хотод хийгджээ.



БҮЛЭГ

8

ХҮН АМЫН  
НАС БАРАЛТ




## БҮЛЭГ 8.

# ХҮН АМЫН НАС БАРАЛТ

Монгол хүн амын өвчлөл, эндэгдлийн шалтгаанд 1990 оноос өмнө амьсгалын тогтолцооны өвчин тэргүүлж байсан бол 1990 оноос хойш зүрх судасны шалтгаант эмгэгүүд тогтмол тэргүүлэн улмаар өсөх хандлагатай боллоо. Зүрх судасны эмгэгийн шалтгаант нас баралт 1950-иад онд 7.1 хувь, 1985 онд 23.4 хувь, 1995 оноос 30.8 хувийг эзэлж байсан ба 2020 оны байдлаар 32.8 хувь байна. Зүрх судасны өвчний шалтгаант нас баралтын дийлэнхи хувийг артерийн даралт ихсэлт, зүрхний шигдээс, тархины цус харвалт эзэлж байна.


Зураг 8.1 Хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан, 10 000 хүн амд, 1979-2000 он



### 8.1 ХҮН АМЫН НАС БАРАЛТЫН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН

Монгол Улсад сүүлийн 10 жилийн дунджаар 16.5 мянган нас баралтын тохиолдол бүртгэгдсэнээс 61 хувь нь эрэгтэйчүүд, 39 хувь нь эмэгтэйчүүд байгаа бөгөөд шалтгаанаар авч үзвэл зүрх судасны тогтолцооны өвчин (34.2%), хавдар (24.3%), осол гэмтэл, гадны шалтгаан (16.9%) зонхилж байна. Нас баралтад эрэгтэйчүүдийн эзлэх хувь өссөөр байна.


Зураг 8.2 Хүн амын нас баралт, 10 000 хүн амд, хүйсээр, 2019-2020 он



Хүн амын нас баралт 2020 онд 15.9 мянга болж, сүүлийн 10 жилийн дунджаас 634 хүн (3.8%)-ээр нэмэгдэж, өмнөх оноос 1283 (7.5%) хүнээр буурсан байна. 10 000 хүн амд ногдох нас баралт 2020 онд 49.4 байгаа ба 10 000 эрэгтэй хүн амд 59.4, эмэгтэй хүн амд 39.1 байна.


Нас баралтын өөр нэг үзүүлэлт нь насны бүлэг дэх нас баралтын коэффициент (НБНБК) бөгөөд хүйс тус бүрээр НБНБК-ийн дүрслэлийг 2020 оны байдлаар үзүүллээ. Манай улсын хувьд нялхсын эндэгдэл өндөр биш тул доорх дүрслэл нь “J” хэлбэртэй байгааг харж болно. Мөн бүх насны бүлэг дээр эрэгтэйчүүдийн нас баралтын коэффициент өндөр байна.

Зураг 8. 3 Насны бүлэг дэх нас баралтын коэффициент, хүйсээр, 2020 он



2020 оны байдлаар нас баралтын түвшний хүйсийн харьцааг насны бүлэг тус бүрээр харахад 25-29 насанд хамгийн өндөр буюу 3.3 байна. Тайлангийн жилд 25-29 насны бүлэгт нийт 288 тохиолдол бүртгэгдсэнээс 222 эрэгтэй, 66 эмэгтэй байна. Тухайн насны 10 000 эрэгтэй хүн амд харьцуулахад 17.4, эмэгтэй хүн амд 5.2 байгаа бөгөөд эрэгтэйчүүдийн нас баралтын шалтгаан осол гэмтэл, гадны шалтгаан хамгийн өндөр хувийг эзэлж байна.

Зураг 8. 4 Нас баралтын түвшний хүйсийн харьцаа, 2020 он




Мөн 35-39 насанд хүйсийн харьцаа 3.1, 40-44 насанд 2.9, 45-49 насанд 3.2 байгаа тухайн насны эрэгтэйчүүдийн нас баралт эмэгтэйчүүдтэй харьцуулахад бусад насны бүлгээс хамгийн өндөр байна. Нас баралтын шалтгаанаар авч үзвэл тухайн насны бүлгийн эрэгтэйчүүд осол гэмтэл, гадны шалтгаан, эмэгтэйчүүдтэй харьцуулахад 4 дахин их байгаа ба хамгийн түгээмэл шалтгаан нь архины хордлого, амиа хорлолт, зам тээврийн осол байна. Мөн 40-49 насны эрэгтэйчүүдийн зүрх судасны эмгэгийн улмаас нас барах тохиолдол эмэгтэйчүүдтэй харьцуулахад 3 дахин өндөр байгаа ба зүрхний шигдээс, тархинд цус харвалт хамгийн түгээмэл шалтгаан болж байна.






Зураг 8. 5 Нас бүлэг дэх нас баралтын хувь, хүйсээр, 2020 он



Манай улсын хүн амын нас баралтыг зонхилох шалтгаанаар авч үзвэл, 1990 онд амьсгалын тогтолцооны өвчин тэргүүлж байсан бол 1992 оноос эхлэн одоог хүртэл зүрх судасны тогтолцооны өвчин тэргүүлэх шалтгаан болж байна.


2020 оны байдлаар Зүрх судасны тогтоцооны өвчний шалтгаант нас баралт 10 000 хүн амд 16.4, хавдар 13.1, осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт 8.6, хоол боловсруулах тогтолцооны эмгэг 3.4, амьсгалын тогтолцооны эмгэгийн шалтгаант нас баралт 1.9 байгаа нь тэргүүлэх 5 шалтгаан болж байна.

Зураг 8. 6 Хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан, 10 000 хүн амд, 2009-2019 он



Нас баралтыг насны бүлгийн эзлэх хувиар харвал нас барсан эрэгтэйчүүдийн 40.4%, эмэгтэйчүүдийн 68% нь тэтгэврийн насандаа нас барсан байна. Нөгөө талаас эрэгтэйчүүдийн 52.2% буюу тал хувь нь, эмэгтэйчүүдийн 24% нь хөдөлмөрийн насандаа нас барсан байна. Хөдөлмөрийн насны эрэгтэйчүүдийн нас баралт эмэгтэйгээс 3.3 дахин илүү байна.

Зураг 8. 7 Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нас баралтын хувь, насны бүлгээр, 2020



Хүснэгт 8. 1 Хүн амын нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан 10 000 хүн амд, 2020 он

Үзүүлэлт	Нийт нас баралт	Зүрх-судасны тогтолцооны өвчин	Хавдар	Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	Амьсгалын тогтолцооны өвчин
<b>Хүйс</b>						
Эрэгтэй	61.0	19.6	14.6	13.5	3.8	2.3
Эмэгтэй	38.0	12.8	11.2	3.6	2.9	1.4
<b>Насны бүлэг</b>						
20 хүртэл	11.5	0.3	0.5	2.8	0.2	0.8
20-44	19.9	3.3	2.2	9.8	1.7	0.6
45-64	96.3	31.3	30.0	17.0	7.8	2.7
65 ба дээш	447.7	207.6	144.6	10.8	27.1	18.7
<b>Байршил</b>						
Хот	52.6	15.2	12.9	10.5	3.9	2.1
Хөдөө	47.0	16.5	13.2	7.0	3.0	1.7
<b>Бүсээр</b>						
Баруун	46.5	17.6	13.8	5.5	2.3	1.1
Хангайн	48.1	18.8	12.5	7.3	2.7	1.7
Төв	44.2	15.4	12.2	7.6	2.8	1.5
Зүүн	49.1	14.0	14.5	7.7	4.0	2.3
<b>Нийт</b>	<b>53.9</b>	<b>16.2</b>	<b>12.9</b>	<b>8.5</b>	<b>3.3</b>	<b>1.8</b>



## 8.2 ЗҮРХ СУДАСНЫ ТОГТОЛЦООНЫ ӨВЧНИЙ ШАЛТГААНТ НАС БАРАЛТ

Зүрх судасны тогтолцооны өвчний шалтгаант нас баралт 1950-иад онд нийт нас баралтын 7.1 хувь, 1985 онд 23.4 хувь байсан бол 1995 оноос 30.8 хувийг эзэлж байсан ба 2020 оны байдлаар 32.4 хувь байна. Зүрх судасны тогтолцооны өвчний улмаас жил бүр 5000-5500 хүн буюу 3 хүний нэг нь нас барж байгаа бөгөөд хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан болсон хэвээр байна.


Хүн амын нас баралтын нэгдүгээр шалтгаан болох зүрх судасны тогтолцооны өвчний улмаас нас барсан хүмүүсийн 59.8% эрэгтэйчүүд, 40.2% нь эмэгтэйчүүд байна.

Зүрх судасны тогтолцооны өвчнөөс зүрхний ишемит өвчин, тархины цус харвалт, бусад зүрх судасны тогтолцооны өвчин, зүрхний шигдээс дийлэнх хувийг эзэлж байна. Эдгээр нийтлэг өвчин тус бүрт эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс харьцангуй их байна.


Нас барсан хүмүүсийн насны хувьд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү залуу насандаа нас барсан нь эрэгтэйчүүдийн дийлэнх нь 45-с дээш настай, эмэгтэйчүүдийн дийлэнх нь 60-с дээш настай байгаагаас харагдаж байна. Нөгөө талаас эрэгтэйчүүдийн 43% нь хөдөлмөр эрхлэх насандаа, эмэгтэйчүүдийн 18% нь хөдөлмөр эрхлэх насандаа зүрх судасны тогтолцооны өвчний улмаас нас барсан байна.

2020 онд зүрх судасны тогтолцооны шалтгаант нас баралтын түвшин 10 000 эрэгтэй хүн амд 19.6, 10 000 эмэгтэй хүн амд 12.8 ногдож байна. Зүрх судасны тогтолцооны өвчний шалтгаант нас баралтын түвшин хангайн бүсийн аймгуудад 10 000 хүн ам тутамд 18.84, баруун бүсийн аймгуудад 17.6 байгаа улсын дундажаас өндөр байгаа ба төвийн бүс, зүүн бүсийн аймгуудад болон улаанбаатар хотод улсын дундажаас бага байна.

Зураг 8. 8 Зүрх судасны тогтолцооны эмгэгийн шалтгаант нас баралт, 10 000 хүн амд, бүсээр, 2020 он



Зураг 8. 9 Зүрх судасны тогтолцооны эмгэгийн шалтгаант нас баралт, насны ангиллаар, хувь, 2020 он




Аймаг, нийслэлээр харвал хамгийн Хөвсгөл (23.3), Булган (20.67), Дундговь (20.01), Говь-Алтай (19.34), Баян-Өлгий (19.07), Завхан (19.1), Архангай (18.9), Өвөрхангай (18.15), Сэлэнгэ (17.3), Увс (16.5) байгаа нь улсын дундаж үзүүлэлтээс өндөр байна.

Зүрх судасны тогтолцооны өвчнөөр нас барсан хүмүүсийн 95.2 хувийг 40-өөс дээш насныхан эзэлж байна. Зүрх судасны тогтолцооны өвчний дотор зүрхний шигдээс 41.9 хувь, тархинд цус харвах өвчин 24.5 хувийг эзэлж байна. Зүрх судасны тогтолцооны өвчнөөр нас баралтыг

байршлаар харвал Улаанбаатар хотод 38.7 хувь нь бүртгэгдсэн байна.


2020 оны байдлаар хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан болсон зүрх судасны тогтолцооны өвчний 41.9 хувийг зүрхний шигдээс өвчний шалтгаант нас баралт эзэлж байгаа ба нийт 2286 хүн нас барсан нь сүүлийн 10 жилийн дунджаас 302 буюу 12.1 хувиар, өмнөх оноос 287 буюу 11.6 хувиар буурсан байна. 10000 хүнд ногдох зүрхний шигдээсээр нас баралтыг хүйсээр, сүүлийн 10 жилийн дунджаар харвал эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 4-өөр их байна.

Зураг 8. 10 Зүрхний шигдээсээр нас баралтын түвшин, 10000 хүнд амд, хүйсээр, 2009-2020 он



Зүрх судасны өвчний шалтгаант нас баралтын дийлэнх хувийг тархинд цус харвалт, зүрхний шигдээс эзэлж байгаа бөгөөд 2009 онд тархинд цус харвалт 40.2%, зүрхний шигдээс 40.1%-ийш эзэлж байсан бол 2020 онд тархинд цус харвалт 24.5%, зүрхний шигдээс 41.9%-ийг эзэлж байна.

Зураг 8. 11 Тархинд цус харвалтын шалтгаант нас баралт, 10000 хүнд амд, хүйсээр, 2009-2020 он



### 8.3 ХОРТ ХАВДРЫН ШАЛТГААНТ НАС БАРАЛТ


Хавдраас шалтгаалсан нас баралт 1990 оноос хойш нас баралтын 2 дахь шалтгаан болсоор байгаа бөгөөд нас барагчдыг хүйсээр авч үзэхэд 55.1 хувь нь эрэгтэйчүүд байгаа нь эмэгтэйчүүдээс илүү өвчилж, нас барж байна. Насны хувьд 40-өөс дээш насныхан 94.9 хувийг эзэлж байна.

2020 оны байдлаар хавдрын шалтгаант нас баралт нийт нас баралтын 26.1 хувийг эзэлж, нас баралтын түвшин 10 000 эрэгтэй хүн амд 14.9, 10 000 эмэгтэй хүн амд 11.6 байна.



Нас баралтын зонхилох өвчлөлийн хоёр дахь гол шалтгаан болох хавдраас шалтгаалсан нас баралтын 55% нь эрэгтэй, 45% нь эмэгтэй хүмүүс буюу эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 1.2 дахин их байна. Хавдрын төрлийн хувьд дийлэнх нь элэг ба элгэн дэх цөсний сувгийн хорт хавдар, ходоодны хорт хавдар болон амьсгуурсны (bronхын) ба уушгины хорт хавдраас болж нас барсан байна.


**Зураг 8. 12 Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин, 10000 хүнд амд, хүйсээр, 2009-2020 он**



Эрэгтэйчүүдийн дунд элэг, ходоод, уушиг, гуурсан хоолой, улаан хоолой, бүдүүн шулуун гэдэс, эмэгтэйчүүдийн дунд элэг, ходоод, умайн хүзүү, улаан хоолой, уушиг, гуурсан хоолойн хорт хавдрын нас баралт тэргүүлэх 5 шалтгаан болж байна.

Элэгний хорт хавдар нь хүн амын нас баралтыг өвчлөлөөр тооцоход эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нас баралтын 1-р шалтгаан болсоор байна. Жил ирэх тутам нас баралтын тоо нэмэгдэж байгаа ба 2020 оны байдлаар 2009 онтой харьцуулахад 143 тохиолдлоор нэмэгдсэн байна.

**Зураг 8. 13 Элэгний хорт хавдрын шалтгаант нас баралт, 10000 хүнд амд, хүйсээр, 2009-2020 он**



## 8.4 ХҮҮХДИЙН ХОРТ ХАВДРЫН ШАЛТГААНТ НАС БАРАЛТ

Хүүхдийн хавдрын шалтгаант нас баралтын мэдээллийг албан ёсны статистикийн Хүн амын нас баралтын мэдээллийн сангаас түүвэрлэн гаргалаа.

Монгол улсад 2010-2020 онд хорт хавдрын улмаас (0-19 нас) нийт 589 хүүхэд эндсэн ба 11 жилийн дунджаар жилд 53 хүүхэд эндсэн байна. Тухайн насны 100 000 хүүхэдэд харьцуулахад 2010 онд 4.5 байсан бол 2020 онд 4.7 болж 100000 хүүхэд тутамд 0.2-оор нэмэгдсэн ба 11 жилийн дундажтай адил түвшинд байна.

Сүүлийн 10 жилийн дунджаар хүүхдийн хорт хавдрын шалтгаант нас баралт нийт хорт хавдрын шалтгаант нас баралтын 1.6 хувийг эзэлж байна.

Шинээр бүртгэгдсэн хорт хавдрын тохиолдолтой харьцуулахад тухайн жилд нас барсан тохиолдлын хувь сүүлийн жилүүдэд буурах хандлагатай байгаа боловч 2020 онд 54 хувь нь нас барсан байгаа нь 2010 онд харьцуулахад 26 хувиар буурсан үзүүлэлттэй байна.


Зураг 8. 14 Хүүхдийн хорт хавдрын шалтгаант нас баралтын тохиолдол, 2010-2020 он



Улсын хэмжээнд 2010-2020 онд хүүхдийн хорт хавдрын нас баралтын шалтгаанд (1) тунгалгийн, цус төлжүүлэх ба тэдгээрийн төрлийн эдийн өмөн; (2) тархи нугасны өмөн; (3) яс ба үений мөгөөрсний өмөн; (4) мезотел ба зөөлөн эдийн өмөн зонхилж байна.

Хорт хавдрын улмаас эндсэн хүүхдийн насны бүлгээс хамаарч ялгаатай байгаа хэдий ч хорт хавдрын улмаас эндсэн хүүхдийн эндэгдлийн голлох шалтгаанд тунгалгийн, цус төлжүүлэх ба тэдгээрийн төрлийн эдийн өмөн буюу Лимфолейкеми, Лейкеми дийлэнх хувийг эзэлж байгаа ба 2010 онд 18 тохиолдол буюу нийт эндэгдлийн 39.1 хувийг эзэлж байсан бол 2020 онд 33 тохиолдол буюу нийт эндэгдлийн 54.1 хувийг эзэлж байна.

Зураг 8. 15 Лимфолейкеми, Лейкеми шалтгаант нас баралтын тохиолдол, 2010-2020 он



Тухайн өвчний шалтгаант эндэгдлийн тоо нэмэгдэж байгаа төдийгүй, хорт хавдрын нас баралтад эзлэх хувь мөн нэмэгдэж байна. Лимфолейкеми, Лейкеми өвчний шалтгаант нас баралтад эрэгтэй хүүхдийн эндэгдэл, эмэгтэй хүүхдийн эндэгдлээс 2 дахин өндөр байна.

Цус төлжүүлэх ба тэдгээрийн төрлийн эдийн өмөн бүх насны бүлэгт адил тохиолджээ. Харин хорт хавдрын улмаас эндсэн 0-4 насны хүүхдийн 20.1%, 5-9 насны хүүхдийн 26.1% тархи



нугасны өмөнгөөр эндсэн бол 10-14 насны хүүхдийн 18.2%, 15-19 насныхны 17.9% яс ба үений мөгөөрсний өмөнгийн улмаас эндсэн байна.

## 8.5 ОСОЛ ГЭМТЭЛ, ГАДНЫ ШАЛТГААНТ НАС БАРАЛТ

Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт нь монгол хүний нас баралтын 3 дахь шалтгаан болсоор байгаа бөгөөд 2020 оны байдлаар нийт нас баралтын 17.2 хувийг эзэлж байна.

Зам тээврийн осол, амиа хорлолт, үйлдвэрлэлийн осол, бусдад хорлогдсон, бусад осол, тодорхой бус гэсэн шалтгаанууд байгаа ба эдгээр бүх хэлбэрт эрэгтэй хүмүүсийн нас баралт эмэгтэйгээс харьцангуй их байна.

2020 онд бүртгэгдсэн 10-35 насны хүүхэд, залуучуудын нас баралтын шалтгааны 50 хувиас илүү нь осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт эзэлж байгаа ба үүнээс 15-19 насныхны 80 хувь орчим нь осол гэмтэл, гадны шалтгааны улмаас амиа алдсан байна. Мөн 10-14 насны хүүхдүүдийн 51 хувь, 20-34 насны залуучуудын 60 хувь, 35-39 насны залуучуудын 49 хувь нь гадны шалтгааны улмаас амь насаа алдсан байна.

Хүснэгт 8. 2 Хүн амын нас баралтын хэлбэр, 2005, 2010, 2015, 2020 он

Хэлбэр		2005		2010		2015		2020	
		эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй
Өвчлөл	Тоо	7158	5484	8112	6,376	7752	6059	7561	5625
	Хувь	75.6	91.4	78.6	91.7	78.9	92.5	77.9	90.5
Бусад осол	Тоо	1051	243	1120	301	914	243	1,112	345
	Хувь	11.1	4.0	10.8	4.3	9.3	3.7	11.5	5.5
Зам тээврийн осол	Тоо	427	116	375	116	447	118	373	114
	Хувь	4.5	1.9	3.6	1.7	4.6	1.8	3.8	1.8
Амиа хорлосон	Тоо	379	70	384	75	408	71	384	67
	Хувь	4.0	1.2	3.7	1.1	4.2	1.1	4.0	1.1
Бусдад хорлогдсон	Тоо	300	66	225	63	197	44	164	44
	Хувь	3.2	1.1	2.2	0.9	2.0	0.7	1.7	0.7
Тодорхой бус	Тоо	110	14	74	16	65	13	93	20
	Хувь	1.2	0.2	0.7	0.2	0.7	0.2	1.0	0.3
Үйлдвэрийн осол	Тоо	42	9	35	4	39	4	18	2
	Хувь	0.4	0.1	0.3	0.1	0.4	0.1	0.2	0.0



Зураг 8. 16 Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт, 2009-2020 он




### 8.4.1 ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ШАЛТГААНТ НАС БАРАЛТ

Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын хэлбэрээр авч үзвэл 23.6 хувийг зам тээврийн осол эзэлж байгаа бөгөөд сүүлийн 10 жилийн дунджаар 556 хүн нас барсан байна.

2019 онд 557 хүн зам тээврийн ослоор нас барсан нь сүүлийн 10 жилийн дунджаас 1, өмнөх оноос 35 тохиолдлоор нэмэгдсэн байна. Эрэгтэйчүүдийн зам тээврийн осолд өртөж амь насаа алдах явдал эмэгтэйчүүдээс 3.4 дахин их байна.

Зураг 8. 17 Зам тээврийн ослыг шалтгаант нас баралт, 2009-2020 он




Зам тээврийн ослын шалтгаант нас баралтыг төрлөөр харуулбал: 2020 оны байдлаар бусад тээврийн осол-45.6%, мотоциклтой зорчигч зам тээврийн осолд орсон-27.6, явган зорчигч зам тээврийн осолд орсон 26.4%-ийг тус тус эзэлж байна.

Хүйсийн хувьд бусад тээврийн ослын улмаас нас барсан эрчүүд эмэгтэйчүүдээс 2.3 дахин их, явган зорчигч нас барсан тохиолдол 1.5 дахин их байгаа бол мотоциклтой зорчигч нас барсан тохиолдолд эрэгтэйчүүд 13 дахин илүү байна.


2020 онд зам тээврийн ослоор нас барсан тохиолдлыг насны ангиллаар харуулбал: 15 хүртэлх насны хүүхэд 14.8 хувь, 15-29 насныхан 18.1 хувийг эзэлж байгаа ба 30-39 насныхан 19.1 хувь, 40-49 насныхан 20.3 хувийг эзэлж байгаа нь насны ангилал дотроо өндөр үзүүлэлт байна.



Зураг 8. 18 Зам тээврийн ослын шалтгаант нас баралт, насны ангиллаар, 2020 он



Зураг 8. 19 Зам тээврийн ослын шалтгаант нас баралт, шалтгаанаар, 2009-2020 он




### 8.4.2 АМИА ХОРЛОЛТ

Сүүлийн 10 жилийн хугацаанд жилд дунджаар 16.9 орчим мянган хүн нас барснаас 2.8% орчим хувь нь амиа хорлон нас баржээ. 2009 оны байдлаар амиа хорлосон нас баралт 10 000 хүн тутамд 1.7 байсан бол 2020 онд 1.4 хүн болж буурсан байна.

Хүйсээр авч үзвэл: 2010-2019 оны дунджаар нийт нас барсан хүн амын 60.5 хувь, харин амиа хорлогчдын 85.0 хувь нь эрэгтэйчүүд байна.

Амиа хорлогчдын тоо 2020 онд 451 байгаа нь нийт нас баралтын 2.8 хувийг эзэлж байгаа ба сүүлийн 10 жилийн дунджаас нийт нас баралт 9 тохиолдлор бага байгаа хэдий ч өмнөх онтой харьцуулахад 4 тохиолдлоор нэмэгдсэн байна.

Зураг 8. 20 Амиа хорлож нас барсан тохиолдол, 10 000 хүн амд, хүйсээр



Нийт нас барсан хүнд эзлэх амиа хорлогчдын хувь бага хэдий ч насны бүлэгт эзлэх хувь харьцангуй ялгаатай байна. Тухайлбал, 2020 онд нас барсан 20-24 насны залуучуудын 20.0 хувь нь буюу 5 хүн тутмын 1, 15-19 насныхны 21.0 хувь буюу мөн 5 хүн тутмын 1, 25-29 насны залуучуудын 27.1 хувь буюу 4 хүн тутмын нэг нь амиа хорлон нас барсан байна.

2003 онд 10-14 насныхны амиа хорлолт энэ насны хүүхдүүдийн нийт нас баралтын 3.3 хувийг эзэлж байсан бол 2020 онд 11.6 хувь болж, 3.5 дахин өссөн нь бусад насны бүлэгтэй харьцуулбал хамгийн их өөрчлөлттэй бүлэг байна.

Нас барсан, эрэгтэй хүн амд амиа хорлогчдын эзлэх хувь 20-24 насанд өндөр байгаа хандлага 2019 онд хэвээр байгаа бол эмэгтэйчүүдийн хувьд 2020 онд 20-24 насныхан хамгийн өндөр байна.

Түүнчлэн нас барсан хүн амыг насны бүлэг болон шалтгаанаар авч үзвэл ялангуяа өсвөр үе, залуучуудын дунд амиа хорлолт тэргүүлж байгаа төдийгүй тэдгээрийн дийлэнх нь эрэгтэйчүүд байна. Тухайлбал, амиа хорлон эндсэн 10-14 насныхны 66.7 хувь, 15-19 насныхны 72.1 хувь, 20-24 насныхны 81.8 хувь, 25-29 насныхны 91.2 хувь, 30-34 насныхны 86.8 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна

Хэлбэрийн хувьд дийлэнх нь дүүжлэх, боймлох, амьсгал боох гэсэн аргаар амиа хорлосон байна.



Хүснэгт 8.3 Амиа хорлолт, хэлбэрээр, 2010, 2015-2020 он


Үзүүлэлт	Хүйс	2010 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
Эмийн бодисоор өөрийгөө санаатайгаар хордуулах	Эр	0	0	0	0	1	0	1
	Эм	2	3	0	1	1	1	2
	Бүгд	2	3	0	1	2	1	3
Хортон шавьж устгах хороор өөрийгөө санаатай хордуулах	Эр	0	0	0	0	0	0	0
	Эм	0	0	0	0	1	0	0
	Бүгд	0	0	0	0	1	0	0
Өөрийгөө санаатайгаар дүүжлэх, боймлох, амьсгал боох	Эр	338	376	352	336	349	358	346
	Эм	55	61	58	55	61	46	56
	Бүгд	393	437	410	391	410	404	402
Санаатайгаар өөрөө живэх	Эр	0	3	3	0	0	0	2
	Эм	1	0	0	1	0	2	0
	Бүгд	1	3	3	1	0	2	2
Өөрийгөө санаатайгаар буу болон галт зэвсгээр хөнөөх	Эр	21	20	15	11	14	23	17
	Эм	3	0	0	1	0	0	2
	Бүгд	24	20	15	12	14	23	19
Санаатайгаар өөрөө өндрөөс үсрэх	Эр	7	3	8	19	1	1	2
	Эм	8	2	1	9	0	0	4
	Бүгд	15	5	9	28	1	1	6
Бусад аргаар өөртөө гэмтэл учруулах	Эр	20	6	9	14	15	15	16
	Эм	7	5	4	3	2	1	3
	Бүгд	27	11	13	17	17	16	19

### 8.4.3 БУСАД ОСЛЫН ШАЛТГААНТ НАС БАРАЛТ

Бусад ослын шалтгаант нас баралтаас архины хордлогын шалтгаант нас баралт 44.6 хувийг эзэлж байгаа ба ус, гал, байгалийн хүчинд өртсөн осол 20 хувийг эзэлж байна.

Бусад осолд спиртэнд хордох, байгалийн хүчинд өртөх, усанд живэх, амьсгал боох бусад аюултай осол, хий, ууранд санамсаргүй хордох, өртөх, барилга байгууламжаас унах, бусад өндрөөс унах, амьгүй механик хүчинд өртөх зэрэг ослууд орж байна. Эдгээр эрсдэлт ослуудын бүх төрөлд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс харьцангуй их өртсөн байгаагаас спиртэнд хордох, байгалийн хүчинд өртөх, амьгүй механик хүчинд өртөх гэсэн төрлүүдэд хамгийн их буюу эрэгтэйчүүд 80-90%-ийг эзэлж байна.

Зураг 8. 21 Архи, спиртэнд санамсаргүй хордож нас барсан тохиолдол, хүйсээр, 2009-2020 он



Зураг 8. 22 Нас баралтын бусад ослын шалтгаан, 2020 он






## 8.5 ХООЛ БОЛОВСРУУЛАХ ТОГТОЛЦООНЫ ӨВЧНИЙ ШАЛТГААНТ НАС БАРАЛТ


Хоол боловсруулах тогтолцооны өвчний шалтгаант нас баралт 2009 онд нийт нас баралтын 8.5 хувийг эзэлж байсан бол 2020 онд 1076 тохиолдол буюу 6.8 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар 1278 тохиолдол бүртгэгдсэн ба 2020 онд сүүлийн 10 жилийн дунджаас 202 тохиолдлоор, өмнөх оноос 97 тохиолдлоор тус тус буурсан байна.

Зураг 8. 23 Хоол боловсруулах өвчний шалтгаант нас баралт, 2009-2020 он




Хүн амын нас баралтын дөрөвдүгээр тэргүүлэх шалтгаан болох хоол боловсруулах тогтолцооны өвчний улмаас нас барсан хүмүүсийн 56.2% эрэгтэйчүүд, 43.8% нь эмэгтэйчүүд байна.

Зураг 8. 24 Хоол боловсруулах тогтолцооны шалтгаант нас баралт, 10 000 хүн амд, хүйсээр, 2009-2020 он



2020 оны байдлаар хоол боловсруулах тогтолцооны шалтгаант нас баралтын 53.4 хувийг элэгний цирроз ба фиброзын шалтгаант нас баралт эзэлж байна. Насны ангиллаар харуулбал, 45-60 насныхан 60 хувь буюу дийлэнх хувийг эзэлж, эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс харьцангуй их байна.


Зураг 8. 25 Элэгний циррозын шалтгаант нас баралтын тоо, хүйсээр, 2009-2020 он



## 8.6 АМЬСГАЛЫН ТОГТОЛЦООНЫ ӨВЧНИЙ ШАЛТГААНТ НАС БАРАЛТ

2020 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд амьсгалын тогтолцооны өвчний шалтгаант нас баралтын 594 тохиолдол бүртгэгдэж өнгөрсөн оны мөн үеэс 209 тохиолдлоор буюу 26 хувиар буурсан байна. Амьсгалын тогтолцооны өвчний шалтгаант нас баралтын 61 хувь нь эрэгтэй, 39 хувь эмэгтэйчүүд байна.


Зураг 8. 26 Амьсгалын тогтолцооны өвчний шалтгаант нас баралтын тохиолдол, хүйсээр








Зураг 8. 27 Амьсгалын тогтолцооны өвчний шалтгаант нас баралт, 10 000 хүн амд, 2009-2020 он



Амьсгалын тогтолцооны өвчний шалтгаант нас баралт 10 000 хүн амд харьцуулахад 2010 онд 2.84 байсан бол 2020 онд 1.84 болж буурсан үзүүлэлттэй байна. 2020 оны байдлаар уушигны хатгалгаа өвчний шалтгаант нас баралтын нийт амьсгалын тогтолцооны өвчний шалтгаант нас баралтын 53.6 хувийг эзэлж байна.

Зураг 8. 28 Уушигны хатгалгаа өвчний шалтгаант нас баралтын тохиолдол, 2009-2020 он





# БҮЛЭГ

# 9

ЦУС СЭЛБЭЭЛТ  
СУДЛАМЫН  
САЛБАРЫН ҮЙЛ  
АЖИЛЛАГАА



## БҮЛЭГ 9.

# ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын статистик мэдээгээр 2018 онд дэлхий дахинд 118.5 сая нэгж цус өгөлт бүртгэгдсэн байна. 1000 хүн амд ногдох цус өгөлтийн тоо өндөр орлоготой орнуудад 31.5, дундаас дээгүүр орлоготой орнуудад 15.9, дунд орлоготой орнуудад 6.8, бага орлоготой орнуудад 5.0 тус тус байна.

Цус сэлбэлтээр дамжих халдвар илрүүлэх шинжилгээний төрлөөр нь авч үзвэл нийт донорын дунд гепатит В вирусын халдварын улмаас хасагдалт хамгийн өндөр хувьтай байна.

Цус, цусан бүтээгдэхүүний хэрэглээгээр нь авч үзвэл өндөр орлоготой орнуудад нийт үйлдвэрлэсэн цус, цусан бүтээгдэхүүний 75 хувь нь 60 ба түүнээс дээш насны хүн амд хэрэглэгдсэн бол бага орлоготой орнуудад 54 хүртэл хувь нь 0-5 насны хүүхдүүдэд хэрэглэгдсэн байна.

### 9.1 ЦУС, ЦУСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХАНГАЛТ


Монгол улсын Цус сэлбэлт судлалын салбар нь 2020 онд улсын хэмжээнд эрүүл мэндийн байгууллагуудыг аюулгүй, чанартай цус, цусан бүтээгдэхүүнээр 100 хувь ханган ажиллалаа.

Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/373 дугаар тушаалаар цусны донорыг элсүүлэх, сонгох, цус цуглуулах, шинжлэх, цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, шинэчлэх журмын дагуу эмнэлгүүдийг мэргэжил арга зүйгээр тогтмол ханган ажиллаж байна.

Үйл ажиллагааныхаа үр дүнг дээшлүүлэх, цусны сэлбэлт судлалын салбарын уялдааг сайжруулахаар Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн бүтэц, дүрэм, Цусны салбар төвийн дүрмийг Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/445 тоот тушаалаар шинэчлэн батлууллаа.

Улсын хэмжээнд нийт цус цуглуулалтын тоо 2016 онд 32966 байсан бол 2020 онд 35646 болж 8.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Нийт цус цуглуулалтын 26835 (75.3%) ЦССҮТ-д, 8811 (24.7%) цусны салбар төвд тус тус цуглуулсан байна (Зураг 1). Мөн нийт цус цуглуулалтын 68.2 хувийг цус цуглуулах суурин төвд, 31.8 хувийг хөдөлгөөнт хэлбэрээр цуглуулсан байна.

Зураг 9.1 Нийт цус цуглуулалтын тоо, 2016-2020 он



Улаанбаатар хотод 1000 хүн амд ногдох цус цуглуулалтын тоо 2019 онд 17.7 байсан бол 2020 онд 18.3 болж өссөн үзүүлэлттэй байна.

Цус, цусан бүтээгдэхүүний хэрэглээ болон хүн амын тооноос шалтгаалан хөдөө орон нутагт 1000 хүн амд ногдох цус цуглуулалтын тоо сүүлийн жилүүдэд тогтвортой байна (Зураг 9.2).


Зураг 9.2 1000 хүн амд ногдох цус цуглуулалтын тоо, 2016-2020 он



Газарзүйн байршлаар нь авч үзвэл төвийн бүсийн аймгуудын дунд цус цуглуулалт өндөр байна. 2020 оны байдлаар цус цуглуулалтын тоо Дархан (874), Хөвсгөл (720), Баян-өлгий (626) зэрэг аймгуудад хамгийн өндөр байсан бол Говьсүмбэр (135), Дундговь (216), Говь-Алтай (221) зэрэг аймгуудад бага байна. (Зураг 9.3).




Зураг 9.3 Цус цуглуулалтын тоо, аймаг, 2020 он



Сүүлийн жилүүдэд улсын хэмжээнд цусны донор хадгалалт, алдаршуулалтын арга хэмжээг тогтмол хэрэгжүүлсэний үр дүнд нийт доноруудын дунд байнгын донорын эзлэх хувь нэмэгдэж байна.

Байнгын донорын эзлэх хувь нэмэгдэх нь цус, цусан бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах, тасралтгүй нөөц бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Донорын төрлөөр нь авч үзвэл, 2016 онд нийт цусны донорын дунд байнгын донорын эзлэх хувь 53 байсан бол 2020 онд 65 хувь болж 12 хувиар өссөн үзүүлэлттэй байна (Зураг 9.4).

Зураг 9.4 Цусны донорын төрөл, 2016-2020 он



Цус цуглуулалтыг насны бүлгээр авч үзвэл 25-44 насныхан 49.2 хувийг эзэлж байна. Нийт цусны донорын 54.4 хувийг эрэгтэйчүүд, 45.6 хувийг эмэгтэйчүүд тус тус эзэлж байна.

Цусаа өгсөн донорын цусны сорьцонд цус сэлбэлтээр дамжих 4 төрлийн халдвар илрүүлэх шинжилгээг 100 хувь хийдэг бөгөөд шинжилгээгээр хасагдалтын хувь жил бүр тогтмол буурч байна. 2016 онд цус сэлбэлтээр дамжих халдвар илрүүлэх шинжилгээгээр хасагдалтын хувь 6.4 хувь байсан бол 2020 онд 3.5 хувь болж 1.8 дахин буурсан үзүүлэлттэй байна (Зураг 5).

Зураг 9.5 Цус сэлбэлтээр дамжих халдвар илрүүлэх шинжилгээгээр хасагдалтын хувь, 2016-2020 он



ДЭМБ-ын зөвлөмжөөр бага, дунд орлоготой орнуудад нийт хүн амын дунд цусны донорын эзлэх хувь 1.5 байхыг зөвлөдөг. Энэ үзүүлэлт 2020 оны байдлаар Улаанбаатар хотын хэмжээнд 1.8 хувь байгаа нь эмнэлгийн захиалгыг бүрэн хангах боломжийг бүрдүүлж байна.


## 9.2 ЦУС, ЦУСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

ЦССҮТ нь 2015 онд 15 нэр төрлийн цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэж байсан бол техник, технологийн шинэчлэлтийг үе шаттайгаар нэвтрүүлж, үр ашигтай нутагшуулсаны үр дүнд 2020 онд 34 нэр төрлийн цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

Улсын хэмжээнд үйлдвэрлэгдэж буй нийт цус, цусан бүтээгдэхүүний 80 хувийг ЦССҮТ-д, 20 хувийг цусны салбар төвүүдэд үйлдвэрлэж байна.

Улсын хэмжээнд 2016 онд 81927 нэгж цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэж байсан бол 2020 онд 106832 нэгж цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийт үйлдвэрлэл 30 хувь өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс: ЦССҮТ-д 85641 нэгж, цусны салбар төвүүдэд 21191 нэгж бүтээгдэхүүнийг тус тус үйлдвэрлэсэн байна (Зураг 6).


Зураг 9.6 Цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 2016-2020 он



Мөн түүнчлэн цус, цусан бүтээгдэхүүнийг шарах технологи, улаан эсийг хөлдөөж хадгалах технологи, бүтээгдэхүүний эмгэг төрүүлэгчийг идэвхгүйжүүлэх технологи зэрэг орчин үеийн шинэ технологийг үйл ажиллагаандаа нутагшуулсантай холбоотойгоор 2020 онд цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэл өмнөх онтой харьцуулахад 7.7 хувь өссөн үзүүлэлттэй байна. Цаашид улаан эсийн бүтээгдэхүүнийг цагаан эсгүйжүүлэх, Эмгэг төрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн цус, цусан бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэн 2024 онд 100 хувьд хүргэхийг зорьж байна. (Зураг 9.7.)



Зураг 9. 7 Цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлд шинэ технологийг нутагшуулах, 2020-2024 он



Цус сэлбэлт судлалын үндэсний төв (ЦССҮТ) нь бүх үйл ажиллагаандаа ЧМТ ISO 9001:2015 ОУ-ын стандартын шаардлагыг бүрэн хэрэгжүүлж, байнга сайжруулж ажилладаг. 2020 онд хөндлөнгийн байгууллагын давтан баталгаажуулалтад амжилттай хамрагдаж гэрчилгээг 3 жилийн хугацаар сунгалаа.

Мөн MNS OHSAS 18001:2012, MNS ISO 15189:2016 стандартын хэрэгжилтийг 2020 оны магадлах аудитад хамрагдаж гэрчилгээ үргэлжлүүлэн эзэмших эрх авлаа.

2020 онд Азийн цус сэлбэлтийн холбоо (AATM)-той 4 жилийн хугацаатай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, Олон улсын Цус сэлбэлтийн нийгэмлэг (ISBT)-ийн XXXVI их хуралд оролцсон амжилттай байна.



БҮЛЭГ

10

БҮЛЭГ 10. ЭС,  
ЭД, ЭРХТНИЙГ  
ШИЛЖҮҮЛЭН  
СУУЛГАХ ҮЙЛ  
АЖИЛЛАГАА





## БҮЛЭГ 10.

# БҮЛЭГ 10. ЭС, ЭД, ЭРХТНИЙГ ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монгол Улсын Донорын тухай хууль анх 2000 онд батлагдан 2012 болон 2018 онд нэмэлт өөрчлөлт хийгдсэн, 2018 онд шинэчлэгдэн батлагдсан дагуу Эрүүл Мэндийн Хөгжлийн Төвийн Эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах алба 2018 оны 03 дугаар сарын 01-нд байгуулагдаж, 5 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Тус алба нь Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/500, А/502, А/503, А/504, 2019 оны А/164 тушаалаар батлагдсан журмууд болон бөөр, элэг, ясны чөмөг, нойр булчирхай шилжүүлэн суулгах заавар, аргачлалын дагуу эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалт, арга зүйгээр ханган ажиллаж байна.

### 10.1 ЭС, ЭД, ЭРХТЭН ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Манай улсад эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслыг Улсын нэгдүгээр төв эмнэлэгт бөөр, элэг, ясны чөмөг үүдэл эс, судас, шөрмөс, Хавдар судлалын үндэсний төвд элэг шилжүүлэн суулгас мэс засал мөн Үр шилжүүлэн суулгах эмчилгээг Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, CLWH, RMC, Өжинмед, Юнимед эмнэлгүүд тус тус амжилттай хийж байна. Эрүүл дөрвөн улирал эмнэлэг нь хэвлийн өөхөн эдээс үүдэл эс ялган тухайн хүнд өөрт нь эмчилгээг хийж эхлүүлээд байна. Мөн түүнчлэн нойр булчирхай, зүрх шилжүүлэн суулгах баг байгуулах шинэ технологи нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Засгийн Газрын 2017 оны тогтоолоор эрхтэн шилжүүлэн суулгах зардлыг төрөөс санхүүжүүлэх шийдвэр гарснаар 2017-2020 онд 9.1 тэрбум төгрөгийн санхүүжилт хүлээн авснаар эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын тоо нэмэгдсэн.

2020 оны жилийн эцсийн байдлаар бөөр шилжүүлэн суулгах мэс засал 230, элэг шилжүүлэн суулгах мэс засал 112, ясны чөмөг үүдэл эс 22, нүдний эвэрлэг 24, арьс шилжүүлэн суулгах мэс засал 735, шөрмөс шилжүүлэн суулгах мэс засал нийт 22 эмчилгээг тус тус амжилттай хийгээд байна.


Хүснэгт 10. 1 Шилжүүлэн суулгасан бөөр, элэгний мэс засал, 1996, 2006-2020 он

Үзүүлэлт			1996 он	2006 он	2007 он	2008 он	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	НИЙТ	
Элэг шилжүүлэн суулгах мэс засал	УНТЭ	Амьд донор	-	-	-	-	-	-	3	4	4	5	6	7	9	23	22	20	103	
		Амьгүй донор	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	2	-	-	4	3	9
	ХСҮТ	Амьд донор	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	7	9	8	24
		Амьгүй донор	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	0	4	1	5
Бөөр шилжүүлэн суулгах мэс засал	УНТЭ	Амьд донор	1	8	4	12	9	9	8	5	12	18	15	16	18	23	18	23	199	
		Амьгүй донор	-	-	-	2	2	2	-	2	-	-	-	-	4	-	2	11	6	31

Монгол улсад 2008 оноос тархины үхэлтэй донорын илрүүлэг, менежмент, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагаа хийгдэж байна. Тархины үхлийг тодорхойлох үйл явц MNS4621:2008 стандартын дагуу явагддаг. Эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах алба байгуулагдснаар 2018 оноос УНТЭ, УГТЭ, ГССҮТ дээр Тархины үхэл тодорхойлох баг шинэчлэгдэн байгуулагдсанаар тогтмол үйл ажиллагаа явуулж байна.

2019 оны 01 дүгээр сард Эрхтэн шилжүүлэн суулгах эмнэлэг, Донор эмнэлэг болон тус алба хамтран ажиллах гурвалсан гэрээг Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлэг, Гэмтэл согог, судлалын үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төвтэй тус тус байгуулсан.


Зураг 10. 1 Амьд болон тархины үхэлтэй донороос хийгдсэн эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын тоо, 2006-2020 он



2020 онд Улсын хоёрдугаар төв эмнэлэг дээр тархины үхэл тодорхойлох баг шинээр байгуулагдснаар одоогоор улсын хэмжээнд нийт 4 баг энэхүү үйл ажиллагааг гүйцэтгэж байна.



Зураг 10. 2 Тархины үхэл тодорхойлох багуудын илрүүлэлт, 2018-2020 он




Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/504 дүгээр тушаалын дагуу эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах алба нь тархины үхэлтэй боломжит донорын гэр бүлтэй уулзалт зохион байгуулан донор болох хүсэлтийг тавьдаг. Тархины үхэлтэй донорын зөвшөөрлийг гэр бүлийн 3 гишүүнээс авдаг.

2018 оноос хойш нийт 149 илрүүлэлт хийгдснээс 33 гэр бүлтэй уулзалт хийж, 16 гэр бүлээс зөвшөөрөл авсан. Үүнээс 14 нь бодит донор болж нийт 19 бөөр, 12 элэг амжилттай шилжүүлэн суулгаж 31 хүний амь насыг аварсан. Мөн 22 хүнд шөрмөс шилжүүлэн суулгаж амьдралын чанарыг сайжруулсан болно. Цаашид нойр булчирхай шилжүүлэн суулгах мэс заслын бэлтгэл ажлын хүрээнд эрхтэн авах мэс ажилбарыг 3 удаа хийгээд байна.


Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааны нэгдсэн бүртгэл мэдээллийн санд улсын хэмжээгээр эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг эрхэлж байгаа байгууллагад бүртгэгдэж буй шинээр мэс засал хийлгэхээр хүлээгдэж буй хүний тоо, түүнээс хасагдсан шалтгаан, гадаад эмчилгээнд явсан, мэс засалд орсон, нас барсан, яг одоогийн байдлаар хэдэн хүн хүлээлгэх жагсаалтад байгаа зэрэг нэгдсэн мэдээллийг хянан, удирдан зохицуулдаг.

Зураг 10. 3 Элэг шилжүүлэн суулгах мэс заслын хүлээх жагсаалтад байгаа хүний тоо, 2020 он



Тархины үхэлтэй донороос элэг шилжүүлэн суулгах мэс засал хийлгэхээр хүлээх жагсаалтад бүртгүүлсэн 255 үйлчлүүлэгч байгаа бөгөөд гепатит В, С халдварын улмаас элэгний хатуурлын шалтгаантай өвчлөл дийлэнх буюу 64.0 хувь, мөн элэгний анхдагч хавдар 24.0 хувь, хүүхдийн цөсний ерөнхий сувгийн төрөлхийн битүүрэл 12.0 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 10. 4 Эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын хүлээх жагсаалтад байгаа хүний тоо, 2020 он



Хүлээх жагсаалтад байгаа мэдээллийг өвчний шалтгаанаар авч үзэхэд хүн амын өвчлөлийн дөрөвдүгээр шалтгаан болсон шээс бэлгийн тогтолцооны өвчний улмаас бөөр шилжүүлэн суулгах мэс засал хийлгэх шаардлагатай болсон хүний тоо 319, элэгний вируст гепатит өвчлөл улмаас үүссэн элэгний хатуурал, элэгний хавдар, цэсний ерөнхий сувгийн төрөлхийн битүүрэл шалтгаант элэг шилжүүлэн суулгах мэс засал шаардлагатай 255, цусны хорт хавдар өвчний улмаас 11 хүн ясны чөмөг, үүдэл эс шилжүүлэн суулгах тус тус эмчилгээ хийлгэхээр бүртгүүлсэн байна.

## 10.2 ЭС, ЭД, ЭРХТЭН ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ЭМЧИЛГЭЭНИЙ ДАРААХ ХЯНАЛТ


Эрхтэн шилжүүлэн суулгуулсан үйлчлүүлэгчдийн дархлаа дарангуйлах эмийн хэрэглээний мэдээллийг тухай бүр шинэчлэл баяжуулалт хийн үйл ажиллагааг тогтмолжуулсан.

2020 оны байдлаар дархлаа дарангуйлах эмийг улсын хэмжээнд 573 хүн, үүнээс орон нутагт 157, нийслэлд 416 хүн тус тус ууж хэрэглэж байна.

Зураг 10. 5 Дархлаа дарангуйлах эм хэрэглэж буй хүний тоо, 2020 он




Зураг 10. 6 Эд, эс, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний дараа хяналтад буй хүний тоо, аймгаар, 2020






*Зураг 10. 7 Эд, эс, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний дараа хяналтад буй хүний тоо, Нийслэлийн дүүргүүдээр, 2020*



Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний талаар сургалтыг Эрхтэн шилжүүлэн суулгах дэлхийн холбоо, БНСУ, БНТУ, Испани, Австрали, Франц, АНУ-ын нийгэмлэг холбоотой хамтран тогтмол зохион байгуулан эмч мэргэжилтний ур чадварыг нэмэгдүүлэн, судалгаа шинжилгээний ажлыг хамтран хийж байна.

*Хүснэгт 10. 2 Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах чиглэлээр сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтний тоо, 2018-2020 он*

Үзүүлэлт	2018 он	2019 он	2020 он
Гадаад сургалт	35	23	4
Дотоод сургалт	400	2020	600
Нийт	435	2043	604



**БҮЛЭГ**

**11**

ЭРҮҮЛ  
МЭНДИЙН  
ЭДИЙН ЗАСАГ





## БҮЛЭГ 11.

# ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭДИЙН ЗАСАГ

Энэхүү бүлгийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн тайлан болон эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагын мэдээлэлд үндэслэн боловсруулав.

### 11.1. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Үндэсний статистикийн хорооноос дотоодын нийт бүтээгдэхүүнийг тооцоходоо 2006, 2010, 2014 онуудад нийт 3 удаа тодотгол хийж, дотоодын нийт бүтээгдэхүүн болон үндэсний нийт орлогыг тооцох аргачлалыг 2007, 2013 онуудад тус тус шинэчлэн баталж, нийт 5 удаагийн өөрчлөлт хийсэн байна.


Зураг 11.1 ДНБ-д эрүүл мэндийн салбарын зардлын эзлэх хувь




Эх үүсвэр: ЭМЯ-ны Санхүү, эдийн засгийн хэлтэс; ҮСХ

Эрүүл мэндийн салбарын зардлын ерөнхий хандлага мөнгөн дүнгээрээ өсөх хандлагатай байна. Эрүүл мэндийн сайдын багцын зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2017 онд 2.5 байсан бол 2018-2019 онуудад тогтмол 2.2 хувь болж 0.3 функтээр буурч, 2020 онд 0.5 функтээр өссөн байна.

Зураг 11. 2 Эрүүл мэндийн салбарын зардал, эдийн засгийн ангиллаар (тэрбум төг)



Зураг 11. 3 Эрүүл мэндийн салбарын зардал, эдийн засгийн ангиллаар (хувиар)



Эх сурвалж: ЭМЯ-ны Санхүү, эдийн засгийн хэлтэс

Засгийн газрын дотоод шилжүүлгийн зардалд 2013 оноос “Төсвийн тухай хууль”, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”-ын дагуу сумын эрүүл мэндийн төв болон орон нутаг дахь биеийн тамир, спортын хороо, клубуудын зардал нэмэгдсэнтэй холбоотойгоор эрс өссөн байна.

2016 онд спортыг эрүүл мэндийн салбараас салгаж Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд шилжүүлсэн. Засгийн газрын дотоод шилжүүлгийн зардал 2016 оныг 2015 онтой харьцуулахад 1.2 дахин буурсан бол 2016-2019 онуудад 2.6-14.3 хувийн өсөлттэй буюу 2020 онд 2019 оноос 30.7 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.


Эрүүл мэндийн салбарын зардлыг 2020 оны байдлаар эдийн засгийн ангилалаар авч үзвэл 31.5 хувийг ажиллагсдын цалин, хөлстэй холбоотой зардал, 14.9 хувийг эм, эмнэлгийн хэрэгсэлийн зардал, 1.3 хувийг хоолны зардал, 3.1 хувийг ашиглалтын зардал, 11 хувийг хөрөнгө оруулалтын





зардал, 16.2 хувийг анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын зардал буюу засгийн газрын дотоод шилжүүлгийн зардал, 22.1 хувийг бусад зардал эзэлж байна. Эрүүл мэндийн салбарын нийт зардлыг эдийн засгийн ангилалаар нь авч үзвэл дийлэнх хувийг цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал эзэлж байна.


**Зураг 11.4 Эрүүл мэндийн салбарын зардал, үндсэн үйл ажиллагааны чиглэлээр (хувиар)**



Эх сурвалж: ЭМЯ-ны Санхүү, эдийн засгийн хэлтэс

Сүүлийн хоёр жилийн үзүүлэлтээс харахад эрүүл мэндийн зардлын эзлэх хувь 2019 онд 88.2 хувь, 2020 онд 89 хувь болж 0.8 хувиар өссөн бол хөрөнгийн зардал 11.8 хувиас 11 болж 0.8 хувиар буурсан байна. Спортын салбарийн зардал 2016 онд Эрүүл мэндийн сайдын багцын зардлаас хасагдаж БСШУЯ-руу шилжсэн.


**Зураг 11.5 Эрүүл мэндийн зардал, дэд бүлгээр (хувиар)**




Эх үүсвэр: ЭМЯ-ны Санхүү, эдийн засгийн хэлтэс

Эрүүл мэндийн зардлыг дэд бүлгээр авч үзвэл, 2017-2018 онуудад нийт санхүүжилтийн 89.5 хувийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зарцуулж байсан бол 2019 онд 91 хувь болж 1.5 хувиар өссөн, 2020 онд 11 хувиар буурсан байна. Эрүүл мэндийн удирдлагын зардал 8 хувиас 20 хувь болж 12 хувиар өссөн, Засгийн газрын тусгай сангууд буюу эрүүл мэндийг дэмжих сан 0.42 хувиас 0.34 хувь болж 0.07 хувиар буурсан, эрүүл мэндийн төвлөрсөн арга хэмжээнд зардал гараагүй байна. Төсөл, хөтөлбөрийн зардал 2019 оноос Сангийн сайдын багцад шилжсэн.

Зураг 11.6 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардал, тусламж, үйлчилгээний шатлалаар (тэрбум төгрөгөөр)



Зураг 11.7 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардал, тусламж, үйлчилгээний шатлалаар (хувиар)



Эх үүсвэр: ЭМЯ-ны Санхүү, эдийн засгийн хэлтэс

